



Монгол Улсын дээд шүүх



Шүүхийн сургалт, судалгаа,
мэдээллийн академи

**“ДАГНАСАН ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО:
ХҮҮХДИЙН ЭРХ АШИГ БА ГЭР БҮЛ”**
ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар хот

2025 он



Монгол Улсын дээд шүүх



Шүүхийн сургалт, судалгаа,
мэдээллийн академи



Creating a Culture of Justice
International Development Law Organization

IDLO Олон улсын эрх зүйн
хөгжлийн байгууллага



**Hanns
Seidel
Stiftung**

Ханнс-Зайделийн сан



“ДАГНАСАН ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО:
ХҮҮХДИЙН ЭРХ АШИГ БА ГЭР БҮЛ”

ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ

Монгол хэл рүү орчуулсан: *

Д.Бямба-Од, Шүүхийн академийн Иргэний эрх зүйн
секторын эрхлэгч (МРА)

Г.Амаржаргал, Шүүхийн академийн судлаач

О.Анхбаяр, Шүүхийн академийн судлаач

А.Нэмүүлэн, Шүүхийн академийн судлаач

П.Чинунар, Шүүхийн академийн судлаач (LL.M)

С.Юмжирдулам, Шүүхийн академийн судлаач

Эмхэтгэсэн:

С.Юмжирдулам, Шүүхийн академийн судлаач

Эхийг бэлтгэн хэвлэсэн:

Юнипресс ХХК

© Шүүхийн академи, 2025.

Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан тул энэхүү бүтээлийг зөвшөөрөлгүй хэвлэх,
нийтлэх, олшруулах, хуулбарлахыг хориглоно.

* Англи хэл дээрх илтгэлүүдийг Монгол хэл рүү хөрвүүлэхдээ нэр томъёоны нэгдмэл байдлыг
хангахыг зорьсон болно. “Нэр томъёоны тайлбар”-ыг Хавсралтаас үзнэ үү.

ГАРЧИГ

ХУРЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	7
НЭЭЛТИЙН ҮГ	9
ҮНДСЭН ИЛТГЭЛ	12
“ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ ГЭР БҮЛИЙН ХАМГААЛАЛТ”	13
П.Золзаяа, УДШ-ийн Иргэний хэргийн танхимын шүүгч (LL.M)	13
“ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ХЭРГИЙН ШҮҮХ: ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, БҮТЭЦ, ХАРЬАЛАЛ, МОНГОЛЫН ЗАГВАР”	25
Ч.Хосбаяр, УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, Хууль зүйн доктор (Ph.D).....	25
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ГЭР БҮЛ БА ХАМТЫН АМЬДРАЛ, ҮРЧЛЭЛТ, ГЭРЛЭЛТ ЦУЦЛАЛТ, ЭХ НЯЛХАС, ХҮҮХДИЙН АШИГ СОНИРХОЛ, АСРАН ХАМГААЛАЛТ, ДУНДЫН ЭД ХӨРӨНГИЙН ХАРИЛЦААН ДАХЬ ТУЛГАМДСАН АСУУДАЛ	32
”ЯПОН УЛСЫН ГЭР БҮЛИЙН ШҮҮХЭЭС ГЭР БҮЛ ЦУЦЛАЛТ, ХҮҮХДИЙН АСРАМЖТАЙ ХОЛБООТОЙ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ НЬ”	33
Харада Аяако, Япон Улсын Нагояагийн их сургуулийн профессор,	33
Хууль зүйн доктор (LL.D)	33
“МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭР БҮЛИЙН ХӨРӨНГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ, ШҮҮХИЙН ПРАКТИК”	51
Н.Баярмаа, УДШ-ийн Иргэний хэргийн танхимын шүүгч,	51
Хууль зүйн доктор (LL.D)	51
“БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ДАХЬ ХҮҮХДИЙН АСРАМЖ БА ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ”	68
Севил Картал, БНТУ-ын дээд шүүхийн Иргэний хэргийн <i>2-р танхимын шүүгч</i> , Гэр бүлийн эрх зүйн үнэлгээний зөвлөлийн дарга	68
“МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮҮХДИЙН АСРАМЖИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ”	76
Ж.Лхагвасүрэн, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч (МРА), Г.Нямсүрэн, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч (LL.M)	76
“ХҮҮХЭД ҮРЧЛЭЛТИЙН ТАЛААРХ ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ”	90
Н.Оюунтуяа, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч (LL.M), Т.Энхтуяа, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч (LL.M)	90

ХОЁРДУГААР ХЭСЭГ: ӨСВӨР НАСНЫ ХҮНД ХОЛБОГДОХ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА	110
--	------------

“МОНГОЛ УЛС ДАХЬ ӨСВӨР НАСНЫ ХҮНД ХОЛБОГДОХ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА”	111
---	------------

С.Өмирбек, Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч (LL.M).....	111
--	-----

ХАВАЙН НЭГДСЭН ГЭР БҮЛИЙН ШҮҮХ: ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ХЭРГИЙН ДАГНАСАН ШҮҮХИЙН ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР	144
--	------------

Маттю Ж. Виола, Хавай мужийн Хонолулу хотын анхан шатны шүүхийн шүүгч (Dr.jur.)	144
---	-----

“ХБНГУ ДАХЬ ӨСВӨР НАСНЫ ХҮНИЙ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ”	154
--	------------

Стефан Сшал, ХБНГУ-ын Бамберг хотын Ерөнхийпрокурорын газрын прокурор, орлогч дарга	154
---	-----

ГУРАВДУГААР ХЭСЭГ: ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА БА ШҮҮХИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	157
--	------------

“ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХ: ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, ШҮҮХИЙН ҮҮРГИЙН ТАЛААРХ ЭРГЭЦҮҮЛЭЛ”	158
---	------------

Тон Лиефаард, Хүүхдийн эрхийн чиглэлээр мэргэшсэн профессор, ЮНИСЕФ-ийн Хүүхдийн эрхийн асуудлыг хариуцсан тэргүүлэх мэргэжилтэн, Лейдений их сургуулийн Хууль зүйн сургуулийн Хүүхэд ба Эрүүл мэндийн салбар хариуцсан тэнхимийн эрхлэгч, Хууль зүйн доктор (Ph.D).....	158
--	-----

“БНСУ-ЫН ГЭР БҮЛИЙН ШҮҮХИЙН ТҮҮХ, СҮҮЛИЙН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА”	162
--	------------

Ким Хён Рюл, БНСУ-ын Сөүлийн Гэр бүлийн шүүхийн Ерөнхий шүүгч, (LL.M).....	162
--	-----

“ГЭР БҮЛИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН СЭТГЭЛЗҮЙН ЭРҮҮЛ МЭНД”	167
--	------------

Карли Шревер, “Human Ethos” захирал, University of Western Australia-ийн Хуулийн тэнхимийн дэд профессор, (PhD), Салли Раян “Human Ethos” захирал	167
---	-----

“ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТАЛААР”	172
---	------------

О.Оюунзул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга (LL.M).....	172
--	-----

ХУРЛЫН ХӨТӨЛБӨР	184
------------------------------	------------

ХАВСРАЛТ	187
-----------------------	------------

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	203
-----------------------------------	------------

ХУРЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Дэлхийн улс орнууд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн эсхүл хохирсон, өөр бусад байдлаар шүүх үйл ажиллагаанд татагдан оролцож буй өсвөр насны хүний хувьд тэдний нас, бие, сэтгэлзүйн онцлогт тохирсон, цаашид бие хүн болон төлөвшихөд нь онцгой анхаарсан хэрэг хянан шийдвэрлэх эерэг орчин, тусгай журам шаардагддагийг харгалзан үзэж, хүүхдийн хэргийн шүүх, гэр бүлийн шүүхийг дагнан байгуулаад цөөнгүй жил болж байна. Тухайлбал Австрали, АНУ-ын зарим муж, ХБНГУ, Канад, БНСУ, Шинэ Зеланд, Энэтхэг, Япон, Бельги зэрэг улсууд гэр бүлийн дагнасан шүүхтэй бол, Англи, Австри, Хонконг, Тайван зэрэг улсын шүүхүүд гэр бүлийн хэргийн танхимтай байна.¹

Монгол Улсын хувьд шүүхийн журмаар гэрлэлт цуцлалт, тэтгэлэг гаргуулах хэрэг маргааны тоо жил тутам өсөж байгаа бөгөөд Иргэний хэргийн анхан шатны шүүхийн нийт шийдвэрлэгдэж байгаа хэргийн 10-12 хувийг Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэрэг эзэлдэг байна. Тиймээс Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулга болон уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудыг баталсан бөгөөд тус хуульд заасны дагуу Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс байгуулахаар болсон юм.

Энэхүү олон улсын хурлаар Монгол Улсад Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх байгуулагдахтай холбогдуулан “Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл” ерөнхий сэдвийн хүрээнд Монгол болон ХБНГУ, Нидерланд, Япон, БНСУ, Бүгд Найрамдах Турк Улс, АНУ-ын эрдэмтэн, шүүгч нар илтгэл танилцуулж, харилцан туршлага солилцоно.

Хурлын зорилго:

Шүүхээс гэр бүл, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шударга, үр дүнтэй, хэрэгжүүлэх үүднээс энэ төрлийн хэргийг харьяалан шийдвэрлэх мэргэшсэн тогтолцоо бүрдүүлсэн улсын сайн туршлагыг хуваалцаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, зохист тогтолцоог бий болгох тодорхойлох бэлтгэл ажлыг хангахад чиглэх юм.

Иймд “Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл” ерөнхий сэдвийн хүрээнд бусад улсын онол, практик туршлагын талаар дотоодын болон гадаадын эрдэмтэн, судлаач болон шүүгч нар илтгэл хэлэлцүүлж, хэлэлцүүлэг өрнүүлэхэд оршино.

Сэдэв:

Тус хурал нь “Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл” гэх ерөнхий сэдвийн хүрээнд явагдах бөгөөд гэр бүл, хүүхдийн эрх ашгийг хамгаалахад тулгамдаж буй асуудал, энэ салбарт үйл ажиллагаа явуулах дагнасан шүүхийн харьяалах маргаан, процесс ажиллагаа болон бүтцийг нарийвчлан тодорхойлоход шаардлагатай дараах үндсэн чиглэлээр илтгэгчид илтгэл

1 Шүүх байгуулах тухай хуулийн үзэл баримтлал, <https://lawforum.parliament.mn/project/492/>.

танилцуулна.

- Гэр бүл ба хамтын амьдрал, үрчлэлт, гэрлэлт цуцлалт, эх нялхас, хүүхдийн дээд эрх, ашиг сонирхол, асран хамгаалалт, дундын эд хөрөнгийн харилцаан дахь тулгамдсан асуудал;
- Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа;
- Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхийн хэрэг хянан, шийдвэрлэх ажиллагаа ба шүүхийн бүтэц, зохион байгуулалт.

Хурлаас хүлээгдэж буй үр дүн:

Эрдэм шинжилгээний хурал нь салбарын эрдэмтэн, судлаач, шүүгчдийн цуврал илтгэлээс бүрдэх бөгөөд илтгэлийн сэдэвтэй холбогдуулан хэлэлцүүлэг зохион байгуулна. Уг эрдэм шинжилгээний хурал нь бусад улс, орны сайн туршлагад үндэслэн гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүхийн бүтэц, зохион байгуулалт, тухайн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохист хувилбарыг эрэлхийлэхэд чиглэгдэнэ.

НЭЭЛТИЙН ҮГ

Өнөөдрийн арга хэмжээнд хүрэлцэн ирсэн эрхэм зочид, төлөөлөгч, хурлын оролцогч та бүхний өглөөний амар амгаланг айлтгая.

“Монгол Улс” шүүхийн шинэтгэлийн үзэл баримтлалд үндэслэн ирэх жилд 3 дахь дагнасан шүүхээ байгуулах бэлтгэл ажлын хүрээнд, энэхүү “*Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл*” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж байна.

Бидний нийгмийн, ялангуяа хууль зүйн олон асуудлын шалтгаан гэр бүлээс үүдэж, үр дагавар нь гэр бүлд нөлөөлдөг. Тийм ч учраас Хүний эрхийн түгээмэл тунхаглал (§16.3)¹ зэрэг олон улсын баримт бичгүүдэд “гэр бүл нийгмийн бүлгийнхээ хувьд” төрийн хамгаалалтад байх ёстойг тодотгодог. Канад, Австрали, Япон, Герман (ХБНГУ), Франц (БНФУ), Солонгос (БНСУ), Сингапур зэрэг олон улсад гэр бүлийн дагнасан шүүх, тухайлсан танхим, эсвэл мэргэшсэн шүүгч ажиллаж гэр бүлийн маргааныг дагнан шийдвэрлэж байна.

Манай улсын хувьд, хүүхэд хамгааллын чиглэлээр 40 гаруй² “олон улсын эрх зүйн баримт бичигт” нэгдэж орсон. Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх байгуулах явдал нь өөрсдийн эрх зүйн тогтолцоог илүү “хүнлэг”, “боловсронгүй” болгохоос гадна олон улсын өмнө өгсөн “амлалтаа” биелүүлж буй хэрэг мөн. Тухайлбал, Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын 1.4 дэх хэсэгт “Насанд хүрээгүйчүүдийн шүүхийн тогтолцоог улс орнууд үндэсний хөгжлийн үйл явцын салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж ойлгох ёстой”-г заасан байдаг.³ Ийм шүүхийн тогтолцоо нь Хүүхдийн эрхийн конвенцын 3-р дугаар зүйлд тусгагдсан “хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах”-д өндөр ач холбогдолтой.

Монгол Улсад 2023 онд Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гэр бүлийн эрх зүйн 5913 хэрэг шийдэгдсэн бол 2024 онд 6520 болон өсөж, нийт шийдэгдсэн хэргийн 10-аад (8.8434) хувийг эзэлжээ. Шийдвэрлэгдсэн тоон эзлэхүүнээрээ нийт хэргийн 3-т эрэмбэлэгдэж байна. 2024 онд 1675 насанд хүрээгүй хүн гэмт хэрэгт холбогдсон нь нийт бүртгэгдсэн гэмт хэрэг үйлдэгсдийн (25291) 6.62 хувийг эзэлж, 209 нь шүүхээр ял шийтгүүлсэн бол мөн онд хүүхэд оролцсон гэмт хэрэг 1373, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 1559 бүртгэгдсэн нь өмнөх оноос ойролцоогоор 10 хувь өсжээ.

Энэ мэт олон тоон үзүүлэлтээс “гэр бүл, хүүхдийн хэргийг дагнан шийдвэрлэх шүүх байгуулах нь “хүүхдийн хууль ёсны эрх ашгийг зохих ёсоор хамгаалах”, “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох онцлогт нийцсэн нөхцөлийг бүрдүүлэх”, “шүүхийн ачааллыг зөв хуваарилах”, “гэр бүлийн

1 Гэр бүл бол нийгмийн жам ёсны буюу суурь бүлэг бөгөөд нийгэм, төрийн хамгаалалтад байна.

2 2021 оны байдлаар 35. <https://mn.usembassy.gov/wp-content/uploads/sites/192/ADAPT-Full-MNG.pdf?#page=44.10>

3 1.4 Насанд хүрээгүйчүүдийн шүүхийн тогтолцоог тухайн улсын үндэсний хөгжлийн үйл явцын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болгон ойлгох ёстой бөгөөд энэ нь бүх насанд хүрээгүй хүүхдэд зориулсан нийгмийн шударга ёсны цогц тогтолцооны хүрээнд хэрэгжих учиртай. Ингэснээр залуу үеийг хамгаалахад болон нийгэмд энх тайван, эмх журмыг сахин хадгалахад хувь нэмэр оруулна.

хариуцлагыг дээшлүүлэх”, “эвлэрүүлэн зуучлалын үр нөлөөг ахиулах” зэрэг олон талын ач холбогдолтой болохыг харж болно.

Энэ утгаараа бидний хувьд тойргийн дагнасан шүүх байгуулагдаж байгаа нь ахиц боловч цаашид олон улсын туршлага, хөгжилд зэрэгцэж очих, дотооддоо дагнасан шүүхийн манлайллыг түүчээлэх өндөр хариуцлага хүлээгдэж байгааг цохон тэмдэглэе. Энэхүү шүүхийн “хэргийн харьяалал”-аас гадна, “олон улсын гэр бүлийн маргаан” дахь шүүхийн харьяаллын асуудлаас эхлээд бусад улсын шүүхтэй харилцан ойлголцох шаардлагатай процессын онцлог асуудлууд нэмэгдэж байгаа талаар Ази, Номхон далайн бүсийн Ерөнхий шүүгчдийн бага хурлаар онцолж байсныг⁴ дуулгая.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” хэрэгжүүлэхээр тусгасан нь энэхүү дагнасан шүүхийг хөгжүүлэхэд эрх мэдэл хоорондын хамтын ажиллагааг дөтлөх боломжийг нэмэгдүүлж буй.

Процессын хувьд хувийн ба нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх учраас шүүхээс хэргийг шийдвэрлэх үндэслэл болох нөхцөл байдлыг тогтоохын тулд шалгах ажиллагаа явуулах, нотлох баримт цуглуулах, нотолгооны онцлог үзэл баримтлалыг мөрдөх, сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр хэрэг үүсгэх, гэр бүл цуцлахад хүүхэдтэй холбоотой бусад асуудлыг заавал хамтад нь шийдвэрлэх, мэргэшсэн сэтгэл зүйч ажиллуулах зэрэг өвөрмөц зохицуулалтыг судлах, хэрэгжүүлэх эсэхэд анхаарлаа хандуулах шаардлагатай. Уг шүүхийн ажиллах процессын хуулийн төслүүдийг санал авахаар Улсын дээд шүүхэд ирүүлсэн. Өнөөдрийн хурлын нэг үр дүн нь тус төслүүдийг улам боловсронгуй болгох санал, санаачилга гаргахад чиглэнэ.

Энд онцолж жишээ татахад, зарим бүсийн шинжтэй олон улсын байгууллагаас (Европын Комиссын сайд нарын зөвлөл) Хүүхдэд ээлтэй шударга ёсны тогтолцооны үндсэн шинжүүдийг:

- Хүртгээмжтэй;
- Насанд нь нийцсэн;
- Шуурхай;
- Хариуцлагатай, нягт нямбай;
- Хувийн болон гэр бүлийн амьдралын халдашгүй байдлыг хүндэтгэдэг;
- Хэргийг нь шийдэхэд хүүхдийн өөрийн оролцоог хангах, шүүхийн процессыг ойлгож ухамсарлах эрхийг нь баталгаажуулах зэргээр (нийт 9 шинж) тодорхойлсон.

Мөн хүүхдийн оролцоог хангаж, ашиг сонирхлыг нь эрхэмлэх, эрхэм чанар-нэр төрийг нь дээдлэх, ялгаварлахгүй байх гэсэн үндсэн зарчмуудыг манай улсад

4 Сингапурын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Сундареш Меноны үндсэн илтгэл: <https://www.judiciary.gov.sg/news-and-resources/news/news-details/chief-justice-sundares-menon-paper-delivered-at-the-18th-conference-of-chief-justices-of-asia-and-the-pacific>

байгуулагдах шүүх хөдөлбөргүй баримтлах ёстой. Шүүгдэгч, гэр бүл цуцлах маргааны оролцогч зэргээр хууль зүйн процесст оролцоно гэдэг хүүхдийн хувьд ойлгоход хүнд, зарим талаар айж эмээх сэтгэгдэл төрүүлэхүйц насанд хүрэгчдийн ертөнцөд хөл тавьж буй явдал гэдгийг ч бид мартаж болохгүй. Иймд Улсын дээд шүүхээс хүүхдийн эрхийн асуудлыг онцгойлон анхаарч, хүүхдэд ээлтэй шүүхийг хөгжүүлэхэд анхаарч ажиллана.

Цаашид энэхүү шүүхийг дэлхийн жишигт нийцүүлж, хөгжүүлэхэд:

Нэгдүгээрт, шүүгч, шүүхийн албан хаагчид бүгд өөрсдийн ажлын онцлогийг бүрэн ухамсарласан, чадварлаг, мэргэшсэн байхыг нэн түрүүнд шаардана.

Хоёрдугаарт, салбар дундын хамтын ажиллагааг оновчтой хөгжүүлэх ёстой. Хүүхдийн ба гэр бүлийн сэтгэл зүйч, мэргэшсэн шинжээчид, хүүхэд хамгааллын байгууллагууд нягт уялдаж ажиллах шаардлагатай. Ингэхдээ хүүхдэд өөрийнх нь эрхийг ойлгуулах, эцэг, эх хүүхдийн харилцаанд байдаг өвөрмөц уламжлал, хүмүүжлийн ололтоо хадгалж байх асуудалд хуулийн байгууллагуудыг манлайлах зэргээр ажиллах шаардлагатай.

Гуравдугаарт, шүүхийн идэвхтэй (active) буюу хязгаарлалттай (restraint) байх асуудал маргаантай байдаг ч гэр бүл, хүүхдийн хэрэг дээр зөвхөн хөндлөнгөөс шийдээд орхихоос илүүтэй, анхаарал хандуулж илүү хариуцлагатай ажиллах хэрэгтэй болно.

Ингээд эцэст нь, энэхүү хурлыг хамтран зохион байгуулж буй **Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, Ханнес-Зайделийн сангийн** хамт олон болон алс холоос хүрэлцэн ирж мэдлэг туршлагаа хуваалцаж буй **ХБНГУ, Нидерланд, Япон, БНСУ, Бүгд Найрамдах Турк Улс, Австрали, АНУ**-ын эрдэмтэн, шүүгч, мэргэжил нэгт нөхөд та бүхэнд талархлаа илэрхийлье.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Д.ГАНЗОРИГ

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч

ҮНДСЭН ИЛТГЭЛ

“ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ ГЭР БҮЛИЙН ХАМГААЛАЛТ”

П.Золзаяа,
УДШ-ийн Иргэний хэргийн танхимын шүүгч (LL.M)

Агуулга

-
- I. Гэр бүлийн талаарх онолын ойлголт
 - II. Монгол Улсын гэр бүлийн түүхэн хөгжил: Харьцуулсан судалгаа талаасаа буюу өрнө, дорно
 - III. Гэр бүлийн харилцааны Үндсэн хуулийн хамгаалалт
 - IV. Гэр бүлийн харилцааны Иргэний эрх зүйн хамгаалалт
 - V. Монгол Улсын гэр бүлийн онцлог, анхаарах асуудал
-

I. ГЭР БҮЛИЙН ТАЛААРХ ОНОЛЫН ОЙЛГОЛТ

Гэр бүл нь хүний амьдралын анхдагч орчин бөгөөд гэр бүлийн харилцаанаас ангид нэг ч хүн оршин амьдрах боломжгүй. Гэр бүл нь хүн бүрийн хөгжлийн эх суурь болж, нийгмийн хөгжлийг дэмждэг. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд “Гэр бүл нь гэр бүлийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг зохицуулдаг нийгмийн харилцааны анхан шатны нэгж мөн.” гэж тодорхойлжээ.

Онол нь гэр бүлийн харилцааны мөн чанар, эрх зүйн суурийг тайлбарладаг. Онолын үндэслэл дээр тулгуурлаж хуулийг боловсруулдаг, гэр бүлийн маргааныг шийдвэрлэхэд онолын суурь ойлголтууд чухал, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, гэр бүлийн харилцааг зөв ойлгоход ач холбогдолтой юм.

“Гэрээ засаад төрөө зас” гэдэг Монгол онч үг нь философийн гүнзгий утгатай. Хэдийгээр бичмэл хуульд тусгагдаагүй ч монголчууд амьдрал ахуйдаа дээрх онч үгийг бий болгон, гэр бүл нийгмийн суурь, анхдагч орчин гэдгийг аль хэдийн тодорхойлсон байжээ.

Судлаачид “гэр бүл” гэх ойлголтын мөн чанарыг биологи, нийгэм, социологи, хууль зүйн талаас нь тодорхойлсон байна. **Нийгэм, философийн үүднээс** Гэр бүл бол нөхөр эхнэр, эцэг, эх, үр хүүхэд гэсэн хүмүүсийн хоёр буюу хэд хэдэн үеэс бүрдсэн сэтгэл санаа, эд материал, ёс суртахууны харилцаагаар, юуны өмнө бие биедээ чин сэтгэлээсээ харамгүй туслах үйл ажиллагаагаар холбогдсон нийгмийн бүлэг юм.¹

И. Кант: Эрэгтэй эмэгтэй хүйсийн болоод нийгмийн тэгш байдлын илэрхийлэл

Фихте: Хууль ёсоор харилцах хүйсийн харилцаа буюу хууль ёсны гэрээ

Ф. Энгельс: Байгаль, ёс суртахууны холбоо

Г.В. Гегель: Эхнэр ба нөхөр, эцэг, эх ба үр хүүхдийн хоорондын хувийн харилцааны хэв загвар”, мөн “гэр бүл бол ёс суртахууны анхны хэлбэр” тус тус тодорхойлж байжээ.

Хууль зүйн үүднээс: ураг төрөл, үрчлэлт болон өөр ямар нэгэн хэлбэрээр хүүхдийг авч хүмүүжүүлэх ба ёс суртахууны зарчим дээр гэр бүлийн харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоос урган гарсан эрх ба үүргийн холбоотой бүлэг хүмүүс гэж үздэг байна.

Онолын хандлагууд²: Юриспруденцийн хандлага: гэр бүлийг хууль зүйн харилцаа гэж үзэн эрхийн үүсэл, субъект, объектыг тодорхойлдог, социологийн хандлага: гэр бүл бол нийгмийн институт бөгөөд нийгмийн соёл, зан заншлын дагуу өөрчлөгдөж байдаг, гэр бүлийн тогтвортой байдал нийгмийн тогтвортой байдалд нөлөөлдөг гэж үздэг онол, феминист хандлага: гэр бүлийн эрх зүйн харилцаанд жендерийн тэгш бус байдал оршдог гэж үзээд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах ёстойг онцолдог байна.

1 Философский энциклопедический словарь, М.1989, - 602 с.

2 Авирмэдийн Дугармаа, Монгол Улсын гэр бүлийн эрх зүй, (Улаанбаатар: Адмон, хэвлэлийн компани, 2005), 30 дахь тал.

Эдгээр онол дээр суурилан “гэр бүл” гэдэг ойлголтыг авч үзвэл, зөвхөн сэтгэл санааны холбоо биш, харин эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагддаг хувийн эрх зүйн онцгой харилцаа болох нь тогтоогдоно. Гэр бүлийн үндсэн үүрэг нь хүний өсөлт, хүний хүмүүжилд нөлөөлөх, нийгмийн тогтвортой байдлыг хангах, хүүхдийн эрхийг хамгаалах, өмч хөрөнгө, эдийн засгийн хариуцлага хүлээх үүрэг юм.

Ингээд гэр бүлийн эрх зүйн онолын үндэс нь хувийн эрх зүйн шинжтэй, зөвхөн гэр бүлийн гишүүн оролцдог тусгай субъектийн бүрэлдэхүүнтэй, ёс суртахуун, сэтгэл хөдлөлийн нөлөө ихтэй, хайр халамж итгэлцэл дээр суурилдаг мөн чанартай бөгөөд гэрлэлт, үрчлэлт, цуцлалт, асрамж, хүүхэд асрах гэх мэт харилцаа нь тусгай хуулиар хамгаалагдан, зохицуулагддаг онцлогтой билээ. Гэр бүлийн эрх зүйн харилцааг хувийн эрх зүйн харилцаа /эцэг, эх ба хүүхдийн харилцаа, гэрлэгчдийн хоорондын үүрэг, асран хамгаалах, үрчлэх харилцаа/, хөрөнгийн эрх зүйн харилцаа гэж ангилж, хуулиар зохицуулж байгаа нийтлэг шинж харагддаг.

Гэр бүлийн эрх зүй нь дараах зарчмуудад тулгуурлана. Үүнд:³

- Гэр бүлийн эрх зүйн тусгай зарчим
- Гэрлэлт чөлөөтэй
- Гэрлэгчид сайн дурын харилцаанд үндэслэсэн, тэгш эрхтэй байх
- Хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд хангах
- Гэр бүлийн дотоод асуудлыг гэр бүлийн гишүүд харилцан шийдвэрлэх
- Гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн эрх ашгийг нэн тэргүүнд хангах
- Төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн гэрлэлтийг хүлээн зөвшөөрөх
- Нэг нөхөр, нэг эхнэртэй байх

Гэр бүл - Гэрлэлтийн үр дүнд буй болсон эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлнэ гэж хуульд заажээ. **Гэр бүлийн эрх зүй** - Гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох журам, нөхцөл болон үрчлэлт, хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлэх, асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбогдсон гэр бүлийн гишүүдийн хооронд үүссэн эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн хэм хэмжээний системчлэгдсэн нийлбэр цогц ойлголт мөн.

Гэр бүл нь ёс суртахууны болон эрх зүйн хосолсон шинжийг агуулдаг, эрх чөлөө ба үүргийн тэнцвэрт байдал дээр тогтдог, зөвхөн хувь хүмүүсийн сэтгэл дээр тогтсон харилцаа бус ёс суртахуун, эрх зүй, нийгмийн бүтэц, эрх тэгш байдал, хариуцлагын гүн гүнзгий философи агуулсан институци учраас гэр бүлийг зөвхөн хувь хүний хэрэг биш харин нийгмийн, ёс суртахууны, улс төрийн шинжтэй үзэгдэл гэж ойлгоно. Хуулиас гадна ёс суртахууны олон асуудлыг хөнддөг учраас

3 Мөн тэнд, 10-11 дэх тал.

шүүхийн журмаар гэр бүлийн маргааныг шийдвэрлэх нь нарийн төвөгтэй бөгөөд хүнд байдаг.

II. МОНГОЛ УЛСЫН ГЭР БҮЛИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

Монгол Улсад “гэр бүл” гэх ойлголт эртний уламжлалт нүүдэлчин соёл, зан заншлын гүнзгий суурьтай бөгөөд язгуур утгаараа төрөл садан, овог удам, ах дүү, ам бүлийн зохион байгуулалтын нэгж хэлбэрээр олон зуун жилийн өмнөөс оршсоор ирсэн бөгөөд гэр бүлийн харилцаа нь ёс суртахуун, заншлын хэм хэмжээгээр зохицуулагдаж байсан. Эртний уламжлалт нүүдэлчин нийгэмд гэр бүл гэдэг нь ам бүлийн хүмүүсийн хамтран амьдрах үндсэн нэгж байсан, аав, ээж, хүүхдүүдээс гадна өвөө, эмээ, ах дүү, хадам бүгд нэг айл гэр бүлд хамаарах ойлголттой байжээ. Эцгийн эрхт ёс ноёрхсон, эцэг хүн бусдаасаа давуу эрх мэдэлтэй байсан.

Монголчууд гэр бүлд эртнээс онцгойлон ач холбогдол өгч, гэрлэлтийг голомт үүсгэгч гэж үзэж, гэрлэлтийн бат бөх элэг бүтэн байдал, ёс суртахуунлаг хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, удам судраа цэвэр ариун авч явахыг чухалчлан үздэг байжээ. Марко Поло 13-р зуунд *“Эрчүүдийн эхнэртээ үнэнч байгаа байдал нь гайхалтай бөгөөд эхнэрүүд нь маш ёс журамтай”* гэж бичиж үлдээсэн байх юм. Монгол гэр нь гэр бүлийн гишүүд хамтдаа амьдрах, бие биетэйгээ харьцах, улмаар бие биеэ ажих, санаа тавих, туслах зэрэг харилцааны асар том орон зай болж чадсан бөгөөд бидний бахархах ёстой уламжлалын нэг мөн юм. Тийм учраас одоо ч бид гэртээ амьдарч, ахуйдаа хэрэглэсээр энэ уламжлалаа хадгалсаар байгаа билээ.

Харин гэр бүл гэх эрх зүйн ойлголт нь харьцангуй сүүлийн үед буюу 20-р зуунд бий болж хөгжсөн. 1921 онд Ардын Засгийн газар байгуулагдаж, хууль ёсны гэр бүл гэх ойлголтыг хуульчилж эхэлсэн, 1925 онд Гэр бүл, гэрлэлт цуцлалтын дүрмийг Иргэний хуулиар зохицуулж, гэрлэлтийг сүм хийдээс албан ёсоор салгаж төрийн бүртгэлд бүртгэх эхлэл тавигджээ.

1973 онд Гэр бүлийн тухай анхны бие даасан хууль батлагдаж, энэ хуулиар гэрлэлтийг улсын бүртгэлээр баталгаажуулж, эхнэр нөхрийн эрх үүрэг, хүүхдийн асрамж, хөрөнгийн асуудлыг хуульчилсан, одоо 1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хууль үйлчилж байгаа бөгөөд уг хуулиар гэрлэлт, эхнэр, нөхөр, хүүхэд, асрамжийн харилцаа, үрчлэлт зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулсан.

Дэлхийн улс орны соёл, шашин, эдийн засаг, хууль зүйн тогтолцоо нь гэр бүлийн бүтэц, үүрэг, үнэт зүйлд ялгаатай нөлөө үзүүлдэг. Тухайлбал, үзэл суртал, үндсэн хандлага, гэр бүлийн зорилго, нийгмийн үүргээрээ ялгаатай бөгөөд өрнийн орнууд хувь хүний эрх, эрх чөлөөг дээдлэх хандлагатай бол дорнын орнууд хувь хүнийг биш гэр бүлийн нэгдлийг, өрнийн орнуудын хувьд гэр бүлийн зорилго нь хувь хүний хөгжлийг дэмжих бол дорнын орнуудын хувьд нийгмийн тогтвортой байдлыг хангах, өрнийн орны хувьд төрөөс бага оролцдог бол дорнын орнууд төр, уламжлал, ёс суртахууны нөлөө илүү байдаг. Гэр бүлийн бүтцийн хувьд өрнийн орнууд эцэг, эх хүүхдийн хүрээнд байдаг бол дорнын орнуудын тухайд үүнээс гадна өвөө, эмээ, авга гэх мэт өргөжүүлэн тодорхойлдог, өрнөдөд хүүхдийг бие даалгадаг эрх чөлөөг нь дэмждэг бол дорнын орны хувьд эцэг, эхтэйгээ хамт амьдарсан хэвээр байх нь түгээмэл зэргээр соёлын суурь өөр, хувь хүний эрх чөлөө, нийгмийн харилцаа, үүрэг, ёс суртахууны ялгаатай шинжүүд байна.

Орчин үеийн хөгжлийн чиг хандлагын хувьд өнөөдөр Монгол Улсад гэр бүлийн харилцааг хамгаалах, бататгах, хүүхдийн эрхийг дээдлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудал чухалд тооцогдож байна. Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зэрэг нь орчин үеийн гэр бүлийн эрх зүйн гол тулгуур болжээ.

III. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН ХАМГААЛАЛТ

Үндсэн хууль нь тунхаглал төдий баримт бичиг бус хэрэглээ болсон. Гэрлэлт цуцлуулах, хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоолгох зэрэг журмаар шүүхэд нэхэмжлэл гаргаж байгаа нь Үндсэн хууль хэрэгжиж байгаагийн нэг илрэл юм. Монгол Улсын Үндсэн хуульд гэр бүлийн эрх зүйн хамгаалалтын талаар тухайлбал гэр бүлийг хамгаалах, гэр бүлийн гишүүдийн эрх ашгийг хангах, хүүхэд эмэгтэйчүүдийг хамгаалах зорилгоор хэд хэдэн заалт тусгагдсан байдаг.

Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд Монгол Улсын үндсэн нэгж нь гэр бүл, иргэн гэсэн үзэл баримтлалыг тунхагласан нь гэр бүлийг нийгмийн суурь нэгж гэж үзэж, хамгаалах үндэс нь болсон. Үндсэн хуулийн 16.11-д ... Гэр бүл, эцэг, эх, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална, 16.2-т ...Эх, хүүхдийн эрхийг хамгаална, Ээж болох, хүүхэд төрүүлэх, хүүхдээ өсгөхтэй холбоотой эмэгтэйчүүдэд төрөөс тусгай халамж үзүүлнэ, 16.13-т ...Хүүхэд, насанд хүрээгүй хүмүүсийн эрхийг төр хамгаална гэж тус тус заасан.

Үндсэн хуулийн заалтууд нь гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих, хүүхдийн эрхийг хамгаалах, эмэгтэйчүүдийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах эрх зүйн үндэс нь болно. Үндсэн хуулиар төр дараах үүргийг хүлээдэг: гэр бүлийг нийгмийн үндсэн нэгж гэж үзэн хамгаалах, эцэг, эх, хүүхдийн эрх ашгийг тэнцвэртэйгээр хангах, хүүхдийн эрхийг дээдэлж, тэднийг хүчирхийлэл мөлжлөгөөс хамгаалах, эхчүүдийн жирэмслэлт, төрөлт, хүүхэд өсгөх явцад дэмжих бодлого хэрэгжүүлэх. Эдгээр заалтууд нь гэр бүлийн гишүүдийн харилцаанд хүний эрхийн суурь үзэл баримтлалыг шингээж өгсөн чухал зохицуулалтууд юм.

Гэр бүлийг хамгаалах нь зөвхөн хууль зүйн хүрээнд хязгаарлагдахгүй бөгөөд нийгмийн халамжийн бодлого, хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хамгаалалтыг хэрэгжүүлдэг.

Гэрлэлтийг заавал төрийн байгууллагаар бүртгүүлэх нь хууль зүйн хүчин төгөлдөр байдал, нийгмийн зохион байгуулалт, хувь хүний эрхийг хамгаалах зэрэг олон шалтгаантай. Мөн энэ нь зөвхөн Монгол Улсад төдийгүй бараг бүх улс оронд үйлчилдэг нийтлэг зарчим болсон байна. Хууль зүйн хүчинтэй болгохын тулд: 1. гэр бүл үүссэн болохыг албан ёсоор баталгаажуулж, эрх зүйн хамаарлыг тогтооно; 2. гэрлэлтийн гэрчилгээ нь хууль зүйн баримт бичиг болдог; 3. нөхөр, эхнэрийн хооронд үүсэх хамтын өмчийн харилцаа, нийгмийн даатгал, тэтгэвэр, өв залгамжлал, хүүхдийн асрамж, тэтгэлэг, хариуцлага зэрэг эрх үүргийг тодорхой болгодог; 4. Улс орны хүн амын бүтэц, гэр бүл, төрөлт, гэр бүл салалт зэргийг албан ёсоор бүртгэж, судалгаа хийх боломжтой болдог, хууль бус, олон эхнэр нөхөртэй болох, хүчирхийллээс хамгаалдаг.

Гэр бүлийн харилцаанд хамаарах асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хэд хэдэн маргаан шийдвэрлэгдсэн байна.⁴

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2010.03.24-ны өдрийн дүгнэлтээр Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт хүүхэд үрчлэн авах насны дээд хязгаарыг 60 нас гэж хориглосныг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... нас, ... –аар нь ялгаварлан гадуурхаж үл болно”; мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэж үзсэнийг Улсын Их хурал хүлээн зөвшөөрч 2010.04.22-ны өдөр хуульд өөрчлөлт оруулж төрөл садангийн хүнд насны хязгаар хамаарахгүй байхаар өөрчилсөн,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021.01.20-ны өдрийн 01 тоот дүгнэлтээр “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай” хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь ... 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх ...-т тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оришино.”, 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад “”хүүхдээ асарч байгаа” гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 106.1-д заасан хүүхэд асрах чөлөөтэй болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.3-т заасан ажилгүй эх 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгааг;”, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Төрүүлсэн 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх сар бүр хүүхэд асарсны тэтгэмж авах эрхтэй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль ...-ийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... хүйс ...-ээр нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 11 дэх заалтын “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. ...” гэж заасныг тус тус зөрчсөн гэж дүгнэхдээ хүүхдээ асарч байгаа зөвхөн эмэгтэй хүнд хүүхэд асарсны тэтгэмжийг олгохоор хуульчилсан нь агуулгын хувьд ижил нөхцөлд хүүхдээ асарч буй эрэгтэй хүн буюу эцэг дээрх тэтгэмжийг авах боломжийг хязгаарлаж, хүйсээс шалтгаалсан ялгамжтай байдлыг бий болгосон гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2010.11.10-ны өдрийн 06 тоот дүгнэлтээр Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 болон 40.1.2 дахь хэсэгт заасан хүүхдийн насыг ангилсан, хуулиар тогтоосон тэтгэлгийн хэмжээ үндсэн хуулийн зөрчлийн шинжгүй гэж тус тус үзсэн байна.

Монгол Улс одоогийн байдлаар 595 олон талт гэрээнд нэгдэн орсноос гэр бүлийн харилцаа, гэр бүлийн дундын эд хөрөнгийн эрхийг ханган хамгаалахаар Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Сайн дурын үндсэн дээр гэрлэх болон гэрлэх нас, гэрлэлтийг бүртгэх тухай конвенц зэрэгт нэгдэн орж, соёрхон баталжээ. Монгол Улс НҮБ-д **1961.10.27-ны өдөр** элссэн бөгөөд үүнтэй зэрэгцэн **“Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ыг дэмжиж, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн.** Үндсэн хууль тухайн улсынхаа хэмжээнд суурь хууль байдаг бол НҮБ-аас баталсан тунхаглал, конвенц, пакт нь

4 Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн цахим хуудас, <https://www.conscourt.gov.mn/>.

хүн төрөлхтөн, дэлхийн хэмжээнд үнэт зүйлийг тодорхойлж, эрхэмлэн сахихыг хуульчилсан байдгаараа ялгаатай бөгөөд Монгол Улс ийнхүү олон улсын гэрээнд нэгдэж, гишүүн болсноор Үндсэн хууль, хууль тогтоомжид гэр бүлийн харилцааны үнэт зүйлс тусгагдсан байхаас гадна ийнхүү тусгаагүй байсан ч гишүүн орны хувьд олон улсын хэм хэмжээг хэрэглэх боломжтой. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульд шууд заагаагүй асуудлыг олон улсын гэрээ, конвенцоор нөхөж хэрэглэх боломж ч байна.

Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 12 дугаар зүйлд заасан *“Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох ёсгүй...”,* гэсэн заалт, 26 дугаар зүйлийн 3-т *“хүүхдэдээ олгох боловсролын чиглэлийг сонгоход эцэг, эх давуу эрх эдэлнэ”* гэсэн заалт, 1997.03.18-ны өдөр нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 24 дүгээр зүйлийн 1-д *“аливаа хүүхэд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон төрсөн байдлаар алагчлахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйнхээ хувьд шаардлага бүхий хамгаалалт эдлэх эрхтэй”* гэж, 1981.07.20-ны өдөр нэгдэн орсон Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 16 дугаар зүйлийн 1-д гэрлэх, хүүхдээ асран хамгаалах, ажил мэргэжлээ сонгох, хөрөнгийг өмчлөх, эзэмших төлөөр эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй болохыг, төрөөс гэрлэлтийг заавал албан ёсны бүртгэлд бүртгүүлэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааг, түүний дотор хууль тогтоох арга хэмжээг авах үүрэгтэйг заасан байх ба эдгээр хэм хэмжээг маргаантай харилцаанд хэрэглэх боломжтой юм. Энэ утгаар гэр бүлийн харилцаа Үндсэн хуулиар хамгаалагдсан гэж үзнэ.

IV. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ

Гэр бүлийн харилцаа нь иргэний эрх зүйн харилцааны салшгүй хэсэг бөгөөд гэр бүл дотор үүсэх эрх үүргийг зохицуулах, хамгаалах, тэнцвэржүүлэх нь иргэний эрх зүйн чухал үүрэг юм. Иргэний эрх зүй нь гэр бүлийн тогтвортой байдал, гишүүдийн эрхийн тэнцвэр, хүүхдийн ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлдэг. Иргэний эрх зүйн үндсэн зарчим болох тэгш байдал, өөрийн эрхээ хэрэгжүүлэх эрх чөлөө, өмчийн халдашгүй байдал нь гэр бүлийн хүрээнд шууд хамааралтай. /эцэг, эх хүүхдийн хоорондын эрх үүрэг тэнцвэртэй байх, гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах, хүчээр гэрлүүлэхийг хориглох гэх мэт/

Иргэний эрх зүй дараах байдлаар гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаална: гэрлэлтийг хүчингүй болгох, цуцлах, хүүхдийн эрхийг хамгаалах-эцэг, эхийн үүргээ биелүүлээгүй тохиолдолд шүүх, төрийн байгууллага хөндлөнгөөс оролцох, асран хамгаалагч томилох, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотойгоор салалтын маргаан, хүүхдийн асрамж, өмчийн хуваарилалтыг зохицуулж, хохирсон талд нөхөн төлбөр, хамгаалалт олгодог.

1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хууль тогтвортой хэрэгжиж байгаа бөгөөд үүнээс хойш тус хуульд бусад хуулийн шинэчлэлийг дагалдах замаар нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч гэр бүлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж байгаагүй байна.

Одоогийн байдлаар Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын

төслийг боловсруулсан байх бөгөөд зарчмын шинжтэй “хүүхдийн тэтгэлгийн хэмжээг үүрэг бүхий этгээдийн орлогын тодорхой хувь болон заавал төлөх нийтлэг доод хэмжээг тогтоох”, “тусдаа амьдарч байгаа гэрлэгчдийн хүүхдээ асран хамгаалах үүрэг”, “гэрлэгч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талын эрх, нэр төр, алдар хүндэд хохирол учруулсан тохиолдолд Иргэний хуульд заасны дагуу гэм хорын хохирол шаардах”, “хэрэг хянан шийдвэрлэхдээ шаардлага гаргасан эсэхээс үл хамааран хүүхдийн асуудалтай холбоотой зарим ажиллагааг шүүх санаачлагаараа шийдвэрлэх”, “үрчлэлтийг шүүх шийдвэрлэх”, “нөхөн үржихүйн аргаар хүүхэдтэй болох”, “хамтран амьдрагч нарын эрх, үүрэг” зэрэг шинэлэг зохицуулалтыг нэмж тусгах, зарим заалтыг боловсронгуй болох хэм хэмжээг бий болгон, өргөн хүрээнд хэлэлцүүлж байна.

V. МОНГОЛ УЛСЫН ГЭР БҮЛИЙН ОНЦЛОГ

Гэр бүлийн харилцаан дахь дараах зарчмууд болох “нэг эхнэр, нэг нөхөртэй байх”, “гэрлэгч нь төрсөн болон хадам эцэг, эхээ асран хамгаалах”, “хүүхдээ хүмүүжүүлэх”, “хүүхэд тусдаа гартал эцэг, эхтэйгээ хамт амьдрах” хэв маяг, заншил манай улсын түүхэнд олон жилийн турш байсан бөгөөд одоо ч хадгалагдсан хэвээр байгаа нь манай улсын онцлог юм.

Түүнчлэн, хэдийгээр хуульд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй, хүүхдээ адилхан өсгөж хүмүүжүүлэх үүрэгтэй гэж заасан боловч хүүхдээ өсгөх, хүүхдээ хүмүүжүүлэхэд эмэгтэй хүний оролцоо илүү байгаа, тийм ч учраас хүүхдийн асрамжийг эхэд нь үлдээж байгаа шүүхийн тогтсон практик нь мөн л манай улсын онцлог, түүхтэй холбоотой. Нийгэмд ажилгүйдэл, архиан согтуурах, гэр бүлээс гадуурх харилцаа, гэр бүлийн хүчирхийлэл, ёс зүйн зөрчил зэрэг сөрөг зүйл байгаа хэдий ч дээрх заншил хадгалагдсаар байгаа нь бидний үнэт зүйл юм. Жишээ нь: тэтгэврийн хүмүүс тэтгэврийн зээл авч байгаагийн цаана хүүхдүүд нь байгаа бодит байдал өнөөдөр нийгмийн асуудал болон хувирч тэтгэврийн зээлийг олгохгүй байх эсхүл хязгаар тогтоох нь зүйтэй гэсэн маргаан төр, иргэний хооронд өрнөж байгаа нь эцэг, эх, хүүхдийн хоорондын амьдрал тусгаарлагдан, цэвэр бие даасан биш харин байнгын холбоотой байдаг шинжийг харуулна. Мөн хүүхдүүд нь эцэг, эхээ асран тэтгэх явдал хүн бүрийн хүлээн зөвшөөрсөн, нийтлэг шинжтэй үүрэг болсон байна. Гэвч үүний зэрэгцээ гэр бүлийн орчин үеийн шинжийг агуулсан гэр бүл ч байна.

Монгол Улсын гэр бүл нь гэр бүлийн нэгдэл ойр, зан заншлаа хадгалсан байдгаараа онцлогтой юм.

5.1. Анхаарах асуудал

Гэр бүлийн харилцааны тулгамдаж байгаа асуудлыг хөндөж ярихын тулд одоо хэлэлцэгдэж буй Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, түүнд байгаа шинэлэг заалт болон бусад хэм хэмжээнд тулгуурлан саналаа илэрхийлэх замаар анхаарах асуудлын агуулгыг тодорхойлох нь зүйтэй гэж үзсэн болно.

1. Шүүхийн статистик, мэдээг үзвэл, Гэр бүлийн тухай хуулиар жилд 4000-4800 хэрэг шийдвэрлэгдсэн буюу нийт иргэний хэргийн 10,1 орчим хувийг эзэлж байна.

2017 онд шийдвэрлэсэн гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэрүүдээс 50 шийдвэрийг түүвэрлэж, гэрлэлт цуцлах болсон шалтгааныг судлан үзэхэд, таарамжгүй харилцаа 38 буюу 76 хувь, гэр бүлээс гадуурх харилцаа тогтоосон 1 буюу 2 хувь, архидалт 6 буюу 12 хувь, тусдаа амьдарч байгаа 4 буюу 8 хувь, гэр бүлийн хүчирхийлэл 1 буюу 2 хувийг тус тус эзэлжээ.

Харин 2022 оны хувьд, гэрлэлт цуцлах болсон шалтгаанд таарамжгүй харилцаа 32 буюу 64 хувь, архидалт 10 хувь, тусдаа амьдарч байгаа 2 буюу 4 хувь, гэр бүлээс гадуурх харилцаа 10 буюу 20 хувь, мөн гэр бүлийн хүчирхийлэл 1 буюу 2 хувийг тус тус эзэлсэн. Гэрлэлт цуцлах шалтгааны дийлэнх хувийг гэрлэгчид хоорондын таагүй харилцаа эзэлсэн хэвээр байхад гэр бүлээс гадуурх харилцаа 2 хувиас 20 хувь болж эрс өсжээ.⁵

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 9.4-т гэрлэгчдийн хэн нэгний буруутай үйлдлээс шалтгаалж гэрлэлт цуцалсан нь нөхөр, эсхүл эхнэрийн эрх, нэр төр, алдар хүндэд хохирол учруулсан бол гэм хорын хохирол нөхөн төлүүлэх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ гэсэн шинэ зохицуулалт байна. Гэрлэлт цуцлахад гэрлэгчийн хувьд сэтгэл санаагаар унах, гутрах, хүүхдийн эрх ашиг хохирох зэрэг амьдралын чанарт нөлөөлөх сөрөг үр дагавар үүсэх нь зайлшгүй юм.

Гэвч төслийн дээрх заалтад гэм хорын төрлийн хувьд сэтгэл санааны хохирлыг шаардах эсэх нь яг тодорхойгүй, хэрэв эдийн бус хохирол шаардах эрх байгаа бол Иргэний хуулийн 230.1-д заасны дагуу хуульд тусгайлан заах учиртай болохыг анхаарах нь зүйтэй байсан. Өөрөөр хэлбэл, энэ хуулиар сэтгэл санааны хохирлыг арилгуулахыг зорьсон бол Иргэний хуулийн 230.1-т заасны дагуу тусгайлан зохицуулсан тохиолдолд л хэрэгжих бөгөөд зөвхөн Гэр бүлийн тухай хуульд тусгах нь хангалтгүй юм.


2. Гэрлэлтийг дуусгавар болгох нэг үндэслэл нь гэрлэлт анхнаасаа хүчин төгөлдөр бус байсан нөхцөл байдаг. 2018 оноос өмнө ийм хэргийн тоо цөөн байсан ба өссөн үзүүлэлтээс харахад анхаарах асуудлын нэг болсон байна. Улсын хэмжээнд 2018–2025 онд гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон нийт 54 хэрэг шийдвэрлэсэн бөгөөд дийлэнх хэсэг нь **гэр бүл болох зорилгогүйгээр** батлуулсан, өөрөөр хэлбэл анхнаасаа гэрлэлтээ батлуулах хүсэл сонирхолгүй, хуурамч гэрлэлтийн шинжтэй байх бөгөөд үүнийг шалтгаан нөхцөлөөр нь авч үзвэл;

Гадаад улс руу виз авах зорилгоор гэрлэлт батлуулсан (43 тохиолдол, 89 %) буюу иргэншил авах зорилгоор, Засгийн газрын халамж авах зорилгоор 3 тохиолдол 5,7 хувь, гэр бүл хамаатан садны шахалтаар 1, улсын бүртгэлд давхардуулан бүртгэсэн зэрэг шалтгаан тогтоогдов.⁶ Эдгээр шийдвэрийн агуулгаас дүгнэлт хийхэд, гадаад улс руу виз авах зорилгоор байгуулсан гэрлэлтүүд нь бодит амьдрал дээр гэр бүлийн хамтын амьдрал үүсээгүй, хууль зүйн утгаараа “хийсвэр” буюу зөвхөн эрх зүйн хэлбэртэй, бодит агуулгагүй гэрлэлт болох нь тогтоогдож байна.

5 Монгол Улсын дээд шүүхийн цахим хуудас, <https://supremecourt.mn/>

6 Монгол Улсын дээд шүүхийн цахим хуудас, <https://supremecourt.mn/>

Хүснэгт 1.



Дээрх дүгнэлтээр 2019, 2021, 2024 онуудад гадаад улс руу виз гаргуулах зорилгоор гэрлэлт батлуулсан тохиолдол өндөр үзүүлэлтэй харагдаж байна.

Эдгээр нөхцөл байдалд дүгнэлт хийж,

- Гэрлэлт бүртгэх шалгуур, хяналтыг сайжруулах
- Гэрлэлтээ бүртгүүлж буй хүмүүсээс зорилго, хүсэл зоригийг нь тодруулж, ярилцлага хийж байх
- Хуурамчаар гэрлэлтээ бүртгүүлсэн этгээдүүдэд хариуцлага тооцдог байх, хохирлыг арилгуулах зохицуулалтыг бий болгох
- Нийгэмд хууль ёсны гэр бүлийн үнэт зүйлийг таниулах, мэдээллийн ажил зохион байгуулах зэргээр анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

3. Одоо үйлчилж буй Гэр бүлийн тухай хуулиар Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор садан төрлийн хүмүүсийн хоорондын гэрлэлтийг хориглосон байдаг ба үүний тулд иргэний бүртгэлийн байгууллагын мэдээллээс лавлагаа авах, ургийн бичгийг хөтлөх үүргийг гэрлэгчдэд хүлээлгэсэн. Шинэчилсэн найруулгын төсөлд ДНХ-ийн шинжилгээнд хамрагдах боломжоор хангаж байгаагаас өөрөөр хэрэгжүүлэх арга зам, үр дүнтэй арга хэрэгслийг хуульчлаагүй, хэрэгжих нөхцөлийг хангаж чадаагүй байна. Энэ асуудал нь зөвхөн Гэр бүлийн тухай хуулиар хязгаарлагдахгүй бөгөөд хүмүүсийн оршин суух газраа сонгох, шилжих хөдөлгөөнийг нийгмийн талаас хэрхэн зохицуулж, төвлөрлийг хэрхэн сааруулах, хүн амын суурьшлыг оновчтой зохицуулах, хүний боловсрол, хүмүүжил зэрэг цогц бодлого, арга хэмжээг шаардах тул анхаарах ёстой.

4. Одоо үйлчилж буй Гэр бүлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд гэрлэхийг хүсэгчид эмнэлгийн байгууллагаас эрүүл мэндийн тодорхойлолт гаргуулсан байх, өнгөний болон дархлалын олдмол хомсдол, сүрьеэ, сэтгэцийн өвчний шинж тэмдэг илэрсэн бол мэргэжлийн эмнэлгийн байгууллагад шинжилгээ хийлгэх талаар зохицуулсан байдаг бөгөөд энэ заалтыг хүний эрхийг зөрчсөн, ялгаварлан гадуурхсан шинжтэй гэж зарим судлаач, гадаадын төрийн бус байгууллага, төслөөс дүгнэж саналаа илэрхийлсэн байдаг.

Угтаа энэ журам нь гэрлэхэд харшлах шалтгаанд /ГБтХ-ийн 9 дүгээр зүйл/ хамаардаггүй учир гэрлэхийг хүссэн этгээдийн эрхийг зөрчөөгүй бөгөөд гэрлэгчдийн хэн нэг нь энэ талаар мэдэх эрхийг хангаж, ингэснээр эрүүл мэндийн байдлын талаар зөвлөгөө өгөх, гэрлэгч хэрхэн сэргийлэхэд тусалж байгаа зорилготой болох нь Гэр бүлийн тухай хуулийн 8.3-т “Эмнэлгийн байгууллага нь шинжилгээний хариуг гэрлэхийг хүсэгчдэд танилцуулж, удамшил, гэр бүл төлөвлөлтийн талаар зөвлөгөө өгч, тэдний хэн нэг нь энэ хуулийн 8.2-т заасан өвчтэй нь тогтоогдсон бол түүний үр дагаврын талаар тайлбарлаж өгнө” гэж зааснаар батлагдана.

5. Гэрлэлттэй төстэй харилцаа болох хамтын амьдралын хэлбэр манай улсад түгээмэл шинжтэй болсон гэж үзэхээр байна.

Зарим улсад гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч хамтран амьдарч байгаа харилцааг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон байна. Гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч хамтран амьдрах хэлбэр нь эдийн засаг болон бусад хэрэгцээг хангах, гэр бүлийн зарим үүргийг гүйцэтгэдгээрээ гэр бүлийн төлөв байдалтай төстэй харилцаа юм. Хамтран амьдрагч гэдэг нь: хуулийн дагуу гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч хамтран амьдарч буй хүмүүсийг хэлнэ, тэдний харилцаа хууль ёсоор гэр бүл гэж тооцогдохгүй, эрх зүйн үр дагавар нь: хамтран амьдарсан хугацаанд бий болсон хөрөнгө хамтын өмчлөлд шууд тооцогдохгүй, хүүхэдтэй болсон бол зөвхөн эцэг, эхийн бүртгэлийн дагуу хариуцлага хүлээнэ. Өв залгамжлалд шууд эрх байхгүй, эмнэлгийн үйлчилгээ, халамжийн хөнгөлөлтөд сөрөг нөлөөтэй. Хэрэв хууль ёсны хамгаалалт, өмчлөл, хүүхдийн эрх, өв залгамжлал зэргийг бодолцож байгаа бол гэрлэлтээ бүртгүүлэх нь илүү найдвартай, хууль ёсны баталгаатай байдлыг бий болгодог. Хамтран амьдрагчийн харилцаа нь хувийн итгэмжлэлд тулгуурладаг хэдий ч эрх зүйн хамгаалалт султай байдаг байна.

2014-2022 оны хооронд эцэг, эх нь гэрлэлтээ бүртгүүлээгүй буюу хамтран амьдарч байх хугацаанд нь 22924 хүүхэд шинээр мэндэлсэн байна⁷. Энэхүү тоо баримтаас үзэхэд хамтран амьдрах хэлбэр түгээмэл гэж үзэж байна. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хамтран амьдрагчдыг тодорхойлж, гэрлэлттэй адилтган үзэх тэдгээрийн хамтын амьдралын явцад болон хамтын амьдрал дуусгавар болох тохиолдолд эдлэх эрх, хүлээх үүрэг, мөн ийм харилцаанаас төрсөн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бүртгүүлсэн гэрлэлтээс төрсөн хүүхдийн нэгэн адил хамгаалах зохицуулалтыг тусгасан байна.

Хүүхдийн хувьд гэрлэлтээ бүртгүүлээгүй хүмүүсийн дундаас төрсөн хүүхэд гэрлэлтээ бүртгүүлсэн хүмүүсийн дундаас төрсөн хүүхдийн адил тэгш эрхтэй гэж одоогийн үйлчилж буй Гэр бүлийн тухай хуульд зааснаар хүүхдийн эрх ашиг хуулиар хамгаалагдсан гэж үзэж болно.

Хамтын амьдралтай болохыг тогтоолгох тухай нэхэмжлэлийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд өмчлөх эрхээ хамгаалуулах, хүүхдийн асрамж, тэтгэлгийг тогтоолгох, нийгмийн халамжийн асуудалтай холбоотой нэхэмжлэлийн зорилго харагдаж байх ба үүнээс өмчлөх эрхийг тогтооход хамт амьдарч буй факт нөлөөлөхгүй гэдэг шүүхийн тайлбар, нэгдмэл ойлголт тогтсон байна. Харин судалгаанаас үзвэл, яагаад гэрлэлтээ бүртгүүлээгүй шалтгааныг шүүх огт

7 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, <https://www.1212.mn/mn>

тодруулдаггүй, энэ талаар дүгнэлт өгөх боломжгүй байсан. Угтаа хамтран амьдарч буй хүмүүс өөрсдөө бүртгүүлэх боломжтой бөгөөд бүртгүүлээгүй байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох нь чухал ач холбогдолтой.

Хамтын амьдралыг гэрлэлттэй адилтган үзэхийг Шинэчилсэн найруулгын төсөлд хуульчилсан байгаа явдлыг болгоомжтой, эргэлзээтэй өнцгөөс харж байгаа. Төслийн 21 дүгээр зүйлд хамтран амьдрагчид бусад хүнтэй гэрлэлт бүртгүүлээгүй; таваас доошгүй жилийн хугацааны туршид тогтмол хамтран амьдарсан, хөрөнгө дундаа өмчилж байгаа, дундын хөрөнгө бий болсон; нэг оршин суух хаягт бүртгэлтэй бол хамтын амьдралыг гэрлэлттэй адилтган тооцно гэж заажээ.

Хуулиар насны босго, сэтгэцийн эрүүл мэндийн байдал, харилцан зөвшөөрөл байх зэрэг тодорхой шалгууруудыг тавьж гэрлэлтийн хүчин чадлыг тогтоож, хуулиар хамгаалсан атлаа хамтын амьдралыг гэрлэлттэй адилтган тооцохоор бол нэлээн хатуу шалгуурыг тогтоох шаардлагатай. Гэвч хуульчлахаас гадна шүүх практикаар тогтоодог байх нь илүү зохистой гэж үзэж, энэ саналыг дэвшүүлж байна. Шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэх явцад хамтын амьдралын бүхий л нөхцөл байдал тогтоогдож, нотлогдох учир гэрлэлттэй адилтгах эсэхийг хуулиар бус шүүх тогтоох нь илүү бодитой төдийгүй гэрлэлтийг үгүйсгэх, ач холбогдлыг нь бууруулах зэрэг сөрөг хандлагаас сэргийлэх боломжтой юм.

Ингээд энэ хүрээнд тулгамдсан асуудлыг танилцуулж илтгэлээ дуусгая.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Иргэний хууль, 2002 он.
3. Гэр бүлийн тухай хууль, 1999 он.
4. Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн шийдвэрүүд.

Б. Ном, сурах бичиг

1. О.Отгонтуяа, О.Амарсайхан, Монгол Улсын гэр бүлийн хууль, түүний хэрэгжилт, 2009 он.
2. С.Нарангэрэл, Монголчуудын ёс суртахуун: Бадрал, Уналт, Эргэн сэргээлт Монголчуудын зан суртахууны гарваль, 2020 он.
3. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Судалгааны тайлангийн эмхэтгэл, XIII боть, 2023 он. Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ.

В. Бусад

1. Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989 он.
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948 он.
3. ХЗДХЯ-аас боловсруулсан Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга, үзэл баримтлал, 2024 он.
4. Шүүхийн шийдвэрийн судалгаа: Гэр бүлийн маргаан шийдвэрлэсэн 2017-2022, Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон 2018-2025, Хамтын амьдралаас үүдэлтэй маргаан 2014-2022 он хүртэлх судалгаа.

“ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ХЭРГИЙН ШҮҮХ: ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, БҮТЭЦ, ХАРЬАЛАЛ, МОНГОЛЫН ЗАГВАР”*

Ч.Хосбаяр,
УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн,
Хууль зүйн доктор (Ph.D)

* Хурлын видео бичлэгээс буулгав.

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Миний илтгэлийн гол зорилго бол өөрийн гадаад улсад хуримтлуулсан туршлага, судалгааны үр дүнг танилцуулах явдал юм.

Монгол Улс нь Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны шүүхийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс байгуулан ажиллаж эхэлсэн боловч тухайн шүүхийг байгуулахад бэлтгэл тааруу эхэлсэн, үүнтэй холбоотойгоор хүндрэл, бэрхшээлүүд ч үүсэж байсан. Иймээс дээрх хүндрэл бэрхшээл Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхийг байгуулахтай холбоотойгоор үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд миний бие Гэр бүлийн хэргийн шүүхийг хөгжүүлсэн сайн туршлага бүхий улсуудыг судалсан билээ. Ийнхүү судлах явцад Гэр бүлийн хэргийн шүүхийн хөгжлөөрөө тэргүүлж байгаа улсуудыг АНУ манлайлж байх тул, АНУ-ын тэр дундаа тус улсын Хавай мужийн туршлагаас судлан “Гэр бүл, хүүхдийн хэргийн нэгдсэн шүүх” буюу “Unified Family Court”-тэй биечлэн танилцаж, тус шүүхийн Ерөнхий шүүгчтэй уулзалт хийж, сургалтад хамрагдсан билээ.

Тухайн сургалтад хамрагдах үед надад төрсөн сэтгэгдэл, судлаачийн байр сууриас цухас дурдахад, “Монгол Улсад энэхүү шүүхийг байгуулахад ямар бүтэц, загвар, зохион байгуулалттайгаар байгуулах нь зүйтэй вэ”, “Шүүхэд харьяалуулах маргааныг хэрхэн тогтоох вэ буюу харьяаллын асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ” гэсэн бодол ба эдгээр асуултад хийсэн өөрийн дүгнэлтээ танилцуулья.

Гэр бүлийн хэргийн шүүхийг бид буюу шүүгч нар бодохдоо “хиймэл” биш, “зохиомол” биш, харин бодитой нөхцөл байдал, шаардлагад тулгуурлан үүссэн шүүх байгаасай гэж хүсэж байгаа. Бусад улсад Гэр бүлийн хэргийн шүүхийг байгуулах болсон нөхцөл, шаардлага, түүнийг хэрхэн байгуулсан, шүүхийн хөгжил талаас нь доорх агуулгын хүрээнд илтгэлээ дэлгэрүүлэн тайлбарлая. Үүнд:

1. Үзэл баримтлал;
2. Хэргийн харьяалал;
3. Гэр бүлийн шүүхийн зохион байгуулалт, бүтэц, түүний давуу болон сул тал;
4. Монгол Улсын загвар.

АНУ-ын хувьд, XIX зууны сүүл XX зууны эхэн үеэс Гэр бүлийн хэргийн шүүхийн асуудал хурцаар яригдаж эхэлсэн нь АНУ-д иргэний дайн дуусаж, цагаачлалын асуудал ихээхэн дэлгэрч байсан, аж үйлдвэрийн хувьсгал ялж, тэдгээрийн үр дагаварт хараа хяналтгүй хүүхдүүдийн тоо ихээр өсөн нэмэгдэж байсантай холбогдоно. Иймд АНУ-ын Гэр бүлийн хэргийн шүүхийн хөгжил нь тухайн хараа хяналтгүй хүүхдүүдтэй холбогдон Эрүүгийн хэргийн шүүхийн хэлбэрээр эхэлж үйл ажиллагаа явуулж байжээ.

Ингэхдээ анх 1910-1920 оны хооронд Гэр бүлийн маргаан шийддэг “бүтцүүд” бий болж байснаас гадна тэнд гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг олоод түүнийг саатуулж, хүүхдийг тэнсэн харгалзаад эсхүл ямар нэг албадлагын арга хэмжээ аваад эргээд тухайн хүүхдийг хариуцуулж өгөх гэхэд тэднийг хариуцуулж өгөх хүн буюу эцэг, эх нь байхгүй байх явдал тохиож байсан байна. Тиймээс хүүхдэд хариуцлага хүлээлгэж, үүрэг оногдуулж, энэхүү харилцаанд боловсролын байгууллагыг урьж

оролцуулаад түүнд хүүхдийг сургах үүрэг өгөх гэх мэтээр цогцоор хүүхдийн асуудлыг шийдвэрлэж хамтран ажиллаж байж шийдвэр гаргадаг тогтолцоог энэхүү шүүхийг байгуулахдаа харгалзан үзэж нэгтгэхийг зорьсон. Ингэхдээ нийгмийн хамгааллын байгууллагад асуулт тавьж, түүнийг шүүх шийдэхээр, цаашилбал, шүүхийн шийдвэрийн хүчин чадал, шийдвэрийн хүчин төгөлдөр байдалд олон төрийн байгууллагын шийдвэр, хамтын ажиллагаа нэгдэн “нэг гэр бүлд нэг шүүх” зарчмаар үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Ийнхүү АНУ-д тухайн Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх нь 1962 оноос хэлбэр, зохион байгуулалтын хувьд бүрэн тогтворжиж үйл ажиллагаагаа явуулж байсан байна.

АНУ-ын хувьд, 1910-1920 онд барагцаалбал 10 жилийн туршид “criminal nonsupport” буюу хараа хяналтгүйгээр хүүхдээ үлдээсэн эцэг, эхэд шийтгэл оногдуулж, ийнхүү хараа хяналтгүй байснаасаа үүдэн тухайн хүүхэд гэмт хэрэг үйлдсэн бол хүүхэд албадлагын арга хэмжээ авч хариуцлага хүлээлгэх, эцэг, эх байх эрхийг хасах асуудлыг шүүх байгуулалгүйгээр, нэг “бүтэц”-ийг байгуулан түүнд харьяалуулж шийдвэрлэж байсан бол 1922 онд анх Хүүхдийн хэргийн шүүхийг байгуулж тэр нь Эрүүгийн хэргийн шүүхийн бүтцэд хамаарч үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Энэ үед хүүхдийн асуудалд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тавигддаг аливаа процесс, стандартыг арай зөөлрүүлэх буюу хасах арга хэмжээ авч хүүхдийг хорихгүйгээр, шүүх хуралдааныг гав гинжнээс холуур явуулж, шүүгч нар сүрдмээр өмсгөл өмсөхгүйгээр, нэр томьёоны хувьд ч баривчлах, саатуулах гэх бус өөр нэр томьёо хэрэглэж хэвшиж, хүүхдийг нийгэмшүүлэх зорилгод төвлөрч үйл ажиллагаа явуулж байжээ.

1962 онд тухайн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргааны төрөл нэмэгдсэнээс гадна Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх сонгодог утгаараа үүсэж үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба ингэхдээ өмнөх загваруудаас үүдэн гарч байсан хэд хэдэн дутагдалтай талыг ажиглаж, насанд хүрээгүй хүний холбогдсон хэргийг ийнхүү хялбар журмаар шийдвэрлэх нь хангалтгүй буюу оролцогч нарын эрх хангагдаагүй, нотолгооны стандарт хангагдаагүй бол мэтгэлцээний үед шийдвэрлүүлэхээр мэтгэлцээний үе шатыг нэмж, өмгөөлөгч, төлөөлөгчтэй оролцох нөхцөлийг бүрдүүлж процессын шаардлага, нотолгооны стандартыг төлөвшүүлж бүрэн хэмжээний цогц үйл ажиллагаатай шүүх ийнхүү бий болжээ.

АНУ-ын дээрх туршлагаас бидний авах сургамж нь: 1/анхдагч зорилгыг үл мартах, 2/харьяаллыг аажмаар тэлэх явдал юм.

Олон улсын хэмжээнд ямар загвар тогтсон талаар судалсны үндсэнд түгээмэл нэг хандлагыг сонгон тайлбарлахаар шийдлээ. Энэ нь 1/шүүх өөрийн гэсэн үзэл баримтлалтай, 2/шүүхэд тодорхой төрлийн харьяалан шийдвэрлэх маргаантай, 3/шүүх нь шүүх бүрэлдэхүүнтэй буюу тогтсон бүтэцтэй, 4/хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процесстой байх ёстой ба энэ нь их чухал юм. Нэгдүгээр онцлогийг дэлгэрүүлбэл, Гэр бүлийн шүүхийн үзэл баримтлал нь “гэр бүл нь нийгмийн анхдагч нэгж” тул гэр бүл тогтвортой байснаар төр тогтвортой байна. Гэр бүл уналтад орвол дан ганц шүүхийн байгууллага биш, төрөөс түүнийг нөхөн сэргээх бодлого, чиглэл баримталж цогц арга хэмжээ хэрэгжүүлэх нь зүйтэй. Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх дээр гэр бүлтэй холбогдож үүссэн гэр бүлийн холбогдолтой маргааныг ч тэр, хүүхэдтэй холбоотой маргааныг ч тэр нэг зэрэг, нэг дор, цогцоор шийдвэрлэх нь


энэхүү шүүхийн гол зорилго юм. Зорилгын хүрээнд процесс нь мэтгэлцээнгүй, гэр бүлийн гишүүдийг аль болох харилцан ойлголцуулж, эвлэрүүлэх, гэр бүлийн харилцааг хамгаалах, дэмжиж, эмчлэх зорилготой юм.

Харьяаллын хувьд, үндсэн 5 загвар байна:

1. Гэр бүлийн харилцаанаас үүдэлтэй маргааныг шийдвэрлэх гэр бүлийн шүүхийн загвар,
2. Гэр бүлийн гишүүн насанд хүрээгүй хүн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хэргийг хүлээж авч шийддэг, эцэг, эхэд нь хариуцлага, шийтгэл оногдуулдаг шүүхийн загвар,
3. Гэр бүлийн харилцаанаас үүсэх маргаан, насанд хүрээгүй хүний үйлдсэн болон хохирогч нь насанд хүрээгүй хүнд холбогдох хэргийг шийддэг шүүхийн загвар,
4. Эцэг, эх нь хүүхдийнхээ эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэргийг шийддэг шүүхийн загвар,
5. Зөрчлийг хамааруулан шийддэг шүүхийн загвар

Үүнийг доорх зургаар үзүүлбэл:

Зураг 1.




Монгол Улсын хувьд хуульчилсан ойлголт нь 3 дахь загвар буюу гэр бүлийн харилцаанаас үүсэх бүх төрлийн маргаан болон насанд хүрээгүй хүний үйлдсэн бүх маргааныг Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх эрхтэй байх загварыг сонгосон байж болох юм гэж үзсэн.

Шүүхийн бүтэц, зохион байгуулалтын хувьд, Хавай мужийн анхан шатны шүүхэд нийт 30 шүүгч байгаагаас 10 шүүгч нь Гэр бүлийн хэргийн шүүхийн шүүгч байна. Гэр бүлийн хэргийн шүүгч нь бусад төрлийн маргаанд шүүгчийн өмсгөлөө өмсөн зохих журмын дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах бол гэр бүл, хүүхдийн холбогдолтой хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ тусгай танхимд, нарийвчилсан буюу зөөлрүүлсэн дэгийг баримтлан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулдаг онцлогтой.

Шүүхийн бүтэц зохион байгуулалтын талаар бусад улсын бүтцийг ерөнхийлөн харвал үндсэн 4 загвар байна:

Зураг 2.



Дээрх зурагт үзүүлсэн гуравдугаар бүтцэд, давж заалдах гомдлыг зөвхөн Улаанбаатар хотод буюу нийслэлд ирж гаргах боломжтой байхаар зохицуулах нь давж заалдах эрхийг орон зайгаар хязгаарласан шинжтэй байх тул шүүхэд хандах эрхийг аливаа хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэхэд бэрхшээл үүсгэж болох юм. Энэ хүрээнд миний санал бол, Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх байгуулж, түүний бүтэц, зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэхдээ тухайн иргэний оршин сууж байгаа, маргаан гарсан газрын анхан шатны шүүх нь хэргийг ердийн харьяаллын дагуу шийдвэрлэж, давж заалдах шатны шүүх нь хэргийг мэргэшсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн хянан шийдвэрлэх нь зохистой ба илүү үр дүнтэй гэж үзсэн. Харин тухайн шүүхэд ажиллах шүүгчийн хувьд, шүүгч нь тусгай мэдлэгтэй, тодорхой шаардлагыг хангасан, сургалтад хамрагдсан шүүгч байх ёстой.

Хавай мужийн шүүхийн өөр нэгэн онцлог нь шүүхэд жижиг бүтэц ажилладаг буюу жишээлбэл охидын маргаан шийдвэрлэх бүтэц, 3 хүртэлх насны хүүхдэд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх бүтэц зэргийг багтаасан байдаг. Ялын хувьд, насанд хүрээгүй хүний үйлдсэн хэрэгт бүх ялыг хөнгөрүүлж буюу сольж болдог ба оноосон хөнгөн ял, шийтгэлийг биелүүлээгүй тохиолдолд үндсэн хатуу ялыг эдлүүлдэг ба энэ систем нь үр дүнтэйд тооцогддог.

Зураг 3.



Процессын хувьд, хэргийн хөдөлгөөний нэгдсэн хяналт, удирдлага маш чухал. Учир нь нэг шүүхэд иргэний, эрүүгийн гэх мэт холимог маш олон хэрэг ирж болно, түүний бүртгэлийг маш нарийн хийж, дэс дарааллыг зөв тогтоон, шүүх хуралдааныг товлж удирддаг байхгүй бол гэр бүлийн маргааныг түрүүлж шийдээд гэрлэлт цуцалсны дараа хүүхдийн асуудлыг шийдвэрлэдэг байж болохгүй. Түүнчлэн залхаалтын процесс байж болохгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процесс хялбаршуулсан байх ёстой. БНЭУ-д процесс ажиллагаанд шат алгасах гэсэн ойлголт байхгүй, “хөнгөнөөр давах буюу дамжих” гэсэн зарчим хэрэгждэг бол АНУ-ын загварт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудыг хөнгөнөөр хэрэгжүүлэн дамжих бус “алгасах” гэсэн ойлголт байдаг онцлогтой.

Зураг 4.

Давуу тал /гэр бүлийг авран туслах шүүх/

- Нэг гэр бүл-нэг шүүгч
- Өргөн эрх, хандалттай байгууллагын оролцоо /төр, шүүх/
- Бүх асуудлаар урт хугацаанд үйлчлэх шийдэл
- Хууль зүй, нийгмийн хамгааллын цогц шийдэл
- Хууль зүй, нийгмийн хамгааллын цогц шийдэл

14

Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх

Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх байгуулснаар үүсэх давуу тал байгаа ч түүний хажуугаар сул тал ч мөн байна. Тэдгээрээс дурдвал, эрэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах хандлагыг хөгжүүлдэг, хэт хялбаршуулсан журмаас үүдэн хүүхдийг нэг бол хэлмэгдэх нэг бол гэм буруутай нь нотлогдохгүй байх гэх мэт сул тал үүсдэг байна. Үүнийг доорх зургаар үзүүлбэл:

Зураг 5.

Шүүмж

- Эрэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах хандлагыг хөгжүүлдэг
- Иргэний хэрэг маргаанд эрүүгийн албадлагыг хэрэглэдэг
- Эрүүгийн ээдрээ, маргаантай хэргийг шийдвэрлэх чадваргүй процесстой
- Өндөр өртөгтэй
- Шүүгч сэтгэл зүйн хямралт өртөх магадлалтай
- Шүүгч хараат бусаар ажиллахад төвөгтэй

15

Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх

Илтгэлийнхээ төгсгөлд Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхээр харьяалан шийдвэрлэх эрүүгийн хэргийн харьяаллыг хэрхэн тогтоох талаар өөрийн саналаа дэвшүүлье. Эрүүгийн хуульд хохирогч нь ямагт хүүхэд байх 16 дугаар бүлэгт заасан гэмт хэрэг болон хүүхэд үйлдсэн гэмт хэргийг, эцэг, эх асран хамгаалагч нь хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргүүдийг тухайн шүүхэд харьяалуулахаас гадна зөрчлийн хэргийг, таслан сэргийлэх арга хэмжээний асуудлыг мөн энэхүү шүүх харьяалан шийдвэрлэх нь зүйтэй гэж бодлоо.

Дээр дурдсанаас гадна АНУ-ын Хавай мужийн шүүхийн хувьд тухайн улсын төрөөс Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх байгуулах санал, санаачилгыг гаргаж дэмжиж зохион байгуулснаар өдгөө хөгжил нь өндөр түвшинд хүрсэн. Үүний нэгэн адил дан ганц Монгол Улсын дээд шүүх болон Хууль зүй, дотоод хэргийн яамны дэмжлэг, санаачилгаас гадна бусад байгууллагууд (төрийн болон төрийн бус байгууллага), Засгийн газар, ард иргэдийн дэмжлэг ч мөн ихээхэн ач холбогдолтой болохыг анхаарвал зохилтой.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ГЭР БҮЛ БА ХАМТЫН
АМЬДРАЛ, ҮРЧЛЭЛТ, ГЭРЛЭЛТ ЦУЦЛАЛТ, ЭХ
НЯЛХАС, ХҮҮХДИЙН АШИГ СОНИРХОЛ, АСРАН
ХАМГААЛАЛТ, ДУНДЫН ЭД ХӨРӨНГИЙН
ХАРИЛЦААН ДАХЬ ТУЛГАМДСАН АСУУДАЛ

”ЯПОН УЛСЫН ГЭР БҮЛИЙН ШҮҮХЭЭС ГЭР БҮЛ ЦУЦЛАЛТ, ХҮҮХДИЙН АСРАМЖТАЙ ХОЛБООТОЙ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ НЬ”

Харада Аяако,
Япон Улсын Нагояагийн их сургуулийн профессор,
Хууль зүйн доктор (LL.D)

Агуулга

I. Оршил

II. Япон Улсын Гэр бүлийн шүүх

- Гэр бүлийн шүүхийн түүх ба бүтэц
- Гэр бүлийн хэрэг
- Өсвөр насны хүнд холбогдох хэрэг
- Гэр бүлийн шүүхийн бүрэлдэхүүн

III. Гэрлэлт цуцлалт, хүүхдийн асрамж тогтоохтой холбоотой ажиллагаа

- Гэрлэлт цуцлалтын төрлүүд
- Гэрлэлт цуцлалт ба хүүхэд
- Хүүхдийн асрамж тогтоох тухай маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах нь
- Гэр бүлийн шүүхээр асрамж тогтоох тухай маргааныг хянан шийдвэрлэхэд тулгарч буй шүүмжлэлүүд

IV. Шинэ сорилтууд

- Хүүхдийн оролцоог хангах
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах
- Эцэг, эхийн бүрэн эрх, хүүхдийн асрамжийн асуудлаар хийгдсэн Иргэний хуулийн шинэчлэл

V. Дүгнэлт

I. ОРШИЛ

Энэхүү илтгэлээрээ Япон Улсын Гэр бүлийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар, тухайлан гэрлэлт цуцлалт, хүүхдийн асран хамгаалалтай холбоотой маргаан, мөн шүүхийн үйл ажиллагаатай холбоотой бусад тулгарч буй асуудлуудын талаар тайлбарлахыг зорилоо. Илтгэлийн эхлэлд Япон Улсын Гэр бүлийн шүүхийн тогтолцоо (2 дугаар хэсэг), дараа нь гэрлэлт цуцлалт, хүүхдийн асрамжтай холбоотой хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа болон уг ажиллагаанд эвлэрүүлэн зуучлал хэрхэн явагддаг талаар тайлбарлах болно (3 дугаар хэсэг). 4 дүгээр хэсэгт гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн санал, бодлыг анхаарах хэрэгцээ, шаардлага, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, мөн Иргэний хууль дахь хүүхдийн асрамжийн талаарх зохицуулалтын шинэчлэлтэй холбоотойгоор шинээр үүсэх боломжтой хэргүүд зэрэг асуудлуудын талаар, эцэст нь дүгнэлт хэсгээр илтгэлээ танилцуулах болно.

II. ЯПОН УЛСЫН ГЭР БҮЛИЙН ШҮҮХ

Энэхүү хэсгээр Гэр бүлийн шүүхийн түүх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон тус шүүхийн бүтэц, бүрэлдэхүүний талаар тоймлон хүргэх болно.

2.1. Гэр бүлийн шүүхийн түүх ба бүтэц

Япон Улсын Гэр бүлийн шүүх нь гэр бүлийн болоод өсвөр насны хүн гэмт хэрэг үйлдсэнтэй холбоотой хэргийг давхар хянан шийдвэрлэдгээрээ онцлог юм. Энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэхдээ зөвхөн хэргийн үйл баримтыг хуулийн хүрээнд шалгах аас гадна тухайн гэр бүлийн холбогдох маргаан болоод гэмт хэрэг гарах болсон суурь сэтгэлзүйн асуудал, гэр бүлийн гишүүд хоорондын болоод нийгмийн харилцаа зэргийг давхар харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай.

Япон Улсын Гэр бүлийн шүүх нь 1949 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр Өсвөр насны хүний танхим (англ. *Juvenile Tribunal*) болон Гэр бүлийн хэргийн танхим (англ. *Family Tribunal*)-ийг нэгтгэсэн хэлбэрээр байгуулагджээ. Ийнхүү байгуулах үйл явц амаргүй байсан.

Юун түрүүнд, дээрх 2 танхимыг нэгтгэхэд практикийн болон философийн зөрчилдөөн үүсэж байв. Өсвөр насны хүний танхим нь 1922 оны Өсвөр насны хүний тухай хуулийн хүрээнд хамаарах хэргүүдийг хянан шийдвэрлэж ирсэн нь 1946 оноос эхлэн гэр бүлийн холбогдох хэрэг маргааныг хянан шийдвэрлэж эхэлсэн Гэр бүлийн хэргийн танхимаас нэлээдгүй ялгарч байлаа. Учир нь энэхүү танхимууд нь тус тусдаа үйл ажиллагаа явуулдаг байхаас гадна нэг нь эрүүгийн, нөгөө нь иргэний хэргийн шинжийг агуулсан, мөн Өсвөр насны хүний танхим нь шүүхийн тогтолцоонд бус Хууль зүйн яамны харьяа захиргааны засан хүмүүжүүлэх тогтолцоонд хамаарч байсан тул ийнхүү нэгтгэн байгуулахыг хүлээн авахад бэрхшээлтэй болгож байв. Мөн шинээр шүүх байгуулах төсөв хязгаарлагдмал байхаас гадна Япон Улс бүхэлдээ эд материал болон хүний нөөцийн хомсдолд орсон байжээ.

Гэсэн ч эдгээр саад бэрхшээлүүдийг үл харгалзан “гэр бүлд амар тайван

байдал, хүүхдэд итгэл найдвар” гэх философи дор гэр бүлийн хэрэг маргааныг шийдвэрлэх, өсвөр насны хүнийг засан хүмүүжүүлэх зорилгоор Гэр бүлийн шүүх байгуулсан байна. Ийнхүү тус шүүхийг байгуулах болсон цаад шалтгаан нь дэлхийн хоёрдугаар дайны дараагаар хүнд байдалд орсон гэр бүл, хүүхдүүдэд тухайлбал дайны уршгаар өнчирч, гэр оронгүй болсон хүүхдүүд, дайнд нөхрөө алдсан бэлэвсэн эхнэрүүд болон дайны дараагаар гэр бүлийн хүнд хэцүү асуудлуудтай тулгарч буй хүмүүст туслах байв. Нэгдсэн хүчний дээд командлагчийн удирдах газар (англ. *General Headquarters of the Supreme Commander for the Allied Powers* (GHQ))-аас шүүх байгуулах процесст оролцсон хэдий ч шүүхийн байгууллагын удирдлага, шүүгч Жүнширо Удагава, Ёорихиро Наито, Ёшико Мибүчи нар дийлэнх санаачилгыг гарган ажиллажээ.¹

2025 оны байдлаар газар нутгийн хэмжээнээс хамаараад Хоккайдо муж нь 4, бусад мужууд нэг, нэг үндсэн Гэр бүлийн шүүхтэй ба эдгээр нь нийт 203 салбар, 77 дэд салбартай байна. Жишээ нь Аичи муж (ойролцоогоор 7.5 сая хүн амтай)-ийн үндсэн Гэр бүлийн шүүх нь Нагояа хотод, салбар шүүхүүд нь Оказаки, Ханда, Тоёохаши, Ичиномияа хотуудад байдаг байна.² Шүүх салбартай байснаар хүн амын нягтаршил бага газар нутагт амьдарч байгаа иргэдэд хүртээмжтэй байх боломж бүрдэх юм.

Гэр бүлийн шүүх нь 2 танхимаас бүрдэнэ. Үүнд: гэр бүлийн эвлэрүүлэн зуучлал (*kaji chotei*), гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэлт (*kaji shinpan*) болон хувийн байдал тогтоох (*inji sosho*)-той холбоотой хэргийг хянан шийдвэрлэдэг Гэр бүлийн хэргийн танхим; өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэдэг Өсвөр насны хүний танхим хамаарна. Токио болон Осака хотын Гэр бүлийн шүүх нь Олон улсын хүүхдийн хулгайн иргэний асуудлаарх Гаагийн конвенцын дагуу хүүхдийг эргэн гэр бүлд нь буцаахтай холбоотой хэргийг хянан шийдвэрлэдэг байна.³

2022 онд Гэр бүлийн шүүхүүд нийт 1,147,813 гэр бүлийн хэрэг, 45,740 өсвөр насны хүнд холбогдох хэрэг шинээр хүлээн авчээ.⁴ Энэхүү 2 төрлийн хэрэг нь өөр өөрийн онцлог бүхий ялгаатай, бие даасан дүрэм, журмаар зохицуулагддаг ба тэдгээрийн талаар дараагийн хэсэгт тайлбарлах болно.

2.2. Гэр бүлийн хэрэг

Талуудын эрх, үүрэг болоод шүүхээс хэргийг шийдвэрлэх эрх хэмжээг Иргэний хууль (Хууль № 89)-ийн IV болон V хэсэгт хуульчилжээ. Хэдийгээр гэр бүлийн хэрэг нь иргэний хэрэгт хамаардаг ч Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг бус Гэр бүлийн харилцаанд хамаарах хэрэг хянан шийдвэрлэх (эвлэрүүлэн зуучлал болон маргаан шийдвэрлэх гэсэн 2 харилцааг зохицуулдаг) болон Хувийн байдал тогтоох хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (англ. *The*

1 Япон Улсад Гэр бүлийн шүүх байгуулагдах үйл явцын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг Satoshi Kiyonaga (2018) *The Tale of Family Court (Katei Saibansho Monogatari)*, Nippon Hyoron Sha-с үзнэ үү.

2 Нийт шүүхийн байршлыг шүүхийн нэгдсэн цахим хуудас болох <https://www.courts.go.jp/about/sosiki/gaiyo/index.html>-с харна уу. (Сүүлд үзсэн: 2025.08.25).

3 Уг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь “Act for Implementation of the Convention on the Civil Aspects of International Child Abduction (Act No. 48 of 2013)” гэх хуулийн дагуу явагддаг.

4 2025 оны Гэр бүлийн хэргийн тоон мэдээ, (*Reiwa 4 Nen Shiho Tokei Nempo Kaji Hen*), https://www.courts.go.jp/toukei_siryou/shihotokei_nenpo/index.html, (Сүүлд үзсэн: 2025.08.28).

Personal Status Litigation Act) -ийг хэрэглэдэг байна.

Хэрэв эвлэрүүлэн зуучлалын гэрээ бичгээр гарсан тохиолдолд шүүхийн шийдвэрийн нэгэн адил хүчин чадалтайд тооцогдоно (Гэр бүлийн харилцаанд хамаарах хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 268 зүйлийн 1 дэх хэсэг). Харин гэр бүлийн маргааныг хянан шийдвэрлэсний дүнд гарах шүүхийн шийдвэр нь өргөн хүрээний судалгаа шинжилгээний үндсэн дээр гардаг байна. Өөрөөр хэлбэл, эвлэрүүлэн зуучилж байгаа болон хэргийг шийдвэрлэж байгаа тохиолдолд нэгэн адил шүүхээс нотлох баримт цуглуулахад оролцдог.⁵ Шүүгч өөрөө хэрэгтэй холбогдох судалгаа, шинжилгээ хийх тохиолдол байдаг ч ихэнх хэргийн хувьд Гэр бүлийн хэргийн шинжээч (англ. *investigator*) нь хэргийн нотлох баримтыг цуглуулдаг байна.⁶ Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэргийн оролцогч талууд болон гуравдагч этгээдийн хувийн мэдээллийг хамгаалах зорилгоор хаалттай явагддаг (33 дугаар зүйл).⁷

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөл тухайн хэргээсээ хамаарна. Тухайлбал, талууд харилцан тохиролцох боломжгүй, шүүхийн оролцоо зайлшгүй байх тохиолдолд зөвхөн шүүхээр гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна. Эдгээр төрлийн маргаан нь “Хүснэгт 1”-д хамаарах ба үүнд эцэг, эх байх эрх хасах, асран хамгаалагч тогтоох, хүүхдийн овгийг өөрчлөх зэрэгтэй холбоотой хэргүүд хамаардаг байна. Харин харилцан тохиролцох, хэлэлцэх боломжтой тохиолдолд ихэвчлэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар эхлэх ба тухайн ажиллагааны үр дүнд талууд эвлэрэх боломжгүй гэж үзвэл шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа руу тухайн хэрэг шилжинэ. Энэхүү хэргүүд нь “Хүснэгт 2”-т хамаарах ба үүнд хүүхдийг асран хамгаалах эрхийн хуваарилалт, өөрчлөлт, хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоох, уулзах болон өвлөн авсан хөрөнгө хуваарилах зэрэг хамаарна.

Хувийн байдал тогтоох хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хувийн байдал тогтоох хэрэг гэдэг нь гэрлэлт хүчингүй болсныг тогтоох, гэрлэлт цуцалсан тухай шийдвэр авах, хүүхэд гэрлэгчдийн дундаас төрсөн эсэхийг тогтоох, эцэг тогтоох, үрчлэлтийг хүчингүйд тооцох зэргийг ойлгоно. Мөн “гэр бүлийн байдал тогтоох, өөрчлөх”-тэй холбоотой хэргүүд хамаардаг байна.⁸ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай төсөөтэй буюу мэтгэлцэх зарчимд үндэслэдэг хэдий ч гэр бүлийн хэрэгт тохирсон онцлогтой.⁹

5 Гэр бүлийн харилцаанд хамаарах хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 “Гэр бүлийн шүүх нь нотлох баримтыг өөрийн эрх хэмжээний хүрээнд болон хүсэлтийн дагуу хянан шалгах үүрэгтэй”

6 Гэр бүлийн харилцаанд хамаарах хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 “Гэр бүлийн шүүх нь хэргийн нотлох баримтыг хянан шалгах үүрэг бүхий ажилтантай байна”

7 Улсын дээд шүүхээс Япон Улсын Үндсэн хуулийн 32 дугаар зүйлээр шүүхээр үйлчлүүлэх эрхийг, 82 дугаар зүйлээр шүүх хуралдаан нээлттэй явуулахаар заасан нь гэр бүлийн хэрэгт хамаарахгүй байхаар шийдвэрлэжээ. Тодруулбал, гэр бүлийн хэрэг нь бүрэн маргаантай шинжийг агуулдаггүй тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүх хуралдаан нээлттэй байх шаардлагагүй байна. 1965 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Улсын дээд шүүхийн шийдвэр, https://www.courts.go.jp/app/hanrei_jp/detail2?id=56273, (Minshu, Vol. 19, No. 4, p. 1114). (Сүүлд үзсэн: 2025.08.28).

8 Хувийн байдал тогтоох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль (2003)-ийн 2 дугаар зүйл.

9 Эдгээр онцлогуудыг дурдвал:

- нэхэмжлэл гаргахаас өмнө эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдсэн байх.

- шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд шүүхээс зөвлөгөө өгөх этгээдийг томилж болно.

- шүүх өөрийн эрх хэмжээний хүрээнд талуудаас гаргаж өгөөгүй баримтыг цуглуулах, хянан шалгах

Гэр бүлийн шүүхэд бүхий л гэр бүлийн холбогдолтой хэргүүд хамаарна гэж үзэж болох ч үл хамаарах нэг тохиолдол нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас хамгаалалт тогтоолгохтой холбоотой хэргийг Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах тухай хууль (Хууль № 31, 2001 он)-д заасны дагуу Дүүргийн шүүхэд харьяалуулсан байна (11 дүгээр зүйл).

2.3. Өсвөр насны хүнд холбогдох хэрэг

Япон Улсад гэмт хэрэг үйлдсэн этгээд нь насанд хүрсэн эсхүл өсвөр насны хүн байхаас хамааран ялгаатай хариуцлага оногдуулдаг. 14 насанд хүрснээр эрүүгийн хариуцлага хүлээх боломжтой гэж үздэг ба 14 болон түүнээс дээш насны хүний үйлдсэн гэмт хэргийг эрүүгийн хэргийн шүүхээр, харин 20-оос доош насны хүнийг өсвөр насны хүн хэмээн үзэж Эрүүгийн хууль (англ. *Penal Code*)-ийг хэрэглэхээс илүүтэйгээр Өсвөр насны хүний тухай хууль (англ. *Juveniles Act*)-ийг хэрэглэдэг байна.

Өсвөр насны хүний тухай хуулийн зорилго нь “өсвөр насны хүний эрүүл хөгжлийг дэмжих, зан байдлын доголдлыг засах, үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон арга хэмжээ авах” юм (1 дүгээр зүйл). Үүний тулд өсвөр насны хүнийг хамгаалах тусгай арга ашиглах, мөн Гэр бүлийн шүүхээс өсвөр насны хүнийг эрүүгийн хариуцлага хүлээх боломжтой хэмээн үзсэн тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэхээр прокурор руу шилжүүлнэ (20 болон 45 дугаар зүйл).

Тус хуулиар дараах өсвөр насны хүнийг Гэр бүлийн шүүхийн оролцогч хэмээн үзнэ:

1. Гэмт хэрэг үйлдсэн;
2. 14-өөс доош настай, эрүүгийн хууль тогтоомжийг зөрчсөн;
3. Дараах шалтгаануудаас үүдэн гэмт хэрэг үйлдэх эсхүл Эрүүгийн хууль, тогтоомж зөрчих магадлалтай гэж үзсэн: (а) асран хамгаалагчийн хууль ёсны хяналтад орохгүй байх хандлагатай, (б) хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээсээ явсан (в) гэмт хэргийн шинжтэй, ёс суртахуунгүй хүмүүстэй харилцах, нэр хүнд муутай газар байнга явдаг, эсхүл (г) өөрийн болон бусдын ёс суртахууны чанарыг хохироох хандлагатай байх (3.1 дэх хэсэг).

Гэр бүлийн шүүх дэх өсвөр насны хүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь боловсролд төвлөрсөн арга хэмжээг авах, хувь хүнд суурилсан шударга ёсыг баримтлах (англ. *individualized justice*) болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үл маргах журмаар явагдах ажиллагааг баримтлах (англ. *non-adversarial proceedings*) гэсэн 3 суурь зарчмыг үндэслэл болгодог байна.¹⁰ Доорх хэсэгт тус 3 зарчмыг дэлгэрүүлэн авч үзье.

боломжтой.

- хэргийн оролцогч тал, гэрч, төлөөлөгч нар шүүх нээлттэй байгаагийн улмаас хангалттай өөрийгөө илэрхийлэх боломжгүй гэж дүгнэсэн тохиолдолд шүүхийг хаах эрхтэй

10 Дэлгэрэнгүйг: Шүүхийн сургалт, судалгааны хүрээлэн (2025) *The Introduction to Juvenile Law* (8th edition), 29-32 дахь тал.

Нэгдүгээрт, боловсролд төвлөрсөн арга хэмжээг авах хүрээнд өсвөр насны хүнийг засан хүмүүжүүлэх зорилгоор ял, шийтгэл бус хамгааллын шинжтэй ажиллагаа хийдэг. Гэмт хэрэг үйлдсэн хэмээн сэжиглэгдэж байгаа өсвөр насны хүн тодорхой хэдэн хэргээс бусад тохиолдолд (20.1 дэх хэсэг) прокуророор дамжин Гэр бүлийн шүүх рүү очно (41 дүгээр зүйл, 42.1 дэх хэсэг). Ийнхүү Гэр бүлийн шүүх нь тухайн хэргийг үргэлжлүүлэн хянан шийдвэрлэх, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дагуу шийдвэрлүүлэхээр прокурор руу буцаах талаар шийдвэр гаргана.

Хоёрдугаарт, хувь хүнд суурилсан шударга ёсыг баримтлах гэдэг нь шүүх зөвхөн өсвөр насны хүний зан байдал, үйлдлийг бус тухайн үйлдлийг хийх болсон суурь шалтгаан нөхцөл, тухайн хүний хувийн зан төлөв, амьдарч буй орчин болон гэр бүл зэргийг давхар харгалзан үзэхийг ойлгоно. Эдгээрийг харгалзан үзсэнээр хүн тус бүрд тохирсон шийдвэр гарах үндэс болно хэмээн үздэг байна. Иймд Гэр бүлийн шүүх нь мөрдөн шалгах, өөрөөр хэлбэл судалгаа, шинжилгээ хийх (англ. *investigation*) эрхтэй (8.1 дэх хэсэг) ба уг ажлыг хийж гүйцэтгэж буй шинжээчид өсвөр насны хүн, тэдгээрийн асран хамгаалагч, эсхүл бусад шаардлагатай этгээдүүдээс ярилцлага авах үүрэг хүлээлгэх эрхтэй (8.2 дахь хэсэг). Энэхүү эрхийг Өсвөр насны хүнийг засан хүмүүжүүлэх байгууллага (англ. *Juvenile Classification House (shonen kanbetsu sho)*, орч. түр цагдан хоригдсон өсвөр насны хүнд эрүүл мэнд, сэтгэлзүй болон боловсролын шинжтэй шинжээчийн дүгнэлтэд үндэслэн үнэлгээ өгөх чиг үүрэг бүхий байгууллага)-ч мөн хэрэгжүүлдэг. (9 дүгээр зүйл).

Гуравдугаарт, өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үл маргах журмаар явагдана. Гэр бүлийн шүүх нь бие даан мөрдлөг, шинжилгээ явуулахаас гадна цагдаа, хүүхэд хамгааллын зэрэг байгууллагаас дэмжлэг авах боломжтой (16.1 дэх хэсэг). Мөн шүүх нь сургууль, эмнэлэг болон хувийн эсхүл төрийн байгууллагуудаас хамтран ажиллахыг хүсэх боломжтой байна (16.2 дугаар зүйл). Шүүх хуралдаан нь өсвөр насны хүнийг өөрийн хийсэн үйлдлээ ухаарахыг дэмжсэн байдлаар явагдах шаардлагатай ба олон нийтэд нээлттэй явагддаггүй (22.2 дахь хэсэг). Хуралдааны үеэр шүүгч нар, цагдаа болон шинжээчийн гаргасан баримт, дүгнэлт, мөн өсвөр насны хүн, түүний асран хамгаалагч, бусад оролцогч (ихэнх тохиолдолд өмгөөлөгч¹¹)-ийн тайлбар, мэдүүлгийг хянан шалгаж сонссоноор гэм буруутай эсэхийг тогтоох ба гэм буруутай хэмээн үзсэн тохиолдолд тохирсон засан хүмүүжүүлэх арга хэмжээг авахаар шийдвэрлэдэг.

Уг арга хэмжээнд сонсголын өмнөх үе шат (19 дүгээр зүйл), хэргийг хэрэгсэхгүй болгох (23 дугаар зүйл), Хүүхдийн чиглүүлэх төв (18.1 дүгээр зүйл), прокурор руу буцаах (20 дугаар зүйл, 23.1, 19.2, 23.3 дахь хэсэг) эсхүл тэнсэх, хүүхдийн асрамжийн байгууллага, өсвөр насны хүний бэлтгэх сургууль руу шилжүүлэх (24.1 дүгээр зүйл) зэрэг хамаарна.

Өсвөр насны хүний хэрэг прокурорт шилжсэн тохиолдолд тухайн прокурор яллах дүгнэлтийг хангалттай үндэслэлд тулгуурлан үйлдэнэ. Ийнхүү яллагдагчаар татагдсаны дараагаар Өсвөр насны хүний тухай хуульд заасан тусгай журмын

11 Дэлгэрэнгүй мэдээллийг: Япон Улсын өмгөөлөгчдийн холбоо (2023), *White Paper on Attorneys 2023 Edition*, 40-42 дахь тал, <https://www.nichibenren.or.jp/library/en/about/data/WhitePaper2023.pdf>, (Сүүлд үзсэн: 2025.08.28).

дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цааш үргэлжлэх ба үүнд тэнсэх (48 дугаар зүйл) болон ялын хэмжээг бууруулан оногдуулах (51, 52, 54 дүгээр зүйл) хамаарна. Харин бусад тохиолдолд Эрүүгийн хэргийн шүүх өсвөр насны хүнийг насанд хүрсэн хүнтэй адилтган хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна (40 дүгээр зүйл).

2.4. Гэр бүлийн шүүхийн бүрэлдэхүүн

Иргэн болон Эрүүгийн хэргийн шүүх нь шүүгч болон шүүхийн захиргааны ажилчдаас бүрддэг бол Гэр бүлийн шүүхэд гэр бүлийн болон өсвөр насны хүнд холбогдох хэргийн онцлогоос хамааран нэмэлтээр мэргэшсэн албан хаагчид ажилладаг байна.

2.4.1. Шүүгч нар

Япон Улсад шүүгчийн томилгоо нарийн, төвөгтэй журмын дагуу явагддаг. Хэдийгээр Улсын дээд шүүхээс бусад шатны шүүхийн томилгоог Улсын дээд шүүхээс санал болгосон нэрсийн жагсаалтаар Засгийн газар албан ёсоор хийдэг ч уг жагсаалтыг бэлтгэдэг Шүүхийн тамгын газрын хүний нөөцийн хэлтэс сонгон шалгаруулалтыг үр дүнтэй хийдэг хэмээн Хали (*Haley*) тэмдэглэсэн байна. Бүх шатны шүүгч нар 3 жилийн хугацаатайгаар томилогддог.¹²

2.4.2. Гэр бүлийн хэргийн шинжээч

Гэр бүлийн хэргийн шинжээч (*Kateisaibansho chosakan*) нь Гэр бүлийн шүүхийн бусад шүүхээс ялгарах онцлог болдог ба тэд зан байдлын шинжлэх ухаанаар мэргэшсэн байдаг. Энэхүү албан тушаалыг горилж буй, шаардлага хангасан хүмүүсийг эхний ээлжид Шүүхийн сургалт, судалгааны хүрээлэнгийн 2 жилийн сургалтад хамруулдаг ба тус сургалтад хууль, эрх зүй болон зан байдлын шинжлэл, клиникийн сэтгэл судлал, хүүхдийн хөгжил зэрэг нийгмийн шинжлэх ухаан, мөн хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг сэдвүүдийн лекц багтана. Сургалт танхимаар явагдахаас гадна албан ёсны шинжээчдийн удирдлага дор практик байдлаар мөн явагддаг.¹³

Гэр бүлийн хэрэгт шинжээч нь хэргийн цаад, суурь шалтгааныг илрүүлэх зорилгоор оролцогч талууд болон хүүхдээс ярилцлага авна. Мөн хүүхэд хамгааллын байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой. Тэдний гол үүрэг бол үүсээд буй гэр бүлийн хэрэг, маргаанд тохирох арга замыг тодорхойлон, түүнийгээ шүүгчид танилцуулах юм. Үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор шинжээчийн зүгээс хэргийн оролцогч талуудад зөвлөгөө өгөх боломжтой.

Өсвөр насны хүний хэргийн хувьд шинжээч нь өсвөр насны хүн болон тэдний асран хамгаалагчаас ярилцлага аван нөхцөл байдлын талаар ойлголт авч, гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийх болсон зорилго, шалтгааныг тодруулах,

12 John O. Haley (2011) “5 The Japanese Judiciary: Maintaining Integrity, Autonomy, and the Public Trust” in Daniel H. Foote (ed.) *Law in Japan: A Turning Point*, University of Washington Press, pp. 99–135, at 102–105. Haley argues that the “central personnel office responsible for recruiting, mentoring, assigning, and promoting all career judges, combined with spiraling assignments across courts nationwide, is unique to Japan and South Korea” (at 105).

13 Шүүхийн албан тушаалтны сургалтын талаар дэлгэрэнгүйг <https://www.courts.go.jp/saikosai/syokuinkensyujo/youseikensyukenyu/index.html>-с үзнэ үү. (Сүүлд үзсэн: 2025.08.25).

цаашлаад тухайн өсвөр насны хүний амьдрал, зан ааш, амьдарч буй орчныг судалдаг байна. Мөн тэд хувийн зан байдал, хүсэл сонирхлынх нь талаар дүгнэлт хийхийн тулд сэтгэлзүйн үнэлгээ хийж, өсвөр насны хүний үнэлгээний газар зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж болно. Ийнхүү шинжилгээ, судалгаа хийсний дараагаар тэд, хамгийн тохиромжтой шийдвэрийг гаргахын тулд шүүгч нар нөхөн сэргээх зохих арга хэмжээг санал болгож, тайлагнадаг.¹⁴

2.4.3. Эрүүл мэнд хариуцсан ажилтан

Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь оролцогч талууд болон өсвөр насны хүнд аль алинд нь сэтгэлзүйн дарамт учруулж байдаг. Иймд сэтгэл засалч, сувилагч зэрэг эрүүл мэнд хариуцсан ажилтан нь биеийн байдал нь муудсан, сэтгэлзүйн асуудалтай тулгарсан, мөн сэтгэцийн эмгэгтэй эсхүл асуудалтай хүмүүст туслалцаа үзүүлж ажилладаг байна. Мөн оношилгоо хийхээс гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор талуудад зөвлөгөө өгөх боломжтой ба Гэр бүлийн хэргийн шинжээч болон бусад ажилтнууд нь хэргийн оролцогчид, насанд хүрээгүй хүний нөхцөл байдлыг үнэлэхэд туслалцаа үзүүлэхийн тулд эрүүл мэнд хариуцсан ажилтныг оролцуулахаар хүсэлт тавьж болно.¹⁵

2.4.4. Шүүхийн нарийн бичгийн дарга

Шүүхийн нарийн бичгийн дарга нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулж, албан ёсны бүртгэл хөтөлдөг.

2.4.5. Шүүхийн зөвлөх

Шүүхийн зөвлөх (*sanyo in*) нь гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон хувийн байдал тогтоох хэрэгт иргэн хүн (англ. *common citizen*)-ий өнцгөөс үзэл бодлоо илэрхийлдэг ба тэднийг ёс зүйтэй иргэдийн дундаас сонгон авахаар зохицуулсан байдаг.¹⁶

2.4.6. Гэр бүлийн эвлэрүүлэн зуучлагч

Гэр бүлийн эвлэрүүлэн зуучлалын хэрэг үүсэх үед Гэр бүлийн шүүхийн шүүгч болон 2 эвлэрүүлэн зуучлагчаас бүрдсэн эвлэрүүлэн зуучлах комисс байгуулагддаг. Эвлэрүүлэн зуучлагч (*chotei in*) нь шүүхийн орон тооны бус албан тушаалтнаар ажилладаг бөгөөд 40-70 насны хүн байх ёстой. Судалгаанаас үзэхэд, тэдний 70 орчим хувь нь 60 гаруй насныхан, 90 орчим хувь нь мэргэжлийн бус хүмүүс байдаг байна.¹⁷

14 Гэр бүлийн хэргийн шинжээчийн практикийн талаар дэлгэрэнгүйг <https://www.courts.go.jp/saiban/zinbutu/tyosakan/index.html>-с үзнэ үү. (Сүүлд үзсэн: 2025.08.28).

15 Гэр бүлийн хэрэг дэх эрүүл мэндийн ажилтны оролцооны талаар дэлгэрэнгүйг Kumamoto Family Court (1996) “Cooperation between Family Court Medical Officers and Family Court Investigators in Family Cases,” *Family Court Monthly Report (Katei Saiban Geppo)* 48 (6), 87–140 дэх талаас үзнэ үү.

16 Улсын дээд шүүхийн 2003 оны №25 болон 2012 оны №9 дэх шийдвэрийг үзнэ үү.

17 “Саяхныг хүртэл эвлэрүүлэн зуучлагчийг идэвхтэй ажиллаж байгаа эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан товч ярилцлага хийх замаар элсүүлдэг байсан. Харин одоо сонгон шалгаруулах үйл явц нь илүү нээлттэй, өрсөлдөөнтэй болсон ба эхний танилцуулах сургалтад хамрагдсаны дараагаар албан ёсоор эвлэрүүлэн зуучлагчаар томилогддог. Гэр бүлийн шүүх болон тухайн бүс нутгийн эвлэрүүлэн зуучлагчдын холбооноос зохион байгуулж буй сургалтуудад гэр бүлийн маргаан хянан шийдвэрлэхэд шаардагдах анхан шатны мэдлэг, ур чадварыг эзэмшүүлдэг боловч үүнд эвлэрүүлэн зуучлагчийг заавал хамрагдах шаардлагагүй. Эвлэрүүлэн

III. ГЭРЛЭЛТ ЦУЦЛАЛТ, ХҮҮХДИЙН АСРАМЖТАЙ ХОЛБООТОЙ АЖИЛЛАГАА

3.1. Гэрлэлт цуцлалтын төрлүүд

2020 онд Япон Улсад 525,507 гэрлэлт, 193,257 гэрлэлт цуцлалт бүртгэгдсэн байна.¹⁸ 1970-аад оноос гэрлэлтээ батлуулах явдал буурч эхэлсэн бөгөөд 1990-ээд оноос хойш эдийн засгийн уналт болон ажилгүйдлийн түвшин өссөн явдал нь залуучуудын амьдралд нөлөөлснөөр энэ байдал улам ихсэх болсон. Үүний зэрэгцээ гэрлэлт цуцлалтын тоо тогтмол өсөж, 2002 онд 2.31 хувьд хүрсэн нь дэлхийн 2 дугаар дайнаас хойших хамгийн өндөр түвшинд хүрсэн байв. Харин үүнээс хойш гэрлэлт цуцлалтын түвшин буурсаар 2020 он гэхэд 1.57 хувьд хүржээ. Үүнийг залуус гэрлэлтээс зайлсхийх болсонтой холбон тайлбарлаж болох юм. Өөрөөр хэлбэл, гэрлэлт багассанаар гэрлэлт цуцлалт мөн багасдаг.

Япон Улсад доор тайлбарласны дагуу хэд хэдэн төрлийн журмаар гэрлэлт цуцлах боломжтой.

3.1.1. Харилцан тохиролцсоноор гэрлэлт цуцлах

Гэрлэлт цуцлалтыг шүүхийн оролцоогүйгээр гэрлэгчид харилцан тохиролцсоноор гүйцэтгэх боломжтой (*kyogi rikon*). Энэ аргыг дундын өмч, насанд хүрээгүй хүүхэдтэй эсэхээс үл хамааран бүх гэрлэгчид ашиглах боломжтой ба 2020 онд нийт гэрлэлт цуцлалтын 88.3 хувь нь харилцан тохиролцсоны дагуу шийдвэрлэгдсэн байна.¹⁹

3.1.2. Эвлэрүүлэн зуучлалаар гэрлэлт цуцлах

Гэрлэлт цуцлалтыг эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар гүйцэтгэх боломжтой. 2020 онд нийт гэрлэлт цуцлалтын 8.3 хувь нь энэ аргыг ашигласан байна. Хүүхэдтэй уулзах уулзалт, хүүхдийн тэтгэлэг зэрэг хүүхдийн асран хамгаалалтай холбоотой асуудлыг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад шийдвэрлэдэг. Хэрэв талууд хүсвэл эдгээр асуудлыг тусад нь асран хамгаалах эвлэрүүлэн зуучлал (англ. *custody conciliation*)-ын журмаар хэлэлцэж болно.

Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Гэр бүлийн шүүх «эвлэрлийн оронд шүүхээр шийдүүлэх» замыг сонгох боломжтой (*shinpan rikon*). Энэ нь ихэвчлэн ихэнх нөхцөлийг тохиролцсон ч ялимгүй асуудлууд шийдэгдээгүй хэвээр байгаа тохиолдолд авч хэрэгжүүлдэг арга хэмжээ юм. Хэрэв хоёр долоо хоногийн дотор эсэргүүцэл гаргаагүй бол шүүхийн шийдвэрээр гэрлэлт цуцлагдана. Энэ аргаар гэрлэлт цуцлагдах нь ховор бөгөөд нийт тохиолдлын 1.2 хувийг л эзэлжээ.²⁰

3.1.3. Хувийн байдал тогтоохтой холбоотой маргаанаар гэрлэлт цуцлах

зуучлагчийн ажиллах хугацаа 2 жил бөгөөд сунгах боломжтой. Практикт хоёр жил тутамд томилгоогоо сунгуулж, тэтгэвэрт гартлаа ажилладаг байна.”, Ayako Harada (2019) “Family Reorganization in the Japanese Family Conciliation System: Resolving Divorce Disputes Involving Minor Children,” *International Journal of Law, Policy and the Family*, 33, pp. 75–103, at 79–80. DOI:10.1093/lawfam/ebz019. □

18 Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хамгааллын яам, Япон Улс (2022), Гэрлэлт цуцлалтын тоон мэдээ, 2020, <https://www.mhlw.go.jp/toukei/saikin/hw/jinkou/tokusyuu/rikon22/dl/suii.pdf>, (Сүүлд үзсэн: 2025. 08.25).

19 Мөн тэнд.

20 “Domestic Relations Procedure Act”-ийн 284 дүгээр зүйл.

2.2 дахь хэсэгт дурдсанчлан, хувийн байдлын маргаан нь хэргийн оролцогч тал өөрийн аргумент, нотлох баримтаа ирүүлэх байдлаар явагддаг. Гэрлэлт цуцлах үндэслэлд садар самуун, хүчирхийлэл, сэтгэцийн эмгэг, эхнэр, нөхрийн аль нэг нь амьд эсэх нь тодорхойгүй байх, гэрлэлтийг үргэлжлүүлэхэд хүндрэлтэй ноцтой шалтгаан байх зэрэг хамаарна (Иргэний хуулийн 770 дугаар зүйл). Мөн гэрлэлт цуцлах тухай маргаанд асран хамгаалал, уулзалт, хүүхдийн тэтгэлэг, эд хөрөнгө хуваах зэрэг дагалдах асуудлыг давхар шийдвэрлэдэг.

Хэдийгээр зарчмын хувьд зөрчилдөөнтэй боловч шүүхээр гэрлэлт цуцлах ажиллагаа нь хүүхдийн эрх ашгийг хөндөж байгаа тохиолдолд мөрдөн шалгах зарим элементээр явагддаг. Гэр бүлийн хэргийн шинжээч нь хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулдаг бөгөөд тус дүгнэлтийг шүүхэд нотлох баримт гэж үзнэ.

Шүүхээс гарах шийдвэрийг дараах байдлаар ангилж болно:

- Хариуцагч тал нэхэмжлэлийг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд гэр бүл цуцлалтыг хүлээн зөвшөөрснөөр эцэслэн шийдвэрлэнэ (nindaku rikon: нийт гэрлэлт цуцлалтын 0.1-ээс бага хувь).
- Хоёртал тохиролцоонд хүрснээргэрлэлт цуцлалт эцэслэн шийдвэрлэгдэнэ (wakai rikon: 1.3 хувь).
- Талууд тохиролцоонд хүрээгүй мөн нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шүүх шийдвэр гаргана (hanketsu rikon: 0.9 хувь).

Эдгээр үзүүлэлтээс харахад Япон Улсад гэрлэлт цуцлалтын дийлэнх нь үл маргах журмаар шийдэгддэг байна.

3.2. Гэрлэлт цуцлалт ба хүүхэд

2020 онд гэрлэлт цуцлуулсан 193,253 гэрлэгчдийн 57.6% (111,335) нь насанд хүрээгүй хүүхэдтэй байжээ.²¹ 2002 оноос хойш эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан хүүхдийн тоо буурч байгаа нь төрөлтийн тоо ерөнхийдөө буурч, гэрлэлт цуцлалтын түвшин буурсантай холбоотой байж магадгүй ч олон хүүхэд гэрлэлт цуцлалтын улмаас болж хохирсон хэвээр байна (График 1-ийг үзнэ үү).

График 1. Эцэг, эх нь гэрлэлтээ цуцалсан насанд хүрээгүй хүүхдийн тоо²²

1980 он	1985 он	1990 он	1995 он	2000 он	2005 он	2010 он	2015 он	2020 он
166,096	202,585	169,624	205,901	268,929	262,345	252,617	229,048	194,129

3.2.1. Гэрлэлт цуцлалтын дараах хүүхдийн нөхцөл байдал

Гэрлэлт цуцлалт нь хүүхдэд ихээхэн нөлөөлдөг. Хамгийн муу тохиолдолд эцэг, эх нь асран хамгаалах асуудлаар удаан хугацааны маргаантай хэвээр байх боломжтой.

21 Япон Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар (2022) Гэрлэлт ба гэр бүлийн тоон мэдээлэл, <https://www.gender.go.jp/kaigi/kento/Marriage-Family/10th/pdf/1.pdf>, (Сүүлд үзсэн: 2025.08.25).

22 Япон Улсын амин чухал статистикуудыг: <https://www.e-stat.go.jp/stat-search/files?page=1&toukei=00450011&t-stat=000001028897-c> үзнэ үү. (Сүүлд үзсэн: 2025.08.25).

2025 оны 08 дугаар сараас эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Япон Улсын Иргэний хуулиар (энэ нийтлэлийг бичиж байх үед) эцэг, эх нь гэрлэлт цуцлах тохиолдолд эцэг, эхийн зөвхөн нэг нь хүүхдийг асрамждаа авахаар зохицуулжээ. Үүнд хүүхдийг асрамжлах болон хүмүүжүүлэхтэй холбоотой эрх, үүргийг аль алиныг нь ойлгоно. Мөн эцэг, эх нь хүүхдийг асрамжлах, хүүхэдтэй уулзах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах гэх мэт асуудлыг тохиролцох эрхтэй хэдий ч тохиролцох боломжгүй тохиолдолд шүүхээс шийдвэрлэнэ.

Хэдийгээр Иргэний хууль нь хүйсийн тэгш байдлыг хангасан зохицуулалтуудтай боловч гэр бүлийн хэргийн хувьд хүүхдийг эхийн асрамжид үлдээн шийдвэрлэх тохиолдол давамгайлдаг байна.²³

Гэрлэлт цуцлалтын дараа хүүхэдтэй уулзах, хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээлтэй байдаг буюу гэрлэлт цуцлалтын дараах өрх толгойлсон эцэг эсхүл эхтэй гэр бүлүүдийн:

Хүүхдийг асрамждаа аваагүй эцэг эсхүл эхийн зөвхөн 30 хувь нь уулзалтын талаар тохиролцоо хийсэн байдаг.

Гэрлэлт цуцалсны улмаас хүүхдийн тэтгэлгийг эцгээс гаргуулж буй тохиолдлын 56.9 хувьд нь “огт аваагүй”, 14.2 хувьд нь “өмнө нь авч байсан” ба зөвхөн 28.1 хувьд нь “одоо авч байгаа” тэтгэлэг хамаарч байна.²⁴

3.2.2. Хүүхдийн асрамжтай холбоотой маргаан ихэссэн

1990-ээд оноос хойш хүүхдийн асрамж, ялангуяа хүүхэдтэй уулзах, хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой маргаан эрс нэмэгдсэн²⁵ (График 2-ыг үзнэ үү).

График 2.²⁶

Он	Хүүхэдтэй уулзах уулзалт		Хүүхдийн тэтгэлэг	
	Эвлэрүүлэн зуучлалаар	Шүүхээр	Эвлэрүүлэн зуучлалаар	Шүүхээр
2000	2,406	322	11,880	1,059
2005	5,013	760	15,353	2,129
2010	7,749	1,201	18,394	2,901
2015	12,264	1,977	18,283	3,017
2020	12,929	1,939	17,655	3,072

Хүүхдийн асрамжтай холбоотой маргаан өсөхөд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөн ба тэдгээрээс дурдвал: Гэрлэлт цуцалсны дараа хүүхэд болон тусдаа

23 2023 онд хүүхэдтэй гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулсан нийт тохиолдлын 86.6 хувьд нь хүүхэд эхийн асрамжид байхаар шийдвэрлэсэн байна. <https://www.e-stat.go.jp/stat-search/file-download?statInfId=000032118635&fileKind=1>, (Сүүлд үзсэн: 2025.08.25).

24 Япон Улсын Хүүхэд, гэр бүлийн агентлаг (2021), Эцэг, эхийн аль нэг нь өрх толгойлсон талаарх судалгаа, https://warp.da.ndl.go.jp/info:ndljp/pid/12862028/www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/0000188147_00013.html, (Сүүлд үзсэн: 2025.08.25).

25 Хүүхдийн асрамжтай холбоотой гэр бүлийн хэрэгт: хүүхэдтэй уулзах уулзалт, хүүхдийн тэтгэлэг, хүүхдийн асрамжлагчаар томилогдох эцэг, эхийг тогтоохтой холбоотой асуудлууд хамаарна.

26 Жил бүрийн шүүхийн статистик, гэр бүлийн хэргүүдийг https://www.courts.go.jp/toukei_siryou/shihotokei_nenpo/index.html-c үзнэ үү. (Сүүлд үзсэн: 2025.08.25).

амьдарч байгаа эцэг, эхийн хоорондын харилцааг зогсоох жишиг байсан хэдий ч үүнийг шударга бус хэмээн үзэх эцэг, эхчүүд олшрох болсон. Мөн нэхэмжлэлийн шаардлага нь хүүхэдтэйгээ уулзах замаар харилцаагаа хадгалах, хүүхдийн тэтгэмжээр дамжуулан санхүүгийн тогтвортой байдлыг хангах эцэг, эхийн ашиг сонирхолд тулгуурлахаас гадна жендерийн тэгш байдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зэрэг болно.

“Ихэвчлэн ээж нь хүүхдийнхээ өмнө бүх үүрэг, хариуцлагыг хүлээдэг” гэх уламжлалт ойлголт орчин үед тохиромжгүй бөгөөд үүнээс үүдэн хүүхдийг асрамждаа байлгаж байгаа эцэг, эхийн аль нэг, ялангуяа аав нь хүүхдийнхээ амьдралд оролцох оролцоонд ач холбогдол өгөх шаардлагатай болж байна. Энэ нь гэр бүлийн хүчирхийлэл, гэрлэлт цуцлалтын үед болон цуцлалтын дараа хохирогчийг хамгаалах зэрэг асуудлуудад анхаарал хандуулах шалтгаан болж өгчээ. Учир нь хүчирхийлэлтэй холбоотой гомдол нь хэргийн ээдрээтэй байдлыг нэмэгдүүлж, шүүхийн оролцоогүйгээр хэргийг шийдвэрлэхэд хүндрэлтэй болгодог байна.

3.3. Хүүхдийн асрамжтай холбоотой хэрэгт эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах нь

Асрамж тогтоолгох хэрэгт эцэг, эхийн хоорондын зөрчилдөөнийг багасгах, мөн хүүхдэд ээлтэй шийдвэр гаргах зорилгоор эхлээд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулдаг ба Гэр бүлийн бүх шүүхээр дамжуулан, харьцангуй бага зардлаар уг ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой. Жишээлбэл, хүүхдийн асрамжтай холбоотой эвлэрүүлэн зуучлах үйл явц нь нэг хүүхдэд 1200 иен болдог.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа гэдэг нь нэг удаа болоод дуусдаг процесс биш юм. Ихэвчлэн 5-6 удаагийн, зарим нарийн төвөгтэй тохиолдолд түүнээс ч олон тооны уулзалт хийх шаардлагатай болдог. Уулзалт бүр сард нэг удаа болдог тул эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дуусгахад 6 сар ба түүнээс дээш хугацаа шаардагдах ба уулзалтад эвлэрүүлэн зуучлагч нар заавал оролцоно. Харин шүүгч нар уулзалт бүрийн өмнө болон дараа нь эвлэрүүлэн зуучлагч нарт зааварчилгаа өгдөг.

Ихэнх тохиолдолд эвлэрүүлэн зуучлагч хэргийн талуудтай ганцаарчлан уулздаг ба энэ нь тухайн уулзалтад оролцож буй тал өөрийн жинхэнэ мэдрэмжээ саадгүй, бүрэн илэрхийлэх боломжийг олгодог хэдий ч үүнийг нөгөө талын эсрэг ашиглах эрсдэлтэй²⁷.

Дийлэнх тохиолдолд хүүхдийн тэтгэлгийн талаар тохиролцох нь хүүхэдтэй уулзах уулзалтын хуваарь гаргахаас илүү хялбар байдаг. Учир нь хүүхдийн тэтгэлгийн хэмжээг шүүхээс баталсан тооцооны удирдамж (yoikuhī santei hyō)-ийг ашиглан гаргах боломжтой бөгөөд төлбөрийг талууд хоорондоо шууд харилцахгүйгээр, банкаар эсхүл бусад аргаар гаргуулах боломжтой. Харин хүүхэдтэй уулзах уулзалтын асуудал нь ямар нэг тодорхой зааварчилгаа, удирдамжгүйн дээр хүүхдийн эцэг, эхтэйгээ тав тухтай, тогтмол уулзах боломжийг хангахад тал бүрийн хамтын ажиллагааг байнга шаардаж байдгаараа онцлог юм.

²⁷ Харада (fn. 17), 80 дахь тал.

Энэ утгаараа уулзалттай холбоотой хэргийн хувьд хэрэгжих бүрэн боломжтой, үр дүнтэй шийдвэр гаргахад Гэр бүлийн шүүхээс нэмэлт хүчин чармайлт шаарддаг ба үүнд тухайн гэр бүлийн амьдралын нөхцөл, хоорондын харилцаа болон хүүхдийн байр суурийг үнэлэх Гэр бүлийн хэргийн шинжээчийг түргэн шуурхай томилох явдал хамаарна. Мөн шүүхийн зүгээс эцэг, эхчүүдэд боловсрол олгох зорилгоор дүрс бичлэг болон бичгийн хэлбэрээр сургалт явуулдаг ба үүгээр гэрлэлт цуцлалтын улмаас хүүхдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, хүүхдийг эцэг, эхийн зөрчилдөөнөөс хамгаалах мөн хүүхдийн эцэг, эхтэйгээ харилцах харилцааг эрүүл байлгах зэрэг асуудлуудад төвлөрдөг байна. Мөн эцэг, эхийн хүүхэдтэйгээ уулзах лзалтыг амжилттай зохион байгуулах практик зөвлөмжийг хүргэдэг.²⁸

3.4. Гэр бүлийн шүүхээр асрамж тогтоолгох хэргийг хянан шийдвэрлэхэд тулгарч буй шүүмжлэлүүд

Гэр бүлийн шүүхээс хүүхдийн асрамж тогтоолгох хэргийг хэрхэн хянан шийдвэрлэх ажиллагааг сайжруулах талаар байнгын арга хэмжээ авсаар байгаа хэдий ч хүчтэй шүүмжлэлд өртсөн хэвээр байна.

Нэгт, Гэр бүлийн шүүхэд хүүхэдтэй холбоотой асуудлаар эвлэрлийн гэрээ байгуулахад бэрхшээлтэй байдаг хэмээн шүүмжилдэг. Шүүхийн бус аргаар гэрлэлт цуцлах боломжтой улсуудад ихэнхдээ талууд харилцан тохиролцох замаар хүүхэдтэй холбоотой шийдвэрээ бие даан гаргах эрхтэй байдаг ч хүүхдийг сайн сайхан, аюулгүй байлгахтай холбоотой асуудлаар мэргэжлийн туслалцаа авах боломжгүй байдаг. Маргаан нь шүүхэд хандахаас өөр аргагүй болох нөхцөл байдалд хүрсэн эцэг, эхийн хувьд хүүхдийнхээ хүсэл сонирхлыг хүндэтгэх талаар хангалттай ойлголцогүй байдаг. Энэ үед эцэг, эхийг мэдээллээр хангасан ч зөрчилдөөн аль хэдийн гүнзгийрсний улмаас харилцан тохиролцоход хүндрэлтэй байж болзошгүй юм. Удаан үргэлжилсэн маргаан нь эцэг, эхчүүдэд сэтгэл санааны дарамт учруулдаг гадна хүүхдэд хохиролтой байдаг.²⁹

Мөн хүүхэдтэй уулзах уулзалтын талаар талууд тохиролцсон ч ихэнх тохиолдолд «хонохгүйгээр сард 1 удаа» уулзах байдлаар шийдвэрлэсээр байна.³⁰

Хоёрт, Гэр бүлийн шүүхийн шийдвэрийн хэрэгжилт сул гэх шүүмжлэл байдаг. Хүүхэдтэй уулзах уулзалт болон хүүхдийн тэтгэлгийн талаар гэрээ байгуулсан хэдий ч зарим тохиолдолд тухайн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх нь бий. Гэр бүлийн эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулсан гэрээ, Гэр бүлийн шүүхийн шийдвэр аль аль нь хуулийн хүчин төгөлдөр байдаг. Хүсэлтийн дагуу Гэр бүлийн шүүх зөрчил гаргасан эсэхийг шалгаж, зөрчил гаргасан тохиолдолд засаж залруулах арга хэмжээг санал болгож болно (Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 289 дүгээр зүйл). Хүүхдийн тэтгэлэг олгох гэх мэт санхүүгийн холбогдолтой үүрэг хүлээсэн бол Гэр бүлийн шүүх үүргээ биелүүлэхгүй байгаа талаас төлбөр шаардаж болно (290 дүгээр зүйл). Мөн Гэр бүлийн шүүхээс авч буй эдгээр арга хэмжээнүүдээс гадна талууд Иргэний

28 Улсын дээд шүүхээс эцэг, эхээсээ холдсон хүүхдийн мэдрэмж, эцэг, эхийн зөрчилдөөнөөс тэднийг хамгаалахын чухлыг эцэг, эхчүүдэд харуулах зорилго бүхий богино хэмжээний кино бүтээжээ. Үүнд хүүхдийн сонирхлыг хангах үүднээс хүүхэдтэй уулзах ажлыг үр дүнтэй зохион байгуулах практик зөвлөмжийг мөн өгсөн болно. https://www.courts.go.jp/links/video/kodomo_video/index.html, (Сүүлд үзсэн: 2025.08.25).

29 Аяако Харада (2015) “АНУ болон Япон Улс дахь хүүхдийн асрамж болон хүүхэдтэй уулзах уулзалттай холбоотой маргааныг шийдвэрлэх тогтолцооны хөгжил: Шилжилтийн үеийн хэм хэмжээ, журамд анхаарлаа хандуулах нь” *Japanese Law and Society Review*, 1, 65-97 дахь тал, 86-87 дахь тал.

30 Мөн тэнд., 86 дахь тал.

шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу шийдвэр гүйцэтгүүлэх арга хэмжээ авах боломжтой. Харин хүүхэдтэй уулзах уулзалтын талаар гарсан шийдвэрийг албадан биелүүлэхэд ихээхэн бэрхшээлтэй байдаг тул Гэр бүлийн шүүхүүд уулзалттай холбоотой нарийвчилсан, тодорхой шийдвэр гаргахаас аль болох зайлсхийдэг. Мөн процессын нарийн төвөгтэй ажиллагаанаас шалтгаалан хүүхдийн тэтгэлэг гаргуулахад ч их бэрхшээлтэй байдаг. Хэдийгээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд эдгээр тохиолдлуудад (817-15, 817-16 дугаар зүйл) зарим талаар хялбаршуулсан журмыг ашиглахаар хуульчилсан байдаг боловч бүрэн хэрэгжихгүй хэвээр байна.

Гуравт, Гэр бүлийн шүүхийн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийг үр дүнтэй шийдвэрлэх чадавх хязгаарлагдмал байна хэмээн шүүмжилдэг. Япон Улсын хохирогчийг хамгаалах болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийг дахин нийгэмшүүлэх тогтолцооны хөгжил удаашралтай байна. Хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнийг хүүхэдтэй нь хамт нүүлгэх, мөн хүүхдээ өөрийн асрамждаа авах эрхээр хангадаг ба хүүхдийг асрамжлах эрхгүй эцэг, эхийн аль нэгтэй нь уулзуулахаас татгалздаг. Сүүлийн үед Гэр бүлийн шүүхүүд гэрлэлт цуцалсны дараах эцэг, эхийн хүүхэдтэйгээ уулзах асуудалд илүү идэвхтэй оролцох болсон. Гэр бүлийн хүчирхийллийн тухай гомдол гарсан байгаа нь дангаараа хүүхдийг асрамждаа аваагүй талыг хүүхэдтэй уулзахыг хориглох үндэслэл болохгүй. Харин үүний оронд Гэр бүлийн шүүхээс хүүхдийн аюулгүй байдал болон эцэг, эхтэйгээ харилцах харилцааг аль алиныг нь хангасан уулзалтын төлөвлөгөөг боловсруулахыг зорьж байна. Гэвч гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч болон тэдний өмгөөлөгчийн зүгээс шүүх нь хохирогчийн аюулгүй байдлыг бүрэн хангаж чадахгүй байгаа гэж үздэг. Иймд эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд шүүхийн хүчирхийлэлтэй холбоотой хэргүүдийг хэрхэн шийдвэрлэж байгаа байдал болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээг сургалт болон бусад байгууллагатай хамтран ажиллах замаар сайжруулах шаардлагатай байна³¹.

IV. ШИНЭ СОРИЛТУУД

Гэр бүлийн хэрэгт хүүхдийн эрхийг хамгаалах хэрэгцээ шаардлага болоод техник технологийн дэвшил, Гэр бүлийн тухай хуулийн өөрчлөлт, шинэчлэл зэрэгтэй холбоотойгоор дараах сорилтууд тулгарч байна.

4.1. Хүүхдийн оролцоог хангах

Япон Улс Хүүхдийн эрхийн тухай конвенцыг 1994 онд соёрхон баталсан. Энэхүү конвенц батлагдсанаас хойш гишүүн орнууд хүүхдийн үг хэлэх эрхийг илүү сайн хамгаалах тогтолцоог шинэчлэхээр ажиллаж байна (12 дугаар зүйл). Улс орнууд хүүхдэд ээлтэй шүүхийн тогтолцоонд шилжих, хүүхдийн шударга ёсны хүртээмжийг хангах шаардлагатай байна³².

31 Мөн тэнд., 89-90 дэх тал

32 Олон улсад: Европын Зөвлөлийн Хүүхдийг хамруулсан шударга ёсны талаарх удирдамж (2011) болон НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 01 дүгээр сарын 09-ний өдөр болсон 95 дугаар чуулганаар 01 дүгээр сарын 02-ны өдөр 2004 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн янз бүрийн хэлэлцүүлгээр баталсан Хүүхдийн эрхийн хорооны 27 дугаар ерөнхий тайлбарын төсөл, Шүүхэд хандах эрх, үр дүнтэй арга хэрэгсэл зэрэг багтана. гэр бүлийн эрх зүйн үйл явцад хүүхдийн оролцоо, Венди Шрама, Мэрилин Фриман, Никола Тейлор, Маризэлл

Япон Улс энэхүү чиг хандлагыг дагаж байгаа бөгөөд хүүхдийн гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь оролцоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

2011 оны Гэр бүлийн харилцааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар Гэр бүлийн шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ хүүхдийн нас, төлөвшлийг харгалзан тэдний байр суурийг харгалзан үзэхийг шаарддаг (65 дугаар зүйл). Түүнчлэн уг хуульд 15 ба түүнээс дээш насны хүүхдийг эцэг, эхтэйгээ уулзах, үрчлэлт, асрамж тогтоолгохтой холбоотой хэрэгт (152.2 дахь хэсэг, 161.3 (i) дахь хэсэг, 169, 175.2 дахь хэсэг гэх мэт) өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, санал өгөх зэрэг эрхээр хангахаар заасан байдаг.

Хүүхдийн санал, бодлыг хэрхэн авч үзсэнээс шүүхийн шийдвэр хамаарна. Хүүхдээс Гэр бүлийн хэргийн шинжээч эсхүл өмгөөлөгчөөр төлөөлүүлэн ярилцлага авч болно. Ашиг сонирхлын зөрчлийн улмаас хүүхдийг эцэг, эхээр нь дамжуулан сонсох нь эргэлзээтэй байдаг ч заримдаа энэ аргыг зөвшөөрдөг. Япон Улсын шүүгч нар ерөнхийдөө хүүхдийн яриаг шууд сонсохоос зайлсхийдэг.

Хүүхдүүдтэй ярилцлага хийхээр бэлтгэгдсэн Гэр бүлийн хэргийн шинжээч нь ихэвчлэн нээлттэй асуулт ашигладаг бөгөөд хүүхдээр эцэг, эхийн аль нэгийг сонгуулах зорилго бүхий хөтөлсөн асуултуудаас зайлсхийдэг ба шүүх болон эцэг, эхэд өөрийн гаргасан дүгнэлтээ тайлагнадаг. Гэвч шинжээч нь хүүхдийг «өмгөөлөх» байдлаар ажиллахад хэд хэдэн нөхцөл байдал саад болдог. Үүнд:

1. Хүүхэд нийт шинжээчийн хийж гүйцэтгэх үйл ажиллагааны зөвхөн нэг хэсэгт л хамаарах бөгөөд тэдний хэлсэн зүйлийг нууцалдаггүй. Энэ нь хүүхэд өөрийн хэлсэн зүйлийн талаарх мэдээлэл шүүх эсхүл эцэг, эхэд очих эсэхийг мэдэж, хянах боломжгүй гэсэн үг юм.
2. Хүүхэд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх боломжтой ярилцлага ганц л удаа болдог ба энэхүү ярилцлагыг анх удаа уулзаж байгаа хүнтэйгээ хийх нь талууд бие биетэйгээ бүрэн ойлголцоход саад учруулах боломжтой.
3. Хүүхдэд өөрийнх нь үзэл бодол шүүхийн шийдвэр болоод эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хэрхэн нөлөөлөх, мөн шинжээчтэй хийсэн ярилцлагын дараа гарах үр дүнгийн талаар ямар нэгэн мэдээлэл, тайлбар өгдөггүй.
4. Хүүхэд өөрийн гаргасан мэдүүлгээ шинэчлэх, тодруулах зорилгоор шинжээчтэй дахин холбогдох боломжгүй.

Шинжээч хүүхэдтэй ярилцлага хийхээс илүүтэй өмгөөллийн тусламж үзүүлэх явдал нь илүү үр дүнтэй арга гэж үздэг байна. Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд бага насны хүүхэд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даан оролцох чадваргүй гэж заасан байдаг ч зарим тохиолдолд (жишээлбэл, эцэг, эх хүүхдийг асрамжлах эрхээ хасуулах, Иргэний хуулийн 834 дүгээр зүйл) бие даан өргөдөл гаргах боломжтой. Ингэхдээ тэд хэрэг хянан

Брунинг (eds.) (2021) Гэр бүлийн эрх зүй дэх хүүхдийн оролцооны талаарх олон улсын гарын авлага, Intersentia. Хүүхдийн шүүхийн хүртээмжийн талаарх судалгааг хөгжүүлэхийн тулд Тон Лиефард (2019) “Хүүхдэд зориулсан шударга ёсны хүртээмж: тодорхой судалгаа, хэрэгжүүлэх хөтөлбөр”-ийг үзнэ үү. Олон улсын хүүхдийн эрхийн сэтгүүл, 27(2), 195–227. <https://doi.org/10.1163/15718182-02702002> , (Сүүлд үзсэн: 2025.08.28).

шийдвэрлэх ажиллагаанд хараат бусаар оролцоно. Шүүхээс хүүхдийг асрамжлах, түүнтэй уулзах асуудлыг шийдвэрлэх зэрэг зарим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдээр оролцохыг зөвшөөрч болно (Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 118, 151 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг). Хэрэгт гуравдагч этгээдээр оролцохын тулд хүүхэд өөрийн нөхцөл байдлыг ойлгож, үндэслэлтэй шийдвэр гаргах чадвартай байх ёстой. Энэ чадамжийг *ishi noryoku* гэж нэрлэдэг. Практикт ийм чадавхыг хүүхэд ойролцоогоор 10 нас хүрч байж олж авдаг гэж үздэг ч зөвхөн наснаас нь хамааруулан тодорхойлдоггүй³³. Хүүхэд нэхэмжлэл гаргагч эсхүл гуравдагч этгээдийн үүргийг гүйцэтгэх боломжтой гэж үзсэн тохиолдолд хүүхдийг төлөөлөх өмгөөлөгчийг шүүхээс томилж болно (Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 23 дугаар зүйл).

Хүүхэд гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, хүүхдэд өмгөөлөгч томилох явдал харьцангуй бага байгаа ч³⁴ хүүхдийг төлөөлөхтэй холбоотой асуудал нэмэгдсээр байна. Харада (2023)-н хэлснээр хүүхдийн хуульч нь ардчилсан, хүүхдэд ээлтэй замаар дамжуулан хүүхдүүдтэй харилцаж, итгэлцлийг бий болгоход анхаардаг. Тэд хүүхдүүдэд өөрсдийн бодол санаа, мэдрэмжийг илэрхийлэхэд нь тусалж, тэдний үзэл бодлыг шүүх болон эцэг, эхчүүдэд үр дүнтэй хүргэхийг зорьж ажилладаг. Хуульчид мөн шүүх хуралдааны явцад хүүхдүүдийн үзэл бодлыг хэрхэн харгалзан үзэж байгаа талаар санал бодлоо илэрхийлж, хэргийн үр дүнгийн талаар мэдээлдэг³⁵.

4.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах

Технологийн дэвшил нь Гэр бүлийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим хэлбэр (онлайн)-р явагдах боломжийг нээж өгсөн. Япон Улсын шүүхүүд 2021 оноос эхлэн цахим хурлын системийг ашиглаж эхэлсэн бөгөөд процедурын журам шинэчлэгдсэнээр 2026 оны 05 дугаар сар гэхэд иргэний болон гэр бүлийн бүх төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах боломжтой болно.³⁶

Гэр бүлийн шүүхийн шүүгчид шүүх хуралдааныг цахим хэлбэрээр явуулахад илүү нээлттэй ханддаг болсон. Цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах давуу талууд нь: хол зай, эрүүл мэндийн байдал, хүүхдийг асрамжлах үүрэг, ажил зэргээс шалтгаалж шүүхэд очиж чадахгүй байгаа хүмүүст илүү хүртээмжтэй

33 Киёотака Икэда (2022) “Хүүхдийн төлөөлөгчдийн байр сууринаас маргаан шийдвэрлэх” Эцэг, эх нь салсан болон хойд эцэг эсхүл эхтэй хүүхдүүдийн талаарх судалгааны сэтгүүл 4, 80-89 дэх тал, 83 дахь тал.

34 2021 онд 64 томилгоо бүртгэгдсэн (30,000 гаруй хүүхдийн асрамжтай холбоотой хэрэгтэй харьцуулахад), <https://www.yomiuri.co.jp/national/20230604-OYT1T50057/>, (Сүүлд үзсэн: 2025.08.28).

35 Аяако Харада (2023) Хүүхдийн сонсогдох эрхийг хамгаалах: Гэр бүлийн шударга ёсны тогтолцоо дахь хүүхдийн эрх, Бүлэг 2. Англи хэл дээрх бүлгийн танилцуулгыг Аяако Харада, “Хүүхдийн эрх ашгийг хамгаалахад хуульчид хэрхэн хувь нэмрээ оруулж чадах вэ? Япон Улсын гэр бүлийн эрх зүйн олон улсын хурлын дэлхийн улсуудад Гэр бүлийн шүүх хуралдааны шинээр гарч ирж буй туршлага” хэсгээс үзнэ үү. 2023.06.14, 10.13140/RG.2.2.32387.16169.

36 Шүүхийн үйл ажиллагааг цахимжуулах, онлайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өргөжүүлэх тухай албан ёсны мэдээллийг https://www.moj.go.jp/MINJI/minji07_00336.html-с, Гэр бүлийн шүүх хуралдааныг цахимжуулах, онлайнаар шийдвэрлэх талаар сүүлийн үеийн хөгжлийн тоймыг: Шинжи Вакияма, Норико Хатано (2023) “Хувийн байдал тогтоох болон Гэр бүлийн шүүхийн ажиллагааг цахимжуулах: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Хувийн байдлын тухай хууль болон холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 2022, 2023 оны нэмэлт, өөрчлөлтийн тойм”-оос үзнэ үү. Гэр бүлийн шүүх Сэтгүүл, 47, 94–104 дэх тал; Наоко Нагай (2024) “Гэр бүлийн шүүх ба цахимжилт”, <https://www.sn-hoki.co.jp/articles/article3167726/>, (Сүүлд үзсэн: 2025.08.25).

байх явдал юм. Цахим оролцоо нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийн аюулгүй байдлын асуудлыг ч хөнгөвчлөх боломжтой.

Гэсэн хэдий ч, ялангуяа гэр бүлийн эвлэрүүлэн зуучлалын хувьд биечлэн харилцах нь илүү дээр байж болох юм. Нүүр тулсан харилцаа холбоо нь эвлэрүүлэн зуучлагч болон талуудын хооронд итгэлцлийг бий болгоход тусалдаг. Тодруулбал, биеийн хэлэмж зэрэг аман бус харилцааны хэлбэрийг биечлэн тайлбарлахад хялбар байдаг. Цахим харилцаа холбоо нь ложистик болон техникийн сорилтуудыг бий болгож байдаг: зарим хүнд цахим хэрэгсэл байхгүй, мөн цахим хэрэгсэл ашиглах ур чадвар байхгүй гэх мэт. Мөн шүүх хуралдааны нууцлал, хувийн нууцтай холбоотой асуудал бий. Цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны давуу болон сул талыг харгалзан шүүхүүд биечлэн болон цахим хуралдааныг хослуулсан тэнцвэртэй загварыг судлах нь зүйтэй байна.

4.3 Эцэг, эхийн бүрэн эрх, хүүхдийн асрамжийн асуудлаар хийгдсэн Иргэний хуулийн шинэчлэл

Хууль зүйн яамны Хууль тогтоох зөвлөлийн Гэр бүлийн тухай хуулийн хэлтсээс 3 жил орчим хэлэлцэж, олон нийтээс санал авсны эцэст 2024 оны 01 дүгээр сард Гэр бүлийн тухай хууль тогтоомжийн шинэтгэлийн төслийг Засгийн газарт өргөн мэдүүлсэн. Ингээд Иргэний хууль болон холбогдох бусад хуульд хэсэгчлэн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр хэлэлцсэнээр Засгийн газарт өргөн мэдүүлсэн. Шинэчилсэн хууль 2 жилийн дотор буюу 2026 оны 05 дугаар сараас хэтрэхгүй хэрэгжиж эхэлнэ.

Шинэчилсэн найруулгын гол санаанууд нь:

- хэн нь хүүхдийг асрамждаа байлгаж байгаагаас үл шалтгаалан эцэг, эхийн үндсэн үүргийг тодорхойлох;
- гэрлэлт цуцалсны дараах эцэг, эхийн хамтарсан хариуцлагын хувилбарыг нэвтрүүлэх;
- гэрлэлт цуцалсны дараах хүүхдийн асрамжтай холбоотой зохицуулалтыг өргөжүүлэх;
- эцэг, эхээс бусад хууль ёсны төрөл төрөгсөд нь хүүхэдтэй уулзах журам тогтоох;
- хүүхдийн тэтгэлгийг нэмэгдүүлэх арга замыг эрэлхийлэх³⁷.

Эдгээр нь хэргийг хэрхэн шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх боловч эцэг, эхийн хоорондын зөрчлийг нэмэгдүүлж болзошгүй байна. Шинэ зохицуулалтуудын нарийн төвөгтэй байдал нь маргааныг улам хурцатгаж болзошгүй. Тиймээс Гэр бүлийн шүүх дэх хүүхдийн асрамжтай холбоотой хэргийн тоо өсөхөд бэлтгэлтэй байх хэрэгтэй. Мөн хугацаа хойшлуулах нь хүүхдэд ноцтой нөлөөлдөг тул аливааг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх нь чухал юм.

37 Иргэний хуулийн 2024 оны нэмэлт, өөрчлөлтийн талаар тайлбарыг: Хууль зүйн яамны Иргэний хэргийн танхим, “2024 оны Япон Улс дахь Гэр бүлийн тухай хуулийн шинэчлэл - 2024 оны тавдугаар сарын Иргэний хуульд хэсэгчлэн өөрчлөлт оруулах тухай хуулийн тойм”, <https://www.moj.go.jp/content/001421487.pdf>-с үзнэ үү. (Сүүлд үзсэн: 2025.08.28).

Шүүхийн нөөц бололцоогоос гадна нийгмийн дэд бүтэц, байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь чухал юм. Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд шаардлагатай мэдээллээр хангах, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг чиглэсэн ажиллагаа явуулах, хүүхэдтэй уулзах уулзалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, эцэг, эх, хүүхдүүдэд зөвлөгөө өгөх үйлчилгээ зэрэг олон нийтийн үйлчилгээг мөн харгалзах нь зүйтэй. Мөн хүүхдийн оролцоо, бие даасан байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг тус тус бэхжүүлэх шаардлагатай. Гэр бүлийн шүүх хүүхдэд ээлтэй болж, хүүхдийн шударга ёсны хүртээмжтэй байдлыг мөн хангаж ажиллах ёстой.

V. ДҮГНЭЛТ

Япон Улс дахь Гэр бүлийн шүүх нь «гэр бүлд амар тайван байдал, хүүхдэд итгэл найдвар» гэсэн философийн дор хөгжсөн ба эрхэм зорилго нь хүмүүсийн амьдрал, харилцаанаас үүсэж буй асуудлуудыг шийдвэрлэх явдал юм. Үүнийг зөвхөн болж өнгөрсөн зүйлд хууль хэрэглэснээр биелүүлэх боломжгүй; Харин Гэр бүлийн шүүх нь ээдрээтэй асуудлыг шийдвэрлэж, цаашид түүнийг сайжруулахын төлөө ажиллах ёстой. Энэ нь шүүхийн хувьд нэлээд хэцүү ажил юм. Тодруулбал, зөвхөн хууль, эрх зүйн мэдлэг төдийгүй бусад шинжлэх ухааны мэдлэг болоод практик чадварыг шаарддаг. Мөн шүүх болон гаднын бусад байгууллагуудын хамтын ажиллагаа чухал юм.

Гэр бүлийн шүүхүүдийг байгуулах, үргэлжлүүлэн хөгжүүлэхэд төрөөс хангалттай хөрөнгө мөнгө зарцуулж, тус шүүхийн онцлогийг хүлээн зөвшөөрөх асуудал чухал байдаг. Үүний тулд шүүхийн ач холбогдлын талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх ёстой. Хэдийгээр Гэр бүлийн шүүх заримдаа шүүмжлэлтэй тулгардаг ч гэр бүл, хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд тэдний үүргийг өөр ямар ч шүүхийн байгууллага орлож чадахгүй. Шүүх нь шүүхээр үйлчлүүлж буй иргэдийн сэтгэл ханамжгүй байдлыг анхааралтай сонсож, үйлчилгээг сайжруулах үндэс болгон ашиглах ёстой.

Эцэст нь хэлэхэд, гэр бүлийн хэрэг шийдвэрлэлтийг боловсронгуй болгох эцсийн зорилго нь насанд хүрэгч төдийгүй хүүхдийн эрхийг хамгаалах явдал гэдгийг бид үргэлж санаж байх ёстойн дээр хүүхэд гэдгээс нь шалтгаалж тэднийг шударга бус байдалтай нүүр тулахаас сэргийлэх нь хамгийн чухал юм.

“МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭР БҮЛИЙН ХӨРӨНГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ, ШҮҮХИЙН ПРАКТИК”

Н.Баярмаа,
УДШ-ийн Иргэний хэргийн танхимын шүүгч,
Хууль зүйн доктор (LL.D)

Агуулга

I. Удиртгал

II. Гэр бүлийн хөрөнгө ба дундын өмч

- 2.1. Гэр бүлийн дундын өмчийн тухай ерөнхий ойлголт
- 2.2. Жишгийн эрх зүй дэх дундын өмч ба гэр бүлийн хөрөнгө

III. Монгол Улсын гэр бүлийн хөрөнгийн эрх зүйн зохицуулалтын онцлог

- 3.1. Гэр бүлийн хөрөнгийн өмчлөгч
- 3.2. Иргэний хууль дахь гэр бүлийн хөрөнгө
- 3.3. Гэр бүлийн хөрөнгийг хуваах, ногдох хэсгийг тодорхойлох

IV. Гэр бүлийн хөрөнгөтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэж буй шүүхийн практик

- 4.1. Хөрөнгийг захиран зарцуулах зөвшөөрөл авсан байх шаардлага
- 4.2. Дундын хөрөнгийг хүүхдэд хувааж буй байдал, ногдох хэсгийн хэмжээг тогтоох
- 4.3. Гэрлэгчдийн өр, хариуцлагын хуваарилалт
- 4.4. Дундын хөрөнгийг хуваах үеийн эд хөрөнгийн эзэмшил
- 4.5. Гэр бүлийн дундын хөрөнгө эсэхийг тодорхойлох
- 4.6. Хамтран амьдрагчдын дундын эд хөрөнгийг хувааж буй байдал

V. Дүгнэлт

Ном зүй

I. УДИРТГАЛ

Дангаар болон дундын өмчлөх эрхийн аль аль ойлголтыг өөртөө багтаасан гэр бүлийн хөрөнгө гэх ойлголт цаг хугацааны явцад онцгойрон хөгжиж, эх газрын болон жишгийн эрх зүйн тогтолцоонд “marital property”, “matrimonial property” гэх нэршлээр бие даан судлагдах болжээ. Монгол Улсын хувьд гэр бүлийн хөрөнгийг дундын өмчийн нэг төрөл болох хамтран өмчлөх дундын өмчийн илрэх хэлбэр, жишээ төдийхнөөр авч үзэх нийтлэг хандлага ажиглагддаг. Манай улсын хувийн эрх зүйд бие даасан хуультай болох хувьдаа гэр бүл, хөдөлмөрийн эрх зүйн салбар түлхүү хөгжсөн мэт харагдавч өмчийн эрх зүйн хөгжлийн хоцрогдлоос шалтгаалан гэр бүлийн хөрөнгө хангалтгүй судлагдсан, орхигдсон салбар хэвээр байна.

Гэтэл гэр бүлийн харилцаанд өмч чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд гэрлэгчийн гэр бүлийн хөрөнгө (дундын (англ.*community property*) болон дангаар өмч (англ.*separate property*))-ийн талаарх өмчийн эрх зүйн статус, хөрөнгийг удирдах (ашиглах, захиран зарцуулах) үйл явц, гэрлэгчийн ашиг сонирхлын үүднээс тогтоож болох хязгаарлалт, гуравдагч этгээд (зээлдүүлэгч, бусад үүрэг гүйцэтгүүлэгч)-ийн өмнө хүлээх хариуцлага, өмчийн харилцаа дуусгавар болсноор хөрөнгийг хуваах журам зэргийг агуулсан цогц хэм хэмжээг гэр бүлийн хөрөнгийн зохицуулалт гэнэ.¹

Өөр хоорондоо зөрчилдөж болзошгүй ашиг сонирхлын тэнцвэрт байдлыг хангахад гэр бүлийн хөрөнгийн зохицуулалтын зорилго оршино.² Гэр бүлийн хөрөнгийн харилцаанд гэрлэгчийн хувийн ба гэр бүлийн нийтлэг ашиг сонирхол, нөхрийн ба эхнэрийн ашиг сонирхол, гэрлэгчдийн ба гуравдагч этгээд (үүрэг гүйцэтгүүлэгч, өвлөгч)-ийн ашиг сонирхол харилцан зөрчилдөх явдал гарна.

Гэр бүлийн хөрөнгийн харилцаанд гэрлэгчийн дангаар өмчлөх эрх, гэрлэгчдийн дундаа өмчлөх эрхийн аль аль хэлбэр багтах тул ганц төрлийг нь онцгойлон авч гэр бүлийн хөрөнгө гэж үзэн хуульчлах боломжгүй.

Гэр бүлийн хөрөнгийн харилцааг хууль болон гэрлэлтийн гэрээ гэсэн эрх зүйн эх сурвалжаар зохицуулна. Иргэний хуулийн 125.1, 132.1-д Гэрлэгчид гэрлэгч тус бүрээс өрхийн төсөв, зардлыг хариуцах журам, гэрлэлтийг цуцалсан нөхцөлд ногдох хөрөнгийг тодорхойлох, хөрөнгийн эрхтэй холбогдсон бусад нөхцөлийг энэ хуульд нийцүүлэн байгуулсан гэрээний үндсэн дээр зохицуулж болохоор заасан ба энэ нь гэрлэлтийн харилцаанд хөрөнгийн эрхийн асуудлыг гэрээгээр буюу үүргийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулахыг зөвшөөрсөн хэм хэмжээ юм.

Тус илтгэлийн хүрээнд гэр бүлийн хөрөнгийн талаарх хуулийн зохицуулалтыг авч үзэх бөгөөд нэгдсэн тоо баримт гарах боломжгүй хэдий ч гэрлэлтийн гэрээгээр өмчийн харилцааг зохицуулсан тохиолдол Монгол Улсад төдийлөн түгээмэл биш нь олон жилийн шүүхийн практикаас илэрхий юм.

II. ГЭР БҮЛИЙН ХӨРӨНГӨ БА ДУНДЫН ӨМЧ

Өмнө дурдсанчлан гэр бүлийн хөрөнгө нь гэр бүлийн гишүүний дангаар өмчлөлийн төдийгүй дундын өмчийн харилцааг агуулдаг онцлогтой. Эдийн

1 Kai Kullerkupp, “Statutory marital property Law de lege lata and de lege ferenda”, 2001, https://www.juridicainternational.eu/public/pdf/ji_2001_VI_78.pdf

2 Ibid.

баялгийн бүрэн эрх буюу өмчлөх эрхийн талаарх онолын ойлголт, өмчлөл ба эзэмшлийн талаарх эрх зүйн бүл, уламжлал хоорондын ялгаа заагийг дотоодын судлаачид харьцангуй нухацтай авч үзэх болсон хэдий ч дундын өмчийн талаарх судалгаа төдийлөн түгээмэл биш байгаа нь гэр бүлийн хөрөнгийн талаарх зохицуулалтын боловсронгуй бус байдалд нөлөөлөх юм.

2.1 Гэр бүлийн дундын өмчийн тухай ерөнхий ойлголт

Иргэний хуулийн 126.1-д гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болсон гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгөөс бусад хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч байхаар заасан. Үүнээс үзвэл гэр бүлийн гишүүдийн дундын өмч нь мөн хуулийн 108.1-д заасан хамтран өмчлөх дундын өмчид хамаарна гэж үзэхээр байна. Гэр бүлийн харилцаанд хэсгээр өмчлөх дундын өмчийн хэлбэрийг бус, хамтран өмчлөх хэлбэрийг баримталж байгаа нь гэр бүл хэмээх нийгмийн суурь нэгжийн онцлогтой холбоотой. Хэсгээр (англ. *co-ownership*) ба хамтран өмчлөл (англ. *joint ownership*)-ийн ялгаа нь эдгээр эд хөрөнгийн талаарх өмчлөгчдийн эрх хэмжээ буюу хөрөнгийг ашиглах, захиран зарцуулах дүрэм журмаар илрэх бөгөөд гэр бүлийн харилцаанд өмчлөгч бүр дундын өмчийн зүйлийг бүхэлд нь ашиглах, хэрэглэх эрх эдэлж, нөгөө өмчлөгчийн эрх бусад өмчлөгчийн дундын өмчийн эрхээр хязгаарлагддагаараа хамтран өмчлөх дундын өмч илүүтэй тохирно гэж үзэх хандлага тогтжээ.

Хэсгээр өмчлөх дундын өмчийн өмчлөгчийн хувь хэмжээ тодорхой байж, өмчлөгч дундын өмчийн харилцаанаас аливаа шалтгаан, үндэслэл дурдахгүйгээр хэзээ ч гарах буюу дундын өмчийг дуусгавар болгох боломжтой. Түүнчлэн хэсгээр өмчлөх дундын өмчийн үед өмчлөгч өөрт ногдох хэсгээ бусад өмчлөгчдийн зөвшөөрөлгүйгээр худалдах, захиран зарцуулах боломжтой байдаг бол хамтран өмчлөх дундын өмчийн харилцаанд өмчлөгчийн дээрх эрх харьцангуй хязгаарлагдмал байна. Дундын өмчийг ашиглах, удирдах хязгаарлах хандлагатай хамтран өмчлөх дундын өмчийн төрөлд гэр бүлийн хөрөнгийг хамаатуулах нь гэр бүлийн эдийн засгийн баталгааг бэхжүүлэх, эд хөрөнгө найдвартай байж, гэрлэгч хэн нэгний, цаашилбал хүүхдийн эрх ашиг зөрчигдөхгүй байх баталгааг хангах зорилготой.

Гэвч гэр бүлийн хөрөнгийг хамтран өмчлөх дундын өмч гэж хуульчлан, гэр бүлийн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулахгүй байх, энэ хэлбэрийг зөрчсөн хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзэх тухай Иргэний хуулийн 128.2, 128.3-т заасан зохицуулалтыг гагцхүү гэрлэгчдийн хооронд хэрэглэх замаар үгүйсгэх шүүхийн практик тогтож эхэлснээр дээрх зорилго зарим талаар алдагдах болсон.

Манай улстай төстэй эрх зүйн бүлийн зарим улсад гэр бүлийн хөрөнгийг дундын өмчийн аль нэг хэлбэрт шууд хамааруулахаас зайлсхийх хандлага ажиглагдах болсон. Тухайлбал, Эстони Улс 1995 онд баталсан Гэр бүлийн тухай хуулиа 2001 онд шинэчлэн найруулах явцдаа гэр бүлийн хөрөнгийг дундын хөрөнгийн аль нэг хэлбэрт шууд хамааруулахгүйгээр гэрлэгчид гэр бүл болсноос хойш бий болсон бүх хөрөнгөд тэнцүү эрх эдлэх бөгөөд гэрлэлт дуусгавар болох үед гэрлэгчид хуваарьт хөрөнгөө болон дундын хөрөнгийн тал хувийг хүртсэн ч ийнхүү хуваасан нь шударга бус гэж үзэж байгаа бол бие биедээ үүргийн

эрх зүйн журмаар нэхэмжлэл гаргах боломжтой байхаар зохицуулсан байна.³ Ийнхүү гэрлэгчдийн хөрөнгийг хамтран өмчлөх дундын өмчийн төрөлд шууд хамааруулаагүйгээрээ гэрлэснээс хойш бий болсон аливаа хөрөнгийг бүхэлд нь хамтын өмч гэж үзсэнээс бий болдог эрсдэл, гэрлэгчдийн дундын өмчөөр гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага, гэрлэгч хэн нэгний эрхэлж байгаа бизнестэй холбоотой хөрөнгийн зааг тогтоох хүндрэлүүдээс сэргийлэх боломжтой гэж үзжээ. Гэрлэгчдийн хөрөнгийг ингэж өөрчлөн загварчилсныг “Off set claim”⁴ буюу “Тооцон шаардах эрх” гэж нэрлэсэн байна.

2.2 Жишгийн эрх зүй дэх дундын өмч ба гэр бүлийн хөрөнгө

Жишгийн эрх зүйн тогтолцооны улсуудад дундын өмчийн дараах төрөл бий гэж үздэг. Үүнд:

1. Хэсгээр өмчлөх (англ. *Tenancies in common*),
2. Хамтран өмчлөх (англ. *Joint tenancies*),
3. Бүхэлд нь өмчлөх (англ. *Tenancies by the entirety*),
4. Нөхөрлөл хэлбэрээр өмчлөх (англ. *Tenancies in partnership*)⁵.

Хэдийгээр хэсгээр ба хамтран өмчлөл гэх эх газрын системтэй адил нэр томъёог хэрэглэсэн боловч агуулгын хувьд эдгээр нь эх газрын эрх зүйн бүлийн улсын хэсгээр ба хамтран өмчлөлийн хэлбэрээс ялгаатай ойлголт.

2.2.1 Жишгийн эрх зүй дэх хэсгээр өмчлөл (*Tenancies in common*)

Хэсгээр өмчлөх хэлбэрийн үед өмчлөгч бүр эд хөрөнгийн тодорхой хувийг өмчлөх эрхтэй байдаг. Энэ төрлийн өмчлөгчид тэгш ба тэгш бус аль ч хэсгээр эд хөрөнгийг дундаа өмчилж болно. Жишээ нь, хоёр өмчлөгч газрыг тал талаар нь тэнцүү хуваан өмчилж болно, эсхүл нэг нь гуравны нэгийг нөгөө нь гуравны хоёрыг өмчлөх эрхтэй байж болно.⁶ Энэ хэлбэрээр өмчлөгчид өөр цаг хугацаанд өмчлөх эрхийг олж авч болохын зэрэгцээ өмчлөх эрхээ өмчлөгч амьд байх хугацаандаа, эсхүл өв залгамжлалаар бусад шилжүүлж болно. Хэсгээр өмчлөх үед өмчлөгч тус бүр эд хөрөнгийг эн тэнцүү эзэмших эрхтэй байна. Хэрэв нэг өмчлөгч эзэмших онцгой эрхтэй бөгөөд бусад өмчлөгчид эзэмшлийн тэнцүү эрхээ хэрэгжүүлэх боломжгүй бол тэдгээрт төлбөр төлөх үүрэгтэй.

2.2.2 Жишгийн эрх зүй дэх хамтран өмчлөл (*Joint tenancies*)

Энэ нь оролцогч талууд ижил тэнцүү хувиар өмчлөх ба “амьд байгаа нь өмчлөх” зарчим (англ. *survivorship*)-ыг баримтлах онцгой эрхтэй өмчлөх эрхийн төрөл юм. Жишээ нь нэг өмчлөгч нас барснаар түүний өмчлөх эрх нөгөө өмчлөгчид шилжих ба хамтын өмчлөлийн зүйл тухайн өмчлөгчийг нас барснаар өв залгамжлалаар бусад этгээдэд шилжих боломжгүй.

³ Kai Kullerkupp, *Supra* note 1

⁴ *Ibid.*

⁵ Marianne M. Jennings, *Real Estate Law, South-Western*, (Cengage Learning press, 2011), 155.

⁶ *Ibid.*

Жишгийн эрх зүйн тогтолцоонд хамтран өмчлөх дундын өмч үүсэхэд дараах 4 төрлийн нэгдмэл байдлын шаардлага тавигдах ба эдгээрийг хамтын өмчлөлийн элемент буюу хамтын өмчлөлийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлнө гэж үздэг. Үүнд:⁷

а. Цаг хугацааны нэгдмэл байдал: Хамтран өмчлөгчид эд хөрөнгийг цаг хугацааны хувьд нэгэн зэрэг өмчилсөн байна. Жишээ нь, О газар өмчлөх эрхээ А болон Б нарт 2009.12.30-ны өдөр шилжүүлснээр өмчлөх эрхийг нэгэн зэрэг олж авч, А болон Б нар цаг хугацааны нэгдмэл байх шаардлагыг хангаж байна Хэрэв О 2009.12.30-нд А-д, 2010.06.30-нд Б-д шилжүүлэхээр заасан бол тэдгээр нь өмчлөх эрхийг ялгаатай цаг мөчид олж авсан үндэслэлээр хэсгээр өмчлөгчид болох бөгөөд хамтын өмчлөл үүсэх боломжгүй юм.

б. Эрхийн нэгдмэл байдал: Хамтын өмчлөлөөр эрх шилжүүлсэн этгээд нь нэг этгээд байхыг шаарддаг. Өөрөөр хэлбэл хамтран өмчлөгчид нь нэг этгээдээс эрх шилжүүлж авсан байх ёстой. Жишээ нь, О нь А болон Б-д хамтын өмчлөлөөр газар шилжүүлсэн байна. Энэ тохиолдолд А болон Б нар нэг этгээдээс нэгэн зэрэг эрх шилжүүлж авсан тул хамтран өмчлөгч мөн. Хэрэв А энэ эрхээ С-д шилжүүлсэн бол С нь хамтран өмчлөгч биш, хэсгээр өмчлөгч болно. Учир нь Б өөрийн эрхийг О-оос олж авсан бол С өөрийн эрхийг А-аас олж авсан.

с. Ашиг сонирхлын нэгдмэл байдал: Энэ шаардлагын дагуу хамтран өмчлөгчид эд хөрөнгөд тэнцүү хэмжээгээр ашиг сонирхолтой байна. Тухайлбал А болон Б нар эд хөрөнгийг 50, 50 хувиар хамтран эзэмшинэ. Хэрэв А 1/3 –ийг Б 2/3-ийг эзэмшдэг бол энэ өмчлөлийг хэсгээр өмчлөл гэж үзнэ.

д. Эзэмшлийн нэгдмэл байдал: Энэхүү шаардлага нь хэсгээр өмчлөлд ч мөн нэгэн адил хамаарна. Энэ шаардлагын дагуу талууд эд хөрөнгийг эзэмших ижил тэнцүү эрхтэй байна. Нэг тал газрын бусад хэсгийг эзэмшихгүй байх тухай ойлголт байх боломжгүй. Хэрэв тухайн газар болон газрын эрх газарзүйн, эсхүл цаг хугацааны хувьд (одоогийн болон ирээдүйн эрх) хуваагдаж байвал талуудыг дундаа өмчлөгч гэж үзэхгүй. Учир нь эзэмшлийн нэгдмэл байдал алдагдана.

2.2.3 Жишгийн эрх зүй дэх бүхэлд нь өмчлөх эрх (*Tenancies by the entirety*)

Бүхэлд нь өмчлөх эрх нь дээр дурдсан нэгдмэл байдлын 4 элементээс гадна нэмэлт элемент болох өмчлөгчийн нэгдмэл байдлыг давхар шаардана.⁸ Энэхүү нэмэлт элемент нь эрхийг эзэмшигчид гэрлэсэн байхыг шаардах ба амьд үлдсэн нь өмчлөх эрхийг олж авах боломж олгогддоогоороо онцлог эрх юм. Өөрөөр хэлбэл, гэрлэгчид гэрээслэлээр эд хөрөнгийг бусдад шилжүүлэх боломжгүй.

2.2.4 Жишгийн эрх зүй дэх нөхөрлөл хэлбэрээр өмчлөх эрх (*Tenancies in partnership*)

Нөхөрлөлийн гишүүд нөхөрлөлд хувь хөрөнгөө оруулснаар, эсхүл нөхөрлөлийн хөрөнгөөр эд хөрөнгө шинээр худалдан авснаар нөхөрлөлийн

7 William E. Francis, “Joint tenancy and Tenancy by the Entirety, Four unities requirement”, Kentucky Law Journal, Volume 36, Issue 2, 203.

8 Kai Kullerkupp, Supra note 1, 160.

хэлбэрээр өмчлөх эрх үүснэ. Нөхөрлөлийн гишүүдийг тухайн эд хөрөнгийг дундаа өмчлөгч, эсхүл нөхөрлөлийн хэлбэрээр өмчлөгч гэж үздэг. Нөхөрлөлийн хэлбэрээр өмчлөх эрх нь хамтран өмчлөлийн шинжийг агуулна. Түншлэгч нэг этгээд нас барснаар түүний өмчлөлд байсан хувийг бусад түншлэгчид олж авах эрхтэй. Хууль ёсоор болон гэрээслэлээр өвлөгчид нь нөхөрлөлийн хэлбэрээр өмчлөх эд хөрөнгийн хувьд аливаа эрхгүй хэдий ч нас барсан түншлэгчид оногдох хувийн үнэ цэнэд тохирсон хариу төлбөрийг шаардах эрхтэй байж болно.

Хэдийгээр муж улс тус бүрт өөр өөр хэдий ч нөхөрлөлийн хэлбэрээр өмчлөх эрхийн хувьд өмчлөгчид бүгд эд хөрөнгийг бүхэлд нь өмчлөх эрхтэй байдаг онцлогтой. Түншлэгч тус бүр нөхөрлөлийн зорилгоор эд хөрөнгийг эзэмших, ашиглах эрхтэй ба нэг түншлэгч нөгөөгийн, эсхүл нөхөрлөлийн эзэмшлийг дуусгавар болгох эрхгүй. Олон муж улсуудын хувьд нөхөрлөлийн эд хөрөнгийг бусдад шилжүүлэхэд бүх түншлэгчийн гарын үсэг шаардлагатай байдаг.

2.2.5 Жишгийн эрх зүй дэх гэр бүлийн хөрөнгө

Жишгийн эрх зүй дэх гэр бүлийн хөрөнгө нь зарим нэг нэмэлт зохицуулалтыг эс тооцвол дээр дурдсан бүхэлд нь дундаа өмчлөх эрхийн хэлбэр юм. Гэр бүлийн хөрөнгийн нэмэлт зохицуулалт гэдэгт бэлэвсэн эхнэрийн эрх буюу dower right, бэлэвсэн нөхрийн эрх буюу curtesy right гэх эрхүүдийг АНУ-ын зарим мужуудад хуульчилж өгсөн байдаг.

Dower right нь бэлэвсэрч үлдсэн эхнэрийг хамгаалах зорилготой бол curtesy right нь бэлэвсэн нөхрийг хамгаалах агуулгатай. Жишгийн эрх зүйд бэлэвсэн эхнэр гэрлэлтийн хугацаанд нөхрийн өмчилж байсан бүх, эсхүл аль нэг үл хөдлөх эд хөрөнгийн 1/3-ийг насан туршдаа өмчлөх эрхтэй гэж үзнэ. Олон муж улсад энэ эрхийг нэг мөр хэрэглэгддэг байх үүднээс “амьд үлдэгчийн эрх буюу surviving spouse’s right” гэх агуулгаар ойлгож, нас барагчийн бүх хөрөнгө гэдэгт гагцхүү үл хөдлөх эд хөрөнгө бус, бусад хөрөнгийг ч хамааруулан ойлгож байна. Түүнчлэн зарим муж улсад амьд үлдсэн гэрлэгчид зайлшгүй үлдвэл зохих хөрөнгө буюу минимум дүнг тогтоох явдал ч байх ба энэ нь ихэнхдээ орон байр, зарим амин хувийн хөрөнгө, амьдрах тэтгэмж, тээврийн хэрэгслийг ойлгодог. Энэхүү зайлшгүй үлдэх хөрөнгийг нас барагчийн хөрөнгийг хуваах, түүнд холбогдох үүргийг гүйцэтгэхээс өмнө тодорхойлдог.

Цааш үргэлжлүүлэн ажиглавал жишгийн эрх зүй дэх гэр бүлийн хөрөнгийн загвар Эстони Улсын гэр бүлийн хөрөнгийн шинэчилсэн загвартай нэлээд төстэй байна. Тодруулбал, жишгийн эрх зүйн бүхлээр өмчлөх эрх нь хамтран өмчлөх эрхийн нэгдмэл байдлын дөрвөн шалгуурыг зэрэг хангах ёстой ба уг шалгуурт ашиг сонирхлын нэгдмэл байдал болох өмчийн зүйлийн тухайд өмчлөгчид адил тэнцүү эрх эдлэх шалгуур хамаарч байна. Улмаар уг шалгуурт бүхэлд нь өмчлөх эрхийн нэмэлт шалгуур болох өмчлөгч нэгдмэл байх шалгуур тавигдаж байх ба энэ нь амьд үлдэгчийн эрх ашгийг дээгүүр тавьсан онцлогтой байна. Эдгээр шинжийг анхаарч үзвэл Эстонийн шинэчилсэн загварын дагуу гэрлэгчид хувь хувьдаа бие даасан хуваарьт хөрөнгөтэй байж болох ч дундын хөрөнгийн хувьд адил тэнцүү 50:50 хувийг өмчлөх үндсэн дүрэмтэй төстэй гэж үзэхээр байна.

Эдгээр улс орны зохицуулалтыг ерөнхийд нь авч үзвэл Монгол Улсад байхгүй

гэж хэлж болох хоёр нийтлэг хандлага байгааг анзаарч болно. Үүнд:

1. Гэр бүлийн хөрөнгийг гагцхүү гэрлэгчдийн хөрөнгө гэж үзэх
2. Гэрлэгчийн хэн нэг нь нас барснаар гэр бүлийн хөрөнгийг хуваах үед амьд үлдсэн гэрлэгчийн эрх ашгийг хамгаалах үзэл санаа (survivorship) илэрхий байна.

III. МОНГОЛ УЛСЫН ГЭР БҮЛИЙН ХӨРӨНГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ

3.1 Гэр бүлийн хөрөнгийн өмчлөгч

Монгол Улсын Иргэний хууль нь Нийтлэг үндэслэл, Үүрэг, Гэрээний эрх зүй, Гэрээний бус үүрэг, Өвлөх, Олон улсын иргэний эрх зүй гэх зургаан үндсэн хэсгээс бүрдэнэ. Гэр бүлийн хөрөнгийн эрх зүйн зохицуулалт нь Нийтлэг үндэслэл буюу нэгдүгээр хэсэгт хамаарах Эдийн болон эдийн бус баялгийн эрх гэх тавдугаар дэд хэсэг дэх Өмч гэсэн арван хоёрдугаар бүлэгт багтсан ба нийт 9 зүйл, 29 заалт, 15 хэсгээс бүрдэж байна.

Иргэний хуулийн 125.1-д “гэр бүлийн хөрөнгө” гэх ойлголтыг тодорхойлж, энэ нь гэрлэгчдийн хөрөнгө, гэр бүлийн бусад гишүүдийн хөрөнгөөс бүрдэхээр заажээ. Энэ тодорхойлолтоос гэр бүлийн хөрөнгийн объектив шинжийг мэдэх боломжгүй, харин гэр бүлийн хөрөнгө хэний мэдэлд байж болохыг ойлгох боломжтой. Энэ зохицуулалтаас манай улсын гэр бүлийн хөрөнгийн зохицуулалтын олон улсад тогтсон нийтлэг жишгээс ялгагдах онцлог болох гэр бүлийн хөрөнгө дан ганц гэрлэгчдэд бус гэр бүлийн бусад гишүүдэд ч хамаатай болохыг анзаарч болно.

Иргэний хуулийн 129.2-т Гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийн хэмжээ нь насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнийг оролцуулан нийт гишүүдэд адил байхаар зааснаас үзвэл гэр бүлийн бусад гишүүд гэдэгт насанд хүрээгүй хүүхдүүд, насанд хүрсэн ч хөдөлмөрийн чадваргүй бусад хүмүүс багтахыг анзаарч болно. Түүнчлэн дээрх заалтын “оролцуулан” гэх томъёолол гэр бүлийн бусад гишүүд нь гагцхүү насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй этгээдээр хязгаарлагдахгүй байх боломжтойг илтгэх ба гагцхүү гэр бүлийн бусад гишүүдээс насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй хүнийг онцгойлон дурдсан байж болох юм.

Эндээс Монгол Улсын гэр бүлийн хөрөнгийн зохицуулалт нь өмчлөгчийн өргөжүүлсэн бүрэлдэхүүнтэй анзаарч болно. Энэ онцлогоос шалтгаалан хууль хэрэглээний олон асуултууд урган гардаг. Тухайлбал:

- а) гэр бүлийн хөрөнгөөс ногдох хувь шаардах эрх бүхий “хүүхэд” гэх ойлголтыг хэрхэн тодорхойлох, (Хоёр хандлага байж болно: 1. Хүүхэд ба насанд хүрэгч, 2. Эцэг, эх ба хүүхэд);
- б) гэрлэгчдийн асрамжид байгаа хүмүүсийн хүрээ, хамаарлыг хэрхэн тогтоох, энэ хүрээний асрамжийг өв залгамжлалын эрх зүй, гэр бүлийн талаарх уламжлалт ойлголт, асран хамгаалал, харгалзан дэмжих ойлголттой хэрхэн уялдуулах;

в) гэр бүлийн хөрөнгөд үүссэн үүргийг гэр бүлийн бусад гишүүдэд, тэр дундаа насанд хүрээгүй гишүүнд хэрхэн хуваарилах гэх мэт асуудлууд урган гардаг.

Бусад улс оронд гэр бүлийн хөрөнгийг гагцхүү гэрлэгчдийн дунд хуваах зарчим нийтлэг үйлчилдэгтэй холбоотойгоор дээрх асуудлууд тулгардаггүй байх боломжтой. Харин манай улсын зарим судлаач, шүүгч энэхүү онцлог зохицуулалтыг нүүдлийн соёлоос улбаатай гэр бүлийн харилцаа, хамтын аж ахуй дахь өрхийн гишүүн бүрийн оролцоотой холбон тайлбарлах хандлага бий. Хувийн эрх зүйн бусад салбаруудтай харьцуулбал гэр бүлийн болон өв залгамжлалын эрх зүй манай улсын өвөрмөц онцлогийг илүүтэй шингээсэн салбар эрх зүй болохыг эндээс харж болох юм.

3.2 Иргэний хууль дахь гэр бүлийн хөрөнгө

Иргэний хуульд “гэр бүлийн хөрөнгө”, “гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгө” гэх хоёр ойлголт зэрэгцэн хэрэглэгддэг ба эдгээр концепцын агуулга, ялгааг хуулийн зохицуулалтаас тогтооход бэрх. Гэр бүлийн хөрөнгө нь агуулгын хувьд дундын өмч мөн хэдий ч өөрийн өвөрмөц зохицуулалттай байж болохыг хүлээн зөвшөөрөх байдлаар шүүхийн практикийг хөгжүүлбэл зохино.

Манай улсын хууль тогтоомж дахь дундын өмчийн “хэсгээр” ба “хамтран” гэх төрлүүдийн үндсэн ялгаа тодорхой бус, бүрхэг байдаг нь гэр бүлийн хөрөнгийн зохицуулалтын онцлогийг тодорхойлоход хүндрэл үүсгэж байна. Өөрөөр хэлбэл, суурь ойлголтууд танин мэдэхүйн түвшинд бүрэн судлагдаагүй, концепцын хөгжил сул байгаагаас хэм хэмжээний зохицуулалтыг боловсронгуй болгож чадахгүй байна. Улмаар энэ нь хууль хэрэглээний нэгдмэл байдалд сөргөөр нөлөөлж байгаа нь гарцаагүй. Жишээ нь гэр бүлийн хөрөнгийг өмчлөх эрх бүхий этгээд нь гэрлэгчээс гадна гэр бүлийн бусад гишүүд байхаар заасан. Нөгөө талаас гэр бүлийн хөрөнгийг хамтран өмчлөх дундын өмч байхаар хуульчилсан. Гэтэл гэр бүлийн дундын хөрөнгийг захиран зарцуулах, ногдол хэсгийг хуваах, өр үүргийг хариуцуулахад хамтран өмчлөх дундын өмчийн хатуу хязгаарлалт, бүрхэг бус зохицуулалт улам бүр төвөгтэй байдал үүсгэж байна. Иймд гэр бүлийн хөрөнгө дэх дундын өмчийн харилцааг хэсгээр, эсхүл хамтран өмчлөлийн аль нэг төрөлд шууд хамаатуулалгүйгээр, гэр бүлийн хөрөнгө гэх ойлголтоор нь бие даан хөгжүүлж, Монголын ахуй соёл, гэр бүлийн харилцааны онцлогийг таньсан зохицуулалтыг бий болгон, дахин загварчлах шаардлага бий болжээ.

3.3 Гэр бүлийн хөрөнгийг хуваах, ногдох хэсгийг тодорхойлох

Иргэний хуулийн 129 дүгээр зүйлээр гэр бүлийн хамтран өмчлөх дундын өмчөөс гэр бүлийн гишүүдэд ногдох хэсгийг тодорхойлох үндэслэл, зарчмыг тогтоосон. Тодруулбал дараах үндэслэлээр гэр бүлийн хөрөнгийг хуваана:

1. Гэр бүлийн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарах бол
2. Гэрлэгчдээс төлбөр гаргуулах үед түүний хуваарьт хөрөнгө хүрэлцэхгүй байгаа бол
3. Гэр бүлийн бусад гишүүнээс төлбөр гаргуулах бол
4. Гэр бүлийн гишүүн нас барснаар өв нээгдсэн бол.

Гэвч дээрхээс гадна мөн хуулийн 130.1-д гэр бүлийн хөрөнгийг хуваах талаар зохицуулсан. Энэ заалтын дагуу гэрлэгчдийн хэн нэгний буюу гэр бүлийн насанд хүрсэн гишүүний шаардлагаар

1. Гэрлэлт хүчин төгөлдөр байх хугацаанд,
2. Гэрлэлт цуцалсны дараа,
3. Гэр бүлийн гишүүн хэн нэгний хуваарьт хөрөнгө төлбөр гаргуулахад хүрэлцэхгүй бол гэх гурван үндэслэлээр гэр бүлийн хөрөнгийг хуваахаар заасан байна.

Иргэний хуулийн 129 дүгээр зүйл нь “Гэр бүлийн хамтран өмчлөх эд хөрөнгөөс гишүүнд ногдох хэсгийг тодорхойлох” гэх нэртэй бол мөн хуулийн 130 дугаар зүйл “Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмчийг хуваах” гэсэн нэртэй байх ба эдгээр заалтыг анзаарга муутай уншвал дундын хөрөнгөөс гишүүнд ногдох хэсгийг тодорхойлох харилцааг хуваах үндэслэлээс тусдаа томъёолсон шалтгаан ойлгомжгүй санагдана.

Энэ хоёр зүйлийг нэг нь нөгөөгөөс үл хамаарах харилцаа мэтээр салангид хэрэглэхэд бэрх. Жишээ нь, Иргэний хуулийн 129.1.1-д заасан гэр бүлийн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарах үндэслэл нь мөн хуулийн 130.1-д заасан гэрлэлт хүчин төгөлдөр байх, эсхүл гэрлэлт цуцлах аль ч цаг хугацаанд хамаарч болохоор байдаг бол, гэрлэлтийн хүчин төгөлдөр байдлыг хадгалж, гэр бүлийн хөрөнгөөс ногдох хэсгээ тодорхойлуулах шаардлага аль нэг гэрлэгч, эсхүл гэр бүлийн бусад гишүүн хувийн хөрөнгөөрөө төлбөрөө хариуцах чадваргүй болох зэрэг нөхцөл бүрдсэн үед үүсэх боломжтой.

Гэвч өмнө дурдсанчлан гэр бүлийн хөрөнгийг өмчлөх эрх бүхий этгээдийн цар хүрээг өргөжүүлсэнтэй холбоотойгоор Иргэний хуулийн 129.1-д заасан үндэслэл тус бүрийн агуулгыг зөв, нэг мөр тодорхойлоход ихээхэн хүндрэл үүсдэг. Жишээ нь, гэр бүлийн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарах гэх ойлголтыг оновчтой тайлбарлахад анхаарах шаардлагатай. Мэдээж хэрэг гэрлэгчдийн хэн нэгэнд гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарах асуудлыг хамаатуулах нь ойлгомжгүй мэт санагдана. Учир нь ийм асуудал яригдвал зүй нь “гэрлэлт цуцлах” харилцаа гэж үзэх үндэслэл бүрдэнэ.

Гэвч нөгөө талаас гэрлэгчдийн хэн нэгний хүсэлтээр гэрлэлтийг дуусгавар болгосон ч хүүхэд ба эцэг, эсхүл хүүхэд ба эх гэх бүрэлдэхүүнтэй “өрх” буюу “гэр бүл” оршсоор байх тул магадгүй энэ үндэслэлээр хууль тогтоогч “гэр бүлийн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарах” ойлголтод “гэрлэлт цуцлах”-ыг ч хамаатуулсан байх боломжтой. Учир нь гэрлэлт цуцалснаар гэр бүлийн хөрөнгийг хуваах, ногдол хэсгийг тооцох тухай тусдаа үндэслэл хуулийн хаа нэгтээ байхгүй байна.

Иймд хуулийн 130.1-д заасан “гэрлэлт цуцалсны дараа” гэх ойлголтыг түүний өмнөх хэсэг болох “гэрлэлт хүчин төгөлдөр байх хугацаанд” гэх ойлголттой хамтад нь авч үзвэл энэ нь дундын хөрөнгийг хуваах цаг хугацааг илэрхийлсэн буюу гэр бүлийн хөрөнгийг гэрлэлт цуцлах үетэй давхцуулахаас гадна цуцалснаас хойш тодорхой хугацааны дараа ч хувааж болохыг илтгэсэн байх боломжтой.

Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 130.1-д заасан “гэрлэлт цуцалсны дараа” гэдэг нь бие даасан үндэслэл бус харин гэрлэгчид хүсвэл гэрлэлт цуцалснаас хойш тодорхой хугацааны дараа, эсхүл гэрлэлтийг хүчин төгөлдөр байх хугацаанд ч гэр бүлийн хөрөнгөө хувааж болох санааг илтгэсэн гэж үзэхээр байна. Эндээс гэрлэлт цуцалснаар хөрөнгө хуваагдах үндэслэл нь Иргэний хуулийн 129.1.1-д, харин цуцлах үед хуваах, эсхүл цуцалсны дараа хуваах сонголт нь гэрлэгчийн хүсэл зоригоос хамаарч болохыг хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэг хэлсэн байж болох юм.

Харин хуулийн 130.1 дэх хэсгийн гэр бүлийн гишүүн хэн нэгний хуваарьт хөрөнгө төлбөр гаргуулахад хүрэлцэхгүй бол гэх үндэслэл нь хуулийн 129.1.1-д заасан гэрлэгчдээс төлбөр гаргуулах үед түүний хуваарьт хөрөнгө хүрэлцэхгүй байгаа бол, гэр бүлийн бусад гишүүнээс төлбөр гаргуулах бол гэх хоёр үндэслэлтэй давхцаж байна. Хуулийн 130.1-д заасан дээрх үндэслэлийг энэ заалтын өмнөх хоёр үндэслэлийн нэгэн адил цаг хугацааг илтгэсэн гэж хэлэхэд хэцүү. Ямартай ч хуулийн 129.1.1 дэх хэсэгт заасан хоёр үндэслэлийг тодруулсан, дэмжсэн агуулга байгааг анзаарч болно.

Энэ мэтчилэн хөрөнгө хуваах хууль зүйн үндэслэлийг гэрлэлт цуцлалт, хөрөнгийн харилцааг дуусгавар болгох хүсэлт (гэр бүлээс гарах, өөрийн төлбөрийг хариуцах), гэрлэлтийг хүчин төгөлдөр бусд тооцох, гэрлэгч нас барах гэх агуулгаар тодорхой хуульчлах шаардлага байх ба энэ үндэслэлээр гэрлэлт хүчинтэй байхад, эсхүл цуцлах үед, эсхүл цуцалсны дараа хуваах байдлаар томьёолж хөрөнгө хуваах үндэслэл, хэрэгжих цаг хугацааг ялган зааглан цэгцтэй зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

Түүнчлэн гэр бүлийн хөрөнгийг гэрлэгчдээс гадна гэр бүлийн бусад гишүүдэд хуваах тухай хууль тогтоогчийн үзэл баримтлал нь дан ганц гэрлэгчийн ногдол хувьд нөлөөлөхөөс гадна гэр бүлээс гарах, үл хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулах зөвшөөрөл олгох, хөрөнгө хуваах шаардлага гаргах эрхийг хэрэгжүүлэх гэх мэт хууль зүйн бусад харилцаанд нөлөөлж, эдгээр асуудлыг хэрхэн тайлбарлан хэрэглэх явдлыг илүү төвөгтэй болгох үр дагавартай. Иймд энэ зохицуулалтын нөлөөг тухайн харилцаа бүрт зураглан тодорхойлж, үр дагаврыг зохицуулсан хууль тогтоогчийн шийдэл шаардлагатай байна.

IV. ГЭР БҮЛИЙН ХӨРӨНГӨТЭЙ ХОЛБООТОЙ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИК

Тус судалгааны явцад “гэрлэлт цуцлах”, “гэр бүлийн дундын хөрөнгө”, “дундын өмч”, “гэр бүлийн хөрөнгө”, Иргэний хуулийн зарим зүйл, заалтын дугаарыг түлхүүр үгээр сонгон шүүхийн шийдвэрийн цахим сангаас хайлт хийхэд илэрсэн, сүүлийн 3 жил (2021 оноос өмнөх хугацааны УДШ-ийн цөөн тооны тогтоолыг судалсныг эс тооцвол)-ийн хугацааны анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн 70 орчим шийдвэрт анализ хийлээ. Гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүхийн нийтлэг практик, онцлог хэрэглээ, хууль хэрэглээний нэгдмэл байдалд тулгарч буй хүндрэл бэрхшээлийн шалтгаан, үндэслэлийн нэлээд хэсэг нь гэр бүлийн хөрөнгөөс хувь хүртэх эрх бүхий гишүүдийн хүрээг өргөжүүлэн тогтоосон манай улсын онцлогтой холбоотой байна.

Тодруулбал, гэр бүлийн дундын хөрөнгийг захиран зарцуулахад гэрлэгчээс гадна гэр бүлийн насанд хүрсэн бусад гишүүдийн зөвшөөрлийг бичгээр авсан байх, дундын хөрөнгийг хуваах үндэслэл бүрдсэн эсэхийг тогтоох, дундын хөрөнгийг хуваах үед насанд хүрсэн гишүүдийг хэрхэн ялган зааглах, гэр бүлийн гишүүн бүрт ногдох хэсгийг хэрхэн тодорхойлох, гэр бүлийн хөрөнгөд хамаарах үүрэг, өрийг гэрлэгч ба бусад гишүүдэд хэрхэн хариуцуулах гэх мэт олон асуудалд гэр бүлийн гишүүдийн цар хүрээг тогтоосон байдал нөлөөлж байна.

4.1 Хөрөнгийг захиран зарцуулах зөвшөөрөл авсан байх шаардлага

Иргэний хуулийн 128.2-т Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгөө захиран зарцуулахдаа гэр бүлийн насанд хүрсэн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авахаар заасан бөгөөд энэ зөвшөөрлийг аваагүй нь хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болохоор мөн хуулийн 128.3-т заасан. Гэвч үл хөдлөх эд хөрөнгө гэр бүлийн нэг гишүүний нэр дээр бүртгэлтэй үед уг хөрөнгөтэй холбоотой хэлцэл хийхдээ гэрлэгчээс бусад насанд хүрсэн бүх гишүүний зөвшөөрлийг авсан байхыг шаардах нь тус заалтыг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэдэг. Түүнчлэн гэрлэгчид энэ заалтыг буруугаар хэрэглэж, зориудаар зөвшөөрөлгүй байгуулсан хэлцлээ (ипотек г.м) хожим нь хүчингүй болгоход ашиглах тохиолдол ч гарч байна. Иймд энэ үндэслэлээр хэлцлийг хүчингүй болгох эсэх асуудалд “өмчлөх эрх шударгаар олж авах” зарчим хүчтэй нөлөөтэй шүүхийн практик үйлчилж байна.

Тодруулбал, гэрлэгчийн хэн нэгний нэр дээр бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийн тухайд гэрлэгч нөгөө талдаа хэлэлгүйгээр орон сууцаа бусдын зээлийн барьцаанд тавих, шийдвэр гүйцэтгэлийн журмаар шилжүүлэх, худалдах зэргээр захиран зарцуулсан тохиолдлуудад зөвшөөрөл олгох ёстой байсан гэрлэгчээс, эсхүл насанд хүрсэн гэр бүлийн бусад гишүүдээс хэлцлийг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгохоор шүүхэд хандах үед хариуцагчийн өмчлөх эрх олж авсан үеийн итгэл үнэмшил шударга байсан эсэх асуудал нөлөөтэй байх хууль хэрэглээ тогтжээ. Энэ нь гэр бүлийн хөрөнгийг онцгойлон хамгаалах зарчим үйлчилж, good faith буюу шударгаар өмчлөх эрх олж авах зарчмаас гажих тохиолдол гэж үздэг эх газрын эрх зүйн тогтолцооны зарим улсаас ялгаатай хэрэглээ гэж үзэхээр байна.

4.2 Дундын хөрөнгийг хүүхдэд хувааж буй байдал, ногдох хэсгийн хэмжээг тогтоох

Шүүхийн практикт дундын хөрөнгийг гэрлэгчдээс гадна хүүхдэд хуваах зарчим нэгдмэл байдалтай үйлчилж байна. Ингэхдээ хүүхдийн нас, хамтын амьдралыг үндсэн шалгуур болгох хэдий ч цөөн тохиолдолд насны шалгуурыг үл харгалзан хамт амьдарч байгаа үзүүлэлтийг илүү чухалчилж байгаа нь анзаарагдаж байна. Хүүхдэд хөрөнгө хуваахтай холбоотой дараах хэрэглээ ажиглагдаж байна.

1. Хүүхэд насанд хүрээгүй бөгөөд хамт амьдарч байх – Хэрэв хүүхэд насанд хүрээгүйн зэрэгцээ эцэг, эхтэйгээ хамт амьдарч байсан бол гэрлэлт цуцлах үед гэрлэгчдийн нэгэн адил хэмжээгээр дундын өмчөөс хувь хүртэнэ. Гэтэл насанд хүрээгүй боловч хамт амьдарч байгаагүй үзүүлэлтийг хувь хөрөнгө хуваахгүй байх үндэслэл болгосон шүүхийн практик байна. Тодорхой хэргийн тухайд насанд хүрээгүй хүүхэд гэрлэгчийн дагавар хүүхэд байх ба төрсөн үеэс эхлэн эмээ,

өвөө дээрээ өссөн, хойд эцэг ба төрсөн эхтэйгээ хамтран амьдарч байгаагүй үйл баримтыг шүүх дүгнэхдээ гэрлэгчийн нэгэн адил ногдол хувь авах үндэслэлгүй гэж дүгнэсэн байна.

2. Гэрлэлт хүчин төгөлдөр байхад гэр бүлийн бусад гишүүн буюу хүүхэд насанд хүрснээр гэр бүлийн гишүүнээс гарах боломжтой. Гэвч насанд хүрсэн байх шалгуур нь дангаараа энэ үндэслэл бүрдсэн гэж үзэж болох эсэхийг анхаарах шаардлагатай. Насанд хүрсэн боловч өөрийн гэр бүлийг үүсгээгүй, эцэг эхтэйгээ хамт амьдарч байгаа бол түүнийг гэр бүлийн гишүүнээс гарсанд тооцохгүй, ингэснээр гагцхүү насанд хүрсэн л бол энэ нь дангаараа хөрөнгө хуваах харилцааг үүсгэхгүй. Харин хүүхэд насанд хүрч, улмаар гэр бүлээс тусдаа амьдрахаар болж, гэр бүлийн гишүүнээс гарч байгаагаа илэрхийлэн хөрөнгө хуваах шаардлага гаргаж байгаа бол энэ нь хуулийн 129.1.1-д хамаарах үндэслэл болж болохыг үгүйсгэхгүй. Гэвч манай практикт ийм тохиолдол элбэг биш бөгөөд илүүтэй эцэг, эх гэрлэлтээ цуцлах үед насанд хүрсэн, тусдаа амьдардаг хүүхэд дундын хөрөнгөөс ногдох хэсгээ авахаар бие даасан шаардлага гаргах, эсхүл, эцэг, эхийн аль нэг нь түүнийг төлөөлөн хувь хэмжээг нэхэмжлэх явдал ажиглагддаг.

3. Шүүхийн практикт эцэг, эх гэрлэлтээ цуцлах үед аль хэдийн өрх тусгаарлан тусдаа гарсан хүүхэд хөрөнгөөс хувь нэхэмжлэн шүүхэд маргах үед дундын хөрөнгөөс хуваахгүй байх хандлага ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, хүүхэд насанд хүрч, гэр бүлээс тусдаа амьдрахаар шийдсэн тухайн цаг мөчдөө шаардлага гаргаагүй бол хожим нь дундын хөрөнгөөс ногдох хэсгээ гаргуулах боломжгүй гэж үзэхээр байна. Гэвч судалгаанд хамрагдсан тогтоолд нэг тохиолдолд дундын хөрөнгийн ногдох хэсгийг тодорхойлохдоо гэрлэгчид болон тэдний насанд хүрсэн, хүрээгүй бүх хүүхдийг оролцуулан тэнцүү хувааж, ногдох хэсгийг тооцсон байна.

4. Хүүхэд насанд хүрч өөрийн гэр бүлийг зохиосон ч санхүүгийн болон хувийн бусад шалтгааны улмаас эцэг, эхийн хамт амьдарсаар байх нь олонтоо бөгөөд энэ тохиолдлыг гэр бүлээс гарсанд тооцохгүй байх практик давамгай. Нөгөө талаас тэрээр өөрийн гэр бүлийг үүсгэсэн тул түүнийг нэгэн зэрэг хоёр гэр бүлийн гишүүн гэж үзэхэд бэрхшээлтэй хэдий ч Иргэний хуулийн 129.1.1-д заасны дагуу гэр бүлээс гарсан гэх үндэслэлийн хүрээнд хамтын амьдралын шалгуур хүчтэй тавигдана. Иймд нэгэнт хамтран амьдарч дундын хөрөнгийг хамтран ашигласаар байх тул түүнд хөрөнгөөс ногдох хэсгийг хуваах асуудлыг шийдвэрлэх нь өөрөө учир зүйн хувьд ойлгомжгүй юм.

5. Шүүх дундын хөрөнгөөс хувь авах эрх бүхий этгээдийн хүрээг нэгэнт тогтоосон бол ногдол хувийг Иргэний хуулийн 129.2-т зааснаар адил тэнцүү байх зарчим баримталж байна. Иргэний хуулийн 129.3 дахь хэсэгт дундын хөрөнгө гэрлэгчдийн дунд адил тэнцүү биш байх үндэслэл (эрүүл мэндийн шалтгаан, хүүхдийн эрх ашиг)-ийг, 129.4 дахь хэсэг гэрлэгчдээс бусад гишүүдэд адил тэнцүү биш байх тохиолдол (хөдөлмөрийн оролцоо, оруулсан хөрөнгийн хэмжээ)-ыг хамаарч байгаа бол 130.2 дахь хэсэг талууд өөрсдөө сайн дураараа адил тэнцүү хуваахгүйгээр шийдвэрлэж болох нөхцөлийг тусгасан. Гэвч эдгээр үндэслэлийн алинд ч хамаарахгүй тохиолдлууд амьдралд гарч байна. Жишээ нь дундын өмчийг бий болгох эх үүсвэрийн ихэнх хэсгийг гэрлэгч өөрийн хуваарьт хөрөнгийг захиран зарцуулж олсон орлогоос бүрдүүлэх тохиолдолд шүүх Иргэний хуулийн 130.3 дахь

заалтыг баримталж ийнхүү ихэнх хэсгийг бүрдүүлж дундын өмчийг бий болгосон гэрлэгчид адил тэнцүү биш байх зарчим барьсан байна.

4.3 Гэрлэгчдийн өр, хариуцлагын хуваарилалт

Дундын хөрөнгийн тухайд гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргийг гэрлэгчид тэнцүү хариуцах зарчмыг шүүх баримталж байна. Гэрлэгчдийн хамтран, эсхүл нэг гэрлэгчийн дангаар авсан орон сууцны зээлийн үүргийг гэрлэлт цуцлах үед хуваан хариуцуулах тохиолдол практикт хамгийн түгээмэл гарч байна. Энэ тохиолдолд зээлийн гэрээний үлдэгдлийг нэхэмжлэл гаргах, эсхүл маргаан шийдвэрлэх үеийн байдлаар тодорхойлон, үүргийг гэрлэгчдэд тэнцүү хуваах хандлага ажиглагдаж байна.

Харин гэрлэлт цуцлах үеийн өр төлбөрийг хүүхдэд хариуцуулахгүй байх буюу дундын хөрөнгийн үнийг шаардах эрх бүхий этгээдийн тоонд хувааж, өрийг гагцхүү гэрлэгч тус бүрийн хэсгээс хасаж тооцож хүүхдэд өр ногдуулахгүй байх” зарчмыг баримталж байна. Гэвч хүүхдийг асрамждаа авсан тал ногдох хэсгээрээ өрөө барагдуулж хүрэлцэхгүй бол түүний саналыг харгалзан үлдэгдэл өрийг хүүхдийн ногдох хэсгээс гаргуулах агуулгатай шүүхийн практик байна. Өрийг хүүхдэд хариуцуулахгүй, эсхүл хожим өрөө төлөхөд хүндрэл учирсан бол төлөөллийн зарчмын хүрээнд хүүхдэд ногдох хэсгийг хэрэглэх эсэх асуудлаар хүүхдийн эрх ашгийг харгалзан гаргасан хууль ёсны төлөөлөгчийн шийдлийг буруутгахгүй гэх дүгнэлтийг шүүх хийжээ.

Гэрлэгчийн хэн нэгэнд хөрөнгийг үлдээж, нөгөө талд ногдох хэсгийг мөнгөн хэлбэрээр төлүүлж байгаа тохиолдолд тус харилцаа нь гагцхүү дундын өмчийг дуусгавар болгосонтой холбоотой эрх зүйн маргаанд хамааралтай гэж үздэг хэдий ч энэ нь гэрлэгчдийн банк санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээний харилцаанд хэрхэн нөлөөлөх тухайд дүгнэлт өгсөн шийдвэр цөөн байна. Өөрөөр хэлбэл хожим зээлийн гэрээ, барьцааны гэрээтэй холбоотой маргаан үүсэхэд гэрлэгчдийн дундын өмчийн харилцаа дуусгавар болсон нь банк санхүүгийн байгууллагын шаардах эрхэд нөлөөлөх эсэх талаар дүгнэлтийг маргаан гарахаас өмнө урьдчилан хийхээс шүүхүүд зайлсхийж байна.

4.4 Дундын хөрөнгийг хуваах үеийн эд хөрөнгийн эзэмшил

Гэрлэлт цуцлан гэр бүлийн дундын хөрөнгийг хуваах үед эд хөрөнгийн эзэмшлийг шийдвэрлэх нь шаардлага үүснэ. Гэвч энэ талаар чиг баримжаа болохуйц урьдчилсан нөхцөл, шалгуур тогтоосон хуулийн зохицуулалт үгүй. Иймд шүүх энэ асуудлыг зарчмын дагуу шийдвэрлэж байна. Энэ тухайд шүүхийн практикт дараах хандлага тогтжээ:

- Хөрөнгийн дийлэнх хэсэг ногдож байгаа талд хөрөнгийн эзэмшил буюу өмчлөлийг үлдээж, бага хувь ногдож байгаа талд ногдох хэсгийг мөнгөөр төлөх замаар дундын хөрөнгийн харилцааг дуусгавар болгож байна.
- Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа ногдох хэсгээ мөнгөн хэлбэрээр гаргуулахаар шаардсаныг хөрөнгийн эзэмшлийг шилжүүлэх шаардлага гаргаагүй гэж үзэн, хариуцагчийн тус шаардлагын талаарх тайлбарыг харгалзах буюу хэрэв хариуцагч эзэмшлийн талаар эсрэг

тайлбар гаргаагүй бол нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд эзэмшлийг хариуцагчид үлдээж шийдвэрлэж байна. Талуудын хэн аль нь хөрөнгийн эзэмшлээс татгалзан маргах тохиолдол ховор бөгөөд эзэмшлийг өөртөө үлдээхээр шаардлагаа тодорхойлон маргах нь түгээмэл.

- Хөрөнгийн эзэмшлийн талаар талууд харилцан маргаантай байгаа бол хүүхдийн эрх ашгийг харгалзаж байна. Гэвч хүүхдийн асрамж тогтоолгосон талд үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэхэд хөрөнгийг дагаж өр зээлийн дарамт үүсэхээс болгоомжлох байр суурь баримталж байна.
- Дундын хөрөнгийн өмчлөлийг шийдвэрлэхдээ тэнцвэржүүлэх хандлага баримтлах буюу үл хөдлөх эд хөрөнгийг нэг талд өгсөн бол нөгөө талд тээврийн хэрэгслийг үлдээх гэх мэт хандлагатай байна.

4.5 Гэр бүлийн дундын хөрөнгө эсэхийг тодорхойлох

Иргэний хуулийн 126.1-д заасны дагуу гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болсон гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгөөс бусад хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч мөн бөгөөд Иргэний хуулийн 127.1-д заасны дагуу талууд (энэ нь мөн зөвхөн гэрлэгчдэд хамаатай юу, эсхүл гэр бүлийн бүх гишүүд үү гэх асуулт тулгарна) хамтран өмчлөлд шилжүүлэхээр тохиролцоогүй бол гэр бүлийн гишүүний гэрлэхээс өмнө болон хойно олж авсан хуваарьт хөрөнгө гэр бүлийн дундын өмчид тооцогдох боломжтой.

Шүүхийн практикаас үзвэл гэрлэгч гэр бүл болохоосоо өмнө өмчилж байсан үл хөдлөх эд хөрөнгөө худалдаж олсон орлогоо нэмэрлэн орон сууцаа томруулж эхнэр/нөхрийн хамт худалдан авах, эсхүл гэрлэгчийн хэн нэгний эцэг, эх банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн мөнгөн хөрөнгийг оролцуулан үл хөдлөх эд хөрөнгө худалдаж авсныг Иргэний хуулийн 126.1, 126.3⁹ -т заасны дагуу гэр бүлийн дундын өмч гэж тодорхойлох нь нийтлэг байна. Өөрөөр хэлбэл, тэтгэврийн болон бусад зээлийн эх үүсвэрээ шилжүүлсэн эцэг эхийн оролцоог дундын өмчид хамаатуулахгүй байх ба шаардлага гаргасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон эцэг, эхийн мөнгөн оролцооны талаар дүгнэхгүй орхих нь түгээмэл байна. Ийнхүү дүгнэлгүй орхиж байгаа нь эцэг эхийн мөнгөн шилжүүлэг, санхүүгийн нэмэр тусыг гэрлэгч хуваарьт хөрөнгөө худалдан хамтын хөрөнгө үүсгэхэд зарцуулсантай адилтгаж буй мэт таамаг төрүүлж байна.

Хэдийгээр Иргэний хуулийн 127.1-д гэр бүлийн гишүүд хуваарьт хөрөнгөө дундын өмчид шилжүүлэх талаар тохиролцсон байхыг шаардаж байх боловч энэ тохиролцоо хийгдсэн эсэх талаар шүүхүүд тухайлсан дүгнэлт өгөхгүйгээр хэргийг шийдвэрлэх нь түгээмэл байна.

4.6 Хамтран амьдрагчдын дундын эд хөрөнгийг хувааж буй байдал

Гэрлэлтээ бүртгүүлээгүй хамтын амьдралын хугацаанд бий болсон “эд

⁹ Иргэний хууль (2002)-ийн 126 дугаар зүйлийн 126.3 “Гэр бүлийн гишүүний хуваарьт эд хөрөнгийг гэр бүлийн бусад гишүүд их засвар хийсэн, шинэчилсэн, өөрчлөн тоногдосны улмаас үнэ нь үлэмж нэмэгдсэн, эсхүл анх гэр бүл болоход нь зориулагдсан /орон сууц, гэр, хашаа, байшин зэрэг/ бол хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болгон тогтоож болно.”

хөрөнгө”-ийг Иргэний хуулийн 108 болон 487-р зүйлийг баримтлан шийдвэрлэж байна. Хамтран амьдрагчдын эд хөрөнгийн харилцааг дундын өмчийн буюу түүний дотор дундаа хэсгээр өмчлөх хэлбэр гэж үзэн ногдох хэсгийн хувь хэмжээг тодорхойлох хандлага нийтлэг ажиглагдлаа.

1. Тухайн хөрөнгийг бий болгоход оруулсан хөрөнгөд хувь тэнцүүлэн хамтран амьдрагч тус бүрийн ногдох хэсгийг тодорхойлж байна. (001/ХТ2024/00034)
2. Тухайн хөрөнгийг бий болгоход оруулсан хөрөнгийн хувь хэмжээ нь тодорхойгүй буюу нотлогдохгүй байгаа, энэ талаар талууд өөрөөр тохиролцоогүй тохиолдолд Иргэний хуулийн 487.1¹⁰-ын дагуу тэнцүү хувааж байна. (001/ХТ2024/00034)
3. Дундын эд хөрөнгийн хувьд хүүхдийн өмчлөх эрх гагцхүү гэр бүлийн эрх зүйн хүрээнд үүснэ гэж дүгнэн зөвхөн хамтран амьдрагчдын хувьд ногдох хэсгийг тодорхойлж байна. (001/ХТ2024/00293)
4. Гэвч хүүхэд болон хамтран амьдрагчид дундын өмчлөгчөөр улсын бүртгэлд бүртгүүлсэн тохиолдолд дундын эд хөрөнгийг хамтран амьдрагчид болон тэдний дундаас төрсөн хүүхдэд тэнцүү хувааж байна. (001/ХТ2016/01212)

V. ДҮГНЭЛТ

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн орчны хүрээнд гэр бүлийн хөрөнгийн хамгаалалт иргэний эрх зүйн хэм хэмжээгээр илрэн хэрэгжиж байх ба тус зохицуулалтын боловсронгуй байдал гэр бүлийн харилцааны бат бэх байдалд зохих хэмжээгээр нөлөөтэй. Манай улсад гэр бүлийн хөрөнгийн харилцааг гэрээгээр зохицуулах боломжийг одоогоос 20 гаруй жилийн өмнө хуульчлан тусгасан ч гэрлэлтийн гэрээ бус хууль тогтоомжоор (statutory) маргаанаа шийдвэрлүүлэх хандлага илэрхий давамгайлж байна. Иймд энэ чиглэлийн хууль тогтоомжийг сайжруулах, орчин үеийн хандлага, гэр бүлийн хөгжил, эрэлт хэрэгцээнд нийцсэн зохицуулалтаар баяжуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүний тулд гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг хянан шийдвэрлэж байгаа шүүхийн практикийг судалж, асуудлыг танин мэдэх нь чухал. Шүүхийн практикийг судлах нь дан ганц хуулийн хэм хэмжээг боловсронгуй болгох бус шүүх өөрийн хууль хэрэглээний янз бүр байдлыг ойлгох, нэгдмэл зөв хандлагыг хэвшүүлэх, хуулийн зөв хэрэглээ жишиг болох сайн талтай.

Монгол Улсад гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх байгуулагдах гэж буй энэ цагт гэр бүлийн холбогдолтой өнөөгийн хууль тогтоомжийн зохицуулалт, шүүхийн практикийг тандан судлах нь ирээдүйн шүүхийн хөгжлийн чиг баримжаа, хууль тогтоомж, хууль хэрэглээний сул тал, оновчгүй байдлыг тодорхойлох, цаг алдалгүй зөв шийдэл гарган хэрэгжилтийг хангахад дөхөм болно. Энэ зорилтын хүрээнд дараах дүгнэлт хийж байгааг товч дурдъя. Үүнд:

¹⁰ Дундаа хэсгээр өмчлөгчид харилцан өөрөөр тохиролцоогүй бол өмчлөгч бүр тэнцүү хэмжээгээр өмчлөх эрхтэй бөгөөд өөрт оногдох хэсэгт ногдох үр шимийг өмчлөх эрхтэй.

1. Гэр бүлийн хөрөнгө нь гагцхүү гэрлэгчдийн хөрөнгө байх үндсэн загвар эрх зүйн бүлийг үл хамааран олон улсад үйлчилж байна. Манай улсын хувьд гэр бүлийн дундын хөрөнгийн талаар эрх эдлэх субъектийн хүрээг өргөжүүлэн тогтоосноор бусад улс оронд тохиолддоггүй өвөрмөц асуудал тулгарч байна. Хүүхдийн эрх ашгийн зохист хамгаалалтын тогтолцоо, өв залгамжлалын боловсронгуй хэм хэмжээний тусламжтайгаар гэр бүлийн дундын хөрөнгийг гэрлэгчийн хүрээгээр хязгаарлахаар хууль тогтоомжийг дахин загварчлах боломж байж болох юм. Хэрэв эрх зүйн бусад институтийн сул талыг гэр бүлийн хүрээг өргөжүүлэн тайлбарласнаар нөхөх боломжтой гэж үзвэл хүүхэд буюу гэр бүлийн бусад гишүүн гэх ойлголтыг гэр бүлийн хөрөнгийн харилцаанд тодорхой болгох, энэ ойлголтыг нэмснээр бий болж буй бусад үр дагаврыг шүүхийн өнөөгийн практикт суурилан эрх зүйн зохицуулалтыг сайжруулах нь зүйтэй.
2. Гэр бүлийн хөрөнгө нь дангаар өмчлөх хуваарьт хөрөнгө, дундын хөрөнгөөс бүтэх тул энэ нь цогц бөгөөд иж бүрдэл, бие даасан ойлголт болохыг зөвшөөрч хуулийн зохицуулалтыг бүтээх, хууль хэрэглээг төлөвшүүлэх шаардлага байна.
3. Гэр бүлийн дундын хөрөнгийг захиран зарцуулах зөвшөөрлийн механизмыг шударгаар өмчлөх эрх олж авах зарчимтай уялдуулан хэрэглэхдээ нэг талаас гэр бүлийн хөрөнгийн хамгаалалт, гэр бүлийн эрх ашиг, нөгөө талаас гэр бүлийн гишүүдийн шударга бус итгэл үнэмшил, өмчлөх эрх олж авч буй этгээдийн шударга итгэл үнэмшлийг тэнцвэржүүлэн уян хатан хэрэглэх шаардлага байна.
4. Гэр бүлийн хөрөнгийн харилцааг дуусгавар болгох үндэслэл тодорхой байх, энэ үндэслэл бүрдсэнээр хөрөнгийг хуваан, ногдох хэсгийг тогтоох маргаан эхэлдгийг анхаарч, холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 129 ба 130 дугаар зүйлийн зохицуулалтын ялгаа заагийг тодорхой болгон сайжруулснаар хууль хэрэглээний янз бүр байдал зүгшрэхэд дөхөм болох сайн талтай.
5. Гэр бүлийн хөрөнгийн зохицуулалт боловсронгуй байх нь гэр бүл бат бэх байх, гэрлэгч, хүүхдийн эрх ашгийг тэнцвэржүүлэхэд онцгой ач холбогдолтой. Иймд хууль хэрэглээ ч энэ зарчим, зорилгын дор төлөвшөл зохино. Үүний тулд шат шатны шүүхүүд янз бүрийн практик тогтоохоос зайлсхийж, нэг мөр хэрэглээ бүхий тодорхой байдлыг бий болгохыг эрмэлзэх нь зүйтэй.
6. Өмчийн эрх зүй, тэр дундаа дундын өмчийн эрх зүй, гэр бүлийн хөрөнгийн асуудлаар танин мэдэхүйн чиглэлд ч болов судалгаа хийхийг дэмжих шаардлагатай байна. Энэ чиглэлээр мэргэшсэн судалгаа бага байна. Хуулийн зохицуулалт ойлгомжгүй, бүрхэг байгаагаас тодорхойгүй, савалгаатай хууль хэрэглээ тогтож, нэгдмэл байдал алдагдаж байна. Зохицуулалт, үзэл баримтлалын тодорхойгүй байдлыг хуулийг боловсронгуй болгох, судалгааны ажлыг дэмжих, урамшуулах арга замаар даван туулна.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. УДШ-ийн тогтоол, 2016.11.15, Дугаар 001/ХТ2016/01212
2. УДШ-ийн тогтоол, 2021.06.24, Дугаар 001/ХТ2021/00839
3. УДШ-ийн тогтоол, 2022.03.29, Дугаар 001/ХТ2022/00375
4. УДШ-ийн тогтоол, 2022.04.08, Дугаар 001/ХТ2022/00449
5. УДШ-ийн тогтоол, 2022.10.28, Дугаар 001/ХТ2022/01012
6. УДШ-ийн тогтоол, 2022.11.22, Дугаар 001/ХТ2022/01128
7. УДШ-ийн тогтоол, 2022.11.23, Дугаар 001/ХТ2022/01161
8. УДШ-ийн тогтоол, 2022.12.01, Дугаар 001/ХТ2022/01205
9. УДШ-ийн тогтоол, 2022.12.13, Дугаар 001/ХТ2022/01264
10. УДШ-ийн тогтоол, 2022.12.15, Дугаар 001/ХТ2022/01274
11. УДШ-ийн тогтоол, 2023.03.21, Дугаар 001/ХТ2023/00053
12. УДШ-ийн тогтоол, 2023.06.27, Дугаар 001/ХТ2023/00138
13. УДШ-ийн тогтоол, 2023.10.03, Дугаар 001/ХТ2023/00166
14. УДШ-ийн тогтоол, 2023.10.10, Дугаар 001/ХТ2023/00176
15. УДШ-ийн тогтоол, 2024.01.23, Дугаар 001/ХТ2024/00015
16. УДШ-ийн тогтоол, 2024.02.20, Дугаар 001/ХТ2024/00034
17. УДШ-ийн тогтоол, 2024.02.27, Дугаар 001/ХТ2024/00036
18. УДШ-ийн тогтоол, 2024.05.21, Дугаар 001/ХТ2024/00108
19. УДШ-ийн тогтоол, 2024.05.28, Дугаар 001/ХТ2024/00110
20. УДШ-ийн тогтоол, 2024.06.11, Дугаар 001/ХТ2024/00139
21. УДШ-ийн тогтоол, 2024.06.18, Дугаар 001/ХТ2024/00150
22. УДШ-ийн тогтоол, 2024.06.25, Дугаар 001/ХТ2024/00165
23. УДШ-ийн тогтоол, 2024.06.27, Дугаар 001/ХТ2024/00169
24. УДШ-ийн тогтоол, 2024.10.01, Дугаар 001/ХТ2024/00190
25. УДШ-ийн тогтоол, 2024.10.03, Дугаар 001/ХТ2024/00201
26. УДШ-ийн тогтоол, 2024.11.07, Дугаар 001/ХТ2024/00247
27. УДШ-ийн тогтоол, 2024.11.28, Дугаар 001/ХТ2024/00279
28. УДШ-ийн тогтоол, 2024.11.28, Дугаар 001/ХТ2024/00281
29. УДШ-ийн тогтоол, 2024.12.10, Дугаар 001/ХТ2024/00293
30. УДШ-ийн тогтоол, 2024.12.10, Дугаар 001/ХТ2024/00298
31. УДШ-ийн тогтоол, 2024.12.17, Дугаар 001/ХТ2024/00308
32. УДШ-ийн тогтоол, 2025.01.07, Дугаар 001/ХТ2025/00018
33. УДШ-ийн тогтоол, 2025.01.30, Дугаар 001/ХТ2025/00022
34. УДШ-ийн тогтоол, 2025.03.07, Дугаар 001/ХТ2025/00050
35. Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шүүхийн магадлал, 2024.06.19, Дугаар 208/МА2024/00041
36. Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2024.10.08, Дугаар 102/ШШ2024/04704

2. Гадаад хэл дээр эх сурвалж:

А. Англи хэл дээр

1. Kai Kullerkupp, Statutory marital property law de lege lata and de lege ferenda, 2001.
2. Marianne M. Jennings, Real Estate Law, South-Western, Cengage Learning press, 2011.
3. William E. Francis, Joint tenancy and Tenancy by the Entirety, Four unities requirement, Kentucky Law Journal, Volume 36, Issue 2.

“БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ДАХЬ ХҮҮХДИЙН АСРАМЖ БА ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ”

Севил Каргал,
БНТУ-ын дээд шүүхийн Иргэний хэргийн
2-р танхимын шүүгч, Гэр бүлийн эрх зүйн
үнэлгээний зөвлөлийн дарга

Агуулга

-
- I. БНТУ-ын эрх зүйн тогтолцоон дахь эцэг, эхийн хүүхдээ асрамжлах талаарх ерөнхий зарчим
 - II. Асрамж тогтоох тухай маргаанд хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд харгалзана
 - III. Хүүхдийн асрамж тогтооход баримтлах зарчим
 - IV. Хүүхдийн асрамж тогтоох тухай маргаанд эцэг, эхийн баримтлах зарчим
 - V. Шаардлагатай тохиолдолд мэргэжилтний саналыг авах
 - VI. Хамтарсан асрамжийн асуудал
-

Бүгд Найрамдах Турк Улс (цаашид БНТУ” гэх)-д Гэр бүлийн шүүх 2003 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 4787 дугаар “Гэр бүлийн шүүх байгуулах, шүүхийн харьяалал болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль”-ийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Эцэг, эхийн хүүхдээ асрамжлахтай (англ. *Parental Custody*) холбоотой бүх хэрэг Гэр бүлийн шүүхийн харьяалалд хамаарна. Энэхүү шүүхээр Гэр бүлийн шүүхийн ердийн харьяалалд хамаарах хэргүүд, түүнчлэн хүүхдийн асрамж тогтоолгохтой холбоотой хэргүүдийг хянан хэлэлцэж шийдвэрлэдэг. Миний албан үүргээ хэрэгжүүлж буй БНТУ-ын дээд шүүхийн Иргэний хэргийн 2 дугаар танхим нь Гэр бүлийн шүүхээс гаргасан шийдвэрийг давж заалдах журмаар хянаж шийдвэр гаргах эрх бүхий танхим юм.

I. БНТУ-ЫН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООН ДАХЬ ЭЦЭГ, ЭХИЙН ХҮҮХДЭЭ АСРАМЖЛАХ ТАЛААРХ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

1.1. Эцэг, эхийн асрамж нь нийтийн хэв журмын хүрээнд хамаарна.

Хүүхдэд хамаарах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатанд шүүгч өөрийн санаачилгаар (ex officio) оролцоно. Шүүгч хүүхдийн эрх ашгийг хамгаалахын тулд талууд хүсэлт гаргаагүй байсан ч шаардлагатай арга хэмжээг өөрийн санаачилгаар авна. БНТУ-ын эрх зүйн тогтолцоонд асрамж тогтоох тухай зохицуулалтыг тодорхойлохдоо, хүүхэд эцэг, эхийнхээ алинтай нь хамт амьдрах буюу хүүхдийн асрамж тогтоох маргааныг шийдвэрлэхдээ «хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол»-ыг (англ. *best interest of the child*) чухалд тооцдог.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн болон хувийн хэвшлийн нийгэм хамгааллын байгууллага, шүүх, захиргааны байгууллага, хууль тогтоох байгууллагаас хүүхдэд хамаарах аливаа үйл ажиллагаанд хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд анхаарч үзэх ёстой. Хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахын тулд тухайн хүүхдийн бие махбод, сэтгэлзүй, сэтгэл хөдлөл, ёс суртахууны болоод нийгмийн хөгжлийг харгалзан үзэх шаардлагатай. Харин эцэг, эхийн ашиг сонирхол, гэрлэлт цуцлалтын шалтгаан, ёс суртахууны үнэлэмж, нийгмийн байдал зэргийг хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхгүй тохиолдолд харгалзан үзнэ.

“Хүүхдийн асрамж тогтоолгох маргаан нь нийтийн хэв журамд хамаарах бөгөөд шүүхийн санаачилгаар шалган тогтоох зарчмын (англ. *Court ex officio investigation*) дагуу шийдвэрлэгддэг. Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарч болох аливаа нөхцөл байдлыг заавал харгалзан үзэх шаардлагатай юм. Талуудын зөвшилцөл нь дангаараа эрх зүйн үр дагавар үүсгэхгүй.”

1.2. Хуульд зааснаар асрамжлах эрхийн хуваарилалтыг зайлшгүй хийх ёстой (англ. *Custody Arrangements Are Mandatory by Law*)

БНТУ-ын эрх зүйн тогтолцоон дахь эцэг, эх хүүхдээ асрамжлах эрх, үүргийг тогтоохтой холбоотой зохицуулалтыг авч үзвэл;

Асрамж тогтоох тухай зохицуулалт нь заавал биелэгдэх шинжтэй байна.

Шүүхээс гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргахдаа шүүгч аль болох эцэг, эхийг нь сонсож, асран хамгаалагч, харгалзан дэмжигч байгаа бол тэдний саналыг авч, эцэг, эх байх эрх болон хүүхэдтэй харилцах хувийн харилцааг зохицуулна.

Хүүхдийг асрамжлах эрхгүй эцэг, эхтэйгээ (англ. *noncustodial parent*) хэрхэн харилцах талаар зохицуулахдаа хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, ёс суртахууны эрх ашгийг нэн тэргүүнд тавина. Хүүхдийн асрамж болон боловсрол эзэмшихтэй холбогдон гарах аливаа зардлыг асрамжлах эрхгүй эцэг эсхүл эх нь санхүүгийн чадавхаасаа хамааран хамтран гаргах үүрэгтэй. (БНТУ-ын Иргэний хуулийн 182 дугаар зүйлийн 1; 2 дахь хэсэг)

- Өсвөр насны хүн эцэг, эхийн асрамжид байна (18 наснаас доош). Хуульд заасан үндэслэлгүйгээр асран хамгаалах эрхийг эцэг, эхээс бусад хүнд шилжүүлэхийг хориглоно.
- Шүүгч хүүхдийн асрамжлагчийг томилох шаардлагагүй гэж үзвэл насанд хүрээгүй, эрх зүйн бүрэн чадамжгүй хүүхэд мөн эцэг, эхийн асрамжид үлдэнэ.
- Гэрлэлт дуусгавар болоогүй тохиолдолд эцэг, эхийн хүүхдийг асрамжлах эрх адил байна.
- Гэрлэлт цуцалсан тохиолдолд гэрлэгчдийн аль нэг нь хүүхдийг асрамжлах эрхийг өөртөө шилжүүлж авна.
- Гэрлэгчдийн аль нэг нь нас барсан тохиолдолд хүүхдийн асрамжийг аль амьд байгаа талд үлдээнэ. (Иргэний хуулийн 336 дугаар зүйл)
- Гэрлэлтээ батлуулаагүй тохиолдолд хүүхдийг эхийн асрамжид үлдээнэ.

1.3. Хүүхдийн асрамж тогтоолгох тухай маргааныг шүүх санаачилгаар шийдвэрлэнэ.

Гэрлэлт цуцлах шийдвэр гарсны дараа шүүгч хүүхдийн асрамжийг ямар нэгэн хүсэлт шаардалгүйгээр, өөрийн санаачилгаар шийдвэрлэнэ. Өөрөөр хэлбэл, аль талд асрамжийг үлдээхийг шүүгч тогтооно гэсэн үг юм. Хүүхдийн асрамжийн талаар асуудлыг шийдвэрлээгүй гэрлэлт цуцлах тухай шийдвэрийг хүчингүйд тооцдог.

1.4. Хүүхдийн асрамж тогтоох тухай маргааныг тодорхойгүй байдалд үлдээж болохгүй.

Хүүхдийн асрамж тогтоох тухай маргаан тодорхойгүй, шийдвэрлэгдээгүй байж болохгүй. Тухайлбал, гэрлэлт цуцлах шийдвэрээр эхэд нь хүүхдийн асрамжийг олгохоор шийдвэрлэсэн боловч эх нь нас барсан тохиолдолд асрамж амьд үлдсэн эцэгт шууд шилжихгүй, тодорхойгүй байдалд үлдэх юм. Уг тохиолдолд асрамж тогтоолгох маргааныг шийдэх ёстой бөгөөд, асрамжийг эцэгт нь шилжүүлэх боломжгүй тохиолдолд хүүхдийн асрамжлагчийг томилох асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх шаардлагатай.

1.5. Өөрийн санаачилгаар шалган тогтоох зарчмыг баримтална.

Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд хүүхдэд хамаарах бүх асуудлаар ямар нэг албан ёсны хүсэлт, өргөдөл шаардахгүйгээр өөрийн санаачилгаар шалган тогтоож, асрамж тогтоох тухай асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх үүрэгтэй.

1.6. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд нотлох баримт гаргаж өгөхийг зөвшөөрнө.

БНТУ-ын эрх зүйн тогтолцоонд шүүх хуралдааны явцад хэрэглэгдэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүрмийг тодорхой заасан байдаг. Гэвч хүүхдийн асрамжтай холбоотой асуудалд шүүх зөвхөн энэхүү дүрэмд баригдахгүйгээр шаардлагатай ажиллагааг явуулж, нотлох баримт цуглуулж, цуглуулсан нотлох баримтыг үнэлэн хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалсан шийдвэр гаргах үүргийг хүлээдэг.

II. АСРАМЖ ТОГТООЛГОХ МАРГААНД ХҮҮХДИЙН ДЭЭД АШИГ СОНИРХЛЫГ НЭН ТЭРГҮҮНД ХАРГАЛЗАН ҮЗНЭ

1. Хүүхдийн дээд ашиг сонирхлыг тодорхойлохдоо түүний бие махбод, оюун санаа, сэтгэлзүй, ёс суртахуун, нийгмийн хөгжил, төлөвшилд анхаарах нь зүйтэй.
2. Эцэг, эхийн нас, амьдралын хэв маяг, эрүүл мэнд, хүүхдэд хандах хандлага, эрхэлсэн ажил, ажлын цаг, эдийн засгийн нөхцөл зэргийг хүүхдийн дээд эрх, ашиг сонирхолд нөлөөлөх хэмжээгээр харгалзан үзнэ.
3. Эцэг, эхийн ашиг сонирхол, гэрлэлт цуцлалтад нөлөөлсөн байдал, ёс суртахууны үнэлэмж, нийгмийн байдал зэргийг зөвхөн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нөлөөлөх хэмжээгээр харгалзан үзнэ.
4. Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол болон ёс суртахууны төлөвшлийг нэн тэргүүнд харгалзан үзэх шаардлагатай.
5. Эцэг, эхийн зүгээс хүүхдийн асрамжтай холбоотой асуудлаар ямар нэгэн зөвшилцөлд хүрсэн нь дангаараа эрх зүйн үр дагавар үүсгэхгүй.
6. Хүүхдийн бие махбод, оюун ухаан, ёс суртахууны хөгжил нь эцэг, эхийн хүсэл сонирхлоос илүү тэргүүн зэрэгт тооцогдох ёстой.

III. ХҮҮХДИЙН АСРАМЖ ТОГТООХОД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

1. Хүйс
2. Нас
3. Боловсролын түвшин
4. Эрүүл мэндийн байдал

5. Амьдарч буй нөхцөл
6. Аюулгүй байдал
7. Хүүхдийн үзэл бодол (Иргэний хуулийн 339 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг; НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 12 дугаар зүйл; Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх тухай Европын конвенцын 3; 6 дугаар зүйл)
8. Хүүхдийн дассан орчныг алдагдуулахгүй байх

Талууд харилцан тохиролцон нь дангаар эрх зүйн үр дагавар үүсгэхгүй. Бидний соёрхон баталсан олон улсын баримт бичгүүдийн дагуу хүүхдийн санал зайлшгүй чухал боловч тухайн санал нь хүүхдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх боломжтой гэж үзсэн тохиолдолд саналын эсрэг шийдвэр гаргах нь зүйтэй.

- БНТУ-ын дээд шүүхийн Иргэний хэргийн 2 дугаар танхимын 2022/11086 Е, 2024/3226 К дугаартай шийдвэр:

“...НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн болон хувийн нийгэм хамгааллын байгууллага, шүүх, захиргааны байгууллага, хууль тогтоох байгууллагаас хүүхдэд хамаарах аливаа үйл ажиллагаанд хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд анхаарч үзнэ. Хүүхдийн дээд ашиг сонирхлыг тодорхойлохдоо хүүхдийн хөгжлийн бүх асуудлыг анхаарах ёстой буюу бие бялдар, оюун ухаан, сэтгэл хөдлөл, ёс суртахуун, нийгмийн зэрэг бүх талаар эрх зүйн байдлыг дордуулахгүй, хүүхдийн дээд ашиг сонирхлыг зохих ёсоор анхаарах шаардлагатай. Эцэг, эхийн ашиг сонирхол, гэрлэлт цуцлалтын шалтгаан, ёс суртахууны үнэлэмж, нийгмийн байдал зэргийг хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхгүй тохиолдолд харгалзан үзнэ. Мөн НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 2 дугаар зүйл, Европын Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх тухай конвенцын 3 ба 6 дугаар зүйлд зааснаар насанд хүрээгүй ч “ойлгох насанд хүрсэн” хүүхдийг өөрт нь хамаарах асуудлаар үзэл бодлыг нь сонсох бөгөөд тухайн хүүхдийн саналыг харгалзан үзэх ёстой. Гэвч хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол хөндөгдсөн тохиолдолд шүүх хүүхдийн саналтай зөрчилдөх шийдвэрийг гаргаж болно гэжээ. Хүүхдийн асрамж тогтоолгох маргаан нь нийтийн хэв журмын хүрээнд хамаарах тул *өөрийн санаачилгаар шалган тогтоох зарчим* үйлчилнэ. Иймд хэрэг хянан шийдвэрлэх явцад гарсан шинэ нөхцөл байдлыг ч мөн харгалзан үзэх шаардлагатай.”

- БНТУ-ын дээд шүүхийн Иргэний хэргийн 2 дугаар танхимын 2023/4646, 2024/1502 К дугаартай шийдвэр

“Гэрлэлт цуцлах үед хүүхдийн асрамж тогтоох тухай зохицуулалтын үндсэн зорилго нь хүүхдийн ирээдүйн сайн сайхан байдлыг хамгаалахад оршино. Өөрөөр хэлбэл, асрамж тогтоох тухай асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалж, ирээдүйн баталгааг хангах ёстой. БНТУ-ын №4721 ИХ-ийн 335–351 дүгээр зүйлд хүүхдийн асрамж тогтоох тухай асуудал нь нийтийн хэв журамд хамаарна. Асрамж тогтоолгохтой холбоотой хэрэгт “ex officio” буюу шүүх өөрийн санаачилгаар шалган тогтоох зарчим үйлчилдэг тул шүүгч зөвхөн талуудын хүсэлтээр хязгаарлагдах ёсгүй байдаг. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 3 дугаар зүйл, Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх тухай Европын конвенцын 1 дүгээр

зүйл, БНТУ-ын №4721 Иргэний хуулийн 339 дүгээр зүйлийн 1, 343 дугаар зүйлийн 1, 346 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасанчлан асрамж тогтоолгох маргааныг шийдвэрлэхэд баримтлах үндсэн зарчим нь “хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэрлэх” явдал юм. Хүүхдийн эрхийг хамгаалах үндсэн зарчмыг дагаж мөрдөх ёстой зохицуулалт нь хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 12 дугаар зүйл, Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх тухай Европын конвенцын 3 болон 6 дугаар зүйлд “аливааг ойлгох насанд хүрсэн” (англ. *age of discernment*) хүүхдийн саналыг тухайн хэрэгт харгалзан үзэх бөгөөд түүний үзэл бодолд зохих ач холбогдол өгөх нь зүйтэй талаар заасан байдаг. БНТУ-ын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимуудын нэгдсэн хуралдааны шийдвэрт (№2018/2-1072, №2019/185) тэмдэглэгдсэнээр, хүүхдийн саналыг сонсох зарчим нь олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжид тусгагдсан, хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн зарчим юм. Энэхүү зарчмыг зөвхөн хүүхдийн сайн сайхны төлөө, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэхгүй тохиолдолд хэрэглэдэг.”

IV. АСРАМЖ ТОГТООЛГОХ МАРГААНД ЭЦЭГ, ЭХИЙН БАРИМТЛАХ ЗАРЧИМ (англи. *Principles regarding the parents in custody arrangements*)

1. Хүүхдэд чиглэсэн үйлдэл

Хүүхдийг үл тоомсорлох, хайхрахгүй орхих, бусдад үлдээх, хайхрамжгүй хандах гэх мэт

2. Хувь хүний онцлог

Нас, бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэнд, архи, мансууруулах бодисын хамаарал, сэтгэцийн эмгэг, тогтворгүй зан байдал, ажил мэргэжил, эдийн засгийн боломж, амьдрах орчин

3. Зан төлөв

Үлгэр жишээ үзүүлэх чадвар (англ. *Ability to serve as a role model*) (бэлгийн чиг хандлага, ёс суртахууны төлөвшил гэх мэт), хүчирхийлэл үйлдэх, заналхийлэх, дарамт үзүүлэх, шаардлагыг биелүүлэхээс татгалзах болон бусад ижил төстэй үйлдэл

V. ШААРДЛАГАТАЙ ТОХИОЛДОЛД МЭРГЭЖИЛТНИЙ САНАЛЫГ АВАХ

Асрамжийн асуудалд зөвхөн хүүхдээс саналыг нь авахаас гадна эцэг, эхийн байр суурийг сонсож, шаардлагатай бол сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан зэрэг мэргэжилтнүүд (№4787 Иргэний хуулийн 5 дугаар зүйл) оролцож, хүүхэд бүрийн эцэг, эхтэйгээ хамт амьдрах болон оршин суух нөхцөлийг үнэлдэг. Нийгмийн судалгааны дүгнэлт гаргуулж (англ. *social investigation report*), бүх нотлох баримтыг хамтатган үнэлсний үндсэн дээр хүүхдийн эрх ашигт нийцэх байдлаар эцэг, эхийн хэнд нь хүүхдийн асрамжийг үлдээх нь зүйтэй болохыг тогтоодог. Үүний дагуу асрамжийн асуудлыг шийдвэрлэдэг.

Түүнчлэн төрсөн ах/эгч дүүсийг салгахгүй байх зарчим чухал ач холбогдолтой.

Хүүхдийн санал бодлыг сонсохын тулд тухайн хүүхэд тодорхой насанд хүрсэн байх шаардлагатай. БНТУ-ын дээд шүүхийн Иргэний хэргийн 2 дугаар танхимын шийдвэрүүдэд хүүхдийн аливаа зүйлсийг ойлгох насыг ихэнх тохиолдолд 7-8 нас гэж үздэг.

БНТУ-ын хууль тогтоомж, холбогдох дүрэм журмаас гадна нэгдэн орсон олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Тодруулбал, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 12 дугаар зүйл, Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх тухай Европын конвенцын 3 болон 6 дугаар зүйлд хүүхэд аливааг ойлгох насанд хүрсэн тохиолдолд тэдний дээд ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар заавал саналыг нь сонсох талаар тодорхой заасан. Энэхүү зарчим нь шүүхийн шийдвэрүүдэд бодитоор тусгагдаж, зохих ёсоор хэрэгждэг.

Гэвч аливааг ойлгох насанд хараахан хүрээгүй (жишээлбэл, нялх хүүхэд гэх мэт танин мэдэхүйн насанд хараахан хүрээгүй) хүүхдийн хувьд эхийн асрамжид байх зайлшгүй хэрэгцээг харгалзан үзэж, хуульд харшлахгүй тохиолдолд эхийг нь асрамжлагчаар тогтоодог.

VI. ХАМТАРСАН АСРАМЖИЙН АСУУДАЛ (англ. *Joint custody matter*)

БНТУ-ын Иргэний хуулийн дагуу гэрлэлт цуцлах тохиолдолд асрамжийн эрхийг эцэг эсхүл эхийн аль нэгэнд нь олгодог (Иргэний хуулийн 336 дугаар зүйл) ба хамтарсан асрамжийн тухай нарийвчлан зохицуулаагүй байна. БНТУ-ын дээд шүүхийн Иргэний хэргийн 2 дугаар танхим нь дээрх асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулаагүйн улмаас хамтарсан асрамжийг зөвшөөрсөн шийдвэр 2017 он хүртэл гаргаж байгаагүй юм.

2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн шийдвэрээр талууд буюу эцэг, эх нь зөвшилцөж, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцсэн саналыг аль ч тал хүлээн зөвшөөрсөн бол хамтарсан асрамжийн эрхийг олгох боломжтой хэмээн шийдвэрлэжээ. Харин санал нэгдээгүй тохиолдолд хуулиар нарийвчлан зохицуулаагүйн улмаас хамтарсан асрамжийн талаар шийдвэрлэхгүй гэжээ.

Хүүхэд нь нийгмийн хамгийн эмзэг бүлгийн гишүүн болохынхоо хувьд онцгой хамгаалалт шаарддаг. Ийм учраас асрамжийн байгууллага нь хүүхдийн эмзэг байдал, тэднийг хамгаалах хэрэгцээ болон хууль ёсны төлөөллийг хэрэгжүүлэх шаардлагаас үүдэн бий болсон. Нийгмийн ирээдүй болсон хүүхдийг хамгаалах, зөв хүмүүжүүлэх нь зөвхөн хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалахаас гадна бүх нийтийн ашиг сонирхолд хамаарч байдаг. Иймээс хүүхэдтэй холбоотой бүхий л асуудал, тэр дундаа асран хамгаалагчийн талаар зохицуулалтад олон нийтийн оролцоо зайлшгүй шаардлагатай юм.

Хүүхдийг асрамжлах эрхийг эцэг, эхийн аль нэгэнд нь олгох шаардлагатай тохиолдолд шүүгчийн тодорхойлсон шаардлагуудыг хангасан эсэхийг харгалзан шийдвэр гаргана. Ийм тохиолдолд шүүгчийг чиглүүлэх гол зарчим нь хүүхдийн

дээд ашиг сонирхлыг дээдлэх зарчим болох бөгөөд шүүгч тухайн хэрэгт тохирох нөхцөл байдлыг үндэслэн асрамжийг тогтооно.

- БНТУ-ын дээд шүүхийн Иргэний хэргийн 2 дугаар танхимын 2016/15771, 2017/1737 дугаартай шийдвэр

Шийдвэрийн агуулга: Талууд Их Британийн иргэд бөгөөд нэхэмжлэгч (эцэг) гэр бүлээс гадуурх харилцаанаас төрсөн хүүхдийг асран хамгаалах эрхийг эцэг, эхийн аль алинд нь олгож шийдвэрлэж өгнө үү гэжээ.

Шүүхээс гэрлэлтээс гадуур төрсөн хүүхдийн хамтарсан асрамж нь үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрөгдөх боломжтой боловч БНТУ-ын нийтийн хэв журамд харш гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Эцэг, эхийн хоорондын харилцааг холбогдох хуулиар зохицуулах бөгөөд эцэг, эх болон хүүхдийн харьяалагдах улсын холбогдох хууль байгаа тохиолдолд тус хуулиар зохицуулна. Харин холбогдох хууль байхгүй тохиолдолд тэдний оршин суугаа газрын хуулийг хэрэглэнэ. (Олон улсын хувийн эрх зүйн болон хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)

Тухайн хэрэгт хэрэглэгдэх гадаад улсын хууль БНТУ-ын нийтийн хэв журамд илт харш байвал уг хуулийг хэрэглэхгүй. Харин шаардлагатай гэж үзвэл БНТУ-ын хуулийг хэрэглэнэ. (Олон улсын хувийн болон хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)

Дээрх “хамтарсан асрамж”-ийн асуудалтай холбоотой маргаан нь БНТУ-ын нийтийн хэв журамд илт харшилж байгаа эсэхтэй холбоотой ба шүүх тус хэргийг хамтарсан асрамжийн харилцааг харилцан тохиролцсоноор олгох боломжтой бөгөөд энэ нь нийтийн хэв журамд харшлахгүй байх тул хамтарсан асрамжийг зөвшөөрч шийдвэрлэжээ.

“МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮҮХДИЙН АСРАМЖИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ”

Ж.Лхагвасүрэн,
Нийслэлийн Иргэний хэргийн
давж заалдах шатны шүүхийн шүүгч (МРА),

Г.Нямсүрэн,
Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн
Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч (LL.M)

Агуулга

I. Удиртгал

II. Үндэсний хууль тогтоомжид хүүхдийн асрамжийн талаарх зохицуулалт

III. Хүүхдийн асрамжийн талаарх ойлголт

3.1. Биечилсэн асрамж

3.2. Хууль ёсны асрамж

IV. Хүүхдийн асрамжийн хууль зүйн үр дагавар

4.1. Оршин суух газраа сонгох эрхийг хэрэгжүүлэх

4.2. Хүүхэд эд хөрөнгөө өмчлөх эрхээ хэрэгжүүлэх

4.3. Хүүхдийн бусдад учруулсан хохирлыг арилгах

4.4. Хүүхдийн боловсрол, эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх эрх

4.5. Хүүхэдтэй уулзах эрх

V. Олон улсын харьцуулсан судалгаа

5.1. Америкийн Нэгдсэн Улс

5.2. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

5.3. Япон Улс

5.4. Бүгд Найрамдах Солонгос Улс

VI. Дүгнэлт

Ном зүй

I. УДИРТГАЛ

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад гэр бүлийн бүтэц, хэв маяг улам бүр олон талт, нийлмэл шинжтэй болж байна. Уламжлалт гэр бүлээс гадна дахин гэрлэсэн, дагавар хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй, улс дамнасан, олон соёлт, ижил хүйстэн, хамтран амьдрагч бүхий гэр бүлийн хэлбэрүүд түгээмэл болжээ. Энэхүү өөрчлөлт нь гэр бүлүүдэд санхүүгийн дарамт, сэтгэлзүйн хямрал, эрүүл мэнд, боловсрол, харилцааны асуудлуудыг үүсгэж, улмаар гэр бүлийн хүчирхийлэл болон гэрлэлт цуцлалт нэмэгдэх хандлагатай байна. Эдгээр сөрөг үр дагавар хамгийн түрүүнд хүүхдэд нөлөөлдөг нь нийгмийн хувьд онцгой анхаарах асуудал болоод байна.

Статистик мэдээллээс үзэхэд, Монгол Улсад 2015 онд 17586 хос гэрлэлтээ бүртгүүлж, 3873 хос гэрлэлтээ цуцлуулсан бол 2024 оны байдлаар 14225 хос гэрлэж, 4463 хос гэрлэлтээ цуцлуулсан буюу гэрлэлт цуцлалтын хувь 20-31 болж өссөн байна.¹

Монгол Улсын шүүхийн 2024 оны шүүх таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээгээр Гэр бүлийн тухай хуулиар 6520 маргаан шийдвэрлэсэн ба нийт хэргийн 8.8%-ийг эзэлж байгаа нь 2023 онд шийдвэрлэсэн хэрэгтэй харьцуулбал энэ төрлийн маргаан 10.3%-аар өсжээ. Задалж авч үзвэл, гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж, дундын хөрөнгөтэй холбоотой маргаан 7.4%-аар, хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргаан 22.5%-аар өсжээ.²

Ийм нөхцөлд шүүх байгууллага нь гэр бүлийн маргаанд оролцогч талуудын эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, ялангуяа хүүхдийн дээд эрх ашиг, тэдний аюулгүй, сайн сайхан байдлыг хангах үүргийг гүйцэтгэх шаардлагатай болсон.

Хүүхдийн асрамжийн асуудлыг зүй зохистой харж шийдвэрлэх нь тэдний ирээдүйн амьдрал, хөгжлийн суурийг тавьдаг онцгой чухал алхам юм. Хүүхдийн асрамжийг шүүхээр шийдвэрлэхэд гэрлэгчдийн үндсэн маргаанд дарагдаж, гэрлэлт цуцлалтыг дагалдаж үүсдэг дагавар асуудал болж, гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгө хуваарилахад давуу эрх олох, дундын хөрөнгөөс илүү хэсгийг өмчлөх, тэтгэлэг төлөх үүргээс чөлөөлөгдөх зэрэгт урвуулан ашиглах зорилгоор хүүхдийг өөрийн асрамжид авахаар маргах нь түгээмэл байна.

Энэ нь хүүхдийн асрамж гэх ойлголтын хууль зүйн нэр томьёо бүрхэг, хуульд бүрэн тусгаагүй, шүүхийн практикаар нөхөн зохицуулсан шинжтэй, эцэг эхийн эрх, үүрэг, хариуцлагыг тэдгээрийн харилцаа, эрх зүйн соёл, ухамсарт найдан орхисон байгаагаас үүдсэн гэж үзэж болно. Үүнээс гадна хүүхдийн асрамжийг тогтоох шалгуур үзүүлэлт, түүний эрэмбэ дараалал, үнэлэх аргачлал, хүүхдийн санал авах арга зүй тодорхойгүй, асрамжийн асуудлаар зөвшилцөлд хүргэх шүүхийн өмнөх тогтолцооны үр нөлөө бага, шүүхийн шийдвэрийн хэрэгжилт тааруу зэрэг хүчин зүйлс хүүхдийн асрамжийн харилцааны ач холбогдлыг бууруулж, дагалдах шинжтэй болгожээ.

1 “Гэрлэлт, цуцлалтын тоо, аймаг/нийслэлээр” Үндэсний статистикийн мэдээ, <https://www.1212.mn/mn>, (Сүүлд үзсэн: 2025.08.26).

2 Шүүхийн ерөнхий зөвлөл, “Монгол Улсын шүүхийн 2024 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ”, 2024, https://www.judcouncil.mn/site/news_full/14795

Хүүхдийн асрамжийн талаарх эдгээр цогц бүтцээс эхний ээлжид энэхүү илтгэлээр хүүхдийн асрамж гэх ойлголтод ямар асуудлыг багтааж байгаа, асрамжийг тогтоосноор эцэг, эхийн эрх, үүрэгт эрх зүйн ямар үр дагаврыг бий болгож байгаад дүн шинжилгээ хийж, тодорхой санал дэвшүүлэхэд оршино.

II. ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХҮҮХДИЙН АСРАМЖИЙН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын Үндсэн хуульд гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй оролцох, гэрлэлт нь насанд хүрсэн хоёр хүний сайн дурын үндсэн дээр үндэслэх, төрөөс гэр бүл, эх, нялхас, хүүхдийн эрх ашгийг хамгаална хэмээн тунхагласнаар гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын суурь зарчим, чиглэлийг тогтоож өгсөн. Мөн гэр бүл дэх хүүхэд хамгааллын харилцааг Гэр бүлийн тухай хууль, Жендерийн тэгш байдлыг хангах тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиудаар зохицуулсан байна.

Гэвч эдгээр хууль тогтоомжид хүүхдийн асрамжийг тогтоох тухай нарийвчилсан ойлголт, шалгуур, аргачлал, журмын талаар тодорхой зохицуулалт дутмаг байна. Хуулийн зохицуулалт Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт гэрлэлт цуцлах үед хүүхдийн асрамжийг хэний эрхэд үлдээх талаар харилцан тохиролцож болох, тус зүйлийн 14.6 дахь хэсэгт хэрэв тохиролцоогүй бол хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, амьдрах орчин, ёс суртахуун, хүчирхийлэл үйлдсэн эсэх зэргийг харгалзан шүүх шийдвэрлэнэ гэж заасан нь хүүхдийн асрамжийг тогтоох шийдвэрийг шүүхийн бүрэн эрхэд үлдээж байна.

Улсын дээд шүүхийн 2017 оны “Гэр бүлийн холбогдолтой эрх зүйн маргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах зарим асуудлын зөвлөмж”-д “хүүхдийн асрамж” бол эцэг, эхийн хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргийг хуваарилан хувааж буй асуудал биш, харин тусдаа амьдрах болсон эцэг, эхийн хэнтэй нь тухайн хүүхэд байнга оршин суухыг тодорхойлж, хүүхдийн амьдрах газрыг тогтоож байна гэсэн үг хэмээн тодорхойлжээ.³

Энэ цаг хугацаанд Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулан олон нийтээр хэлэлцэгдэж байна. Тус хуулийн төслүүдэд гэрлэлт цуцлах процесс, тэр дундаа хүүхдийн асрамжийг шийдвэрлэхэд эрх зүйн хувьд тодорхойгүй байсан зарим асуудлыг тусгаж өгсөн нь ач холбогдолтой болжээ. Тухайлбал Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шүүх гэрлэлт цуцлахдаа нэхэмжлэлийн шаардлага гаргасан эсэхээс үл хамаарч хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэх, ийнхүү асрамжийг шийдвэрлэхдээ тусдаа амьдрах эцэг, эхийн хүүхэдтэй уулзах эрх, үүрэг, шаардлагатай гэж үзвэл уулзах хугацаа, байршил, нэмэлт зардал, сургалтын төлбөрийг хариуцах асуудлыг нэг мөр шийдвэрлэхийг зааж өгчээ. Харин хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эхийн эрх, үүрэг гэсэн шинэ бүлэг оруулсан хэдий ч одоогийн үйлчилж буй зохицуулалттай адил, одоо үүсэн гарч буй харилцааг бүрэн зохицуулах шинэлэг зохицуулалт орж

3 Монгол Улсын дээд шүүх, “Гэр бүлийн холбогдолтой эрх зүйн маргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах зарим асуудлын зөвлөмж”, 2017, <https://supremecourt.mn/mn/>

ирээгүй байгааг анхаарах шаардлагатай.

III. ХҮҮХДИЙН АСРАМЖИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

Хүүхэд бол өөрийгөө бүрэн хамгаалж чадахгүй, насанд хүрсэн хүнээс хамааралтай орших тусгай субъект бөгөөд тэдний амьдрал, аюулгүй байдал, хөгжлийг хангах нь зөвхөн хууль ёсны үүрэг бус, мөн ёс суртахууны хариуцлага, нийгмийн хандлагын илрэл болдог. Иймд хүүхдийн асрамж нь зөвхөн хууль зүйн хүрээнд бус, ёс суртахуун, хүний эрх, нийгмийн шударга ёсны үнэт зүйлсээр хэмжигддэг өргөн хүрээтэй ойлголт юм.

Монгол Улсад гэр бүлийн эрх зүйн харилцааны хүрээнд “хүүхдийн асрамж тогтоох”, “асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилох” гэх мэт ойлголтууд хэрэглэгддэг. Эдгээр нь нийтлэгээр хүүхдийн дээд эрх ашгийг хангахад чиглэсэн боловч эрх зүйн агуулга, зохицуулалтын хувьд ялгаатай байдаг. Өнөөдөр хуульд заасан тодорхой шаардлага, шалгуурыг үндэслэн захиргааны байгууллага, албан тушаалтан, зарим тохиолдолд шүүх хүүхдийг асран хамгаалах эрхийг эцэг, эхээс өөр этгээдэд шилжүүлж байгаа бол асран хамгаалах, харгалзан дэмжих гэх агуулгад хамааруулж байна. “Хүүхдийн асрамж” гэх ойлголтыг эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулснаар хүүхэдтэйгээ хамт амьдрах боломжгүй болсон нөхцөлд шүүхээс насанд хүрээгүй хүүхдийг эцэг, эхийн хэнд үлдээх вэ гэдэг асуудлыг шийдвэрлэж байгаа ажиллагааг ойлгож байна.⁴

Олон улсын эрх зүйн практикт “child custody” буюу хүүхдийн асрамж нь хүүхдийн дээд эрх ашгийг хангахын тулд шүүхээс эцэг, эх болон холбогдох этгээдүүдийн хооронд хүүхдийг хэн анхаарал, халамж, хяналтад авах вэ гэдгийг шийдвэрлэдэг ойлголт хэмээн хоёр үндсэн төрөлд хуваан авч үздэг.⁵

Биечилсэн асрамж (англ. *physical custody*): Энэ нь хүүхдийг өдөр тутам биечлэн халамжлах, амьдрах орчныг бүрдүүлэх, хоол хүнс, хувцас хунар, эрүүл мэнд, боловсрол, чөлөөт цаг, амралт зугаалгыг зохицуулахтай холбоотой ойлголт юм. Хүүхэд эцэг, эхийн хэнтэй тогтмол амьдрах вэ гэдгийг шийдвэрлэхдээ шүүх тухайн орчны аюулгүй байдал, хүүхдийн дасан зохицох чадвар, эцэг, эхийн боломж, хүүхдийн хүсэл зэргийг нэн тэргүүнд харгалзан үздэг.

Хууль ёсны асрамж (англ. *legal custody*): Энэ нь хүүхдийн өмнөөс чухал шийдвэр гаргах эрхийг тодорхойлдог бөгөөд хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, шашин шүтлэг, шилжилт хөдөлгөөн, хилийн чанадад зорчих, өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэр гаргах зэрэг асуудлыг хамардаг. Энэхүү асрамж нь хүүхдийн ирээдүйн амьдралд нөлөөлөх хэмжээний учир эрх зүйн хувьд онцгой ач холбогдолтойд тооцогддог.

Эдгээр асрамжийн хэрэгжих хэлбэр нь дараах хоёр үндсэн хэлбэртэй байна: Дангаараа хэрэгжүүлэх асрамж (англ. *Sole custody*): Биечилсэн болон хууль ёсны асрамжийг нэг тал дангаараа хэрэгжүүлнэ. (англ. *Sole legal custody/sole physical custody*) Энэ тохиолдолд хүүхдийг асрамждаа аваагүй тал нь хүүхэдтэй уулзах эрхтэй боловч шийдвэр гаргах, өдөр тутмын асрамжид оролцохгүй.

⁴ Авирмэдийн Дугармаа, Гэр бүлийн эрх зүй, (Улаанбаатар: Адмон, хэвлэлийн компани, 2016), 54 дэх тал.

⁵ Bryan A.Garner, Black’s law dictionary, 8th ed, (Standard edition) 412.

Хамтарсан асрамж (англ. *Joint custody*): Эцэг, эх хоёр хүүхдийн асрамжийг хамтран хэрэгжүүлдэг. Энэ хэлбэр нь хүүхдийн амьдралд аль аль тал идэвхтэй оролцох боломжийг олгож, хүүхдийн эцэг, эхтэйгээ харилцах эрхийг тэнцвэртэй хангадаг. Хамтарсан асрамж нь хоёул шийдвэр гаргах эрхийг хуваалцах (*joint legal custody*) эсхүл хүүхэд аль алинд ээлжлэн амьдрах (англ. *joint physical custody*) хэлбэрээр байж болно.

Хүүхдийн асрамжийг тогтоохдоо хүүхдийн нас, бие бялдар, сэтгэлзүйн байдал, хүүхэд аль эцэг, эхтэйгээ илүү ойр дотно, тогтвортой харилцаатай байгаа, эцэг, эхийн асран хамгаалах чадвар (ажлын нөхцөл, орлого, орон байр, амьдралын хэв маяг) хүүхдийн сурч боловсрох, хөгжих орчин, хүүхдийн өөрийн хүсэл сонирхол, эцэг, эхийн хоорондын харилцааны зөрчил нь хүүхдийн сэтгэлзүйд хэрхэн нөлөөлж байгаа зэргийг дүгнэж, хүүхдийн тогтвортой, аюулгүй, халамжтай орчинд амьдрах нөхцөл хамгийн сайн хангагдахаар талд нь шийдвэрлэх чиг хандлагатай.

Харин манай улсын хувьд гэрлэлт цуцлахад хүүхэд эцэг, эхийн хэнтэй нь байнга оршин суухыг тодорхойлдог гэдэг агуулгаараа ганцаарчилсан биечилсэн асрамжийг тогтоож байгаа мэт боловч эцэг, эхийн хүүхдийн өмнө хүлээх үүрэг хэвээр үлдэж байгаагаас үзэхэд хамтарсан асрамжийн хэлбэрийн шинжийг давхар агуулж байна.

IV.ХҮҮХДИЙН АСРАМЖИЙН ХУУЛЬ ЗҮЙН ҮР ДАГАВАР

Гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж тогтоолгох, тэтгэлэг гаргуулах, эцэг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлага бүхий маргааныг шийдвэрлэхэд шүүх хүүхдийн асрамжийг хамтатган шийдвэрлэдэг практик төлөвшсөн байна.⁶

Жишээлбэл, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024.03.04-ний өдрийн 184/ШШ2024/01181 дүгээр шийдвэрээр гэрлэлт цуцалж, 5-15 насны 4 хүүхдийг эхийн асрамжид үлдээн, эцгээс хүүхдүүдэд тэтгэлэг гаргуулан шийдвэрлэжээ. Хариуцагч буюу нөхөр хүүхдүүдийг өөрийн асрамжид авахаар маргасан боловч 7-оос дээш насны 3 хүүхдийн санал, гэрлэгчид тусдаа байснаас хойш хүүхдүүд эхийн асрамжид байсан, амьдарч буй газартаа ойр сургууль, цэцэрлэгт хамрагдаж байгаа, дассан орчныг өөрчлөх ноцтой шалтгаан байхгүй зэрэг нөхцөлийг харгалзан хариуцагчийн татгалзлыг хүлээн аваагүй байна. Шийдвэрийн үндэслэх хэсэгт хүүхдүүдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээж буй явдал нь тусдаа амьдрах болсон эцэг, эхийн хэнтэй нь тухайн хүүхэд байнга оршин суухыг тодорхойлж, хүүхдийн амьдрах газрыг тогтоож буй болохоос эцэг, эхийн хүүхдийн өмнө хүлээсэн үүргийг хуваарилж буй асуудал биш гэдгийг анхаарах нь зүйтэй гэж дүгнээд тогтоох хэсэгт Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.6-д зааснаар хуулиар хүлээсэн эцэг, эхийн үүрэг хэвээр үлдэхийг, уг үүргээ хэрэгжүүлэхэд нь зохигчдын хэн аль нь саад болохгүй” хэмээсэн нь гэрлэлт цуцлах шийдвэрийн хүүхдийн асрамжийн талаарх загвар жишиг болсон дүгнэлт юм.

6 Монгол Улсын дээд шүүх, “Гэр бүлийн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар /тойм/”, 2013.12.23, <http://old.supremecourt.mn/act/view/58>, (Сүүлд үзсэн: 2025.08.26).

Гэтэл гэрлэлт цуцалж, хүүхдийн асрамжийг ийнхүү шийдсэнээр дараах асуудлууд хариу хүлээн гарч ирнэ. Хариуцагч эцгийн үүргээ, жишээлбэл, өсгөн бойжуулах, төлөвшүүлэх, асран хамгаалах үүргээ хэрхэн хэрэгжүүлэх вэ? Хүүхдийн талаас эцгийнхээ анхаарал халамжид байх, байнгын харилцаатай байх эрх хэрхэн хэрэгжих вэ? Хүүхдийн өдөр тутмын хоол унд, орон байраар хангах, цэцэрлэг, сургуульд хүргэх, авах үүргийг хэн хүлээх вэ, хэрэв хүүхэд гадаадад, эсхүл өөр орон нутагт амьдрах болоход асрамжид авсан эцэг эх дангаар шийдвэр гаргах уу? Хүүхдийн эрүүл мэндийн асуудлаар хэн шийдвэр гаргах вэ? Хүүхдийг эрх зүйн харилцаанд хэн төлөөлөх вэ? Хүүхдийн бусдад учруулсан хохирлыг хэн хариуцах вэ?

Одоогийн байдлаар бодит амьдрал дээр хүүхдийг асрамжид авсан тал өдөр тутмын хэрэглээг хангаж, хүүхдийн талаар аливаа шийдвэр гаргаж, хүүхдийг эрх зүйн харилцаанд төлөөлж, улмаар хүүхдийн өмнөөс хариуцлага хүлээх хандлага давамгайлдаг бол асрамжийг аваагүй тал эдгээр үүрэг шууд оногдохгүй ч хүүхэдтэйгээ уулзах, харилцах нөхцөл журам нь тодорхойгүй болж, энэ нь салсан эхнэр, нөхөртэйгөө харилцаа ямар байгаагаас шалтгаалсан шинжтэй байдаг.

Тэгэхээр хүүхдийн асрамжийг тогтоох гэдэг ойлголт нь зөвхөн хүүхдийн хаягийг тодорхой болгох төдийгөөр авч үзэх биш амьдрал дээр эцэг, эх, хүүхдийн эрх, үүрэг, хариуцлагад хэрхэн нөлөөлж, үр дагавар үүсгэж буйг авч үзэх нь зүйтэй.

4.1 Оршин суух газраа сонгох эрхийг хэрэгжүүлэх

Сүүлийн жилүүдэд Монголоос гадаад улс руу нүүх хөдөлгөөн эрчимтэй, тасралтгүй үргэлжилж байгаа, мөн гадаад улсын иргэнтэй гэрлэгчдийн тоо өсөн нэмэгдэж байна. Мөн хүүхдийг эмээ, өвөөгийн өсгөх нь Монголын уламжлал соёлын хүрээнд хүлээн зөвшөөрөгддөг хандлагын хувьд хүүхэд гадаад, дотоодод шилжин суурьших явдал гарах нь дамжиггүй.

Хүүхдийг эмээ, өвөөгийн гэрт өсгөж байгаа нь эцэг, эх хүүхдээ асран хамгаалах үүргээ зөрчсөн гэх үндэслэлээр хүүхдийн асрамжийг өөрчлүүлэхээр асрамжийг аваагүй тал нэхэмжлэл гаргаж шүүхээр шийдвэрлүүлдэг.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга болон түр оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхэд нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт гадаадад цагаачлах, дүрвэх, байнга болон түр оршин суух, эх орондоо амьдрах эрхтэй байхаар заасан. Хүүхдийн уг эрх эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс шууд хамаарах ба хүүхдээ асрамжид авсан тал нөгөө талаасаа зөвшөөрөл авах шаардлагагүйгээр хүүхдийг гадаадад амьдруулах шийдвэр дангаар гаргах боломжтой байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журамд зааснаар хүүхдийн төрсний гэрчилгээнд эцэг, эхийн аль нэгний мэдээлэл байгаа тохиолдолд зөвхөн нэг талтай нь хамт, эсхүл нэг талаас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр Монгол улсын хилээр нэвтрэх эрхтэй байна.

Өөрөөр хэлбэл, өөр орон нутагт байтугай өөр улс оронд шилжин суурьшихад эцэг, эхийн аль нэгнийх нь л зөвшөөрөл хангалттай байна. Хүүхдийн гадаад, дотоодод шилжин суурьших явдал ихсэж байгаа нь Монголын энэ цаг үеийн үзэгдэл

бөгөөд үүнийг шийдвэрлэхгүй орхигдуулах нь хүүхдийн хэл, соёл, боловсрол, эрүүл мэнд, эцэг эхийн аль нэгтэй харилцах эрхэд шууд нөлөөлж, хүүхдийн хөгжлийн эрхийг хязгаарлах эрсдэлтэй юм.

4.2 Хүүхэд эд хөрөнгө өмчлөх эрхээ хэрэгжүүлэх

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар хүүхэд эд хөрөнгө өмчлөх, түүний үр шимийг хүртэх эрхтэй. Гэхдээ хүүхэд иргэний эрх зүйн бүрэн чадамжтай этгээд биш тул хөрөнгийг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч түүний өмнөөс удирдах, захиран зарцуулна.

Шүүхээр гэрлэлт цуцалж, хүүхдийн асрамж шийдвэрлэхэд хүүхдийн хөрөнгийг хэн удирдах талаар тусгайлан зааж өгдөггүй боловч сүүлийн жилүүдэд хүүхдэд сар бүр 100,000 төгрөгийн мөнгөн тэтгэмж олгох болсон, Монгол Улсын иргэн бүр “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааг эзэмшиж, ногдол ашгийг хүртэх болсонтой холбоотой хүүхдийн мөнгөн тэтгэмжийн дансны эзэмших эрхийг шилжүүлэх, уг мөнгийг гаргуулах зэрэг хүүхдийн хөрөнгөтэй холбоотой нэхэмжлэл нэмэгдэх хандлагатай байна.

Бодит байдал дээр арилжааны банкны дотоод дүрэм журмаас хамааран хүүхдийн асрамж тогтоосон шүүхийн шийдвэрийг үндэслэн хүүхдийн дансны эзэмшигчийг эцэг, эхийн хэн нэгнээс нөгөөд шилжүүлдэг байна.

Магадгүй хүүхэд бусдаас хөрөнгө өвлөх, өөрийн авьяас чадвараар их хэмжээний орлого олсон нөхцөлд гэрлэлт цуцлахад хүүхдийн нэрийн өмнөөс хөрөнгийг удирдах этгээдийг зааж өгөх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Энэ асуудлыг тухайлбал, ХБНГУ-д хүүхдийн хөрөнгийг удирдах эрхийг шүүхээс өөрөөр тогтоогоогүй нөхцөлд ихэвчлэн эцэг, эх хамтаар хэрэгжүүлдэг. Гэрлэлт цуцлахад шүүх хөрөнгө удирдах эрхийг эцэг, эхийн хэн нэгэнд дангаар олгосон тохиолдолд хэрэв энэ талаар талууд маргасан бол их хэмжээний хөрөнгийн хувьд хөрөнгийг хамгаалах нэмэлт асран хамгаалалт томилдог. Мөн хүүхдийн үл хөдлөх хөрөнгийг зарах, санхүүгийн томоохон шийдвэр гаргах, их хэмжээний өв хүлээн авах, татгалзах нөхцөлд Гэр бүлийн шүүхээс зөвшөөрөл авдаг байна.

АНУ-д мөн ялгаагүй ойролцоо зохицуулалттай байна. Их хэмжээний хөрөнгө, өв хүлээн авах, захиран зарцуулах тохиолдолд хөрөнгийн удирдлагын эрх нэг эцэг, эхэд (sole custody) олгогдсон нөхцөлд нөгөө эцэг, эх, эсхүл гуравдагч этгээдийг хөрөнгийн хамгаалагч (guardian of the estate)-аар томилдог. Зарим онцгой тохиолдолд мөн шүүхийн зөвшөөрөл шаарддаг байна.⁷

Иймд хүүхдийн хөрөнгийг удирдах эрхийг хэнд олгохыг шүүхээр шийдвэрлэхгүй, орхигдуулах нь хүүхдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх, хууль зүйн эрсдэл дагуулсан асуудал болохыг онцлох нь зүйтэй юм.

7 § 1626 Absatz 1 Satz 1 BGB
§ 1642 Abs. 1 BGB
§ 1643 Abs. 1 BGB
§ 1642 Abs. 1 BGB

4.3 Хүүхдийн бусдад учруулсан хохирлыг арилгах

Хүүхдийн бусдад учруулсан гэм хорыг Иргэний хуулийн 503 дугаар зүйлд⁸ зааснаар тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, эцэг эх, асран хамгаалагч хариуцан арилгадаг. Гэм хор учруулсан хүүхдийг эрх зүйн чадамжгүй эсхүл хохирлыг арилгах бодит эдийн засгийн чадавхгүй гэх үндэслэлээр хариуцлагаас чөлөөлсөн тохиолдолд уг гэм хорын улмаас хохирсон этгээдийг хамгаалах шаардлага зүй ёсоор урган гарна. Ийнхүү хохирогчийг хамгаалах болон хүүхдийг хариуцлагаас чөлөөлөх аль аль зорилгын үүднээс эцэг, эхэд нь хариуцлага хүлээлгэхдээ хүүхдийн зан байдалд хяналт тавих үүргээ зөрчсөн гэх үндэслэлийг баримжаалсан тогтолцоо хөгжих болжээ.⁹ Хяналтын үүрэг (supervision) бүхий этгээдийг тодорхойлохдоо хүүхдийг асран хамгаалах эцэг, эхийн хуулиар хүлээсэн эрх, үүрэгтэй холбон тайлбарладаг.

Гэрлэлт цуцлах шүүхийн практикт эцэг, эхийн асран хамгаалах үүргийг хуваарилаагүй, хамтран хэрэгжүүлэхээр шийдвэрлэж байгаа нөхцөлд хяналтын үүрэг хэнд байгааг тогтооход хүндрэл учирч болзошгүй.

4.4 Хүүхдийн боловсрол, эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх эрх

Боловсрол болон эрүүл мэндийн асуудал нь хүүхдийн урт хугацааны сайн сайхан байдал, хөгжил, ирээдүйн боломжид шууд нөлөөлдөг тул томоохон шийдвэрүүд гэж тооцогддог. Энэхүү төрлийн шийдвэрүүд өдөр тутмын энгийн асаргаанаас ялгаатай бөгөөд үндэслэлтэй судалгаа, хууль ёсны зөвшөөрөл, хариуцлага хүлээх шаардлагатай байдаг. Нэгдүгээрт, боловсрол нь хүүхдийн ирээдүйн амжилт, үнэт зүйлс, хэл соёл, нийгмийн байр суурьт нөлөөлдөг чухал хүчин зүйл юм. Тухайлбал, төрийн болон хувийн сургууль, шашны боловсрол, олон улсын сургалтын төрөл зэргийг сонгох нь хүүхдийн ирээдүйн замналд онцгой ач холбогдолтой. Тусгай хэрэгцээт боловсрол, давтлага хичээл, дугуйлан зэргийг шийдэх нь хүүхдийн академик амжилт болон хувь хүний хөгжилд шууд хамаатай. Хоёрдугаарт, хүүхдийн бие физиологийн болон сэтгэцийн эрүүл мэндэд шууд нөлөө үзүүлдэг агуулгаар хүүхдийн эрүүл мэндийн асуудал томоохон чухал шийдвэрт ордог байна. Тухайлбал, вакцин хийлгэх, мэс засалд орох, эмнэл зүйн эмчилгээ авах, сэтгэл заслын тусламж авах зэрэг нь хүүхдийн эрүүл мэндэд нөлөө бүхий үр дагавар авчрах боломжтой тул шийдвэрийг болгоомжтой, хариуцлагатайгаар гаргах шаардлагатай гэж үздэг байна.

8 Иргэний хууль (2002)-ийн 503 дугаар зүйлийн 503.1 “7-14 хүртэлх насны болон эрх зүйн чадамжгүй иргэний бусдад учруулсан гэм хорыг тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, эцэг эх, асран хамгаалагч хариуцан арилгана.” ИХ-ийн 503.2 “7-14 хүртэлх насны иргэн сургууль, хүүхэд хүмүүжүүлэх болон эрүүл мэндийн байгууллагын шууд хяналтын дор байхдаа бусдад учруулсан гэм хорыг эдгээр хуулийн этгээд хариуцан арилгана.” ИХ-ийн 503.3 “Сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон иргэний бусдад учруулсан гэм хорыг түүний асран хамгаалагч буюу түүнд байнгын хяналт тавих үүрэг бүхий этгээд хариуцан арилгана.” ИХ-ийн 503.4 “Эцэг, эх, асран хамгаалагч нь хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлсэн гэдгээ нотолж чадвал тэдгээрийг гэм хор арилгах үүргээс чөлөөлж болно.” ИХ-ийн 503.5 “Насанд хүрээгүй хүмүүс бусдад учруулсан гэм хорыг өөрөө хариуцан арилгах бөгөөд түүний цалин хөлс, орлого, захиран зарцуулах эрхэд нь байгаа хөрөнгө гэм хорыг арилгахад хүрэлцэхгүй бол хүрэлцэхгүй байгаа тэр хэмжээгээр эцэг эх, харгалзан дэмжигч нь нөхөх хариуцлага хүлээнэ.” ИХ-ийн 503.6 “Энэ хуулийн 503.5-д заасан гэм хорыг арилгахад энэ хуулийн 503.4-т заасан журам нэгэн адил үйлчилнэ.”

9 Жаргалсайханы Оюунтунгалаг, Иргэний эрх зүйн онолын асуудал, Гэм хорыг арилгах үүргийн тусгай төрөл: Эрх зүйн чадамжгүй болон зарим чадамжтай этгээдийн гэм хорын хариуцлага, (Улаанбаатар: 2018), 182 дахь тал.

Одоогийн эрх зүйн зохицуулалт, шүүхийн практикт хүүхдийн боловсрол, эрүүл мэндийн талаар шийдвэр гаргах эрх нь тусгайлан авч үздэггүй, эцэг, эх хамтран хэрэгжүүлж байгаа гэж ойлгож болно.

4.5 Хүүхэдтэй уулзах эрх

Практикт хүүхдийг эцэг, эхтэй уулзуулахгүй байх, холбоо барихыг хориглох, хүүхдэд сөрөг мэдээллээр нөлөөлөх, шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх зэрэг нийтлэг зөрчлүүд гарч байна. Гэр бүлийн тухай хуульд зааснаар эцэг, эх байх эрхийг хасах, хязгаарласнаас бусад тохиолдолд гэрлэлтээ цуцлуулсан эцэг, эхийн хүүхэдтэйгээ уулзах эрхийг хязгаарлаж болохгүй. Асрамжийг тогтоосон бол эцэг, эхийн нөгөө нь хүүхэдтэй уулзаж болохгүй гэсэн ташаа ойлголт байдаг.

Хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эх хүүхэдтэйгээ уулзах, харилцах гэдэг нь нэг талаас хүүхдийн эрх, нөгөө талаас эцэг эхийн үүрэг тул үүнийг баталгаатай эдлүүлэх шаардлага зүй ёсоор үүсэж байна. Шүүхэд хүүхдийн асрамжийг шийдвэрлэх үед хүүхдээс тусдаа байх эцэг, эхэд хүүхэдтэйгээ ямар давтамжтай, ямар хугацаагаар, хэрхэн уулзах талаарх зохицуулалтгүйгээс энэ талаар шүүхийн шийдвэрт тэр бүр заадаггүй боловч сүүлийн жилүүдэд зохигчдын тавьсан шаардлагын дагуу хүүхэдтэй уулзах давтамж, хугацаа, нөхцөлийг нь зааж өгөх хандлага нэмэгдэж байна. Тухайлбал Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 2022 онд хүүхэдтэй уулзах журам тогтоосон шийдвэр гаргаж, эцгийг хүүхэдтэй сар бүрийн 2, 4 дэх амралтын өдөр уулзуулж байхыг, мөн Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2021 онд эцгийг хүүхэдтэй нь долоо хоног бүр цахимаар 2 удаа харилцах эрхийг тус тус тогтоож шийдвэрлэж байсан.¹⁰

Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5 дахь хэсэгт гэрлэлт цуцлуулсан тохиолдолд эцэг, эх үүргээ хэрэгжүүлэх журмыг тусгайлан тохиролцоогүй бол түүнийг шүүх тогтоохоор тусгасан байдаг боловч энэ заалт нь ерөнхий тул хуулийн нарийвчилсан зохицуулалтгүйгээр хүний үндсэн эрхэд хязгаарлалт үүсгэх эрсдэлтэй байж болох юм.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын үзэж буйгаар хүчирхийллийн төрлийг бэлгийн, биеийн, сэтгэлийн, үл хайхрах хүчирхийлэл гэж дөрөв болгон ангилсан байдаг.¹¹

Үл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхдэд сэтгэлээр унах, сэтгэл хөдлөлөө барьж, хянаж чадахгүй байх, анхаарал халамж байнга хүсэх, шаардах, зүй бус үйлдэл гаргах, бие, сэтгэц, оюуны хөгжлөөрөө хоцрох, өөртөө итгэлгүй болох зэрэг шинж илэрдэг. Ялангуяа гэрлэлт цуцлалтаас хамааралтай эцэг, эхийн хэн нэгний асрамжид шилжсэн хүүхэд үл хайхрах хүчирхийлэлд өртөх магадлал өндөр байдаг.

¹⁰ Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 02 сарын 08-ны өдрийн 183/ШШ2022/00273 дугаар шийдвэр, https://shuukh.mn/single_case/120236?daterange=2020-01-01%20-%202025-05-8&id=1&court_cat=1&bb=1 ХУДИХАШШ-ийн 2020 оны 04 сарын 07-ны өдрийн 183/ШШ2020/00857 дугаар шийдвэр, https://shuukh.mn/single_case/99457?daterange=2020-01-01%20-%202025-05-08&id=1&court_cat=1&bb=1 ХУДИХАШШ-ийн 2021 оны 11 сарын 17-ны өдрийн 183/ШШ2021/02629 дүгээр шийдвэр, https://shuukh.mn/single_case/107582?daterange=2020-01-01%20-%202025-05-08&id=1&court_cat=1&bb=1

¹¹ World Health Organization Geneva, World report on violence and health, (2002) https://iris.who.int/bitstream/handle/10665/42495/9241545615_eng.pdf

Энэ нь эцэг, эхийн өдөр тутмын харилцаа үгүй болсноор хүүхдэд тавих хараа хяналт суларсантай шууд холбоотой юм.

АНУ-д асрамжийг аваагүй тал уулзалтын эрхтэй байх ба дараах 3 төрлийг тогтоож өгчээ. Үүнд:

1. Тогтсон уулзалт: Жишээ нь, амралтын өдрүүд, амралтын үе гэх мэт.
2. Харилцан тохиролцсон уулзалт: Уян хатан, эцэг эх хоёрын тохиролцоонд тулгуурладаг.
3. Хяналттай уулзалт: Хүүхдийн аюулгүй байдалд эрсдэлт хүчин зүйл байгаа гэж үзвэл шүүхийн шийдвэрээр гуравдагч этгээд хянадаг.

Хүүхдийг асрамждаа аваагүй эцэг, эх уулзалтын эрхийг голчлон авдаг боловч зарим муж улсад өвөө, эмээ, хойд эцэг, эх, ах, эгчийн уулзалтыг хүүхдийн эрх ашигт нийцэж байвал зөвшөөрдөг байна. Хэрвээ уулзалтыг хориглох, тохирсон цагийг мөрдөхгүй бол нөгөө тал нь шийдвэрийг албадан гүйцэтгэх эсхүл асрамжийг өөрчлөх хүсэлт гаргаж болно.

ХБНГУ-д хүүхэд эцэг эхтэйгээ холбоотой байх, уулзах эрхийг хүлээн зөвшөөрч, хяналттай ба уян хатан уулзалтын хэлбэрээр хэрэгжүүлдэг. Хүүхэдтэй уулзах нь зөвхөн эрх биш, үүрэг ч мөн гэж үздэг. Хэрвээ уулзалтыг тасалдуулбал албадан гүйцэтгэх, асрамжийг өөрчлөх эрхтэй байхаас гадна торгуулийн арга хэмжээ авдаг байна.¹²

Манай улсын хувьд шүүхийн шийдвэрээр уулзах журам, нөхцөлийг тогтоосон тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраар албадан гүйцэтгүүлэх боломжтой боловч гэр бүл, хүүхдийн харилцаанд энэ тогтолцоо тийм ч тохиромжтой биш гэж үзэж байна. Харин Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор хүүхэдтэйгээ уулзах эрхээ удаа дараа хэрэгжүүлээгүй, мөн уулзах эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулсан бол зөрчлийн хуулиар шийтгэл ногдуулах зохицуулалтыг нэмж тусгажээ.

Хүүхдийг асрамждаа аваагүй талд уулзах нөхцөл, журмыг тодорхой болгож, хэрэгжүүлээгүй тохиолдолд албадлагын тохирсон арга хэмжээ, хариуцлагын механизм, уулзах эрхээр дамжуулан хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

V. ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

5.1 Америкийн Нэгдсэн Улс (АНУ)

Хүүхдийн асрамжийн талаарх зохицуулалт нь муж бүрд ялгаатай хэдий ч дараах нийтлэг зохицуулалттай байна¹³.

Хүүхдийн асрамжийн төрөл:

¹² § 1684–1686 Abs. BGB

¹³ National Council of Juvenile and Family court judges, National Center for State Courts, Uniform Child Custody Jurisdiction and Enforcement Act https://www.ncjfcj.org/wp-content/uploads/2018/07/UCCJEA_Guide_Court_Personnel_Judges_Final.pdf

Хууль ёсны асрамж (англ. *legal custody*): Хүүхдийн хүмүүжил, боловсрол, эрүүл мэнд, шашин шүтлэгтэй холбоотой томоохон шийдвэр гаргах бүрэн эрх олгодог. Жишээлбэл, мэс засал хийлгэхэд зөвшөөрөл өгөх г.м

Хууль ёсны асрамжийг дангаар хэрэгжүүлэх (англ. *sole legal custody*)

Хууль ёсны асрамжийг хамтран хэрэгжүүлэх (англ. *joint legal custody*)

Биечилсэн асрамж (англ. *physical custody*): Хүүхэд өдөр тутам хаана амьдрахыг илэрхийлдэг.

Биечилсэн асрамжийг дангаар хэрэгжүүлэх (англ. *sole physical custody*)

Биечилсэн асрамжийг хамтран хэрэгжүүлэх (англ. *joint physical custody*)

Асрамжийн шийдвэр гаргахад хүүхдийн дээд эрх ашиг (англ. *best interest of the child*)-ийг хангах зарчимд үндэслэх ба хүүхдийн нас, эрүүл мэнд, эцэг, эхийн энэнгшил (англ. *emotional tie*), хүүхдэдээ анхаарал тавих боломж, чадвар, гэрийн орчны тогтвортой байдал, хүчирхийлэл, үл хайхрал үзүүлж байсан эсэх түүх зэргийг харгалзан үздэг байна.¹⁴

Эцэг эх хүүхдийн асрамжийн талаар өөрсдөө, хуульчаар дамжуулан, эсхүл эвлэрүүлэн зуучлагчийн тусламжтай харилцан зөвшилцөж гэрээ хийж болох ч заавал биелэгдэх хүчин чадалтай болгохын тулд шүүхийн шийдвэр, захирамжаар баталгаажуулдаг байна.

Хэрэв хүүхдийн асрамжийн нөхцөл байдал өөрчлөгдвөл асрамжийг шүүхээр өөрчлүүлэх боломжтой.

5.2 Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)

Хүүхдийн асрамж нь эцэг, эхийн хариуцлага (англ. *Elterliche Sorge-parental responsibility*) гэх үзэл баримтлалын үндсэн дээр хүүхдийн дээд эрх ашгийг харгалзан шийдвэрлэдэг.

Хүүхдийн асрамж нь гэрлэлттэй гэр бүл, гэрлээгүй гэр бүлийн хувьд ялгаатай зохицуулалттай. Гэрлэсэн эцэг, эхийн хувьд автоматаар хамтын асрамжийн үүрэг хүлээдэг бол гэрлээгүй эцэг, эхийн хувьд харин эцэг, эх хамтаар асрамжийг хэрэгжүүлэхээр тохирсон, хүүхдийн эрх ашигт нийцсэн гэж үзсэнээс бусад тохиолдолд эх нь дангаараа хүүхдийг асрамждаа авдаг байна.

Асрамжийн төрлийн хувьд хууль ёсны болон биечилсэн асрамж гэж хуваагдах ба хууль ёсны асрамж нь боловсрол, эрүүл мэнд, шашны хүмүүжлийн талаар шийдвэр гаргах эрхийг олгодог бол биечилсэн асрамжаар хүүхдийн оршин суух газрыг тодорхойлдог. Асрамжийг хамтаар хэрэгжүүлэхээр шийдсэн ч хүүхэдтэй амьдарч байгаа эцэг, эх нь хүүхдийн хувьд шийдвэр гаргах эрх бүхий этгээд (англ. *beneficial*) гэж үзнэ. Шүүхээс хууль зүйн асрамж, биечилсэн асрамжийг шийдвэрлэсэн ч хүүхдээс тусдаа байгаа эцэг, эхэд уулзалтын эрх (*Umgangsrecht*)-ийг мөн тогтоож өгдөг.¹⁵

14 FindLaw: <https://codes.findlaw.com/us/title-18-crimes-and-criminal-procedure/18-usc-sect-3523/>

15 Schlun and Elseven law firm page: <https://se-legal.de/schlun-elseven-lawyers/family-law-germany/internation->

5.3 Япон Улс

Япон Улсад эцэг эхийн бүрэн эрх (*Shinken-parental authority*) гэх ба энэ нь хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, хөрөнгийн менежментийн талаар шийдвэр гаргах эрх, үүргийг багтаасан ойлголт юм.

Япон Улсын Иргэний хуульд 2024 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр гэрлэлт цуцалсны дараа хүүхдийн асрамжийг хамтаар хэрэгжүүлэх зохицуулалтыг оруулж, 2026 оноос мөрдөгдөж эхэлнэ. Одоогийн зохицуулалтаар хүүхдийн асрамжийг дангаараа (*Tandoku Shinken*), ихэвчлэн эх хэрэгжүүлдэг. Харин хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эх нь уулзалтын эрх (*Yōgai no Kenri*)-ийг эдэлдэг.

Хамтын асрамж нь гэрлэлтийг нэгэнт цуцалсан тохиолдолд хуулиар зөвшөөрдөггүй. Эцэг эх салснаас гадна, асрамжтай эцэг эх дангаараа асрамжийг хадгалж, асрамжгүй эцэг эх нь уулзалтын эрх эдэлнэ. Уулзалтын эрх нь ихэвчлэн хязгаарлагдмал байдаг бөгөөд асрамжтай эцэг эхтэй тохиролцох шаардлагатай болдог. Хүүхдийн асрамжийн талаар уян хатан бус уг зохицуулалт нь эцэг эхийн үүрэг, нийгмийн хүлээлт зэрэг соёлын хүчин зүйлс нөлөөлдөг.¹⁶

5.4 Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)

БНСУ-ын гэр бүлийн эрх зүйд хууль ёсны, бодит асрамжийг тогтоодог байна. Хууль ёсны асрамж (**친권** – *Chin-gwon*): хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, шашин шүтлэг, сайн сайхан байдлыг шийдвэрлэх эрх, бодит асрамж (**양육권** – *Yang-yook-gwon*): хүүхдийн өдөр тутмын амьдрал, асаргаа, хаана амьдрахтай холбоотой эрх. Зарим тохиолдолд нэг эцэг, эх хууль ёсны асрамжийг, нөгөө нь бодит асрамжийг эзэмшдэг. Гэвч ихэнх тохиолдолд нэг эцэг, эх хоёр эрхийг хоёулыг нь авдаг. Ихэнх тохиолдолд хууль ёсны асрамжийг нэг талд өгдөг боловч хамтарсан асрамж (*joint custody*) нь харьцангуй ховор ч, хоёр тал тохиролцсон тохиолдолд боломжтой.

Хүүхдийн асрамжийг тогтоох гол шалгуур бол хүүхдийн дээд эрх ашиг байна. Үүнд: хүүхдийн сэтгэлзүйн тогтвортой байдал, хэнд илүү дотно вэ, сургалтын болон амьдрах орчны тогтвортой байдал, эцэг, эхийн эдийн засгийн чадавх, асрамжлах чадвар, хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх хүсэл эрмэлзэл, хүүхдийн хүсэл сонирхлыг мөн харгалзана.

Хүүхэд хүчирхийлэлд өртөх, үл хайхрах, эсхүл эцэг, эхийн амьдралын нөхцөл өөрчлөгдөх зэрэг тохиолдолд хүүхдийн асрамжид өөрчлөлт оруулах боломжтой.

VI. ДҮГНЭЛТ

Гэрлэлт цуцлах, гэрлэлтээ батлуулаагүй эцэг, эхээс төрсөн хүүхдийн хувьд эцэг тогтоолгох, тэтгэлэг гаргуулах шаардлага бүхий маргааныг хянан хэлэлцэх үед хүүхдийн асрамжийг хамтатган шийдвэрлэдэг шүүхийн практик тогтжээ.

Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль зэрэг гэрлэлт цуцлах, хүүхдийн эрх ашиг хөндөгдөх харилцааг зохицуулсан хуулиар

al-family-lawyer-germany/german-us-family-law-child-custody-and-right-of-access/?lang=en&utm_source.com

16 Japanese Verybest Law Offices page: https://global.vbest.jp/en/individuals/divorces/parental_authority/?utm_source

хүүхдийн асрамжийн талаарх ойлголтыг тодорхойлоогүй, Улсын дээд шүүхийн зөвлөмж, шүүхийн практикт хүүхдийн асрамжийг тогтооно гэдгийг хүүхдийн оршин суух газрыг тодорхойлох асуудалд хязгаарлаж, эцэг, эхийн эрх үүргийг нарийвчлан хуваарилахгүйгээр шийдвэрлэн иржээ.

Өнөөгийн нийгэмд гэр бүлийн харилцаа олон төрөл хэлбэртэй хөгжин, хүүхэд нийгмийн идэвхтэй оролцогч болохын зэрэгцээ түүний хөгжих, орлого олох, үзэл бодлоо илэрхийлэх боломж бүрдсэн тул хүүхдийн эрхийг илүү тодорхой хамгаалах, бодит байдалд нийцсэн эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлага тулгарч байна.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлэлцэгдэж байгаа энэ үед хүүхдийн асрамж гэх ойлголтын нэр томъёоны тодорхойлолтыг оруулж, биечилсэн асрамж, хууль ёсны асрамжийн төрлийг, дангаар болон хамтран хэрэгжүүлэх хэлбэрийг тусгаж өгөх нь зүйтэй гэх саналыг энэхүү илтгэлээр дэвшүүлж байна. Тодруулбал, хүүхэд эцэг, эхийн хэнтэй хамт амьдрахыг зааж өгөхийг хүүхдийн асрамж гэж үздэг өнөөгийн хандлагыг өөрчилж, хүүхдийн өдөр тутмын асран хамгаалах үүргийг биечилсэн асрамж (*physical custody*), хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, шилжилт хөдөлгөөн, хөрөнгийн эрхийн талаар шийдвэр гаргах эрхийг хууль ёсны асрамж (*legal custody*) гэж тодорхойлж, үүнийг эцэг, эх дангаар эсхүл хамтран хэрэгжүүлэх нөхцөлийг тусгаж өгөх шаардлагатай байна.

Түүнчлэн асрамжийг шийдвэрлэхдээ ямар шалгуур үзүүлэлтийг баримтлах, эдгээрийн эрэмбэ дараалал, хүүхдийн санал авах арга аргачлал, хүүхдийн асрамжийг хэрхэн хэрэгжүүлж байгаад тавих хяналт, албадан хэрэгжүүлэх тогтолцоо, биелүүлээгүй нөхцөлд хүлээлгэх хариуцлага, асрамжийг өөрчлөх болзол нөхцөлийн талаар судалгаа хийж, санал дэвшүүлэх шаардлага үүсэж байгааг дурдах нь зүйтэй.

НОМ ЗҮЙ

1.Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Гэр бүлийн тухай хууль, 1999 он.
3. Иргэний хууль, 2002 он.
4. Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016 он.
5. Улсын дээд шүүхийн 2008 оны 46 дугаар тогтоол “Гэр бүлийн болон Иргэний бүртгэлийн тухай хуулиудын зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай”
6. Улсын дээд шүүхийн 2017 оны 12 сарын 25-ны өдрийн “Гэр бүлийн холбогдолтой эрх зүйн маргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах зарим асуудал”
7. Хууль зүй, дотоод хэргийг сайдын 2017 оны А/49 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”
8. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 02 сарын 08-ны өдрийн 183/ШШ2022/00273 дугаар шийдвэр,
9. ХУДИХАШШ-ийн 2021 оны 11 сарын 17-ны өдрийн 183/ШШ2021/02629 дугаар шийдвэр,
10. ХУДИХАШШ-ийн 2020 оны 04 сарын 07-ны өдрийн 183/ШШ2020/00857

дугаар шийдвэр,

11. Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 03 сарын 04-ний өдрийн 184/ШШ2024/01181 дүгээр шийдвэр,

В. Ном, сурах бичиг

1. А.Дугармаа, Гэр бүлийн эрх зүй, 2016 он.
2. Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүйн онолын асуудал, 2018 он.
3. SA RINA, Шүүхийн журмаар гэрлэлт цуцлалтаас үүсэх хүүхдийн эрхийг хамгаалах тулгамдсан асуудал шийдэл, 2023 он.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:

А. Англи хэл дээр

- 6.1 Black's law dictionary, Bryan A.Garner. Eighth edition, page 412

3. Цахим эх сурвалж:

1. Үндэсний статистикийн хорооны цахим сайт: <https://www.1212.mn>
2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас: <https://www.judcouncil.mn>
3. ХБНГУ-ын хуулийн мэдээллийн сангийн цахим хуудас: https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/englisch_bgb.pdf
4. БНСУ-ын хуулийн мэдээллийн сангийн цахим хуудас: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55222&lang=ENG
5. Гэр бүл, хүүхдийн шүүгчдийн үндэсний зөвлөлийн цахим хуудас: https://www.ncjfcj.org/wp-content/uploads/2018/07/UCCJEA_Guide_Court_Personnel_Judges_Final.pdf
6. Findlaw хуулийн хайлтын системийн цахим хуудас: <https://codes.findlaw.com/us/title-18-crimes-and-criminal-procedure/18-usc-sect-3523/>
7. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын цахим хуудас: https://iris.who.int/bitstream/handle/10665/42495/9241545615_eng.pdf
8. Schlun болон Elseven хуулийн фирмийн цахим хуудас: https://se-legal.de/schlun-elseven-lawyers/family-law-germany/international-family-lawyer-germany/german-us-family-law-child-custody-and-right-of-access/?lang=en&utm_source.com
9. Япон Улсын хуулийн фирмийн цахим хуудас: https://global.vbest.jp/en/individuals/divorces/parental_authority/?utm_source

ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ”

Н.Оюунтуяа,
Нийслэлийн Иргэний хэргийн
давж заалдах шатны шүүхийн шүүгч (LL.M),

Т.Энхтуяа,
Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн
Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч (LL.M)

Агуулга

I. Удиртгал

II. Манай улсын үрчлэлтийн түүхэн эрх зүйн уламжлал болон
үрчлэлтийн хууль, эрх зүйн зохицуулалтын талаар

III. Үрчлэлтийн агуулга, зарчим болон манай улсын үрчлэлтийн
өнөөгийн байдал, үрчлэлтийг хүчингүйд тооцсон хууль хэрэглээний
талаар

IV. Олон улсын хүүхэд үрчлэлтийн асуудал, зарим улсын үрчлэлтийн
нцлог зохицуулалтын талаар

4.1 Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

4.2 Бүгд Найрамдах Хятад Ард Улс

4.3 Бүгд Найрамдах Эстони Улс

4.4 Америкийн Нэгдсэн Улс

4.5 Япон Улс

V. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өгөх
санал, дүгнэлт

Ном зүй

I. УДИРТГАЛ

Хүүхэд хамгаалахтай холбоотойгоор төрсөн эцэг эхээсээ хагацсан, эцэг эх нь нас барсан, хүүхдээ хаясан тохиолдолд тухайн хүүхдийг шинэ, байнга хамт байх гэр бүлтэй болгож байгаа явдал нь зөв шийдэл болдог гэж үздэгээс хүүхэд үрчлэх тухай асуудал гарч ирсэн.

Үрчлэлт нь зөвхөн хүүхдийг асрамжлах асуудал бус, тодорхой зорилготой, эрх зүйн онцгой үр дагавар үүсгэдэг, олон төрөл бүхий амьдралд өргөн тохиолддог өвөрмөц үйл ажиллагаа.

Үрчлэлтийн харилцаанд хүүхэд өөрийгөө хамгаалах чадваргүй байгааг онцгой анхаарч хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хангах зарчмыг асуудлын гол болгон авч үздэг ч хүний эрх, ялангуяа хүүхдийн эрхийг хөндсөн олон асуудлууд үүсэж, хүндрэл бэрхшээлүүд тулгардаг учраас хуулийн маш нарийн зохицуулалт шаарддаг.

Хүүхдийн эрхийн аливаа төрлийн зөрчил, хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгөөс хүүхдийг хамгаалах үр дүнтэй арга механизмын нэг бол тухайн улс дотоодын хууль тогтоомждоо үрчлэлтийг бүртгэх үйл явц, үрчлэлтийн дараах хяналтыг хэрхэн зохицуулснаас ихээхэн хамаардаг.¹

Үрчлэлтийг хүчингүйд тооцож буй шүүхийн шийдвэрийн судалгаанаас үзэхэд Гэр бүлийн тухай хуульд заасан үрчлэлтийг хүчингүйд тооцох үндэслэлээр бус, “шаардлагатай гэж үзэх” бусад нөхцөл бүрдсэнээр шүүх хүүхдийн эрх ашгийг хамгаалж үрчлэлтийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Мөн зарим үрчлэлт нь хууль зүйн агуулгаар бус, түр зуурын бэрхшээлийг даван туулах, ашиг сонирхлын зорилготой байна.

Иймээс Монгол Улсын үрчлэлтийн өнөөгийн нөхцөл байдлыг тодруулан, үрчлэлтийн зохицуулалтын зарчим, хүүхэд үрчлэх нөхцөл, шаардлага, хяналт тавих асуудлыг гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулах замаар дүн шинжилгээ хийж, “хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах” үрчлэлтийн бүртгэл, хяналтын тогтолцооны сайн туршлагыг илрүүлж, Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг энэ чиглэлээр боловсронгуй болгох асуудлыг дэвшүүлнэ.

Ингэснээр Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд тусгагдсан “хүүхдийн аливаа эрх ашиг хөндөгдөж байгаа тохиолдолд зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор үрчлэх эсэх асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх нь зүйтэй байна”² гэсэн саналыг дэмжиж, хуулийн төслийн зохицуулалтыг боловсронгуй болгох саналыг дэвшүүлэхэд энэхүү илтгэлийн ач холбогдол оршино.

Сэдвийн судлагдсан байдал

Үрчлэлтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр нэг сэдэвт бүтээлүүд нэлээд байна. Үүнд: Үрчлэлтийг бүртгэх, үрчлэлтийн дараах хяналтыг

1 Батаагийн Батцэцэг, “Хүүхэд үрчлэлтийн талаарх эрх зүйн орчин нөхцөл байдал” Хүний эрх (1), 2009, 18 дахь тал.

2 Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалаас

боловсронгүй болгох талаар³, үрчлэлт хийгдэхэд үрчлэгч болон үрчлүүлэгчид насны хязгаарлалт тогтоох асуудлаар⁴, эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс хийгдсэн үрчлэлтийг шүүх онцгой ажиллагааны журмаар маргаангүй харилцаа гэж үзэн хүчингүйд тооцож буй нь ёс зүйд нийцээгүй талаар⁵, үрчлэгчид болон бүрдүүлэх баримт бичигт тавигдсан шаардлага нь үрчлэн авагчийн эрхийг хязгаарлах үндэслэл болж байгаа талаар⁶, Улс хоорондын үрчлэлт болон гадаадын иргэнд хүүхэд үрчлэх эрх зүйн зохицуулалтын талаар⁷, Үрчлэлтийг хүчингүйд тооцох хууль хэрэглээний асуудлаар⁸ тус тус судалсан бүтээлүүд байна.

II. МАНАЙ УЛСЫН ҮРЧЛЭЛТИЙН ТҮҮХЭН ЭРХ ЗҮЙН УЛАМЖЛАЛ БОЛОН ҮРЧЛЭЛТИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР

Үрчлэлтийн түүхээс үзвэл, эрт дээр үеэс Монголчууд хүүхэд өргөн авч, өөрийн хүүхэд мэт өсгөж хүмүүжүүлдэг байжээ. Монголын нууц товчоонд “Чингис хаан тарсан аймгуудыг нэгтгэх дайн хийж байхдаа Мэргэдийн буурин дээрээс Хүчүг, Тайчуудын буурин дээрээс Хөхөчүг, Татарын буурин дээрээс Шихихутаг, Жүрхэний буурин дээрээс Борохули нарыг олж, Өүлэн эхдээ өгч өсгүүлснээр дөрвөн өргөмөл дүүтэй болсон, Эдгээр дөрвөн хүүхдийг Өүлэн эх өөрийн хүүхэд шиг хайрлан өсгөж эрэмгий баатрууд болгосон. Эдгээр баатрууд Их Монгол улсыг байгуулахад гарамгай үүрэг гүйцэтгэсэн. Жишээ нь: Шихихутаг хамгийн анхны улсын заргач байсан бол Борохул Чингисийн дөрвөн хүлэг баатрын нэг байсан.

Үрийн зулай үнэрлэх хувь тавилан хүн болгонд тэгш заяадаггүй. Монголчууд үр хүүхэдгүй нэгэндээ хүүхдээ өргүүлж үр хүүхэдтэй болгодгоос гадна ядарсан нэгнээсээ үр хүүхдийг нь өргөж авах, эцэг эхээсээ хагацсан өнчин хүүхдийг өргөн авч, өсгөж хүмүүжүүлдэг уламжлалтай. Мөн хэлмэгдүүлэлтийн үед өөрийн үр хүүхдээ эсэн мэнд авч үлдэхийн тулд хүнд өргүүлэх, овог нэрийг нь өөрчлөх тохиолдол олноор гарч байсан.

Сонирхолтой нэгэн баримт дурдвал, Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдан буй хүүхдийн эрх, хүүхдийг үрчлэн авах тухай Монгол Улсын Арванзургаадугаар он, 8 сарын 27-ны өдөр /1926 он/, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газар, хурлын олон гишүүдийн хуралдаж тогтоосон 34-р хурлын тогтоолын 5 дугаар зүйлд, ...Хэнтий аймгийн Улз голын буриад хошуунд шинэ нээсэн эвлэлийн үүрийн гишүүн Нанжиддоржоос *“нялх бага хүүхдийг бусдад*

3 Батаагийн Батцэцэг, “Хүүхэд үрчлэлтийн талаарх эрх зүйн орчин нөхцөл байдал” Хүний эрх (1), 2009, 21 дэх тал.

4 Авирмэдийн Дугармаа, “Хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтын боловсронгуй болгох зарим асуудал” Монголын төр эрх зүй (1), 2005, 23-29 дэх тал.

5 Л.Эрдэнэбат, “Үрчлэлтийн хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал”, Шүүх эрх мэдэл (1), 2018, 129-132 дахь тал.

6 Д.Амарбаясгалан, Н.Зунцас, “Үрчлэлтийн харилцаан дахь эрхийн асуудал”, Монголын төр эрх зүй 104 (2), 2023, 100-108 дахь тал.

7 Адъяагийн Тайван, Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлэх гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын асуудал, Бакалаврын судалгааны ажил, 2018.

8 Очирбатын Номуулин, Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалтын хэрэглэхэд тулгарч байгаа бэрхшээлтэй асуудлууд, Монголын төр, эрх зүй (тусгай дугаар), 2014.

худалддаг явдал буйг дурдаад, үр хүүхэдгүй хүмүүс бусдаас хүүхэд авахаар бол тус тусын санал сэтгэл тохирвол 8 нас хүрсэн хойно хүүхдийн саналыг дагуулан авалцах, харин ямарваа гадаадын хүнд хүүхэд өгөх, авах явдлыг бүр мөсөн устгах” санал гаргасныг намын төв хороо хүлээн авч үзээд, урьдах эзэрхэг засгийн үед үр хүүхэдгүй хүн үр хүүхэд олонтой садан төрөл бус хүнээс гуйж, харилцан тохиролцсоноор хүүхэд үрчлэн авч байсныг хүүхдийг худалдаалсантай адилтгаж устгах нь зүйтэй гэж үзсэн боловч, тус улсын хүн ард дотор үр хүүхэдтэй этгээд цөөхөн, ихэнх нь үр хүүхэд байхгүй тул хүүхэд үрчлэн тэжээх асуудлыг хүүхдийг хэлд орж элдвийг мэдсэн хойно түүний саналаар шийдэх, харин гадаадын хүнд хүүхэд үрчлэхийг хориглох асуудлыг хуульд оруулахаар өргөн мэдүүлсэн байна.⁹

1926 оны “Иргэний хууль”¹⁰-ийн 54 дүгээр зүйлд “Аливаа нялхас буюу насанд хүрээгүй багачуудыг үрчлэхэд эрх биш, тэдний эрх ашгийг уртал болговол зохино” гэж заасан ба 1956 оны БНМАУ-ын “Гэрлэх ба гэр бүл асрамж, тэтгэмжийн тухай хууль”¹¹-д үрчлэлтийн харилцааг өргөжүүлж, үрчлүүлсэн хүүхдийн эд хөрөнгийн хувьд эдлэх эрх нь төрсөн хүүхэдтэй адил байвал зохино” гэж заажээ.

Мөн 1973 оны БНМАУ-ын “Гэр бүлийн тухай хууль”¹²-иар хүүхэд үрчлэх нөхцөл, үрчлэлтийг хүчингүйд тооцох, хүчингүй болгох зэргийг нарийвчлан зохицуулж, ...9 насанд хүрсэн хүүхдийн өөрийнх нь саналыг, 3 насанд хүрээгүй бол эрүүлийг хамгаалах байгууллагын зөвшөөрлийг авсны үндсэн дээр хүүхэд үрчилдэг байжээ.

Монгол Улсад Хүүхэд үрчлэх харилцааг зохицуулж ирсэн дээрх үе үеийн хуулиудаас үзэхэд хүүхэд үрчлэхдээ, тухайн хүүхдийн эрх ашгийг илүү харгалзаж, үрчлүүлсэн хүүхдийн эрх, төрсөн хүүхдийнхтэй адил байсан нь тод харагдаж байна.

III. ҮРЧЛЭЛТИЙН АГУУЛГА, ЗАРЧИМ БОЛОН МАНАЙ УЛСЫН ҮРЧЛЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮРЧЛЭЛТИЙГ ХҮЧИНГҮЙД ТООЦСОН ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААР

Энэ дэд сэдвийн хүрээнд үрчлэлтийн талаарх тодорхойлолт, хэлбэр, Гэр бүлийн тухай хуулийн зохицуулалтын үрчлэх нөхцөл болон үрчлэлтийн агуулга, зарчим, шүүхээс үрчлэлтийг хүчингүйд тооцон шийдвэрлэж байгаа практикийг судлах байдлаар үрчлэлт бодитоор буюу жинхэнэ агуулгын хүрээнд хийгдсэн эсэхийг тодруулж, шүүхээс үрчлэлтийг хүчингүйд тооцож байгаа хууль хэрэглээний асуудлыг авч үзлээ.

Үрчлэлт гэдгийг судлаач, доктор Ж.Амарсанаа “...үрчлэгдсэн хүүхэд болон үрчилж авсан эцэг, эх хоёрын хооронд төрсөн эцэг, эхийнхтэй адил эрх, үүрэг, хариуцлага үүсгэж буй харилцаа...”¹³ гэж, судлаач Ц.Алтанцэцэг “...бусдын

9 Г.Сэр-Од, <http://www.archives.gov.mn/>

10 Иргэний хууль, (1926).

11 Гэрлэх ба гэр бүл асрамж, тэтгэмжийн тухай хууль, (1956).

12 Гэр бүлийн тухай хууль, (1973).

13 Жүгнээгийн Амарсанаа, Хүүхдийн эрхийн нэр томъёоны товч тайлбар толь, (Улаанбаатар: 2001), 49 дэх тал.

хүүхдийг өсгөж хүмүүжүүлэх, тэжээн тэтгэхээр гэр бүлдээ авч үрчлэгдсэн хүүхэд үрчлэгчийн хооронд төрсөн эцэг, эх хүүхдийн нэгэн адил эрх, үүрэг үүсэж байгаа үйл явц...”¹⁴ гэж, судлаач, доктор А.Дугармаа “...хуульд заасан нөхцөл, журмын дагуу бусдын хүүхдийг тэдний ашиг сонирхлын үүднээс тэжээн тэтгэж, өсгөж хүмүүжүүлэхээр гэр бүлдээ авч, үрчлэгдсэн хүүхэд, үрчлэгчийн хооронд төрсөн эцэг, эх, хүүхдийн нэгэн адил харилцааг үүсгэж байгаа үйл ажиллагаа юм...”¹⁵ гэж тус тус тодорхойлжээ.

Монгол хэлний тайлбар толь бичигт хүүхэд үрчлэлтийг “...хүүхэд үрчлэх нь бусдын хүүхдийг өөрийн болгон тэжээх, үрчлүүлэх нь үрчлэхийн үйлдүүлэх хэв маяг...”¹⁶ гэж, Монгол ёс заншлын тайлбар толь бичигт “...өөр айлаас хүүхэд өргөн авч өөрийн хүүхдийн нэгэн адил өсгөж хүмүүжүүлж, өөрийн овгоор овоглох нарийн зан үйл...”¹⁷ гэж тодорхойлсон байна.

Эдгээр тодорхойлолтуудаас “Үрчлэлт”-ийг судлаач, доктор А.Дугармаа хууль зүйн агуулгаар оновчтой тодорхойлжээ.

Үрчлэлтийн зорилго¹⁸ нь: Хүүхдийг өв тэгш хөгжүүлэх үүднээс тэднийг гэр бүлийн болон баяр баясгалан, хайр ойлголцлын орчинд өсгөж, хөгжүүлэх

Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцүүлэн, үндсэн эрхийг хангах, хүүхэд худалдах, хулгайлах, хил дамнан худалдахаас сэргийлэхэд оршиж байна.

Онолын хувьд, үрчлэлтийн хэлбэрийг гадаад, дотоод үрчлэлт гэж ангилж, үрчлүүлэх нөхцөлийг хуулиар ерөнхий болон тусгайлан зохицуулсан байх бөгөөд ерөнхий нөхцөлийн хувьд илүүтэйгээр дотоод үрчлэлтийг буюу хүүхэд төрсөн улсдаа үрчлэгдэх нөхцөл, шаардлагуудыг тодорхойлж, харин тусгай нөхцөлийн хувьд гадаадын иргэн, өөр улсад амьдарч буй гэр бүлд хүүхдийг үрчлүүлэх нөхцөл, шаардлагуудыг тодорхойлсон байна.

Манай улсын хувьд гадаад, дотоод үрчлэлтийг хуулиар тодорхойлсон боловч үрчлүүлэх нөхцөл, шаардлагуудыг нарийвчлан зохицуулаагүй байна.

Монгол Улсад хүүхэд үрчлэгдсэн тоон мэдээг Статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас¹⁹ үзэхэд 2022 онд 1478 хүүхэд, 2023 онд 1421 хүүхэд, 2024 онд 1175 хүүхэд тус тус үрчлэгдсэн байна.

Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлсэн тоон мэдээгээр 2001-2022 онд 17 улс руу 274 хүүхэд үрчлэгдсэн. Үүнээс АНУ-д 157, ХБНГУ-д 36, Итали Улсад 23, БНФУ-д 20, БНСУ-д 6, бусад улс руу 1-6 хүүхэд үрчлэгдсэн²⁰.

“Үрчлэлт” нь гэр бүлийн эрх зүйн системд бие даасан нэг институт бөгөөд

14 Ц.Алтанцэцэг, Монгол Улсын Гэр бүлийн эрх зүй, (Улаанбаатар: 2011), 107 дахь тал.

15 Авирмэдийн Дугармаа, Гэр бүлийн эрх зүй, (Улаанбаатар: Адмон, хэвлэлийн компани, 2016).

16 Ядамжавын Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (Улаанбаатар: 2000), 62 дахь тал.

17 Чимэдийн Арьяасүрэн, Монгол ёс заншлын их тайлбар толь, (Улаанбаатар: 2000), 234 дэх тал.

18 Монгол Улсын дээд шүүх, Хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцож буй маргаан шийдвэрлэж буй шүүхийн практик болон харьцуулсан судалгаа, 2025.

19 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, <https://www.1212.mn/mn>

20 УДШ-ийн “Хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцож буй маргаан шийдвэрлэж буй шүүхийн практик болон харьцуулсан судалгаа” 2025.

манай улсын хувьд үрчлэлтийн харилцааг Үндэсний хууль тогтоомж болон Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенцоор зохицуулж байна.

Монгол Улс нь 1990 онд НҮБ-ын “**Хүүхдийн эрхийн тухай олон улсын конвенц**”-д, 1998 онд “**Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай**” Гаагийн конвенцод тус тус нэгдэн орсон бөгөөд эдгээр конвенцод үрчлэлтийн тогтолцоонд хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих-ыг хүүхдийг аль болох төрөлх улсад нь асран хамгаалах, үрчлүүлэх нөхцөлөөр хангахыг уриалж, тухайн хүүхдийг төрсөн оронд нь зохих ёсоор асрамжлах боломжгүй бол өөр оронд, тохирох гэр бүлд үрчлүүлэх, үндэстэн дамнан үрчлүүлэхийг хүлээн зөвшөөрчээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 11-д “... Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан нь 1999 оны Гэр бүлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-д тусгагдаж, мөн хуулийн 54.1.-т “*Хүүхдийг тэдний ашиг сонирхлын үүднээс үрчлүүлнэ*” гэж зааснаар дээрх конвенцын “**Хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих**” зарчмын эрх зүйн хамгаалалт бий болсон.

Гэвч Гэр бүлийн тухай хуулийн Долоодугаар бүлэг “Хүүхэд үрчлэх” хэсэг, 54 болон 55 дугаар зүйлд хүүхэд үрчлэх, үрчлүүлэхдээ зөвшөөрлийн нотлох баримт бичгийг бүрдүүлэх байдлаар хүсэлтээ гаргах, хүсэлтийг сум, дүүргийн Засаг дарга 20 хоногт багтаан шийдвэрлэхээр зааснаас гадна гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх асуудлыг *Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2001 оны 100/32 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам”-аар зохицуулж байна.*

Мөн Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд үрчлэлтийн бүртгэл хийхэд бүрдүүлэх баримт бичиг нь үрчлэх шийдвэр гаргахад бүрдүүлэх баримт бичигтэй нэгэн адил байхаас гадна нэмэлт журам /Сум, дүүргийн Засаг дарга нь хүүхэд, гэр бүл, нийгмийн асуудал хариуцсан ажилтнаар дүгнэлт гаргуулах, хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг дүгнэлтэд үндэслэн 20 хоногийн дотор гаргана/ тогтоожээ.

Гэр бүлийн тухай хууль, **Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам**, *Иргэний улсын бүртгэлийн тухай хууль зэрэгт хүүхэд үрчлэх асуудлыг шийдвэрлэхэд болон хүүхэд үрчилсний бүртгэл хийхэд бүрдүүлэх нотлох баримт бичгийг зааглаагүй, нэгэн адил баримт бичиг байхаар зааж, бүртгэлийн байгууллага нэмэлт баримт шаардахаар зохицуулсан нь эрх зүйн давхардал, зөрчилдөөнийг үүсгэснээс гадна үрчлэлт бол баримт бичгийн бүрдүүлбэрээр хийгддэг ажиллагаа болохыг тодотгожээ.*

Мөн эдгээр хууль, журамд “Хүүхэд үрчлэх” мөн чанар, зорилго, хууль зүйн агуулгыг бүрэн тодорхойлоогүйгээс гадна “Хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих” нөхцөл шаардлагыг бүрэн тусгаагүй, гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх асуудлыг хуулиар бус, журмаар зохицуулж, хүүхдийн эрхийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаггүй байгууллагын шийдвэрээр гадаад үрчлэлт хийгдэж байна.

Үрчлэлтийн агуулга, зарчим болон манай улсын үрчлэлтийн өнөөгийн байдал, үрчлэлтийг хүчингүйд тооцсон хууль хэрэглээний талаар

Үрчлэлтийн агуулга нь гэр бүлээ өргөжүүлэх хүсэлтэй сайн хүмүүс болон шинэ гэр орон, хайртай эцэг, эхтэй болсон хүүхдүүдийн хувьд маш их сэтгэл хөдөлгөм, амьдрал өөрчлөх сайхан аялал байдаг ба, төрсөн эцэг, эхээс үрчлэн авсан эцэг эхэд хүүхдийг болон хүүхдийн бүх эрх, үүрэг, хариуцлага, гэр бүл болох /Filiation/ асуудлыг хамтад шилжүүлдэг, насан туршийн харилцаагаар илэрдэг байна²¹.

Тодруулбал, үрчлэлт бол хайрын үр дүнд бий болдог, үрчлэлээр дамжуулж үрчлэн авсан эцэг, эх хүүхдийг өөрийн гэр бүлдээ оруулж, ойр дотны харилцаа үүсгэн, өөрийнхөө хүүхэд ба өв залгамжлагч болгодог, үргэлжийн тогтвортой, хүүхдийн байр суурь үүрд ганхахгүй, баталгаатай байх явдал юм.

Үрчлэлтийн үр дүн оролцогч бүх хүмүүст эерэг байхын тулд зарим үндсэн зарчмуудыг ойлгож, дагаж мөрдөх нь маш чухал бөгөөд үрчилж авсан гэр бүлүүд болон мөнхийн гэр орноо хүлээж буй хүүхдүүдэд зориулсан хүмүүжлийн орчныг бий болгох үндэс суурийг бүрдүүлдэг.

Үрчлэлтийн харилцаанд үндсэн **5 зарчим** баримталдаг. Үүнд:

1. Хүүхэд төвтэй хандлага (Child-Centered Approach): Хүүхдийн халамж, сайн сайхан байдал хамгийн чухал. Хүүхэд үрчлэн авах үйл явц дахь шийдвэр, үйл ажиллагаа бүрийг заавал хүүхдийн дээд ашиг сонирхлыг харгалзан үзсэний үндсэн дээр гаргаж байх ёстой.

2. Хүндэтгэлтэй байдал (Respectful and Inclusive Language): Хүүхэд үрчлэх ярианд хүндэтгэлтэй, хүсэл зоригийг хангалттай илэрхийлэх үг хэллэг ашиглах нь харилцан сэтгэл хөдлөл, харилцан ойлголцол, эерэг орчныг бий болгодог. Энэ нь үрчлэлтийн гурвалсан бүх талуудын ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг.

3. Насан туршийн амлалт (Lifelong Commitment): Үрчлэх нь насан туршийн аялал бөгөөд үрчилж авсан гэр бүл нь насан туршдаа хүүхдийг хайрлаж, халамжлах орчныг бүрдүүлэх үүрэг хүлээдэг. Энэ бол хайр, тууштай байдал, дэмжлэгийн аялал юм.

4. Бүх талуудыг дэмжих (Support for All Parties): Хүүхэд үрчлэн авах гурвалсан бүх хүмүүст дэмжлэг үзүүлэх нь чухал байдаг - төрсөн эцэг, эх, үрчлэн авсан эцэг, эх, хүүхэд. Хүүхэд үрчлэн авах үйл явц болон түүнээс хойших хугацаанд нөөц, тусламж үзүүлэх нь чухал юм.

5. Сэтгэл хөдлөл болон ойлголт (Empathy and Understanding): Хүүхэд үрчлэн авах аялал бүрийн гол цөм нь хүүхдийг өрөвдөх сэтгэл, ойлголт юм. Та өөрийгөө бусдын оронд тавьснаар хүүхэд үрчлэн авахтай холбоотой нарийн төвөгтэй байдал, сэтгэл хөдлөлийг шингээсэн энэрэнгүй орчныг бүрдүүлдэг.

21 Understanding the Five Core Principles of Adoption, <http://adoption-beyond.org/understanding-the-five-core-principles-of-adoption> (last visited Jul.18, 2025)

Эдгээр 5 зарчмыг баримтлан ихэнх улс орнууд хүүхэд үрчлэх нөхцөл, шаардлагуудыг тогтоосон байдаг.

Үрчлэлтийг үрчлэгдэх хүүхдийн сайн сайхны төлөө буюу “хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хангах” нөхцөл бүрдсэн тохиолдолд хийх нь төрийн байгууллагын үүрэг тул хүүхэд үрчлэхэд тавигдах ерөнхий болон нэмэлт шаардлагуудыг хуулиар тодорхойлж, уг шалгуур хангагдсан эсэхийг шалган тогтоох журмыг ч зохицуулсан байдгаас гадна үрчилсний дараах хяналтын асуудал нь хүүхдийн эрхийн зөрчлөөс сэргийлэхэд чухал ач холбогдолтой байдаг байна.

1. Ерөнхий шаардлагууд:

- **Нас:** Олон улс орнууд үрчилж авах эцэг, эхийг дор хаяж 21 настай байхыг шаарддаг. Зарим мужид хүүхдийн нас 10-аас доошгүй настай байх зэрэг тодорхой насны шаардлага тавигддаг.
- **Санхүүгийн тогтвортой байдал:** Ирээдүйн эцэг, эхчүүд хүүхдийн хоол хүнс, хувцас, орон байр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зэрэг үндсэн хэрэгцээг хангах чадвараа харуулах хэрэгтэй. Тодорхой орлогын түвшин шаардагдахгүй байж болох ч ерөнхийдөө тогтвортой орлоготой байх ёстой.
- **Зан чанар болон хувийн байдал:** Ирээдүйн эцэг, эхчүүд гэмт хэрэгт холбогдож байгаагүй, хүүхдийн хүчирхийлэл, хайхрамжгүй хандсан түүх байхгүй эсэхийг шалгахын тулд суурь шалгалтад хамрагддаг.
- **Амьдрах орчны судалгаа:** Гэрийн орчин, гэр бүлийн динамик байдал, гэр орноо тогтвортой, хайраар хангах чадварыг гүнзгийрүүлэн үнэлдэг.
- **Лавлагаа, мэдээлэл:** Ирээдүйн эцэг, эхчүүд тэдний зан чанар, эцэг, эхийн хувьд хүүхдэд тохирохыг батлах зорилгоор бусад хүмүүсээс лавлагаа авах шаардлагатай байж болох юм.
- **Гэрлэлтийн байдал:** Ганц бие хүмүүс үрчилж авах боломжтой ч зарим улсуудад гэрлэсэн хосууд үрчилж авахыг илүүд үздэг эсхүл шаарддаг.
- **Сургалт:** Үрчлэлтийн олон агентлаг ирээдүйн эцэг, эхчүүдээс үрчлэлтийн сургалтын хөтөлбөрт хамрагдахыг шаарддаг.

2. Бусад нэмэлт шаардлагууд:

- **Эрүүл мэнд:** Ирээдүйн эцэг, эх нь эрүүл мэндийн хувьд сайн, ямар нэгэн эм бэлдмэл хэрэглэдэггүй гэдгийг тодорхойлж харуулна.
- **Сэтгэл хөдлөлийн байдал:** Үрчлэлтийн агентлаг нь ирээдүйн эцэг, эхчүүдийн хүүхдийн төрөлх чадварыг дэмжиж чадах эсэх байдлыг тодруулна.
- **Амлалт:** Үрчлэлтийн агентлагууд болон шүүх нь тухайн хувь хүн хүүхдэд зориулсан хайраар дүүрэн гэр, бусад байнгын хэрэгцээг хангаж чадах эсэхийг тодруулна.
- **Хүүхдийн хэрэгцээ:** Үрчилж авсан хүүхдэд тусгай хэрэгцээ байгаа эсэхийг тодруулж, үрчилж авах хүүхдийн эрүүл мэндийн болон хөгжлийн зэрэг

өвөрмөц хэрэгцээг үрчлэн авч байгаа гэр бүлд нь тааруулахдаа харгалзана.

- **Төрсөн эцэг эхийн лавлагаа:** Зарим тохиолдолд төрсөн эцэг, эх нь үрчилж авсан эцэг, эхийн үндэс угсаа шашин шүтлэг, амьдралын хэв маягийг нь илүүд үздэг байж болно.

Хүүхэд үрчилж авахын тулд ирээдүйн эцэг, эх нь ерөнхийдөө 21-ээс доошгүй настай, санхүүгийн хувьд тогтвортой, сайн боловсролтой, аюулгүй, хайраар дүүрэн гэр оронтой байх ёстой. Үрчлэлтийн агентлагууд болон шүүхүүд мөн үрчилж авах эцэг эхийн хүүхдийн сэтгэл санааны болон бие махбодын хэрэгцээг хангах чадварыг үнэлдэг бөгөөд энэ нь ихэвчлэн гэрээр судлах, суурь шалгалтыг шаарддаг.

Манай улсад “Үрчлэлт”-ээр эцэг, эх, асран хамгаалагчийн хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх эрх, үүрэг үрчлүүлж байгаа хүүхдийн эрхийн хамтаар өөр эцэг, эхэд бүхэлд нь, насан туршид нь шилждэгийг харгалзан үрчлэлтийн бодит нөхцөл байдлыг шалган тогтоох, үрчлэлтийн өмнөх процесс ажиллагааны зохицуулалтгүйгээс үрчлэлт хэлбэр төдий хийгдсэн нь үрчлэлтийг хүчингүйд тооцсон шүүхийн шийдвэрээс харагдаж байна.

Шүүх 2022-2024 онд үрчлэлтийг хүчингүйд тооцуулах тухай шаардлага бүхий нийт 439 хэрэг маргаан шийдвэрлэсэн бөгөөд үрчлүүлэгчийн хүсэлтээр 319, үрчлэн авагчийн хүсэлтээр 81, үрчлэгдсэн хүүхдийн хүсэлтээр 39 хэрэг маргааныг шийдвэрлэсэн байх ба, энэ судалгаанаас хүүхэд үрчлэх болсон үндэслэл нь дараах зорилготой байгааг тодрууллаа. Үүнд:

- а/ Нас залуу, ганц бие, гадаадад суралцаж байхдаа төрүүлсэн хүүхдээ тухайн үед харж хандах боломжгүй байсны улмаас өөрийн эцэг, эхдээ үрчлүүлсэн.
- б/ Хүүхдээ гадаад улсад боловсрол эзэмшүүлэх, гадаад улсад эмчлүүлэх, виз мэдүүлэх зэрэг зорилгоор, гэр бүл, төрөл садны хүндээ үрчлүүлсэн.
- в/ Үрчлэн авагч нь нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмж авах зорилгоор үрчилсэн.
- г/ хойд эцгээр нь хүүхдээ овоглохоор үрчлэлт хийсэн боловч салсан гэх мэт үндэслэлүүд нийтлэг байна.

Үрчлэлтийг хүчингүйд тооцох хууль хэрэглээний талаар

Шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцуулах тухай хэргийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйл болон 145 дугаар зүйлд зааснаар онцгой ажиллагааны журмаар, хүсэлт гаргагчийг болон бусад этгээд /үрчлүүлэгч, үрчлэн авагч, үрчлэгдсэн хүүхэд /14-наснаас дээш бол/-ийг гуравдагч этгээдээр оролцуулан шийдвэрлэж байна. Шийдвэрийн тогтоох хэсгийн удирдлага болгож буй заалтад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1.4, 135 дугаар зүйлийн 135.2.3, 145 дугаар зүйлийн 145.6 дугаар зүйлийг баримтлан, “ТОГТООХ нь:” хэсгийн 1 дэх заалтад ихэвчлэн Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.2, 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийг барьж байгаа боловч зарим тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133.1.4, 135.2.3, 145.6 дахь хэсгийг дангаар болон дээрх Гэр бүлийн тухай хуулийн 61.1, 61.2, 57.2 дахь заалттай давхар баримтлан шийдвэрлэж байгаа

нь хууль хэрэглээний хувьд нэгдмэл байдал тогтоогүйг илэрхийлж байна.

Энэ нь хуулийг эрэмбэлж хэрэглээгүйтэй холбоотой гэж үзэхээр байна. Тодруулбал, материаллаг хэм хэмжээ тогтоосон Гэр бүлийн тухай хуулийн 61.1, 61.2-ийн аль тохирох хэсгийг шийдвэрийн “ТОГТООХ нь:” хэсгийн 1 дэх заалтад баримтлах нь зохистой. Харин хуулийн 57.2 дахь заалт нь 61.1-д байгаа тул баримтлах шаардлагагүй. Мөн процессын хэм хэмжээг зохицуулсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133.1.4, 145.6 дахь хэсгийг тогтоох хэсгийн удирдлага болгох заалтад баримтлах нь зохистой. Харин хуулийн 135.2.3 дахь заалт нь бүртгэлтэй холбоотой байгааг анхаарах, мөн түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.7 дахь заалт нь Гэр бүлийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1, 62.2-тай адил тул эрэмбийн хувьд Гэр бүлийн тухай хуулийн заалтыг баримтлан нь зохистой.

Онцгой ажиллагааны журмаар маргаангүй асуудлыг шийдвэрлэдэг боловч **хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох үндэслэл нь** Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан зөрчлийн хэм хэмжээ агуулсан **нөхцөлөөр тодорхойлогддог тул уг үндэслэлийн талаар** хүсэлт гаргагч болон үрчлэлтийн харилцааны бусад оролцогчид буюу эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдүүд **маргах эрхтэй. Мөн хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох асуудлыг** нотлох баримтыг үндэслэн шийдвэрлэх, үрчлэлтийг хүчингүй болгосон бол үр дагаврын асуудлыг хамт нь шийдвэрлэдэг зэрэг нь маргаан бүхий харилцааны шинжийг агуулдаг боловч хүүхдийн эрх ашгийн хамгаалах үүднээс онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх нь ач холбогдолтой гэж зарим судлаачид үздэг байна.

Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.-д “*Үрчлэгч нь эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэй хэрцгий харьцсан, хуурамч бичиг баримт бүрдүүлэн үрчлэн авах шийдвэр гаргуулсан, хүүхэд үрчлүүлэхийг хориглосон этгээд үрчлэн авсан болох нь илэрсэн тохиолдолд төрүүлсэн эцэг, эх, сонирхогч бусад этгээд, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага, 14 нас хүрсэн хүүхдийн өөрийн нэхэмжлэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцно*” гэж, 61.2.-т “*Шаардлагатай гэж үзвэл бусад үндэслэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцож болно*” гэж тус тус үрчлэлт хүчингүйд тооцох үндэслэлийг тодорхойлсон.

Хуулийн энэхүү хэрэглээний талаар судлаач, шүүгч О.Номуулин, “*Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн зохицуулалтаас харахад үрчлэлтийг хүчингүйд тооцуулах үндэслэл нь зөрчлийн шинжтэй байхыг шаардаж байх бөгөөд уг зөрчлийг гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх хэлбэрээр үрчлэлтийг хүчингүйд тооцох ойлголт илэрхийлэгдэж байна. Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэгт заасан “шаардлагатай гэж үзвэл бусад үндэслэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцож болно” гэсэн зохицуулалт нь 61.1 дэх заалттай заавал уялдах ёстой. Өөрөөр хэлбэл зөрчлийн хэм хэмжээ агуулсан хуулийн нэг зүйлд багтаж байгаа 61.2-т заасан үндэслэл мөн л зөрчлийн хэм хэмжээ агуулсан байхыг шаардана.*”²² гэж тайлбарласан нь үндэслэл бүхий болжээ.

22 Очирбатын Номуулин, Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалтын хэрэглэхэд тулгарч байгаа бэрхшээлтэй асуудлууд, Монголын төр, эрх зүй (тусгай дугаар), 2014.

Шүүх Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсгийн зохицуулалтыг баримтлан үрчлэлтийг хүчингүйд тооцож байгаа бөгөөд шийдвэрийн үндэслэлдээ үрчлэлтийг хүчингүйд тооцуулах нөхцөл байдлыг Монгол Улсын Үндсэн хууль болон НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих зарчимд тулгуурлан тайлбарлан хэрэглэсэн байна.

Судалгаа болон үрчлэлтийг хүчингүйд тооцсон хууль хэрэглээний байдлаас дүгнэхэд шүүх Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд үрчлэлтийг хүчингүйд тооцох зөрчлийн хэм хэмжээ агуулсан хуулийн зохицуулалтын хүрээнд үрчлэлтийг хүчингүйд огт тооцоогүй байна. Харин шүүх хүүхдийн эрх ашгийг хамгаалж, үрчлэлтийг хүчингүй болгосон.

Энэ нь үрчлэлт анхнаасаа хууль зүйн агуулгаар хийгдээгүй, түр зуурын бэрхшээлийг арилгах, эдийн засгийн болон бусад ашиг сонирхлын зорилгоор хийгдсэн нь илэрч, хүүхдийн эрхийн зөрчлийг үүсгэсэн байна.

Үрчлэлтийн харилцаанд илэрч байгаа энэхүү гажуудал нь Гэр бүлийн тухай хуулийн “Хүүхэд үрчлэх” зохицуулалтын дутмагшилтай байдлаас гадна хүүхдийг үрчлэх эсэх асуудлыг шийдвэрлэж буй субъектийн хууль хэрэглээний мэдлэг, ур чадвар дутагдалтай байна гэж бид үзлээ.

Хүүхэд үрчлэх асуудлыг шийдвэрлэхэд, Гэр бүлийн тухай хуулийн хүүхэд үрчлэх зохицуулалтаас гадна олон улсын гэрээ конвенц, үндэсний хууль *тогтоомжийг зөв эрэмбэлж хэрэглэх* бөгөөд “хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд хангах” зарчимд нийцүүлэх үүрэгтэй.

Гэтэл үрчлэлтийг хүчингүйд тооцуулах хүсэлтийн үндэслэлээс үзэхэд үрчлэлт ашиг сонирхлын зорилгоор хэлбэр төдий хийгдсэн нь шийдвэр гаргах эрх бүхий субъект /сум, дүүргийн Засаг дарга/-ын үрчлэлтийн мөн чанар, зорилго, хууль зүйн агуулга, үр дагаврыг ойлгоогүйтэй холбоотой байна.

Гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдийн үрчлэлтийг хүчингүйд тооцуулах асуудлаар сүүлийн 3 жилд шүүхэд маргаан шийдвэрлэгдээгүй байна. Энэ нь үрчлэлтийн дараах хяналтыг хэрэгжүүлсэн эсэх, хяналтыг хэрэгжүүлэх явцад зөрчил илэрснээр гарч ирэх асуудал байсан.

Дээрх үрчлэлтийг хүчингүйд тооцуулах хэргийн дийлэнх нь хүүхдийг эцэг, эх, эмээ өвөө, төрөл садны хүнд үрчлүүлсэн үрчлэлтийг хүчингүй болгуулахаар шүүхэд хандсан байна.

БНХАУ-ын Үрчлэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлд, өнчин болон төрүүлсэн эцэг, эх нь асран тэжээх чадваргүй болсон хүүхдийг эцэг, эхийн төрөл садан, найз нь асран харгалзаж болно. Асран харгалзагч болон асран харгалзуулж буй хүүхдийн хоорондын харилцаанд үрчлэлтийн харилцааг хэрэглэхгүй гэж заажээ²³. Мөн АНУ-ын зарим мужид ураг төрлийн хүмүүсийн хооронд үрчлэлт хийхийг хориглодог байна²⁴.

23 БНХАУ-ын Үрчлэлтийн тухай хууль (1998)-ийн 17 дугаар зүйл.

24 Монгол Улсын дээд шүүх, Хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцож буй маргаан шийдвэрлэж буй шүүхийн практик болон харьцуулсан судалгаа, 2025 он.

Харин Япон Улсын хувьд Хүүхэд үрчлэн авагч нь хүүхэдтэй удам бол байнгын үрчлэлтийг шүүхийн зөвшөөрөлгүйгээр бүртгэж, үрчлэгдсэн хүүхэд болон тэдний төрсөн эцэг, эхийн хоорондын харилцааг бүрэн тасалдаггүй байна.

Үрчлэлт нь хувь хүний эрх, үүргийг өөрчилж байгаа иргэний эрх зүйн чухал хэлцэл бол асран харгалзах гэдэг нь өсвөр насны хүнийг асран харгалзах үүрэг бүхий төрөл, садан эсхүл бусад этгээд тэжээн тэтгэх, асран хамгаалах, сурган хүмүүжүүлэх хариуцлага байдаг. Асран тэтгэх харилцаа нь асран тэтгэгч болон асран тэтгүүлэгч хоёрын хооронд эцэг, эх хүүхдийн харилцаа үүсгэх зорилгогүйгээр асран тэтгэж, тэжээх харилцаа байдаг.

Эндээс үзвэл, Монгол Улсад хийгдэж байгаа зарим үрчлэлт нь хууль зүйн хувьд үрчлэлт бус, харин хүүхдийг асран харгалзах үүрэг бүхий өвөг эцэг, эмэг эх, төрөл, садны хүмүүс эсхүл бусад этгээд /хойд эцэг, эх/ нь өөрсдийн тэжээн тэтгэх, асран хамгаалах, өсгөж хүмүүжүүлэх хуульд заасан болон ёс суртахууны хариуцлагаа хүлээж байгаа, тэжээн тэтгэхтэй холбоотой харилцаа гэж үзэхээр байна.

Тодруулбал, эдгээр тохиолдолд хүүхдийн өсөж байгаа орчин нөхцөл өөрчлөгдөөгүй, үрчлэн авагч, үрчлүүлэгчийн хүүхдийг өсгөж, хүмүүжүүлэх эрх, үүрэг зэрэгцэн хэрэгжсэн, үрчлэлтийн зорилго нь субъектив шалтгаан нөхцөл болох түр зуурын болон бусад бэрхшээлийг арилгах байгаа нь хууль зүйн хувьд үрчлэлт биш юм.

Иймээс үрчлэлтийг хууль зүйн хувьд хийх, хүүхдийн эрхийн зөрчлөөс сэргийлэхийн тулд ихэнх улс орнууд үрчлэлтийн асуудлаа шүүхээр шийдвэрлүүлдэг байна. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хүүхэд үрчлэх асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэхээр тусгасан нь хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд ихээхэн ач холбогдолтой болжээ. Мөн хүүхдийн эрхийг хамгаалах, үрчлүүлэх хүүхэд болон үрчлэн авах эцэг, эхийн хооронд бодитоор эцэг эх, хүүхдийн харилцаа үүсэх эсэх, хүүхэд амьдрах орчин нөхцөлд дасах эсэхийг тогтоохын тулд үрчлэлтийн өмнөх процесс ажиллагаа зайлшгүй шаардлагатай байдаг болох нь гадаад улсын зохицуулалтаас харагдаж байна.

IV. ОЛОН УЛСЫН ХҮҮХЭД ҮРЧЛЭЛТИЙН АСУУДАЛ, ЗАРИМ УЛСЫН ҮРЧЛЭЛТИЙН ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР

Дэлхийн 160 улсад хүүхэд үрчлүүлэх институт байдаг бол 20 орчим улс хүүхэд үрчлэх хуулийн орчингүй байдаг нь судалгаагаар тогтоогджээ. Мөн үрчлэгдсэн хүүхдийн эрхийг зарим улсад өөрийн төрсөн хүүхдийн адил эрхтэй байхаар зохицуулсан байхад зарим улсад арай ялгавартай зохицуулдаг байна.

Ихэнх улсууд өөрийн улс дотроо болон гадаад улсаас хүүхэд үрчлэн авахыг дэмжиж, хүүхэд үрчлэлтийн асуудлыг зөв зохистой шийдвэрлэхэд хүүхдийн тэтгэлэг гол үүрэгтэй гэж үздэг. Жишээ нь: БНФУ нь үрчилж авсан болон үрчилж авахаар тогтсон хүүхэдтэй тохиолдолд 1710.49 евро олгодог. БНСУ нь хүүхэд үрчлэлтийг дэмжих үйл ажиллагаа их явуулдаг бөгөөд хүүхэд үрчилж авах зуучлалын хөлсийг улс хариуцаж, хүүхэд үрчилж авч байгаа хүүхэдтэй гэр бүлд

хүүхэд өсгөх тэтгэмж нэг хүүхдэд сар бүр 100,0 мянган вон байна. Швед Улс нь хүүхэд үрчилж авсан гэр бүлд орон байрны тэтгэмж олгодог. Бельги Улсад хүүхэд үрчлэн авсан эцэг, эхэд улсаас үзүүлэх тэтгэвэр, тэтгэмж нь хүүхэд төрүүлсэн эцэг, эхэд үзүүлдэг тэтгэвэр тэтгэмжтэй адил байдаг.

Улс хооронд хүүхэд үрчлэлт сүүлийн үед нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа төдийгүй ялангуяа Хойд Америк, Баруун Европын улсуудад нэмэгдсэн байна. Урьд нь гэр бүлийн таатай орчин бүрдүүлэх зорилгоор үрчлэлт явагддаг байсан бол сүүлийн үед хэрэгцээ талаас нь хардаг болж, хүүхэд үрчилж авах зорилго, агуулга өөрчлөгдөж түүнийг өөр зорилгод ашиглах явдал нэмэгдэж байна.²⁵ Хүүхдийн эрэлт хэрэгцээ нэмэгдэх тусам түүнийг тойрсон хил дамнуулан худалдах, хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт ашиглагдах хууль бус үйл ажиллагаа ихэсдэг гэсэн судалгаа байна.

Англи, Япон зэрэг улсууд нь өөрийн улс дотроо болон гадаад улсаас хүүхэд үрчлэн авахыг зөвшөөрч, өөрийн улсын харьяат хүүхдийг гадаад улсад үрчлүүлэхийг хориглосон.

Сүүлийн үед гадаад улсад хүүхэд үрчлүүлэх явдлыг багасгах бодлого зарим улс барьж байна. (БНСУ, Бельги Улс, БНФУ, Швед Улс)

ХБНГУ, БНХАУ, Эстони Улс, АНУ, Япон Улсын хүүхдийг үрчлэх онцлог зохицуулалт, үрчлэлтийг хүчингүйд тооцох асуудлыг тодрууллаа.

4.1. ХБНГУ-ын Иргэний хуульд, Хүүхэд үрчилж авч буй этгээд 25 нас хүрсэн байх, гэрлэсэн хосуудын хувьд 21 нас хүрсэн байх шаардлагатай ба хүүхдийг тохирох хугацаанд асарсны дараа үрчлэх,

Үрчлэх үйл явцын тухайд, эрчимтэй зөвлөгөө өгөх замаар үрчлэгдсэн хүүхдийг тухайн этгээд хүлээн авахад бэлэн эсэхийг шалгадаг. Үүнд: сэдэвтэй хамааралтай сургалтад хамрагдах, ярилцлага хийх, гэрт нь очих зэрэг хамаарна. Түүнчлэн өргөдөл гаргагчийн маягтыг бөглөж, амьдралын өмнөх үе шат, гэр бүлийн харилцаа, бусад сэтгэл хөдлөлийн харилцааг нарийвчлан харуулсан амьдралын тодорхойлолтыг бэлтгэх ёстой. Үрчлэгдсэн эцэг, эх сонгогдсоны дараа хүүхдийг таньж мэдэх бүх мэдээллийг хүлээн авдаг. Ийнхүү дасан зохицох үйл явцын хүрээнд эцэг, эх нь үрчлүүлэх шийдвэрээ хүүхдийнхээ төлөө байна уу, эсхүл түүний эсрэг байна уу гэдгийг эргэн хардаг. Хүүхдийг асрамжлах хугацаа нь хүүхэд эцэг, эхийн гэр бүлд орсноор эхэлж, Гэр бүлийн шүүхийн үрчлүүлэх тухай шийдвэр гарснаар дуусгавар болдог. Гэр бүлийн шүүхийн үрчлүүлэх шийдвэрийг бүртгэлд автоматаар бүртгэдэг. Дараа нь хүүхэд төрсөн хүүхдийн эрх зүйн статустай болж, биологийн эцэг, эхийнх нь эрх зүйн харилцаа зогсдог²⁶

Хүүхэд үрчлэлтийг хүчингүй болгох хоёр хэлбэртэй ба, үүнд илэрхийлэл байхгүйн улмаас хүчингүй болгох, албан журмаар хүчингүй болгох зохицуулалт

25 П.Нарантуяа, “Хүүхэд үрчлүүлэх болон үрчлэн авах талаар бусад орны туршлага, эрх зүйн зохицуулалт” Харьцуулсан судалгаа, 2013, https://www.google.com/url?sa=i&url=https%3A%2F%2Fforum.parliament.mn%2Ffiles%2F13670&psig=AOvVaw2gGTWHXWGCMfIcrLQ_qWzA&ust=1755741783144000&source=images&cd=vfe&opi=89978449&ved=0CAYQrpoMahcKEwj4x72ipZiPAxUAAAAAHQAAAAAQBA

26 Adoption of a child in Germany, domestic adoption, 2023, <https://www.service.bremen.de/dienstleistungen/adoption-of-a-child-in-germany-domestic-adoption-144545?reg=verfahren>

байна. Илэрхийлэл байхгүйн улмаас хүчингүй болгох агуулга нь үрчилж авсан этгээдийн хүсэлт байхгүй, хүүхдийн зөвшөөрөл байхгүй, эсхүл эцэг, эхийн нэгнийх нь зөвшөөрөлгүй үүсгэсэн үрчилж авсан харилцааг холбогдох этгээдийн хүсэлтээр Гэр бүлийн шүүх хүчингүй болгодог. Холбогдох этгээдийн үрчилж авах эсхүл зөвшөөрөл олгоход чиглэсэн хүсэл зоригийн илэрхийлэл нь эрх зүйн чадамжгүй байдал, сэтгэцийн түр зуурын сааталд орсон, үрчлэлтийн асуудлыг мэдээгүй, эсхүл мэдсэн ч үрчилж авах хүсэлт гаргахыг хүсээгүй, хүүхдийн болон үрчлэн авч буй этгээдийн хувийн шинж байдлын талаар төөрөгдсөн, хууран мэхэлсэн зэрэг нөхцөлд хүчингүй болно.

Албан журмаар хүчингүй болгох агуулга нь хүүхдийг насанд хүрэхийн өмнө өсвөр насны байх үед түүний сайн сайханд шаардлагатай гэж шүүх үзвэл, гэрлэгсдийн хэн нэг нь эсхүл төрсөн эцэг, эхийн хэн нэг нь хүүхдийг асрах, хүмүүжүүлэхэд бэлэн байгаа бөгөөд асран хамгаалалтыг түүнд шилжүүлэх нь хүүхдийн сайн сайханд харшлахгүй гэж үзвэл, үрчлэлтийг хүчингүй болгосноор хүүхдийг дахин үрчлэх боломж бүрдүүлэх зорилготой байгаа зэрэг тохиолдлуудад Гэр бүлийн шүүх үрчлэлтийг хүчингүй болгох, үрчлэлтийг хүчингүй болгох хугацааг үрчилж авснаас хойш 3 жилийн дотор, хүсэлтийг сүүлийн 1 жилд нь багтаан гаргана гэжээ.

4.2. БНХАУ-ын Үрчлэлтийн тухай хуульд, эцэг, эхээ алдсан өнчин хүүхэд, төрсөн эцэг, эх нь олдохгүй насанд хүрээгүй хүүхэд, төрсөн эцэг, эх нь онцгой бэрхшээлийн улмаас өсгөх боломжгүй болсон хүүхдийг үрчлүүлэх, төрсөн эцэг эх нь үр хүүхдээ үрчлүүлэх тохиолдолд хоёр тал хоёулаа харилцан тохиролцож, хамт үрчлүүлэх хүсэлт өгөх, үрчлэгч нь хэд хэдэн төрлийн шаардлагыг нэгэн зэрэг хангасан байх учиртай. Тухайлбал, 30-аас дээш настай байх, гэрлэсэн хосууд хамтдаа үрчлэх, хүүхдийг тэжээн тэтгэх, сургах, хамгаалах чадамжтай байх, анагаах ухаанаар хүүхэд үрчилж авахад тохиромжгүй гэж тогтоосон өвчингүй байх, гэмт хэргийн бүртгэлгүй байх, ганц бие бол үрчлэх хүүхдээс насны зөрүү 40-өөс дээш байх шаардлага тавьдаг байна.

Үрчлэлтийг цуцлах тухайд, үрчлэн авагч үрчилсэн хүүхдийг насанд хүрээгүй байхад харилцааг цуцлахгүй, гагцхүү үрчлэн авагч, үрчлүүлэгч хоёр хэлэлцэн тохиролцож гэрээгээр цуцалж болно. Үрчилсэн хүүхэд нь 8-аас дээш настай бол түүний зөвшөөрлийг авна.

Үрчлэн авагч нь тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй, хүүхдийг хүчирхийлсэн, хүүхдээ хаяж төөрүүлсэн зэрэг насанд хүрээгүй үрчлүүлсэн хүүхдийн хууль ёсны эрх ашигт халдсан үйлдэл гаргаж байсан бол үрчлүүлсэн этгээд, үрчлэн авагч болон үрчлүүлсэн хүүхэд хоорондын үрчлэлтийн харилцааг цуцлахыг шаардаж болно. Үрчлүүлэгч, үрчлэн авагч хоёр харилцан тохиролцоонд хүрч чадахгүй бол Ардын шүүхэд зарга үүсгэн шийдвэрлүүлнэ.

Мөн үрчлэгч болон үрчлүүлсэн хүүхдийн хоорондох харилцаа муудсан, улмаар хамт амьдрах боломжгүй болсон тохиолдолд гэрээний журмаар үрчлэлтийг цуцалж болно. Хэрэв тохиролцоонд хүрэхгүй бол Ардын шүүхэд зарга үүсгэж болно гэж заасан.

4.3. БНЭУ-ын хувьд, үрчлэлтийн бэлтгэлийн талаар зохицуулсан ба хүүхэд

үрчилж авахыг хүссэн хүн нь Мужийн захиргаанд хүсэлтээ гаргах бөгөөд түүнд хүүхэд үрчлэхтэй холбоотой эрх, үүрэг хууль зүйн үр дагаврыг тайлбарладаг. Улмаар хүүхэд үрчлэн авахыг хүссэн этгээдийн амьдралын нөхцөл, оршин суугаа газар, хүүхдийг өсгөх амьдралын боломжийн талаар судалдаг. Энэ хүн нь хүүхдийг үрчлэн авахаас өмнө мужийн захиргаанаас санал болгосон сургалтад хамрагдах ёстой. Үрчлэлтийн бэлтгэл ажлын явцад Мужийн захиргаа нь 1-д хүүхдийг үрчлэн авахыг хүссэн эцэг, эхтэй ойртуулах, 2-т Хүүхдийг хууль ёсны төлөөлөгчийн хамт хүүхэд үрчлэхтэй холбоотой нөхцөл байдлын талаар түүний хөгжлийн түвшнийг харгалзан хүүхдэд ойлгомжтой байдлаар тайлбарлана. Үрчилж авсан эцэг, эх нь хүүхдийн хувийн түүх, эрүүл мэндийн байдал, зан чанарын талаар Мужийн захиргаанаас ерөнхий мэдээлэл авна. Хэрэв үрчилж авахыг хүссэн эцэг, эх нь үрчлэлтийн бэлтгэлтэй холбоотой үйлдлээ үргэлжлүүлэхийг хүсэхгүй байгаа бол хүүхэд үрчлүүлэх тухай өргөдөл гаргасан Мужийн захиргаанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

БНЭУ-д үрчлэлтийг хүсэлтээр болон шүүхийн санаачилгаар хүчингүйд тооцож болдог байна.

Үрчлэгчийн хүсэлт, эцэг эхийн аль нэгнийх нь зөвшөөрөлгүйгээр үрчлэн авсан бол шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцож болно. Мөн дараах тохиолдолд өргөдөл, зөвшөөрөл хүчингүй болно. Үүнд: 1) өргөдөл гаргах үед хүсэлт гаргагч хүсэл зоригоо хэрэгжүүлэх чадваргүй байсан; 2) хүсэлт гаргагч нь эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай, асран хамгаалагч нь зохих зөвшөөрөл аваагүй, эсхүл зөвшөөрлийг 10 хүртэлх насны хүүхэд биечлэн олгоогүй; 3) өргөдөл гаргагч нь чухал нөхцөл байдлын талаар залилан мэхлэх замаар хүсэл зоригоо мэдүүлэхэд хүргэсэн; 4) хүсэлт гаргагчийг заналхийлэл, хүчирхийллийн улмаас хүсэл зоригоо мэдүүлэхэд хүргэсэн; гэх мэт.

Харин 1) Хүүхэд насанд хүрэхээс өмнө шүүх өөрийн санаачилгаар хүүхдийн ашиг сонирхлын үүднээс үрчлэлтийг хүчингүйд тооцож болно. 2) Хэрэв гэрлэсэн хос хүүхдийг үрчилж авсан бол хүүхэд болон үрчилж авсан эцэг, эхийн нэг нь үрчлэх харилцааг мөн хүчингүй болгож болно. Дараах тохиолдолд шүүх өөрийн санаачилгаар үрчлэлтийг хүчингүйд тооцож болно. 1) Гэрлэсэн хос болон хүүхэд өөрөө үрчлэх харилцааг мөн хүчингүй болгох тохиолдолд нөгөө эхнэр, нөхөр буюу хүүхдийн төрсөн эцэг, эх нь хүүхдийг асран хүмүүжүүлэхэд бэлэн байгаа бөгөөд эцэг, эхийн асран хамгаалах эрх нь хүүхдийн дээд эрх, ашиг сонирхолд харшлахгүй байх, эсхүл 2) хүчингүй болсон гэж зарлах зорилго нь шинээр үрчлүүлэх боломжийг олгож байгаа тохиолдолд шүүхээс өөрийн санаачилгаар үрчлэлтийг хүчингүйд тооцдог байна.

4.4. АНУ-д өөрийн төрсөн гэр бүлтэйгээ эргэж амьдарч чадахгүй болсон хүүхдийг үрчлүүлэхийг улс орнуудын засгийн газар бодлогоороо дэмждэг. Тухайлбал, 2002 онд Клинтон Улсын асрамжид байгаа хүүхдүүдээс үрчлүүлэх хүүхдийн тоог 2 дахин нэмэгдүүлэхийг уриалсан. 1997 онд батлагдсан хүүхэд үрчлэх болон гэр бүлийн аюулгүй байдлын хуульд хүүхэд үрчлэхийг дэмжсэн байдаг ба хүүхэд өргөж авсан хүнд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлсэн байдаг. Ерөнхийлөгч Буш хүүхэд үрчлэлтийг дэмжиж 2002 онд Хүүхэд үрчлэх хуульд хүүхдийн тэтгэлгийг хамгийн чухал үзүүлэлт болгон авч үзсэн.

Харин үрчлэлтийг буцаах үндэслэл нь муж бүрд өөр өөр боловч хамгийн нийтлэг дараах үндэслэлүүд байна. Үүнд: 1) Үрчлэлтийг залилан мэхлэх, албадах аргаар хийсэн, үрчлэлт хийх хуулийн процесс зөрчсөн – хүүхдийн эрүүл мэндийн байдал, гэмт хэргийн түүхийг зориуд нуусан, үрчлэлт нь тухайн муж улсын хуулийг зөрчсөн, төрсөн эцэг, эхэд хүч хэрэглэн зөвшөөрөл гаргуулсан гэх мэт, 2) Үрчлэлтийг эцэг, эх, бусад этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн, 3) Тодорхой нөхцөл байдал хожим илэрсэн – үрчлэлтийн дараа хүүхэд өвчин, хөгжлийн бэрхшээлтэй болох нь илэрсэн тохиолдолд үрчилж авсан эцэг, эхийн зүгээс хүсэлт гаргасан, 4) Үрчлэгдсэн хүн эсэргүүцэл гаргасан. 5) Хүүхдийн дээд ашиг сонирхлын талаарх сургаал – шүүх үрчлэлтийг хүчингүй гэж үзэх эсэхийг шийдвэрлэхэд хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд авч үзэх ёстой гэх сургаал. Энэ тохиолдолд шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцож шүүхийн шийдвэр гаргана.

Мөн үрчлэлт анхнаасаа хүчин төгөлдөр бус байх нөхцөлд, 1) тухайн шүүх үрчлэлтийг хэлэлцэх буюу батлах харьяалалгүй байсан. 2) үрчлэгч болон хүүхэд бэлгийн харилцаатай байх, үрчлэгч болон хүүхэд цусан төрлийн холбоотой байх. 3) Шаардлагатай баримт бичгийг бүхэлд нь хуурамчаар үйлдсэн, эсхүл үндсэн мэдээлэл нь хуурамч байх. Эдгээр тохиолдолд үрчлэлт анхнаасаа хүчингүй тул шүүх зөвхөн баталгаажуулна.

4.5. Япон Улсын хувьд, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага болон шүүхийн шийдвэрээр өөрийн улс дотроо болон гадаадаас хүүхэд үрчилж авахыг зөвшөөрдөг.

Хүүхэд үрчлэлтийн тухай хуулиар байнгын болон тусгай гэсэн хоёр төрлийн үрчлэлтийг зөвшөөрдөг. Хүүхэд үрчлэн авагчтай удам бол байнгын үрчлэлтийг шүүхийн зөвшөөрөлгүйгээр бүртгэж, үрчлэгдсэн хүүхэд болон тэдний төрсөн эцэг, эхийн хоорондын харилцааг бүрэн тасалдаггүй.

Тусгай үрчлэлтийг шүүхийн зөвшөөрлөөр хийдэг бөгөөд үрчлэн авагч, хүүхдийн хооронд хууль ёсны эцэг, эх, хүүхдийн харилцааг бий болгох зорилготой тул төрсөн эцэг, эхийн эрх, үүргийг бүрэн дуусгавар болгодог. Тусгай үрчлэлтээр ганц бие бол 25аас дээш настай байх, гэр бүл бол 20оос дээш настай байх, үрчилж авах хүүхдэд нас заагаагүй.

Үрчлэлтийн үйл явц нь:

1. Туршилтын хүмүүжлийн үе: Ирээдүйн үрчилж авах эцэг, эх нь ихэвчлэн шүүхийн хяналт дор 6 сараас дээш хугацаагаар хүүхдээ асрах туршилтын үеийг туулдаг
2. Шүүхийн зөвшөөрөл: шүүх эцэг, эхийн тохирох байдлыг үнэлнэ.
3. Батлагдсаны дараа үрчлэлтийг бүртгэнэ.

Тусгай үрчлэлтийг 1) үрчилж авсан эцэг, эхийн дарамт шахалтаас болж хүүхэд оргон зугтсан болон бусад хүүхдийн эрх ашигт хохирол учруулсан шалтгаантай бол, 2) Төрсөн эцэг, эх нь хүүхдийг асран хамгаалах боломжтой тохиолдолд шүүх үрчлэгдэгч, түүний төрсөн эцэг, эх, цагдаагийн шаардлагаар цуцлах боломжтой.

Мөн шүүхийн шийдвэрээр үрчлэлтийг хүчингүйд тооцдог. Үүнд: хүүхдийг

зөвшөөрөлгүйгээр, хууль бус аргаар үрчлэн авсан, хүүхдийн эрхийг зөрчсөн, хүүхдийн сайн сайхныг хангаагүй, үрчлэгчийн нөхцөл байдал нь хүүхдийн сайн сайхныг хангахгүй бол,

Эдгээр улсуудын үрчлэлтийн зохицуулалтаас харахад хүүхэд үрчлэх нөхцөл, шаардлага бүрдсэн эсэхийг шалгах үрчлэлтийн өмнөх процесс ажиллагааг тогтоож, үрчлэх эсэх шийдвэрийг гаргаж байна. Энэ нь үрчлэн авч буй эцэг, эх, үрчлүүлж буй хүүхдийн хооронд эцэг, эх-үрийн харилцааг тогтоож, тэднийг сургалтад хамруулснаар сэтгэлзүйг нь бэлтгэж, үрчлэхэд тавигдаж буй шаардлагуудыг бодитойгоор шалгаж, үрчлэлтэд асуудал гарахгүй байх нөхцөл бололцоог бүрдүүлдэг байна.

Мөн үрчлэлтийг хүчингүй болгож байгаа үндэслэл нь үрчлэх нөхцөл, шаардлагыг зөрчиж үрчлэлт хийлгэсэн, хүүхдийн эрхийг зөрчсөнтэй холбоотой байгаа нь манай хуулийн зохицуулалттай адил байна.

V. ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ДҮГНЭЛТ

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалтын талаар: Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд, хүүхэд үрчлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэхээр зааж, “хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалах” зарчмыг тусгаж, үрчлэх нөхцөл, шаардлагыг тодорхой тусгасан нь олон улсын эрх зүйн зохицуулалтуудтай нийцжээ.

Мөн Аймаг, дүүргийн Засаг даргын дэргэд хүүхдийг үрчлүүлэх эсэх асуудлаар санал гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөл ажиллах, үрчлүүлэхээс өмнө үрчлэн авагчийг судлах, сургалтад хамруулах зэргээр үрчлэхийн өмнөх процесс ажиллагааг зохицуулсан сайн талтай байна.

Үрчлэлтийг хүчингүйд тооцох үндэслэлүүдийг “үрчлэгч нь эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан; тухайн хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон; үрчлүүлэгч эцэг, эхийг хүүхдээ үрчлүүлэхийг удаа дараа тулган шаардаж, заналхийлж, эсхүл хууран мэхлэх замаар хүүхэд үрчилж авсан нь тогтоогдсон; хуурамч бичиг баримт бүрдүүлэн үрчлэн авах шийдвэр гаргуулсан; үрчлэхийг хориглосон этгээдэд үрчлүүлсэн нь тогтоогдсон; хориглосон үйл ажиллагаа эрхэлсэн” гэж нэрлэн заасан нь дээр дурдсан гадаад улсуудын үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалттай адил агуулгатай байна.

Ийнхүү зохицуулсан нь одоогийн үйлчилж байгаа Гэр бүлийн тухай хуулийн үрчлэлтийг хүчингүйд тооцоход гарч байгаа хууль хэрэглээний алдаа гарахгүй байх боломжтой болжээ.

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 21 дүгээр зүйлийн 1-ийн (с) -д “Хүүхдийг улс хооронд үрчлүүлэх тохиолдолд тухайн улсад хүүхэд үрчлүүлэхэд дагаж мөрддөг баталгаа болон хэм хэмжээг адил хэмжээнд хангана” гэж заасан.

Гэвч хуулийн төсөлд, Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх асуудлыг тусгайлан зохицуулаагүйг хүүхэд үрчлэх зохицуулалт нэгэн адил үйлчилнэ гэж ойлгох, эсхүл

огт зохицуулагдаагүй гэж үзэх нь тодорхойгүй байна.

Иймд хүүхдийн эрхийн зөрчлөөс сэргийлэх, хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртөхөөс хамгаалахын тулд гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх асуудлыг тусгайлан зохицуулах шаардлагатай байна.

Хэдийгээр энэхүү сэдвийн хүрээнд судлагдаагүй боловч үрчлэлтийн онцлог төрөл болох дагавар хүүхдийн үрчлэлт, ижил хүйстний үрчлэлт, үр хөврөл, тээгч эхтэй холбоотойгоор үүсэх үрчлэлтийн асуудлыг тусгайлан зохицуулах хэрэгцээ, шаардлага байгааг анхаарч хуулийн төсөлд тусгах саналтай байна.

Дүгнэлт:

1. Үрчлэлтийг хүчингүйд тооцож буй шүүхийн шийдвэрүүдийн судалгаанаас үзэхэд үрчлэлт хууль зүйн агуулгаар хийгдээгүй, түр зуурын бэрхшээлийг даван туулах, ашиг сонирхлын зорилгоор хийгдсэн нь Гэр бүлийн тухай хуулийн 7 дугаар бүлэг “Хүүхэд үрчлэх” хэсэгт зөвхөн үрчлэгчид хязгаарлалт тогтоож, үрчлэх нөхцөлийг баримт бичгийг бүрдүүлэх хэлбэрээр зохицуулсантай холбоотой байна. Шүүх хуульд заасан үндэслэлээр бус, хүүхдийн эрх ашгийг хамгаалж үрчлэлтийг хүчингүйд тооцжээ.
2. Дээрх зөрчлийг арилгаж, хуулийн зохицуулалтыг сайжруулахын тулд Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зохицуулалтыг тусгах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

а/ Үрчлэн авагч, хүүхдийн харилцааг ойртуулах, улмаар тэдний хооронд эцэг, эх, хүүхдийн харилцаа тогтох, амьдрах орчин, ээнэгшин дасах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд үрчлэх хүүхдийн насыг харгалзан үрчлэхээс өмнө тэднийг 3-6 сарын хугацаатайгаар хамт байлгах,

б/ Гэр бүлийн тухай хуулийн төслийн 65 дугаар зүйлийн 65.1-д зааснаар хүүхэд үрчлэх асуудлыг шүүх шийдвэрлэхдээ хүүхдийн эрх ашгийн үүднээс шаардлагатай гэж үзвэл үрчлэлтийг бүртгэхээс өмнө дүгнэлт гаргуулахаар шинжээч томилох,

в/ Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх нөхцөлийг тусгайлан зохицуулах,

г/ Гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдэд хяналт тавих эрх бүхий этгээдийг болон хяналт тавих журмыг хуульд заах,

д/ Үрчлэлтийн онцлог төрөл болох дагавар хүүхдийн үрчлэлт, ижил хүйстний үрчлэлт, үр хөврөл, тээгч эхтэй холбоотойгоор үүсэх үрчлэлтийн асуудлыг тусгайлан зохицуулах,

Эдгээр саналыг хуулийн төсөлд тусгаснаар манай улсын үрчлэлтийн зохицуулалт илүү боловсронгуй болно гэдэгт итгэлтэй байна.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Гэр бүлийн тухай хууль, 1999 он.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он.
4. Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016 он.
5. Хүүхэд хамгааллын тухай хууль, 2024 он.
6. Нэгдсэн үндэсний байгууллага, Хүний эрх, Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл, 1992 он.
7. Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, 2018 он.
8. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл 2025 он.
9. Иргэний хууль, 1926 он.
10. Гэрлэх ба гэр бүл асрамж, тэтгэмжийн тухай хууль, 1956 он.
11. Гэр бүлийн тухай хууль, 1973 он.

Б. Ном, сурах бичиг

1. А.Дугармаа, Гэр бүлийн эрх зүй, 2016 он.
2. Ж.Амарсанаа, Хүүхдийн эрхийн нэр томъёоны товч тайлбар толь, 2001 он.
3. Ц.Алтанцэцэг, Монгол улсын Гэр бүлийн эрх зүйн, 2011 он.
4. Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, 2000 он.
5. Ч.Арьяасүрэн, Монгол ёс заншлын их тайлбар толь, 2000 он.
6. Др.Хэнри Клауд, Др. Жон Таунсэнд, Хүүхдийг эх захтай болгох нь, 1998 он.
7. МУИС, Хувийн эрх зүйн тэнхим, ХБНГУ-ын иргэний хууль, орчуулж нэгтгэсэн анхны хэвлэл, 2017 он.

В. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Б.Батцэцэг, “Хүүхэд үрчлэлтийн талаарх эрхзүйн орчин нөхцөл байдал” Хүний эрх сэтгүүл 2009/1, 2009 он.
2. А.Дугармаа, “Хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтын боловсронгуй болгох зарим асуудал” Монголын төр эрх зүй сэтгүүл 2005/1, 2005 он.
3. Л.Эрдэнэбат, “Үрчлэлтийн хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал”, Шүүх эрх мэдэл сэтгүүл №1, 2018 он.
4. Д.Амарбаясгалан, Н.Зунцас, “Үрчлэлтийн харилцаан дахь эрхийн асуудал”, Монголын төр эрх зүй сэтгүүл 104 (2), 2023 он.
5. А.Тайван, Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлэх гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын асуудал, Бакалаврын судалгааны ажил, 2018 он.
6. О.Номуулин, Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалтын хэрэглэхэд тулгарч байгаа бэрхшээлтэй асуудлууд, Монголын төр, эрх зүй сэтгүүл 2014 (тусгай дугаар), 2014 он.
7. П.Нарантуяа, “Хүүхэд үрчлүүлэх болон үрчлэн авах талаар бусад орны туршлага, эрх зүйн зохицуулалт” Харьцуулсан судалгаа, 2013 он.

Г. Бусад

1. Шүүхийн ерөнхий зөвлөл, Судалгааны тайлангийн эмхэтгэл, 2015 он.
2. SA RINA, “Шүүхийн журмаар гэрлэлт цуцлалтаас үүсэх хүүхдийн эрхийг хамгаалах тулгамдсан асуудал, шийдэл”, 2023 он.
3. Нэгдсэн үндэсний байгууллага, “Хүний эрх, Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл”, 1992 он.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:

А. Англи хэл дээр

1. Family law act of Estonia, 2010.
2. Adoption law of the People's republic of China, 1992.
3. Civil code of Japan, 1986.
4. Adoption and Safe Families Act of USA, 1997.

3. Цахим эх сурвалж:

1. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан: <https://shuukh.mn/>.
2. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Иргэн - 2014 цахим систем
3. Эстони улсын хууль тогтоомжийн нэгдсэн цахим хуудас: <https://www.riigiteataja.ee/>.
4. ХБНГУ-ын Бремен хотын цахим хуудас: <https://www.service.bremen.de>.
5. БНХАУ-ын Ардын төлөөлөгчдийн их хурлын цахим хуудас: <https://npc.gov.cn> .
6. Архивын ерөнхий газрын цахим хуудас: <http://www.archives.gov.mn/>.
7. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: <https://www.1212.mn/mn>.

**ХОЁРДУГААР ХЭСЭГ: ӨСВӨР НАСНЫ ХҮНД
ХОЛБОГДОХ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГАА**

“МОНГОЛ УЛС ДАХЬ ӨСВӨР НАСНЫ ХҮНД ХОЛБОГДОХ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА”

С.Өмирбек,
Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн
давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч (LL.M)

Агуулга

I. Өсвөр насныханд зориулсан шударга ёсны тогтолцооны нийтлэг үндэслэл, зарчмууд (Удиртгал)

II. Монгол Улс дахь өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тусгай журам

2.1. Эрүүгийн байцаан шийтгэх хууль (1963, 2002 он)

2.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017 он)

2.3. Эрүүгийн хууль (2002, 2015 он): Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх нь

III. Шүүхийн практик судалгаа, хууль хэрэглээний ялгаатай байдал

3.1. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн статистик

3.2. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, хууль хэрэглээний ялгаатай байдал

IV. Дүгнэлт

Ном зүй

Түлхүүр үг: Өсвөр насны хүн, гэмт хэрэг, Эрүүгийн хууль, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, тусгай зохицуулалт, өсвөр насны хүнд зориулсан шударга ёсны тогтолцоо, ял оногдуулах, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ, Бээжингийн, Гаванагийн, Токиогийн жишиг дүрэм.

Товчлол: Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүнд зориулсан шударга ёсны тогтолцоог, тодруулбал тэдгээрт зориулсан тусгай (процессын болон хариуцлага хүлээлгэх) журмыг насанд хүрэгчдээс ялгаатай авч үзэж, хүүхдийн бие махбод, оюун санааны хөгжил, ухамсар, төлөвшил, нийгмийн харилцаанд бие даан оролцох чадвар, амьдралын туршилага зэрэг хувийн байдалд нь тохируулж, хүүхдийн эрхийг эн тэргүүнд тавьж хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насныханд ял оногдуулахыг урьтал болгохгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг үр нөлөөтэй хэрэглэх тухай эрүүгийн эрх зүйн орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэхийг улс орон бүр эрмэлзэж байна. Монгол Улсын хувьд өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл, журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлэг, Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт тусгайлан хуульчилсан боловч тэдгээр зохицуулалтыг боловсронгуй болгох, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах нь Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх анх удаа байгуулагдаж буй энэ цаг үед тулгамдсан асуудал хэвээр байна.

I. ӨСВӨР НАСНЫХАНД ЗОРИУЛСАН ШУДАРГА ЁСНЫ ТОГТОЛЦООНЫ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ЗАРЧМУУД (УДИРТГАЛ)

Өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, ял оногдуулах, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх нийтлэг үндэслэл, зарчмуудыг Монгол Улсын Үндсэн хууль болон манай улсын нэгдэн орсон, соёрхон баталсан Олон улсын гэрээ, конвенцүүд, түүнчлэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн жишиг дүрмүүд, Хүүхдийн эрхийн тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зэрэг бусад эх сурвалжуудад нарийвчлан тодорхойлжээ.

Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн¹ 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх төрийн нийтлэг үүргийг тодорхойлсон боловч мөн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “хүүхдийн эрх ашгийг төр хамгаална” гэж хүүхдийн эрхийн асуудлыг тусгайлан авч үзжээ. Үндсэн хуульд заасан хүүхдийн эрх ашиг гэдэг нь “бүх насны хүүхдийн амьдрах, хамгаалуулах, хөгжих, нийгмийн амьдралд оролцох хэрэгцээ, сэдэл тэмүүлэл”² тэргүүтнийг хамаатуулсан ойлголт бөгөөд хэрвээ хүүхэд гэмт хэрэгт холбогдсон, өртсөн тохиолдолд тэдгээрийг насанд хүрсэн хүнээс ялгаатайгаар тусад нь авч үзэж, хүүхдийн онцлогт тохирсон

1 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>, (Сүүлд үзсэн: 2025.09.14).

2 Нанзаддоржийн Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар, (2 дахь хэвлэл), (Улаанбаатар: Адмон, хэвлэлийн компани, 2024), 264 дэх тал.

тусгай журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, мөн тусгай журмаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хүмүүжлийн чанартай арга хэмжээ авах зэрэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн хүүхдийн эрх ашгийг төр хамгаалах үзэл санаанд бүрэн нийцэх учиртай.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын³ 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тэдний насыг болон засарч хүмүүжихэд нь дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хангасан, харгалзсан байх ёстой. Тус пактын 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “аливаа хүүхэд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдлаараа алагчлагдахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйнхээ хувьд шаардагдах бүхий л хамгаалалт эдлэх эрхтэй” гэж тунхагласан.

Хүүхдийн эрхийн тухай конвенцын⁴ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар нийгмийн хамгааллын чиглэлийн төрийн болон хувийн хэвшлийн бүхий л байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулахыг үүрэг болгосон ба тус конвенцын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “оролцогч улсууд хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад шаардлагатай хэмээн эрх бүхий байгууллага, шүүхийн шийдвэрийн дагуу, хэрэглэгдэх хууль, журмыг үндэслэн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд хүүхдийг хүсэл зоригийнх нь эсрэг эцэг, эхээс нь салгахгүй байх, ийм шийдвэрийг эцэг, эх хүүхдэдээ хэрцгийгээр харьцах, анхаарал, халамжгүй орхих, эсхүл эцэг, эх нь тусдаа амьдардаг тохиолдолд хүүхдийн оршин суух газрын талаар зохих шийдвэрийг гаргах үүрэг хүлээнэ” гэжээ.

Түүнчлэн уг конвенцын 40 дүгээр зүйлд Эрүүгийн хууль зөрчсөн хэмээн сэжиглэгдсэн, яллагдсан, гэм буруутай нь тогтоогдсон хүүхдийн нэр төр, эрхэм чанар, үнэ цэн, үндсэн эрх, эрх чөлөөг ямар ч нөхцөлд хүндэтгэх үзлийг бататгах, нийгмийн амьдралд болон төрж өссөн гэр бүл, эцэг, эхийнхээ хажууд буцаан оруулах шаардлага, насны онцлогийг нь харгалзан, нийгэмд бүтээлч үүрэг гүйцэтгэх, амьдрах эрхийг нь хүндэтгэх хандлагыг бэхжүүлэх, хүүхдийн холбогдсон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ тэдний эрх ашгийг хангасан, хамгаалсан илүү боловсронгуй, насанд хүрсэн хүнээс өөрөөр авч үзсэн, тэдгээрийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсөн тусгайлсан нөхцөл, журамтай байхыг оролцогч улсуудад үүрэг болгожээ.

Дээрхээс дүгнэвэл, Монгол Улсын Үндсэн хууль дахь хүүхдийн эрх ашгийг төр хамгаалах үзэл баримтлал болон Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан Олон улсын эрх зүйн эх сурвалжуудад гэмт хэрэг, зөрчил үйлдсэн,

3 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1257>, Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 03 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1968 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр гарын үсэг зурж, 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталсан. (Сүүлд үзсэн: 2025.09.14).

4 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail/1276>, НҮБ-аас 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1990 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр гарын үсэг зурж, 1990 оны 07 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталсан. (Сүүлд үзсэн: 2025.09.14).

түүнд холбогдсон, өртөж хохирсон, өөр бусад байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татагдан оролцож буй бүх насны хүүхдийн хувьд тэдний нас, бие, сэтгэлзүйн онцлогт тохирсон, цаашид бие хүн болж төлөвших, хүмүүжих, нийгмийн харилцаанд буцаж оролцох, эцэг, эх, гэр бүлтэйгээ хамтдаа амьдрах, хөгжих сэдэл, тэмүүллийг нь дэмжсэн, тэдгээрийн энэхүү эрх ашгийг хамгаалахад онцгой анхаарсан хэрэг хянан шийдвэрлэх эерэг орчин, тусгай журам шаардагддаг ба уг тусгай журмыг улс орнууд өөрийн хууль тогтоомжоор илүү боловсронгуй болгон бэхжүүлэх үүрэг хүлээхээс гадна тэдгээр нь нэг мөр, үр нөлөөтэй, үр дүнтэй хэрэгжих учиртай.

Манай улсын хувьд энэхүү тусгай журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлэг, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8 дугаар бүлэгт хуульчилснаас гадна Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд хүүхдийн эрхийг хамгаалахад баримтлах (1) ялгаварлан гадуурхахгүй байх, (2) төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, (3) нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах, хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах, (4) хүүхдийн эрхийг хангахад үндэсний уламжлалт зан заншил, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурлах, (5) хүүхдийг нас, бие, сэтгэхүйн онцлогт нь тохирсон мэдээ, мэдээллээр хангах, (6) хүүхдийг бие махбод, танин мэдэхүй, нийгэмшихүйн хувьд жигд хөгжих боломжийг хангах, (7) тэдний хөгжлийг дэмжих үйлчилгээ нь хүүхдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх, (8) хүүхдийн эрхийг хангахад оролцогч талуудын үйл ажиллагаанд хуульд заасан төрийн болон албаны нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарахаас бусад мэдээлэл ил тод, нээлттэй байна гэсэн найман зарчмыг хуульчилжээ.

II. МОНГОЛ УЛС ДАХЬ ӨСВӨР НАСНЫ ХҮНД ХОЛБОГДОХ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА БА ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ, ХҮМҮҮЖЛИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЛЭХ ТУСГАЙ ЖУРАМ

2.1. Эрүүгийн байцаан шийтгэх хууль (1963, 2002 он)

1963 онд батлагдаж, 1994 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн⁵ 34 дүгээр бүлэгт гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй хүмүүст хэрэглэгдэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар онцгой журам тогтоосон нь манай улсын хувьд энэ талаарх зохицуулалтыг тусгай бүлгээр хуульчилсан анхны тохиолдол юм.⁶ 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн⁷

5 Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), (Улаанбаатар: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэр), 2012, 194-318 дахь тал.

6 Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009 он), (Улаанбаатар: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэр), 2012, 85, 98, 109, 126 дахь тал. 1926 оны Монгол Улсын Шүүн таслах газраас аливаа хэргийг байцаан шийтгэх хууль, 1929 оны Аливаа хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай хууль, 1935 оны мөн нэртэй хууль, 1949 оны БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль зэрэгт өсвөр насны хүн буюу өсвөр насныхны холбогдсон эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, хэрэг бүртгэх ажиллагааг тусгайлсан бүлгээр зохицуулаагүй байна.

7 Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн

42 дугаар бүлэгт насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахдаа энэ хуульд заасан ердийнхөөс гадна энэ бүлэгт дурдсан тусгай журмыг удирдлага болгож, гэмт хэрэг үйлдэх үедээ насанд хүрээгүй байсан этгээдийн үйлдсэн хэрэгт хэрэглэхээр зохицуулсан.

1963 оны хуульд насанд хүрээгүй этгээдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчмуудыг тусгай бүлэгт анх удаа тусгаж, хүүхдийн эрхийг хамгаалах зохицуулалтыг оруулсан нь ач холбогдолтой болсон бөгөөд 2002 оны хууль тэдгээр зарчмуудыг баталгаажуулж, хүний эрхийн олон улсын баримт бичгүүдтэй нийцүүлэн нарийвчилж, илүү боловсронгуй болгохыг эрмэлзжээ. 2002 оны хуулийг 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуультай харьцуулбал, хэрэг бүртгэлтийн шатанд хүртэл тусгай журам хэрэглэх, өсвөр насны хүнийг баривчлах, цагдан хорих хугацааг нарийвчлан тогтоож, хууль ёсны төлөөлөгчийн эрх, оролцоог өргөжүүлсэн, байцаалт авах хугацааны дээд хязгаарыг тогтоож, дуу-дүрс бичлэгээр баталгаажуулалт хийх, сурган хүмүүжүүлэгчийн оролцоог уян хатан боловч заавал байх нөхцөлтэй холбох зэрэг онцлох, ахиц дэвшилттэй зохицуулалтуудыг хуульчилжээ. 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 382 дугаар зүйлд гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүний нас, амьдралын нөхцөл, хүмүүжил, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн хүчин зүйл, өдөөн хатгагчийн оролцоо, сэтгэхүйн хөгжлийн түвшнийг тогтоохыг шаардсан нь энэ талаарх 1985 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Бээжингийн жишиг дүрэм (*Beijing Rules*) гарахаас өмнөх зохицуулалт байснаараа онцлогтой юм. Харин 2002 оны хуулийн 365 дугаар зүйлд насанд хүрээгүй этгээдийн хүндэтгэн үзэх хувийн байдалтай нь холбоотой нөхцөл байдлуудыг улам тодруулж, хэрэв хүүхдийн оюун ухааны хөгжилд эргэлзээтэй нөхцөл байдал тогтоогдвол шинжээч томилж тогтоолгох заалтыг тусгасан нь шинжлэх ухааны аргачлалыг хэрэглэж, хүүхдийн хувийн байдлыг илүү нарийвчлан, түүний сэтгэхүйн онцлогийг үнэн зөв тогтоох, улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон хариуцлага хүлээлгэхэд харгалзаж үзэх талаар ахиц дэвшил гарчээ.

2.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017 он)

Монгол Улсын эрүүгийн процессын эрх зүйн хөгжилд өсвөр насны этгээдийн эрхийг хамгаалах, түүнийг хүндэтгэн үзэх хувийн байдал, онцлогийг харгалзан үзэх асуудал чухал байр суурь эзэлдэг. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар бүлэг болон 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн⁸ 18 дугаар бүлэгт өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай журмыг зохицуулсан бөгөөд 2017 оны хууль нь хүүхдийн эрхийн тухай олон улсын баримт бичиг, ялангуяа НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, мөн Бээжингийн жишиг дүрэм зэргийг илүү нягт тусгах, хүний эрхийн хандлагаар шинэчлэхийг зорьжээ.

Ерөнхий зохицуулалтын хувьд, 2002 оны хуульд насанд хүрээгүй этгээдийн хэрэгт ердийн журмаас гадна тусгай журам баримтална гэж заасан (364.1; 2 дахь хэсэг) бол 2017 оны хуульд ижил төстэй зохицуулалтыг оруулсан боловч илүү өргөн

уламжлал (1911-2009), (Улаанбаатар: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэр), 2012, 365 дахь тал.
8 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694>, (Сүүлд үзсэн: 2025.09.14).

хүрээтэй хуульчилжээ. Тухайлбал, өмгөөлөгчийн оролцоог заавал⁹ хангахаас гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэмэлтээр сурган хүмүүжүүлэгч, хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллагын ажилтныг оролцуулах боломжийг хуульчилсан (18.1.2 дахь хэсэг), өсвөр насны хүний хууль ёсны төлөөлөгчийг түүний эрх ашигт нь харш гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахгүй байх¹⁰ (18.1.3 дахь хэсэг) зэрэг шинэ зохицуулалт нэмэгдсэн.

Өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чухал үндэс нь түүний хувийн байдлыг нягт нямбай тогтоох асуудал¹¹ юм. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд туссан хүүхдийн нас, хүмүүжил, амьдралын нөхцөл, хэрэгт хамтрагч байсан эсэх, ухаан санааны хөгжлийн байдлыг тодруулах зохицуулалтыг (365 дугаар зүйл) 2017 оны хуулиар хэвээр нь хадгалж, түүн дээр нэмж хүүхдийн насыг зөвхөн иргэний бүртгэлийн баримтаар тодорхойлох, эргэлзээтэй тохиолдолд шинжээч томилох журмыг хуульчилсан (18.3 дахь хэсэг). Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүн бичиг баримтгүй, эсхүл бичиг баримт нь хуурамч гэж үзэх үндэслэл тогтоогдсон, өөр улсад бүртгэлтэй, бичиг баримтыг олж авахад хүндрэлтэй бол шинжээч томилохоор хуульчилсан нь шинэлэг зохицуулалт бөгөөд түүний хувийн байдлыг нарийвчлан тогтоохтой холбоотойгоор (1) тухайн шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхийн өмнө болон дараа биеэ хэрхэн авч явж байсан зан байдал, араншин, (2) тухайн шүүгдэгч гэмт хэрэг үйлдэх үедээ ямар нөхцөл байдалд байсан зэрэг мэдээллийг прокуророос шаардан гаргуулах шүүхийн эрх хэмжээг тухайлан хуульчилсан нь онцлог зохицуулалт болжээ.

2002 оны хуульд насанд хүрсэн хүнтэй хамт үйлдсэн Өсвөр насны хүний хэргийг бололцоотой бол тусгаарлаж шалгах талаар зохицуулсныг (369 дүгээр зүйл) 2017 оны хуулиар хэвээр нь хадгалсан боловч “хэргийг заавал тусгаарлах” зарчим илүү хүчтэй илэрхийлэгдсэн (18.4 дэх хэсэг). Харин өсвөр насны яллагдагчийн хэргийг тусгаарлах нь хэргийг бүх талаас нь бүрэн бодитой тогтооход саад учруулахаар байвал тусгаарлахгүй байж болно. Түүнчлэн 2002 оны хуульд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний эцэг, эхийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал оролцуулахаар хуульчилсан (374-375 дугаар зүйл) боловч энэ нь хүүхдийн эрх ашигт хохирол учруулах эрсдэлтэй бол оролцуулахгүй байх, хүүхдийг шүүх хуралдааны танхимаас тусгаарлах тохиолдол, журмуудыг 2017 оны хуульд илүү нарийвчилж, өсвөр насны хүнд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулах талаар императив зохицуулалт оруулж (18.2, 18.7

9 “Өсвөр насны хүнд холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбоотой Бээжингийн жишиг дүрэм” (1985)-ийн 15 дугаар зүйлийн 15.1 “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршид өсвөр насны хүн хуульчаар төлөөлүүлэх эрхтэй бөгөөд тухайн улсад ийм тусламжийн зохицуулалт байгаа бол үнэ төлбөргүй хууль зүйн тусалцаа авах хүсэлт гаргах эрхтэй.”, <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/united-nations-standard-minimum-rules-administration-jvenile>, (Сүүлд үзсэн: 2025.09.14).

10 “Өсвөр насны хүнд холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбоотой Бээжингийн жишиг дүрэм” (1985)-ийн 15 дугаар зүйлийн 15.2 “Эцэг, эх эсхүл асран хамгаалагч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхтэй бөгөөд хүүхдийн эрх ашгийн үүднээс эрх бүхий байгууллага тэднийг оролцуулахыг шаардаж болно. Гэвч хүүхдийн эрх ашгийн төлөө тэднийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахгүй байж болно.”

11 “Өсвөр насны хүнд холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбоотой Бээжингийн жишиг дүрэм” (1985)-ийн 16 дугаар зүйлийн 16.1 “Жижиг зөрчилд хамаарах тохиолдлоос бусад бүх хэрэгт эрх бүхий байгууллага эцсийн шийдвэр гаргахаас өмнө, шийтгэл оногдуулахын өмнөх шатанд өсвөр насны хүн амьдарч буй нөхцөл байдал, эсхүл гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн нөхцөл байдлыг зохих ёсоор мөрдөн шалгаж, тухайн хэргийг шударгаар шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ.”

дахь хэсэг), шийдвэрийг олон нийтэд мэдээлэхдээ өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, түүнд учирч болох бусад хор уршгийг тусгайлан харгалзах, түүний хууль ёсны төлөөлөгч шүүхэд хүрэлцэн ирээгүй тохиолдолд шүүхийн хэлэлцүүлэг хойшлогдохгүй байхаар хуульчилжээ. Мөн өсвөр насны шүүгдэгчтэй харьцахдаа түүний нэр төрийг хүндэтгэх, насны онцлогийг нь харгалзаж хүмүүжүүлэх, алдаагаа засах боломж, бололцоог олгохыг анхаарч ажиллахыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нийтлэг шаардлага байхаар хуульчилсан нь НҮБ-аас баталсан жишиг дүрмүүдэд туссан зохицуулалтууд юм.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 376-377 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг хойшлуулах, хүмүүжүүлэгч томилох, хорихоос өөр төрлийн ял оногдуулах боломжийг тусгайлан хуульчилсан бол 2017 оны процессын хуульд эдгээрийг тусгайлан нарийвчилж хуульчлаагүй нь энэ талаарх зохицуулалт 2015 оны Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт шилжиж, шинээр тусгай бүлэг болгож журамласантай холбоотой. 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлгийн нийтлэг зохицуулалтад өсвөр насны хүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хүмүүжих боломж олгох (18.2.2 дахь хэсэг) өсвөр насныханд зориулсан шударга ёсны тогтолцооны нийтлэг зарчмуудыг илүү өргөн хүрээнд тусгаж өгчээ.

Дүгнэвэл, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг 2002 оны хуультай харьцуулбал, өсвөр насны хүнд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай журам нь хууль зүйн зарим баталгаагаар өргөжиж, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиг баримжааг илүү гүнзгий тусгахад чиглэгдсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулж өмгөөлөгчийг заавал оролцуулах, сурган хүмүүжүүлэгч болон хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллагын ажилтны оролцоог хангах, хүүхдийн нас тогтоох нарийвчилсан механизмыг бий болгох, хүүхдийн хувийн байдалтай холбоотой прокуророос нэмэлт мэдээлэл шаардах шүүхийн эрх хэмжээг хуульчлах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай боловч шуурхай явуулах үүргийг тухайлан хуульчилснаараа онцлогтой бөгөөд 2017 оны хуульд процессын хэм хэмжээг хүүхдийн эрх ашигт нийцүүлэх зарчим давамгайлжээ.

Гэвч тухайн зохицуулалтууд дахь хатуу нөхцөлтэй хэм хэмжээнүүдэд өсвөр насныханд зориулсан шударга ёсны тогтолцооны нийтлэг үндэслэл, зарчмуудад тулгуурлаж дүн шинжилгээ хийх, өсвөр насны хүнд ялын бус, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг түлхүү хэрэглэх, шүүхийн өмнөх шатанд процессыг дуусгавар болгох үр нөлөөтэй эрх зүйн арга хэрэгслүүдийг эрэлхийлэх, мөрдөн шалгах болон шүүхийн шатанд тэдэнд зориулсан илүү зөөлөн процесс бүхий хэм хэмжээ тогтоох, шүүх хуралдааны тусгай журам бий болгох зэргээр өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгайлан журмыг улам боловсронгуй болгох шаардлага тавигдсаар байна.

2.3. Эрүүгийн хууль (2002, 2015 он): Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх нь

2015 оны Эрүүгийн хуулийн¹² 8 дугаар бүлэгт өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тусгай журмыг хуульчилсан бөгөөд гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн ба 18 насанд хүрээгүй хүнд,¹³ түүнчлэн 18 насанд хүрсэн бөгөөд 21 насанд хүрээгүй¹⁴ хүнд энэ бүлэгт заасан үндэслэл, журмаар ял оногдуулж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно гэж хуульчилсан.

2002 оны Эрүүгийн хуульд¹⁵ энэ талаар тусгай бүлгээр хуульчлан тогтоогоогүй боловч 62 дугаар зүйлд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах, 62¹ дүгээр зүйлд Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж хорих ял оногдуулах зэрэг өсвөр насны хүнд хэрэглэх ял, эрүүгийн хариуцлагын асуудлыг, 69 дүгээр зүйлд өсвөр насны хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх ялын бус арга хэмжээний төрлийг тус тус хуульчилсан. Харин 2015 оны Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь (1) түүний нас, биед тохирсон, (2) эрүүл мэнд, (3) ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, (4) нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, (5) боловсрол эзэмшүүлэх, (6) үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, (7) гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүний нөлөөнөөс тусгаарлах зорилготой байх бөгөөд (8) **“шаардлагатай тохиолдолд”** гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна гэж хуульчилсан нь:

1. Өсвөр насны хүнд ялын чанартай эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг урьтал болгохгүй байх,
2. Түүний хүндэтгэн үзэх хувийн байдлыг нь харгалзаж аль болох ялын бус, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхийг эрмэлзэх, тийм хууль зүйн боломжийг бий болгох,
3. Эцсийн арга хэмжээ болгож, шаардлагатай тохиолдолд ялын чанартай эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр бол хорихоос өөр төрлийн ялын олон төрөлт сонголттой байх, хорих ял оногдуулах асуудлыг эцсийн арга хэмжээ болгож хэрэглэхээр хуульчилсан¹⁶ нь орчин үеийн эрүүгийн эрх зүйн тэргүүлэх чиглэл болон хөгжиж буй өсвөр насныханд зориулсан шударга ёсны тогтолцооны нийтлэг зарчмуудад үндэслэгджээ.

12 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail/11634>, (Сүүлд үзсэн: 2025.09.14).

13 “Өсвөр насны хүнд холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбоотой Бээжингийн жишиг дүрэм” (1985)-ийн 2 дугаар зүйлийн 2.2 “Эдгээр дүрмийн зорилгоор дараах тодорхойлолтыг гишүүн улсууд өөр өөрийн хууль эрх зүйн тогтолцоо, ойлголттой нийцүүлэн хэрэглэнэ: (а) Өсвөр насны хүн гэдэг нь тухайн улсын хууль эрх зүйн тогтолцооны дагуу гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд насанд хүрэгчдээс өөрөөр хариуцлага тооцож болох хүүхэд эсхүл залуу хүнийг хэлнэ. (б) Гэмт хэрэг гэдэг нь тухайн улсын хууль эрх зүйн тогтолцооны дагуу хуульд зааснаар шийтгэгддэг аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. (с) Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүн гэж гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдсэн, эсхүл гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдсон хүүхэд, эсхүл залуу хүнийг ойлгоно.”

14 “Өсвөр насны хүнд холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбоотой Бээжингийн жишиг дүрэм” (1985)-ийн 3 дугаар зүйлийн 3.3 “Дүрэмд тусгагдсан зарчмуудыг гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдсэн залуучуудад мөн адил хэрэглэхийн төлөө чармайлт гаргана.”

15 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12172>, (Сүүлд үзсэн: 2025.09.14).

16 “Өсвөр насны хүнд холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбоотой Бээжингийн жишиг дүрэм” (1985)-ийн 5 дугаар зүйлийн 5.1, 17 дугаар зүйлийн 17.1 /b, c/ дэх хэсгийн зохицуулалт нь өсвөр насны хүнд ял онохоос илүүтэйгээр түүнийг хүмүүжүүлэх, нийгэмд буцаан төлөвшүүлэх арга хэмжээ авахыг зорилго болгодог.

2002 оны Эрүүгийн хуулиар өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлын хүрээнд мөн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж хорих ял оногдуулах, хорих ял оногдуулсан шийтгэх тогтоолыг хойшлуулах, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх гэсэн эрүүгийн эрх зүйн 3 аспектаар хязгаарлаж зохицуулсан бол 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8 дугаар бүлэгт өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нийтлэг үндэслэлийг тодорхойлж, оногдуулах ялын төрөл, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял тус бүрийн онцлог, хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх асуудлыг системчлэн тусгасан нь онцлогтой болсон.

Эдгээр зохицуулалтууд нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны “Өсвөр насны хүнд холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбоотой Бээжингийн жишиг дүрэм”, 1990 оны “Эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүй хүүхдийн эрхийг хамгаалах тухай Гаванагийн жишиг дүрэм”, 1990 оны “Өсвөр насны хүнд хорихоос өөр төрлийн эрүүгийн хариуцлага хэрэглэх тухай Токиогийн жишиг дүрэм”-ийн зохицуулалт, үзэл санааг тодорхой хэмжээгээр тусгасан боловч хуулийг илүү боловсронгуй болгох шаардлага тулгарсаар байна. Тухайлбал, 2017 оны Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарим төрлийн хатуу хэм хэмжээнүүд (*Lex stricta*) буюу мөн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “*оногдуулсан ял дээр нэмж, ... хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно*”, 4 дэх хэсэгт “*...хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дангаар хэрэглэж болохгүйг*”, 6 дахь хэсэгт “*...шүүхийн шийтгэх тогтоол гарах үед арван найман насанд хүрсэн бол энэ хуулийн 8.6 дугаар зүйл¹⁷ хамаарахгүй*”, 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “*Шүүх анх удаа энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй* гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно”, 4 дэх хэсэгт “*...прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө*”, 8.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “*Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон,...*” гэх зохицуулалтууд өсвөр насныханд зориулсан шударга ёсны тогтолцооны зорилтыг хангаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх шаардлагыг зүй ёсоор бий болгожээ.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай 6 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “*... учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол, ... учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол...*” гэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх нөхцөл, журмыг хуульчилсан 17 дугаар бүлгийн “гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн, эсхүл нөхөн төлөхөө

¹⁷ Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 “Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах”

илэрхийлсэн бол” зэрэг тэдгээр зохицуулалтыг хэрэглэх урьдчилсан нөхцөлийг гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хэрэглэхдээ насанд хүрсэн хүнтэй ижил төвшинд шаардлага тавьж байгаа нь өсвөр насныханд дээрх нийтлэг журмуудыг хэрэглэхгүй байх зүй бус нөхцөлийг бий болгож, шударга ёсны зарчим алдагдаж байгааг тэмдэглэж байна.

2.3.1. Өсвөр насны хүнд холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбоотой Бээжингийн жишиг дүрэм (1985 он)

1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 40/33 дугаар тогтоолоор баталсан “Өсвөр насны хүнд холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбоотой Бээжингийн жишиг дүрэм” нь өсвөр насныханд зориулсан шударга ёсны тогтолцооны чиглэлээр гарсан анхны иж бүрэн баримт бичиг бөгөөд олон улсын хэмжээнд эрх зүйн бодлого боловсруулах, үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгоход хөтөч болж ирсэн. Тус жишиг дүрмийн зорилго нь гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь нийгмийн шударга ёсыг хангах, бэхжүүлэх, өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс илүүтэйгээр боловсрол олгох, хүмүүжлийн арга хэмжээ авч хэргжүүлэхийг чухалчлах зэргээр улс орнуудын хууль тогтоомжид нэгэн төрлийн чиг баримжаа өгдөг.

Энэхүү жишиг дүрмийн гол онцлог нь хүүхдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх явцад зөвлөмжийн дагуу өмгөөлөгч болон эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо хангагдах, өсвөр насныхны буруу үйлдлийг засахад боловсрол, сургалт, нийгмийн дэмжлэгийг түлхүү ашиглах, насанд хүрээгүй хүүхдийг хорих, ялын чанартай эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь эцсийн арга хэмжээ байх, ял шийтгэлийг уян хатан байдлаар, олон хувилбартай зохицуулж шүүх, цагдаа, боловсрол, нийгмийн ажилтнууд хамтран хүүхдийн хэрэгт тэдний хүндэтгэн үзэх хувийн онцлогт нь тохирсон шийдвэр гаргах зэргийг урьтал болгодог. Тодруулбал, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд эхний ээлжид ял оногдуулах бус, харин гэр бүл, хамт олны болон олон нийтийн, төрийн байгууллагын хяналт тогтоох, боловсрол эзэмшүүлэх, нийгэмшүүлэх хөтөлбөрүүдэд хамруулах, энэ төрлийн үйлчилгээ үзүүлэх талаар тус жишиг дүрэмд тусгажээ.

Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1; 2; 3 дахь хэсэгт өсвөр насныхны хэрэгт ердийн журмаас гадна тусгай журам хэрэглэхээр хуульчилсан нь Бээжингийн жишиг дүрмийн 5 дугаар зүйл (*Aims of juvenile justice*) - хүүхдийн сайн сайхныг дээдлэх, 7 дугаар зүйл (*Rights of juveniles*) - өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчийн оролцоог хангах, 8 дугаар зүйл (*Protection of privacy*) - нэр төрийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулах, 16 дугаар зүйл (*Social inquiry reports*) - хувийн байдал, хүмүүжил, зан төлөвийг тогтоох зэрэг заалтын агуулга үзэл санаа туссанаас гадна мөн хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хүүхдийн нас, амьдралын нөхцөл, хүмүүжил, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн хүчин зүйлсийг тогтоох тухай тусгайлан хуульчилсан нь Бээжингийн жишиг дүрэм дэх нийгмийн судалгааны тайлантай ижил төстэй үзэл баримтлал юм.

Өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай

журам тогтоосон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 4-7 дахь хэсэгт хэргийг тусгаарлан шалгах, хууль ёсны төлөөлөгчийн оролцоо, дуудан ирүүлэх, баривчлах, шүүхийн хэлэлцүүлэг явуулах журмууд нь Бээжингийн жишиг дүрмийн 10 дугаар зүйл (*Initial contact*) буюу цагдаа, мөрдөн байцаалтын шатанд хүүхэдтэй тусгай нөхцөлөөр харьцах, 13 дугаар зүйл (*Detention pending trial*) буюу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг эцсийн арга болгон хэрэглэх, 14 дүгээр зүйл (*Juvenile court proceedings*) буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай журмаар явуулах үзэл санаатай ижил төстэй байх бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт хүүхдийг насанд хүрэгчдээс тусгаарлан хорих талаар хуульчилсан нь Бээжингийн жишиг дүрмийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгтэй нэг агуулгатай зохицуулалт юм.

Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийн зорилго, үзэл баримтлалыг Бээжингийн жишиг дүрэмтэй харьцуулан үзвэл, өсвөр насны хүүхдийн хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ хүүхдийн нас, сэтгэлзүй, боловсрол, гэр бүлийн өсөж торнисон нөхцөл байдлыг харгалзаж, хүүхдийн ирээдүйд сөрөг нөлөө багатай, хүмүүжлийн чанартай шийдэл хэрэглэх, эрэлхийлэхийг шаарддаг байдал нь жишиг дүрмийн 1 дүгээр зүйлийн 1-3, 5 дугаар зүйлийн 1, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт буюу хүүхдийн сайн сайхан байдлыг хамгаалах, түүний нас, хөгжлийн онцлогт нийцсэн тусгай журам хэрэглэх, хувь хүний нөхцөл байдлыг харгалзах, тэднийг хүмүүжүүлэх, боловсрол олгох зорилго давамгайлах зэрэг үзэл хандлагатай, тодруулбал, өсвөр насныханд зориулсан шударга ёсны тогтолцооны “шийтгэхээс илүү хүмүүжүүлэх, дахин боломж олгох” зарчимд тулгуурлажээ. 2017 оны Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт өсвөр насныханд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэлзүйн онцлогийг харгалзан, боловсрол эзэмшүүлэх, нийгэмд дасан зохицуулах, гэмт хэргийн хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчноос тусгаарлах зорилго баримталсан нь Бээжингийн жишиг дүрмийн үндсэн үзэл баримтлалтай тохирсон байна.

Бээжингийн жишиг дүрмийн 11 дүгээр зүйлд (*Diversion*) хүүхдийн хэргийг шүүхээр шийдвэрлэхээс өмнө албадлагын арга хэмжээ, нийгмийн үйлчилгээ, зөвлөгөө, түр хяналт зэрэг албан бус арга хэрэглэхийг зааварчилдаг бол 2017 оны Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт шүүх ял оногдуулахыг тэнсэж, 1-3 жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэх, тодорхой үүрэг хүлээлгэх, төрийн байгууллага, эцэг, эх, асран хамгаалагчийн хяналт дор хүмүүжүүлэх боломж олгох хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр зохицуулсан нь зорилго, ач холбогдлын хувьд хүүхдэд ялын чанартай эрүүгийн хариуцлага хүлээлгэх бус, түүнийг хүмүүжүүлэх, боловсрол олгох зэргээр засарч хүмүүжих боломж олгож буйгаараа ижил төстэй зохицуулалтууд юм.

Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулах тусгай журмыг хуульчилсан бөгөөд үүнд 3 төрлийн ялын төрлийг тогтоосон нь Бээжингийн жишиг дүрмийн 17 дугаар зүйлд хүүхдийн гэмт хэрэгт ялын олон хувилбарыг хэрэглэх, хорих ялыг хамгийн сүүлчийн арга болгон ашиглах (*last resort principle*) зарчимд үндэслэгджээ. Энэхүү үзэл санаа мөн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь ... шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж

хүмүүжүүлэхэд чиглэсэн байна” гэж зааснаар тусгагдсан бөгөөд хуулийн 8.2 дугаар зүйлд “гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулах ялын төрлийг (1) нийтэд тустай ажил хийлгэх”, (2) “зорчих эрхийг хязгаарлах”, (3) “сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих” гэж тусгайлан хуульчилсан. Үүнд, манай улсын хувьд хорихоос өөр (нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрх хязгаарлалт) төрлийн ялын сонголтыг бий болгосон нь Бээжингийн жишиг дүрмийн “гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулах ялыг олон хувилбартай болгох” зарчимтай нийцсэн гэж үзэхээр байна.

Монгол Улсын Эрүүгийн хуульд өсвөр насны хүнд оногдуулах хорих ялын онцлог зохицуулалтыг тусгасан нь сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял юм. Энэ нь Бээжингийн жишиг дүрмийн хүүхдэд хорих ял оноосон тохиолдолд боловсрол, сургалт, сэтгэлзүйн тусламж, нийгэмд эргэн нэгтгэх үйлчилгээг хангах тухай 19 болон 26 дугаар зүйлийн үзэл баримтлалтай уялдсан, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ялыг эдлүүлэхдээ ерөнхий болон мэргэжлийн боловсрол олгох, хөдөлмөрийн дадал эзэмшүүлэх, амьдрах ухааны сургалт явуулах талаар Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт хуульчилжээ.

Бээжингийн жишиг дүрмийн 17 дугаар зүйлийн 4, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хүүхдийн ирээдүйд сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийх үүднээс хорих ялаас “илүү хөнгөн нөхцөл”-өөр суллах, ялын биелэлтийг хойшлуулах зэрэг хувилбаруудыг санал болгодог ба Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт шүүх хорих ял оногдуулсан тогтоолын биелэлтийг хойшлуулж, өсвөр насныханд тодорхой хугацаанд хяналт тавьж, нөхцөл биелүүлсэн бол ялаас чөлөөлөх боломжийг хуульчилсан нь жишиг дүрмийн зохицуулалттай үзэл баримтлалын хувьд нийцжээ. Бээжингийн жишиг дүрмийн 17 дугаар зүйлд (*Guiding principles in adjudication and disposition*) гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар зохицуулахдаа түүний үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, хор уршгийн хэр хэмжээнд түүнд оногдуулах ялын болон ялын бус арга хэмжээний тэнцвэрийг хадгалах талаар зааварчилсан бөгөөд Өсвөр насны хүний эрх чөлөөг хязгаарлах эрүүгийн эрх зүйн арга хэмжээг болгоомжтой авч үзэхээс гадна хамгийн бага хэмжээнд хязгаарлах(17b), Өсвөр насны хүний эрх чөлөөг хязгаарлах буюу хорьж шийтгэх (17c) тохиолдолд (1) хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулсан хүнд гэмт хэрэг үйлдсэн, (2) хүнд гэмт хэргийг дахин давтан үйлдсэн бөгөөд (3) өөр тохиромжтой эрүүгийн эрх зүйн арга хэмжээг, тухайлбал хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээргүй тохиолдолд эрх чөлөөг нь хязгаарлах буюу хорих ял оногдуулах талаар тусгажээ.

2.3.2. Эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүй хүүхдийн эрхийг хамгаалах тухай Гаванагийн жишиг дүрэм (1990 он)

НҮБ-ын Эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүй хүүхдийн эрхийг хамгаалах тухай жишиг дүрэм буюу Гаванагийн жишиг дүрэм нь¹⁸ 1990 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор батлагдсан (A/RES/45/113). Энэ дүрэм нь гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг баривчлах, хорих үеийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрх, эрх чөлөө, бие махбодын хувьд бүрэн бүтэн байдлыг нь хамгаалах

¹⁸ Гаванагийн жишиг дүрэм, <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/united-nations-rules-protection-juveniles-deprived-their-liberty>, (Сүүлд үзсэн: 2025.09.14).

чиглэлээр олон орны эрүүгийн эрх зүйд хүлээн зөвшөөрөгдөж, жишиг болсон стандарт нөхцөлүүдийг санал олгодог. Уг жишиг дүрмийн үндсэн зарчмууд нь хүүхдийн эрх чөлөөг хязгаарлаж, хорьж мөрдөхийг хамгийн сүүлчийн арга хэмжээ болгон хэрэглэх, хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчтай нь холбон, эрүүл ахуй, боловсрол, сэтгэл санаа, сэргээн засах үйлчилгээнд хамруулахыг урьтал болгох шаардлагыг хангах явдал юм. Хүүхэд эцэг эх, төрж өссөн гэр бүл, орчин нөхцөлөөс нь салгахгүй байх үндсэн эрхийг баталгаатай эдлэх бөгөөд түүний энэхүү эрх, эрх чөлөөг хязгаарлах асуудал нарийн дэг журам, урьдчилсан нөхцөлүүдийг хуулиар тогтоосон байхыг уг жишиг дүрмээр шаарддаг.

Энэхүү дүрэм нь Олон улсын гэрээний бус баримт бичиг учраас гишүүн орнуудад хууль ёсоор хэрэглэх шаардлагагүй боловч үндэсний хууль, бодлого, журамд нийцүүлэхийг НҮБ-аас уриалах ба НҮБ-ын Хүүхдийн эрхийн зөвлөл нь улс орнуудад зөвлөмж өгч, Өсвөр насны хүний эрх чөлөөг хязгаарлах нь хамгийн сүүлчийн арга хэмжээ байх, богино хугацаагаар хэрэглэх ёстойг үргэлж анхааруулсаар иржээ.

5 бүлэг, 87 зүйлээс бүрдэх уг жишиг дүрмийн агуулга нь хүүхдийн эрх, аюулгүй байдал, бие, сэтгэлзүйн сайн сайхныг хамгаалах, шүүхийн өмнөх шатанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах болон хүүхдийг хорьж шийтгэх арга хэмжээ нь эцсийн арга хэмжээ байх бөгөөд богино хугацаагаар тогтоох, насанд хүрээгүй хүүхдийг ялгаварлалгүйгээр хүнлэг, шударгаар харилцах, хүүхдийн боловсрол, мэргэжил эзэмших, чөлөөт цаг, спорт, урлаг, сэтгэлзүйн дэмжлэгийг тасралтгүй үзүүлэх, хүүхдийн гэр бүл, нийгэмтэй харилцах, эргэн нэгтгэх боломжийг дэмжих, хууль зүйн зөвлөгөө, эмнэлгийн үйлчилгээ, шашин, соёлын эрхийг хүндэтгэх, сахилгын хатуу журам тогтоохгүй байх, тэдгээрт хүнлэг, боловсрол, хүмүүжил олгох зорилготой, хүчирхийлэлгүй арга хэрэгслүүд бүхий олон төрөлт үйлчилгээг сонгож хэрэглэх, хүүхдийн хорих газарт ажиллах ажилтнууд мэргэжлийн боловсролтой, ёс зүйтэй, энэ чиглэлээр байнга сургалтад хамрагдсан байх зэрэг наад захын жишиг стандартыг улс орнуудын хууль зүйн бодлогод санал болгож, хүүхдийг хорьж шийтгэхийн сөрөг нөлөөг бууруулж, өсвөр насны хүнийг төрж өссөн гэр бүл, орчин нөхцөл, нийгэмд нь эргэн нэгтгэх, хүнлэг, боловсрол, хүмүүжил, сэтгэлзүйн дэмжлэг олгох арга замыг эрэлхийлэх үндсэн зорилготой байна.

2.3.3. Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох Токиогийн жишиг дүрэм (1990 он)

Токиогийн жишиг дүрэм¹⁹ нь НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45/110 дугаар тогтоолоор батлагдсан, зөвхөн өсвөр насныханд бус бүх насны “эрхийн зөрчил гаргагч” нарт хамааралтай. Учир нь Токиогийн жишиг дүрмийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт энэ дүрмийн хамаарах заалтууд нь мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлэг болон шүүхийн шийдвэр гүйцэтгэл зэрэг байцаан шийтгэх ажиллагааны бүх шатанд оролцож буй этгээдүүдэд хэрэглэгдэх ба энэ дүрмийн хүрээнд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэн байхаас үл

19 Токиогийн жишиг дүрэм, <https://www.mn-nhrc.org/153-rtr-sr-rtrryosrrs-uus-susrryorr-rsrir-srrrssrr-srrrrrrrs-rtr-rtrrrr-rtyosrryori-rtyissr-rtyeryorrryorr-rtyissr.html>, Монгол хэл дээрх албан бус орчуулга, (Сүүлд үзсэн: 2025.09.14).

хамааран “эрхийн зөрчил гаргагч” гэж нэрлэгдэнэ. Мөн дүрмийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар дүрэм нь шашин шүтлэг, арьсны өнгө, хүйс, хэл, улс төрийн болон бусад үзэл, нийгмийн гарал үүсэл, эд хөрөнгийн байдал, төрсөн газар зэргээр нь ялгаварлан гадуурхахгүйгээр бүх хүнд тэгш хэрэглэгдэнэ гэжээ.

Токиогийн жишиг дүрмээр хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх үндсэн зарчмуудыг тогтоож, хэрэгжүүлэхэд чиглэсэн жишиг хэм хэмжээнүүдийг санал болгосон бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатанд хорихоос бусад арга хэмжээг өргөн хэрэглэх боломжийг хангах, эрх зүйн зөрчил үйлдэгчийг нийгэмд эргэн оруулах, хүмүүжүүлэх арга замыг эрэлхийлэх, нийгмийн аюулгүй байдлыг хангах, хохирогчийн эрхийг хамгаалах, эрх зүйн зөрчил гаргагчийн хүний эрх, нэр төрийг хүндэтгэх зорилгыг агуулна. Тус дүрэм нь зөвхөн хорих ялыг багасгах төдийгүй, эрх зүйн зөрчил үйлдэгчийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, олон талын судалгаа, хяналт, сайн дурынхны оролцоог дэмжих, хүний эрхийг хамгаалах арга замыг тодорхойлжээ.

Бүтэц, агуулгын хувьд Токиогийн жишиг дүрэм нь үндсэн дөрвөн хэсэгт төвлөрөх ба үндсэн зарчмуудын (1-4 дүгээр зүйл) талаар хорихоос бусад арга хэмжээний эрх зүйн үндэс, хүний эрхийг хамгаалах, хохирогчийн болон нийгмийн эрх ашигт анхаарах, шүүхийн өмнөх шатны (5-6 дугаар зүйл) арга хэмжээнүүдийн талаар мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүнийг хорьж мөрдөхөөс зайлсхийх, боломжтой бол хөнгөн арга хэмжээ оногдуулах, шүүхийн шат ба тогтоол гаргах (7-9 дүгээр зүйл) зохицуулалтын хувьд (1) нийгмийн судалгааны илтгэл бэлтгэх, (2) шийтгэх арга хэмжээг зөв сонгох, (3) шийтгэсний дараа нийгэмшүүлэх арга хэмжээ авах талаар, хорихоос өөр төрлийн эрүүгийн хариуцлагын талаарх 10-14 дүгээр зүйлд хяналт тогтоох хугацаа, болзол, сахилга бат болон энэ хугацаанд үйлдсэн эрх зүйн зөрчлийг хэрхэн харгалзаж үзэх талаар, боловсон хүчний асуудлаарх 15-16 дугаар зүйлд мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, хяналт тавих, сургалт явуулах стандарт, олон нийтийн болон сайн дурынхны (17-19 дүгээр зүйл) оролцооны талаар нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, сайн дурынхны үүрэг, хамгаалалтыг тодорхойлох асуудлыг, судалгаа, бодлого боловсруулах (20-22 дугаар зүйл) талаар практик үнэлгээ хийх, мэдээлэл цуглуулах, үндэсний болон олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх зохицуулалтуудыг, мөн олон улсын хамтын ажиллагааны (23 дугаар зүйл) талаар судалгаа, сургалт, туршлага солилцох, хууль эрх зүйн уялдааг сайжруулах талаар жишиг болохуйц наад захын стандартуудыг НҮБ-ын гишүүн орнуудад санал болгож, хэрэгжүүлэхийг уриалжээ.

Дүгнэвэл, Токиогийн жишиг дүрэм нь насанд хүрсэн болон насанд хүрээгүй эрх зүйн зөрчил гаргагчид хорихоос бусад арга хэмжээг хэрэглэх олон улсын стандартын жишиг дүрмүүдийг санал болгож, хүний эрхийг дээдлэх, нийгмийн оролцоог дэмжих, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд уян хатан байдлыг хангах, зөрчил гаргагчийг нийгэмшүүлэхэд чиглэгджээ. Энэ дүрэм нь улс орнуудын шүүх, хууль сахиулах байгууллагын бодлого, практикт дэмжлэг үзүүлэх, хорихоос бусад арга хэмжээг системтэй, үр дүнтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

III. ШҮҮХИЙН ПРАКТИК СУДАЛГАА, ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Монгол Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи (цаашид “Шүүхийн академи” гэх)-ийн Судалгааны төвтэй хамтран өсвөр насны хүнд холбогдсон эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан тусгай журмыг хэрхэн тайлбарлан хэрэглэж байгаад дүгнэлт өгөх зорилгоор, өсвөр насны хүнд холбогдсон хэргийн статистик мэдээг гаргах, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлэгт заасан тусгай журмын хэрэгжилт, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8 дугаар бүлэгт заасан тусгай журмын хэрэглээнд дүгнэлт хийх зорилтуудыг дэвшүүлж “Өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог”²⁰ сэдэвтэй судалгааг 2025 оны 05 дугаар сард хийж гүйцэтгэсэн. Энэхүү судалгаанд Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн статистик мэдээг ашиглахаас гадна Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 473 шийдвэр, давж заалдах шатны шүүхийн 61 магадлал, хяналтын шатны шүүхийн 20 тогтоол, **нийт 554 шүүхийн шийдвэрийг** хамрууллаа.

3.1. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн статистик

Энэ бүлэгт тусгасан дүгнэлтүүд 2022-2024 оны Монгол Улсын шүүхийн статистик мэдээнд тулгуурласан бөгөөд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2022 онд нийт 14200 хэрэг шийдвэрлэж, 14393 хүнд ял шийтгэл оногдуулсны 208 нь өсвөр насны хүн байна. Оногдуулсан ялыг төрлөөр нь авч үзвэл 8165 хүнд торгох ял оногдуулснаас 7 нь өсвөр насны хүн, 1552 хүнд нийтэд тусгай ажил хийлгэх ял оногдуулсны 55 нь өсвөр насны хүн, 1761 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсны 44 нь өсвөр насны хүн, 2915 хүнд хорих ял оногдуулсны 102 нь өсвөр насны хүн байна.

Түүнчлэн, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2023 онд нийт 13977 хэрэг шийдвэрлэж, 14192 хүнд ял шийтгэл оногдуулсны 222 нь өсвөр насны хүн байна. Оногдуулсан ялыг төрлөөр нь авч үзвэл, 8360 хүнд торгох ял оногдуулснаас 10 нь, 1467 хүнд нийтэд тусгай ажил хийлгэх ял оногдуулсны 32 нь, 1814 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсны 77 нь, 2551 хүнд хорих ял оногдуулсны 103 нь өсвөр насны хүн байна. 2024 оны статистик мэдээнээс үзвэл, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2024 онд нийт 14682 хэрэг шийдвэрлэж, 14663 хүнд ял шийтгүүлж оногдуулснаас 209 нь өсвөр насны хүн байна. Оногдуулсан ялыг төрлөөр нь авч үзвэл 8811 хүнд торгох ял оногдуулснаас 18 нь, 1507 хүнд нийтэд тусгай ажил хийлгэх ял оногдуулсны 32 нь, 1840 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсны 65 нь, 2505 хүнд хорих ял оногдуулсны 94 нь өсвөр насны хүн байна гэсэн статистик мэдээлэл гарчээ.²¹

Дээрхээс дүгнэвэл, Монгол Улсын хэмжээнд жил бүр шийдвэрлэгдэж байгаа

20 Шүүхийн академи, Шүүхийн судалгааны төв, “Өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог” судалгаа, 2025.

21 Шүүхийн академи, Шүүхийн судалгааны төв, “Өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог” судалгаа, 2025.

нийт 14 мянга орчим эрүүгийн хэргээс өсвөр насныхны үйлдсэн эрүүгийн хэргийн хувь дунджаар 1.4-1.6% байх бөгөөд хорих ялыг жил бүр дунджаар 100 орчим (хорих ял оногдуулсан шийтгэх тогтоолыг хойшлуулсан тохиолдолтой хамт) өсвөр насны хүнд оногдуулжээ.

Хорих ял оногдуулсан шийтгэх тогтоолын биелэлтийг хойшлуулах, хорих ял оногдуулсны дараа хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, тэнсэж хянан харгалзсан зэрэг эрүүгийн эрх зүйн арга хэмжээнүүдийн дараа сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хоригдож буй өсвөр насныхны тоо үүнээс бага тоогоор гарах боловч өсвөр насны хүнд сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял оногдуулсан статистик тоо баримтыг үндэслэн хүүхдийн эрхийн олон улсын наад захын стандартыг тогтоосон жишиг дүрмүүдийг (хорих ялыг хамгийн сүүлчийн арга гэж үзэх зарчим) шалгуур болговол, Монгол Улсад өсвөр насныханд зориулсан шударга ёсны тогтолцооны зорилт /Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэг болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлгийн зорилт/ хангагдаж байгаа эсэх тухай асуудал анхаарал татаж байна. Хорихоос өөр төрлийн ялыг (нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах) оногдуулах байдал харьцангуй бага байгаа боловч Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8 дугаар бүлэгт хүүхдэд оногдуулж болохоор хуульчлаагүй торгох болон эрх хасах ялыг шүүхүүд хэрэглэсэн нь судалгааны үр дүнгээр тогтоогдсон, энэ нь өсвөр насны хүн гэмт хэрэг үйлдэж, шүүхээр хэрэг нь шийдвэрлэгдэх үед насанд хүрсэнтэй, мөн тогтмол орлоготой буюу хөдөлмөр эрхэлдэгтэй холбоотой гэж зарим шүүхийн шийдвэрүүдэд тэмдэглэсэн зэргээр хууль хэрэглээний ялгаатай байдлууд ажиглагдав.

2022-2024 оны статистик нь өсвөр насныхны гэмт хэрэг тогтвортой өндөр түвшинд байгааг харуулж, хорих ял давамгайлж буй нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн бодлого өсвөр үеийг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх олон улсын зарчимтай нийцэж буй эсэхийг судлах шаардлагыг бий болгож, цаашид хорихоос өөр ялын хэрэглээг нэмэгдүүлэх, хууль хэрэглээний асуудалд бодлогын шинэчлэл шаардлагатайг харуулна.

Өсвөр насны хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийн төрлийг улсын хэмжээний шүүхийн статистик мэдээллээс нарийвчлан гаргах боломжгүй бөгөөд Шүүхийн судалгааны төвөөс гаргасан статистик мэдээгээр 2024 оны байдлаар Улаанбаатар хотын 9 дүүргийн хэмжээнд авч үзлээ. Үүнд, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 42 гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт 33, амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэгт 4, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 5, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт 2, олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1, нийт 87 хэргийг дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд шийдвэрлэжээ. Эндээс үзвэл, өсвөр насны хүүхдүүд бусдын бие махбодод халдах, харилцан зодолдох, хулгайлахаас гадна бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, хүчиндэх, тээврийн хэрэгсэл жолоодох үед гэмт хэрэгт ихээхэн холбогдож, өртжээ. Хөдөө орон нутагт дээрх төрлийн гэмт хэргүүдээс гадна өсвөр насны хүүхдүүд малын хулгайн гэмт хэрэгт ихээхэн холбогдож байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн статистик мэдээллээр сүүлийн

гурван жилд өсвөр насны нийт 89 хүнд таслан сэргийлэх арга хэмжээ авсан бөгөөд 2022 онд 27, 2023 онд 46, 2024 онд 16 хүн байжээ. Энэ хугацаанд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдээс өсвөр насны хүнд таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн захирамжийг Шүүхийн академийн Судалгааны төвд ирүүлэхийг хүссэнээр нийт 80 шүүгчийн захирамж судалгаанд хамрагдсан, үүнд яллагдагчийг цагдан хорьсон 14 захирамж, цагдан хорихоос татгалзсан 12 захирамж, шилжүүлэн цагдан хорьсон 1 захирамж, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгасан 44 захирамж, хүчингүй болгож, өөрчилсөн 3 захирамж, Монгол Улсын хилээр гарахыг хязгаарласан 1 захирамж, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авсан 2 захирамж багтсан байна.

Үүнээс дүгнэвэл, өсвөр насныхныг цагдан хорих болон бусад таслан сэргийлэх арга хэмжээ авах явдал харьцангуй тогтворгүй, статистик мэдээг нарийвчилсан шалгуур үзүүлэлтээр гаргах шаардлагатай байх бөгөөд 2023 онд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний тоо 2024 онд эрс буурсан нь гэмт хэрэгт холбогдсон өсвөр насныхны тоон үзүүлэлттэй шууд холбоотой байх магадлалтай. Мөн хамгийн олон тохиолддог захирамж нь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах явдал бөгөөд энэ тоог цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг шинээр авсан статистик тоон мэдээлэлтэй нэгтгэх эсэх, өсвөр насны хүнийг хорьж мөрдөх урьдчилсан нөхцөлүүд хамгийн эцсийн арга хэмжээ байх хуулийн үзэл баримтлалтай нийцэж байгаа эсэх талаар тусгайлан судалгаа хийх шаардлагатай.

3.2. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, хууль хэрэглээний ялгаатай байдал

Өмнө нь тэмдэглэсэнчлэн, Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэхэд удирдлага болгох тусгай журмыг шүүх хэрхэн хэрэгжүүлж, хэрэглэж байгаад дүн шинжилгээ хийх зорилгоор Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 473 шийдвэр, давж заалдах шатны шүүхийн 61 магадлал, хяналтын шатны шүүхийн 20 тогтоол нийт 554 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж:

- Өсвөр насны хүнд холбогдох хэргийн шүүхийн хэлэлцүүлгийг нээлттэй, хаалттай явуулсан эсэх;
- Өсвөр насны хүний хувийн байдлыг хуульд заасан үндэслэл журмын дагуу тогтоож, шүүхийн шийдвэрт энэ талаар тусгайлан дүгнэлт хийж, тэдгээрт ялын болон ялын бус хүмүүжлийн чанартай албадагын арга хэмжээ хэрэглэх үед харгалзаж үзсэн эсэх;
- Өсвөр насны хүний амьдралын нөхцөл байдал, хүмүүжилтэй холбоотой мэдээлэл хангалттай цугларсан эсэх, энэ талаар шүүх прокурорын байгууллагаас шаардсан эсэх;
- Өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэрэгт хамтран оролцогч байсан эсэх;
- Урьд ял шийтгүүлсэн өсвөр насны хүний хувийн байдлыг хэрхэн харгалзаж үзсэн эсэх;

- Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тусгай журмыг хэрхэн хэрэглэсэн эсэх;
- Өсвөр насны хүнд оногдуулсан ялын төрөл, түүний харьцаа;
- Хорих ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дангаараа хэрэглэсэн байдал зэргийг судалж, судалгааны дүгнэлт өгөхийг зорьсон юм.

3.2.1. Шүүх хуралдааныг хаалттай явуулсан эсэх

Судалгаанд хамрагдсан анхан шатны шүүхийн нийт 473 шийтгэх тогтоолын 118 буюу 25 хувьд нь өсвөр насны хүнд холбогдох хэргийн шүүх хуралдааныг нээлттэй явуулжээ. Энэ нь шийтгэх тогтоол гарах үед шүүгдэгч 18 насанд хүрсэн гэх нөхцөл байдал болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнө мөн хуулийн 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “*Өсвөр насны яллагдагч, ...эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно*” гэсэн зохицуулалт үйлчилж байсантай холбоотой байна.²² 473 шийтгэх тогтоолын 355 буюу 75 хувийг хаалттай шүүх хуралдаанаар шийдвэрлэжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр орсон өөрчлөлтөөр “... шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ” гэж заасан бөгөөд хуулийн өмнөх зохицуулалтаар өсвөр насны хүнд холбогдох хэргийн шүүх хуралдааныг оролцогчийн хүсэлтийг харгалзан шүүх нээлттэй явуулж болохоор хуульчилсан бол тухайн зохицуулалтад өөрчлөлт орсноор шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ гэж тодруулсан.

Угтаа өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх тусгайлсан журмыг тодорхойлсон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “*Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулж, шийдвэрийг олон нийтэд мэдээлэхдээ өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, түүнд учирч болох бусад хор уршгийг тусгайлан харгалзана*” гэж тодорхой хуульчилсан. 1985 оны Бээжингийн жишиг дүрмийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “*Өсвөр насны хүний хувийн нууцыг бүх шатанд хүндэтгэж, ингэснээр олон нийтийн зохисгүй анхаарал болон зүй бус нэр, хоч зүүх аливаа хор хохирлоос сэргийлнэ*”, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “*Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүний аливаа мэдээллийг олон нийтэд ил болгохгүй байхыг үндсэн зарчим болгоно*” гэж, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “*Гэмт хэрэгт*

²² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 2 “Хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ” гэж өөрчлөгдсөн бөгөөд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан уг өөрчлөлтийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байна.

холбогдсон өсвөр насны хүний хувийн мэдээллийг онцгой нууцалж, хадгална. Мэдээлэлд хандах эрхийг тухайн хэрэгт шууд хамааралтай болон зохих ёсоор зөвшөөрөгдсөн этгээдээр хязгаарлана” гэж, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний хувийн мэдээлэл бүхий бүртгэлийг тухайн этгээд насанд хүрсний дараах үйлдсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед ашиглахыг хориглоно” гэж наад захын стандарт тогтоосноос үзвэл, өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, уг ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг болох шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааны ажиллагаа бүхэлдээ хаалттай явагдана.

Манай улсын хувьд өмнө нь оролцогчийн хүсэлтээр, өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор нээлттэй явуулах эсэхийг шүүх шийдвэрлэхээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хуульчилсан боловч сүүлд энэ үндэслэлээр нээлттэй, эсхүл хаалттай явуулахыг шүүх шийдвэрлэнэ гэж хуульчилсныг, мөн хуулийн 18 дугаар бүлгийн үзэл баримтлалтай нийцүүлэн хэрэглэх шаардлагатай.

3.2.2. Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүний хувийн байдлыг дүгнэж, харгалзаж үзсэн байдал

Өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол онцлог нь түүний хувийн байдлыг хуульд заасан үндэслэл, шалгуур тус бүрээр нарийн чанд, нягт нямбай тогтоох асуудал бөгөөд энэ нь түүнд ялын болон ялын бус хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэхэд шалгуур болгож, шүүхээс харгалзаж үзэх гол үндэслэл болдог. Энэ талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт тодорхой хуульчилсан ба судалгаанд хамрагдсан шийтгэх тогтоолуудад мөн хуулийн 18.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан:

1. төрсөн он, сар, өдөр, нас;
2. амьдралын нөхцөл байдал ба хүмүүжилтэй холбоотой мэдээлэл;
3. гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл;
4. гэмт хэрэг хамтран үйлдэгч байсан эсэх;
5. сэтгэцийн өвчинтэй холбогдолгүй боловч ухаан санаа нь гүйцэд хөгжөөгүйн улмаас өөрийнхөө үйлдлийн холбогдлыг бүрэн ойлгож байгаа эсэхэд эргэлзээ төрвөл шинжээч томилж, дүгнэлт гаргуулах зэрэг таван нөхцөл тус бүрийг хэрэгт цугларсан нотлох баримтуудад үндэслэн тухайлан дүгнэж, мөн прокуророос;
6. тухайн шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхийн өмнө болон дараа биеэ хэрхэн авч явж байсан зан байдал, араншин;
7. тухайн шүүгдэгч гэмт хэрэг үйлдэх үедээ ямар нөхцөл байдалд байсан зэрэг мэдээллийг шаардсан буюу энэ талаар шийтгэх тогтоолд тусгайлан дүгнэлт хийсэн тохиолдол байгаагүй юм. Харин эдгээр 7 нөхцөлийн талаар Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ялын төрлийг сонгож оногдуулах, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулах,

хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үед ерөнхий байдлаар дүгнэж, харгалзан үзсэн талаар цөөхөн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт тусгажээ.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүмүүсийн хувийн байдлыг анхан шатны шүүхийн 473 шийтгэх тогтоолоос нэгтгэн үзвэл, тухайлбал 14 настай 51 шүүгдэгч, 15 настай 99 шүүгдэгч, 16 настай 121 шүүгдэгч, 17 настай 214 шүүгдэгч, 18 настай 91 шүүгдэгч, 19-21 настай 19 шүүгдэгч байх бөгөөд үүнд нийт шүүгдэгчийн тоотой харьцуулбал 16-17 насны шүүгдэгчийн эзлэх хувь их байна. Уг ангилалд хамаарч буй өсвөр насны хүнд эцэг, эхийн хараа хяналт сул, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ бусадтай үл ялих зүйлээр маргалдсанаас, түүнчлэн орон нутгаас хот, суурин газарт шилжилт хөдөлгөөн хийж, эцэг эх, асран хамгаалагчаас тусдаа амьдарсан үедээ өсвөр насныхан гэмт хэрэгт холбогдсон зэрэг хүчин зүйлсийг судалгааны тайланд²³ тэмдэглэжээ.

Ял шийтгүүлсэн өсвөр насны хүнийг боловсролын байдлаар нь авч үзвэл, бага боловсролтой 65 хүн, бүрэн дунд, бүрэн бус дунд боловсролтой 388 хүн, тусгай дунд боловсролтой 10 хүн, дунд ангид суралцаж байгаа 98 хүн, ахлах ангид суралцаж байгаа 167 хүн, коллежид суралцаж байгаа 76 хүн, их дээд сургуульд суралцаж байгаа 23 өсвөр насны шүүгдэгч байсан бол сургууль завсардсан 5 хүн, ажил хөдөлмөр эрхэлдэг, эсхүл суралцахын хажуугаар хөдөлмөр эрхэлдэг 41 өсвөр насны шүүгдэгч эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагджээ. Эдгээрээс хүчиндэх гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүн эцэг, эхийн шахалт, шаардлагаар сургууль завсардсан, бага боловсролтой зэрэг нийтлэг шинж ажиглагдсаныг судалгааны тайланд тусгасан байна.

Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүний амьдралын нөхцөл, хүмүүжлийн талаарх хувийн байдлыг нотолгооны уламжлалт хэрэгслүүдээр буюу гэмт хэрэг үйлдэх үеийн өмнө ба дараах зан байдал, араншныг түүний анги удирдсан багш, ангийн хүүхдүүдийн болон гэр бүлийн гишүүдийн мэдүүлэг, суралцагчийн хувийн хэрэг, сургуулийн тодорхойлолт, шагналын бүртгэл зэргээр хязгаарлаж байгаа нь ажиглагдсан бөгөөд гэр бүлийн гишүүдийн мэдүүлэгт дурдсан хүмүүжилтэй холбоотой мэдээллээр гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүн бага насандаа үрчлэгдсэн буюу эцэг, эхээсээ тусдаа амьдардаг, эцэг эхийн хайр, халамж дутагдсан, өмнө нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, энэ нь хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлсөн зэрэг нөхцөл байдлууд дурдагдсан байжээ. Харин энэ талаар анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолуудад түүнд хэрэглэх ялын болон ялын бус сургалт, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэсэн тохиолдолд хэрхэн харгалзаж үзсэн талаар дүгнэлтийг хийдэггүй нь судалгаагаар тогтоогдсон болно.

Анхан шатны шүүхийн 473 шийтгэх тогтоолын 33 нь өсвөр насны хүнийг хэрэг хариуцах чадвартай эсэхийг тогтоолгохоор сэтгэцийн шинжилгээ хийлгэсэн, тус 33 тогтоолын 17 нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны шүүгдэгч хэрэг хариуцах чадвартай эсэх талаар

23 Шүүхийн академи, Шүүхийн судалгааны төв, “Өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог” судалгаа, 2025.

шинжээч томилж дүгнэлт гаргуулсан байх бөгөөд тухайн шийтгэх тогтоолд өсвөр насны хүний хувийн байдлыг, тухайлбал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5 дахь заалтад *“сэтгэцийн өвчинтэй холбогдолгүй боловч ухаан санаа нь гүйцэд хөгжсөөгүйн улмаас өөрийнхөө үйлдлийн холбогдлыг бүрэн ойлгож байгаа эсэхэд эргэлзээ төрвөл шинжээч томилж, дүгнэлт гаргуулах”* гэж заасны дагуу шинжээч томилсон талаар бус, харин өсвөр насны хүнийг хэрэг хариуцах чадвартай эсэхийг тогтоолгох зорилгоор шинжээч томилсон байна.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэр бүлийн байдлыг судалгаанд хамрагдсан анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолоос түүвэрлэн үзвэл, бүтэн өнчин 2 хүн, эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй 25 хүн, эцэг, эхийн аль нэгтэй нь хамт амьдардаг 122 хүн, дагавар хүүхэд 8 хүн, үрчлүүлсэн хүүхэд 4, эцэг эх, асран хамгаалагчаасаа тодорхой хугацаагаар тусдаа амьдардаг 10 хүн, төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байсан 4 хүүхэд байсан бол 31 шүүгдэгч өсвөр насны хүн урьд нь ял шийтгүүлсэн байжээ.

3.2.3. Эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байдал

Судалгаанд хамрагдсан 473 шийтгэх тогтоолоос үзвэл, гэмт хэрэг үйлдсэн 294 өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8 дугаар бүлэгт тогтоосон ялын төрлөөр буюу сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял шийтгэсэн 129 хүн, зорчих эрхийг нь хязгаарлах ял оногдуулсан 72 хүн, нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн 67 хүн, харин мөн хуулийн ерөнхий ангийн 8 дугаар бүлэгт заагаагүй ял оногдуулсан буюу торгох ял оногдуулсан 19 хүн, тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах буюу тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ял оногдуулсан 7 хүн байна.

3.2.3.1. Торгох ял оногдуулсан талаар

Гэмт хэрэг үйлдэх үедээ өсвөр насандаа байсан хүнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас өөр, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ял шийтгэл оногдуулах асуудалд хууль хэрэглээний ялгаатай байдал тогтоогдсон. Энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлэг, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8 дугаар бүлгийн үзэл санаа болон 1985 оны Бээжингийн жишиг дүрэм болон 1990 оны Токиогийн жишиг дүрмийн үзэл санаанд нийцээгүйг тэмдэглэх нь зүйтэй.

Судалгаанд хамрагдсан шийтгэх тогтоолуудаас үзвэл, хууль хэрэглээний энэхүү ялгаатай байдлын шалтгаан нь өсвөр насны шүүгдэгч гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй, харин гэмт хэрэг үйлдсэний дараа хэргээ шүүхээр шийдвэрлэх үед насанд хүрсэнтэй холбоотой байх боловч энэ нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт *“Гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн ба 18 насанд хүрээгүй байсан хүнд энэ бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”* гэж заасан нийтлэг журмын зорилготой илэрхий харшилж байна.

Гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй, харин шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх явцад 18 насанд хүрсэн хүнийг шүүхийн шийдвэрт “өсвөр насны шүүгдэгч” бус харин “шүүгдэгч” хэмээн тодорхойлсон байх ба тэдний дийлэнх хувь

нь шүүх хуралдаанд өөрийгөө өмгөөлж оролцох хүсэлт гаргасан, шүүх хуралдаанд өмгөөлөгчгүй, хууль ёсны төлөөлөгчгүйгээр оролцсон²⁴ байдал нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлгийн тусгайлсан зохицуулалтын үзэл санаанд, тодруулбал өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа энэ хуульд заасан ердийн журмаас гадна энэ бүлэгт заасан тусгай журмыг удирдлага болгоно гэж заасанд нийцээгүй байна.

Судалгаанд хамрагдсан шийтгэх тогтоолуудаас үзвэл, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд торгох ял оногдуулсан 19 тохиолдол байх бөгөөд эдгээр шүүхийн шийдвэрийн дийлэнх хувь нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны шүүгдэгч нарт ял шийтгэл оногдуулсан байв. Шүүх торгох ялыг оногдуулахдаа шүүгдэгч хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан, өсвөр насандаа буюу 18 насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн боловч хэрэг хянан шийдвэрлэх явцад 18 насанд хүрсэн, өсвөр насны шүүгдэгч нь ажил хөдөлмөр эрхэлж, тогтмол орлого олдог зэргийг харгалзан үзсэн талаар тэмдэглэжээ. Гэтэл өсвөр насны хүнд оногдуулахаар хуулиар тухайлан тогтоогоогүй ялын төрөл болох торгох ял оногдуулж, түүнд эд хөрөнгийн шинжтэй хариуцлага хүлээлгэсэн шүүхийн практик нь өсвөр насны хүнд зориулсан шударга ёсны тогтолцооны зорилго, зорилтыг хангаагүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагыг гагцхүү Эрүүгийн хуулиар тодорхойлох хууль ёсны зарчимд нийцэхгүйг тэмдэглэх нь зүйтэй.

3.2.3.2. Нийтэд тусгай ажил хийлгэх ял оногдуулсан талаар

Өсвөр насны хүнд нийтэд тусгай ажил хийлгэх ял оногдуулсан 67 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд дараах хууль хэрэглээний ялгаатай байдал ажиглагдав. Үүнд:

- Өсвөр насны хүнд нийтэд тусгай ажил хийлгэх ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8.3 дугаар зүйлд заасан тусгай журмыг хэрэглээгүй, харин Эрүүгийн хуулийн тусгай ангийн 5.3 дугаар зүйлд заасан ердийн журмыг хэрэглэсэн 1 тохиолдол;

- Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8.3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгчид нийтэд тусгай ажил хийлгэх ял оногдуулж, мөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дахь заалтыг журамлан ялаас чөлөөлсөн 10 шүүхийн шийдвэр байв.

Түүнчлэн шүүх өсвөр насны шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, хор уршгийн шинж чанар, шүүгдэгчийн хувийн байдал, эрүүгийн хариуцлагын хууль зүйн үр дагаврыг ухамсарлаж ойлгосон байдал, шүүгдэгч ерөнхий боловсролын сургуульд сурдаг зэргийг харгалзаж, Эрүүгийн хуулийн 8.3 дугаар зүйл болон 6.7 дугаар зүйлийг давхар хэрэглэн ялаас чөлөөлж, нийтэд тусгай ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийдвэрт өсвөр насны шүүгдэгч нийтэд тусгай ажил

²⁴ Шүүхийн академи, Шүүхийн судалгааны төв, “Өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог” судалгаа, 2025, 32 дахь тал.

хийлгэх ялыг биелүүлээгүй бол уг ялын 8 цагийн ажлыг 1 хоногоор тооцон, хорих ялаар солихыг мэдэгдэх нь зүйтэй хэмээн Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан ердийн зохицуулалтыг тусгажээ.

Улсын яллагч нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулах санал гаргасан ч шүүх шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэг нь хорих ял оногдуулах санкцтай, харин шүүгдэгчийн үйлдсэн тухай төрлийн гэмт хэрэгт нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулахаар Эрүүгийн хуулийн тусгай ангид заагаагүй гэж дүгнэж, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял оногдуулсан зэргээс дүгнэвэл, Эрүүгийн хуулийн тусгай ангид нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны шүүгдэгчид Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт тусгайлан заасан энэ төрлийн ялыг сонгон оногдуулах эсэх дээр шүүхүүд өөр өөр дүгнэлт хийсэн, хууль хэрэглээний ялгаатай байдал ажиглагдав.

Эрүүгийн хуулийн 8.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нийтэд тустай ажил хийлгэх ялыг шүүх энэ хуулийн “тусгай ангид заасан” тохиолдолд оногдуулах талаар тусгайлан хуульчлаагүй, харин 8.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зорчих эрхийг хязгаарлах ялыг, 8.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ялыг тус тус “энэ хуулийн тусгай ангид” тэдгээр ялыг оногдуулахаар заасан тохиолдолд хэрэглэхээр заасан нь мөн хуулийн тусгай ангид нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд уг ялыг хэрэглэх эсэх асуудалд эргэлзээ төрүүлэхүйц болжээ.

3.2.3.4. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан талаар

Өсвөр насны хүнд зорчих эрх хязгаарлах ял оногдуулсан 72 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг баримтлан зорчих эрх хязгаарлах ял оногдуулж, эдлэх ялыг 2 дахин багасгасан буюу энэ талаарх хууль хэрэглээний асуудал харьцангуй тогтвортой байв. Харин 11 шүүхийн шийдвэрт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8.4 дүгээр зүйл болон 6.7 дугаар зүйлийг давхардуулан хэрэглэсэн бөгөөд шүүх өсвөр насны шүүгдэгчид оногдуулсан зорчих эрх хязгаарлах ялыг 2 дахин багасгаж, үүний дараа ялаас чөлөөлжээ. Шүүх гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх эсэхийг гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлсөн зэргийг харгалзан үзэж зорчих эрх хязгаарлах ял оногдуулсны дараа Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийг журамлан ялаас чөлөөлсөн байна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан энэ бүлэгт заасан журмын дагуу ял оногдуулж, оногдуулсан ял дээр нэмж, эсхүл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно хэмээн заасан. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан нийт 72 шүүхийн шийдвэрээс зорчих эрхийг хязгаарлах ял дээр нэмж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 1 тохиолдол байв.

Дээрхээс үзвэл, Эрүүгийн хуулийн 8.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар өсвөр насны хүнд оногдуулсан зорчих эрх хязгаарлах ялыг 2 дахин багасгаж оногдуулахтай холбоотой зохицуулалтыг хэрэглээний хувьд нэгдмэл байдал

тогтсон байх ба шүүгдэгчийн хувийн байдал, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлсөн зэргийг шүүхээс харгалзан үзэж, Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд зааснаар зорчих эрх хязгаарлах ялаас чөлөөлсөн хэдий ч хүмүүжлийн чанартай арга хэмжээг маш цөөн тохиолдолд хэрэглэж байгаа нь ажиглагдав.

3.2.3.5. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял оногдуулсан талаар

Судалгаанд хамрагдсан эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 473 шүүхийн шийдвэрээс 88 шүүхийн шийдвэрээр 129 өсвөр насны хүнд сургалт хүмүүжлийн байгууллагад хорих ял оногдуулсан байв. Шүүх хорих ял оногдуулах үндэслэлдээ учруулсан хохирол хор уршгийн хэр хэмжээг харгалзан үзэхээс гадна өсвөр насны шүүгдэгч урьд нь гэмт хэрэгт ял шийтгэгдэж байсан атлаа засрал хүмүүжлийг олоогүй байдал, гэмт хэрэг үйлдсэн арга, давтамж зэргийг харгалзан үзжээ. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял шийтгэсэн шийтгэх тогтоолуудыг нэгтгэн үзвэл, Шүүхийн академийн Судалгааны төвөөс хийсэн судалгаагаар хууль хэрэглээний дараах ялгаатай байдлууд тогтоогдов. Үүнд:

а) Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тусгай журмыг хэрэглэхгүй байх:

Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалтад гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ баримтлах тусгай журмыг хуульчилсан нь шүүхэд эрх олгосон бус, харин үүрэг болгосон императив хэм хэмжээнүүд юм. Гэтэл судалгаанд хамрагдсан зарим шийтгэх тогтоолуудад хуулийн дээрх тусгай журмыг хэрэглээгүй, хэрэглэхээс татгалзсан ч тохиолдлууд бүртгэгдэв. Энэ талаар Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүх хуралдааны хэд хэдэн тогтоолуудад²⁵ Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт заасан өсвөр насны шүүгдэгчид заавал хэрэглэх хэм хэмжээг шүүхээс хэрэглээгүй байдлыг өөрчлөн залруулсан бөгөөд “...гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй байсан хүн насанд хүрсний дараа шүүхээр ял шийтгүүлж буй тохиолдолд дээрх зохицуулалтыг заавал хэрэглэх нь хууль хэрэглээний тогтсон жишиг бөгөөд үүнийг шүүхүүд цаашид анхаарвал зохино” гэж дүгнэж байжээ.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны шүүгдэгчид сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял оногдуулж, эдлэх ялыг 2 дахин багасгаж байгаа ч зарим шүүхийн шийдвэрт уг заалтыг хэрэглээгүй байгаагаас харвал шүүхүүдэд энэ талаар хууль хэрэглээний ялгаатай байдлууд судалгаагаар тогтоогджээ. Тодруулбал, дүн шинжилгээ хийсэн дийлэнх шүүхийн шийдвэрт шүүх өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон 2 дахин багасгаж байгаа бол зарим шүүх уг зохицуулалтыг хэрэглээгүй орхигдуулсан нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд энэ бүлэгт заасан үндэслэл, журмын

²⁵ Улсын дээд шүүхийн 2023.04.17-ны өдрийн №72, 2022.05.17-ны өдрийн. 98, 2024.12.17-ны өдрийн №143, 2021.12.28-ны өдрийн №11 тогтоол.

дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан зохицуулалтад нийцээгүй байна.

б) Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлд заасан ердийн журмыг дангаараа хэрэглэсэн:

Өсвөр насны шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийг баримтлахгүйгээр мөн хуулийн ерөнхийн ангийн 6.7 дугаар зүйлд заасан гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх зохицуулалтыг дангаар нь журамлаж, хэрэглэсэн тохиолдлууд байв. Энэ талаар судалгаанд хамрагдсан Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүх хуралдааны тогтоолуудад тодорхой жишиг тогтоосон тайлбар тусгагдаагүй боловч зарим тогтоолуудад Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийн зохицуулалт шүүхэд эрх олгосон бус, харин үүрэг болгосон хэм хэмжээ гэж тайлбарласан байдлыг энд тэмдэглэж байна. Гэвч гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийг хэрэглэж эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэснээс мөн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх зэрэг зохицуулалтыг дангаар нь хэрэглэх нь өсвөр насны шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлнэ гэж шүүх үзсэн тохиолдолд, тухайн зохицуулалтыг дангаар нь хэрэглэх эсэх тухай хууль хэрэглээний нэгдмэл байдал тогтоох шаардлагатай.

в) Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тусгай журам болон 6.7 дугаар зүйлд заасан ердийн журмыг давхар хэрэглэсэн байдал:

Дээрх 2 зохицуулалтыг давхар хэрэглэсэн шүүхийн шийдвэрүүдээс үзвэл, шүүх гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн байдлыг харгалзан, эхлээд ердийн зохицуулалт болох 6.7 дугаар зүйлд заасныг баримтлан Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт хорих ял оногдуулсны дараа Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан тусгай зохицуулалт болох 8.5 дугаар зүйлийг баримтлан хорих ялын хэмжээг 2 дахин багасгасан байв. Гэвч Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан нийтлэг үндэслэл болох “... **учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол**”, “... **учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол...**” гэсэн урьдчилсан нөхцөлийг өсвөр насны хүнд хамаатуулж хэрэглэх эсэх талаар хууль хэрэглээний нэгдмэл байдал тогтоох шаардлагатай байна.

3.2.3.6. Эрх хасах ял оногдуулсан талаар

Судалгаагаар шүүх хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулсан ял дээр нэмж тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ялыг нэмэгдэл ялын шинжтэй хэрэглэсэн тохиолдлууд бүртгэгджээ. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8 дугаар бүлэгт өсвөр насны хүнд оногдуулах ялын төрлийг нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих гэж

тухайлан хуульчилсан бөгөөд нэмэгдэл ялын шинжтэй хэрэглэгдэх эрх хасах ялыг гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулах эсэх талаар хууль хэрэглээний ялгаатай байдал ажиглагдав.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд Эрүүгийн хуулиар тогтоосон тусгайлсан журамд заагаагүй атлаа мөн хуулийн тусгай ангид заасан эрх хасах нэмэг ял шийтгэл оногдуулах нь тэдгээрт зориулсан шударга ёсны тогтолцооны зорилго, зорилтод нийцээгүй бөгөөд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан зарим наад захын жишиг дүрмүүдийн үзэл санаанд харшилж байгаа талаар энэхүү илтгэлийн 3.2.3.1 буюу *“Торгох ял оногдуулсан талаар”* хэсэгт тодорхой дурдсан бөгөөд тэндээс дэлгэрүүлж үзнэ үү.

3.2.3.7. Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан талаар

Судалгаанд хамрагдсан хорих ял оногдуулсан 88 шийтгэх тогтоолоос 25 шүүхийн шийдвэрт Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйлд зааснаар хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулжээ. Эдгээр шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж үзвэл дараах хууль хэрэглээний ялгаатай байдал ажиглагдав. Үүнд:

- Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 2 дахин багасгасны дараа хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан - 18 шийтгэх тогтоол,

- Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8.5 дугаар зүйлийг хэрэглэхгүйгээр буюу хорих ял оногдуулахгүйгээр шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан - 7 шийтгэх тогтоол.

Хууль хэрэглээний энэхүү ялгаатай байдлыг нэг мөр болгох шаардлагатай ба Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйлийн гарчигт “хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах” гэж заасан атлаа мөн зүйлийн 1 дэх хэсэгт *“энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн”* гэж заасан нь учир зүйн зөрчилтэй, үүнийг Эрүүгийн хуулийн 7.6 дугаар зүйлийн холбогдох хэсэгт нийцүүлэн, хуулийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

3.2.3.8. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн талаар

Судалгаанд хамрагдсан 473 шийдвэрээс үзвэл, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 263 өсвөр насны хүнд холбогдуулан Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон ял оногдуулахыг тэнсэж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авч хэрэглэжээ. Үүнд ял оногдуулж, оногдуулсан ял дээр нь нэмж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 12 тохиолдол байв. Тодруулбал, өсвөр насны шүүгдэгчид хорих ял оногдуулж, оногдуулсан хорих ял дээр нэмж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 8 шүүхийн шийдвэр, өсвөр насны шүүгдэгчид зорчих эрх хязгаарлах ял

оногдуулж, оногдуулсан ял дээр нь нэмж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 3 шүүхийн шийдвэр, нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулж, оногдуулсан ял дээр нь нэмж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 1 шүүхийн шийдвэр тус тус судалгааны эх сурвалж болжээ.

Шүүх хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгасан байна. Харин хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан өсвөр насны шүүгдэгчийг хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэх үүргийг хууль ёсны төлөөлөгчид нь даалгаж шийдвэрлэсэн 56 тохиолдол байв. Шүүх уг арга хэмжээг хэрэгжүүлэх талаар өсвөр насны шүүгдэгчийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэх үүргийг эцэг, эхэд нь даалгаж шийдвэрлэсэн боловч дийлэнх шүүхийн шийдвэрт уг үүргийг Хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгасан байв.

Шүүхээс гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ялын бус буюу хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авч, хуульд заасан тодорхой үүрэг хүлээлгэж, улмаар хүлээлгэсэн үүргийг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн уг шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулах талаар зарим шийдвэрүүдэд сануулсан, энэ талаар сануулаагүй анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд давж заалдах шатны шүүхээс нэмэлт, өөрчлөлт оруулж “албадлагын арга хэмжээ, үүрэг хүлээлгэснийг биелүүлээгүй, хязгаарлалтыг зөрчсөн, мөн түүнчлэн тухайн хугацаанд санаатай гэмт хэрэг үйлдсэн бол ял оногдуулахыг сануулаагүй байсныг шийдвэрт өөрчлөлт оруулан “сануулсан” тохиолдол судалгаанд²⁶ тусгагджээ.

Үүнээс үзвэл, шүүхүүд Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйл болон 8.7 дугаар зүйлийн ялгаатай зохицуулалтыг нэг мөр, агуулга мөн чанарт нь нийцүүлж хэрэглээгүй бөгөөд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дангаар нь болон өсвөр насны хүнд оногдуулсан ял дээр нэмж хэрэглэсэн аль ч тохиолдолд, тухайн өсвөр насны шүүгдэгчид хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээгээр хүлээлгэсэн үүргийг зөрчсөн нь тухайн гэмт хэрэгт нь дахин ял оногдуулах хууль зүйн үндэслэлгүй. Энэ тухай Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлд тухайлан заагаагүй байхад шүүхүүд энэ талаар 8.6 дугаар зүйлийн 2, 3 болон 4 дэх хэсгийн төстэй зохицуулалтыг гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан тохиолдолд “адилтган” хэрэглэж байгаа нь хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй, хууль хэрэглээний ялгаатай байдлыг бий болгосон байна.

2002 оны Эрүүгийн хуулийн 69 дүгээр зүйл, 2015 оны Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлийн зохицуулалт, агуулга, зориулалт, мөн чанарыг харьцуулан үзэж, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, мөн хуулийн 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан **үүргийг** хүлээлгэнэ” гэж заасан байхад судалгаанд хамрагдсан зарим шийтгэх

26 Шүүхийн академи, Шүүхийн судалгааны төв, “Өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог” судалгаа, 2025, 32 дахь тал.

тогтоолд мөн хуулийн 7.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хязгаарлалт тогтоох арга хэмжээг авч, түүнийг зөрчсөн тохиолдолд дахин ял шийтгэл оногдуулахаар шийтгэх тогтоолдоо сануулж, хэрэглэж байгаа нь хууль ёсны зарчим хийгээд өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тусгайлсан журамд нийцээгүй байна.

3.2.3.9. 18 насанд хүрсэн, 21 насанд хүрээгүй хүнд Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь

Дүн шинжилгээ хийсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрүүдэд Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Шүүхээс 18 насанд хүрсэн ба 21 насанд хүрээгүй хүнд энэ бүлэгт заасан үндэслэл, журмаар ял оногдуулж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэж болно” гэснийг хэрэглэж, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тохиолдол байгаагүй юм. Шүүхийн практикт шүүгчдийн дунд тухайн хэм хэмжээг шүүх хэрэгт цугларсан нотлох баримтыг үндэслэж шүүгдэгчийн хувийн байдлыг тогтоож, тухайн өсвөр насны шүүгдэгч гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрсэн, 21 насанд хүрээгүй боловч оюун ухаан, бие бялдар, сэтгэхүйн онцлогийн хувьд түүнийг өсвөр насны хүнтэй адилтгаж үзэх үндэслэлтэй гэж шүүх дүгнэвэл Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасныг удирдлага болгож, тэдгээрт мөн бүлэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно гэх, нөгөө нэг хэсэг нь энэ нь эрүүл мэндийн шинжлэх ухааны ойлголт бөгөөд 18-21 насны хүн сэтгэхүй болон оюун ухаан, бие бялдрын хөгжлийн хувьд 14-18 насны хүнтэй адилхан хэмжээний байх хувийн байдал тогтоогдсон эсэхийг тусгай мэргэжлийн шинжээчийн тусламжтайгаар тогтоосны эцэст Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг хэрэглэвэл зохино гэж үзэж байна.

Харин судалгаанд хамрагдсан, Улсын дээд шүүхийн Тамгын газраас Шүүхийн судалгааны төвд хүргүүлсэн Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүх хуралдааны тогтоолоос²⁷ үзвэл, тус зохицуулалтын дагуу 18 насанд хүрсэн, 21 насанд хүрээгүй хүн гэдэгт хэдийгээр насанд хүрсэн боловч “оюун санаа, сэтгэхүйн хөгжлийн хувьд өсвөр насны хүүхдийн хэмжээнд, юмс үзэгдлийн мөн чанар, үр дагаврыг ухамсарлан ойлгох чадвар сул”, өөрөөр хэлбэл, сэтгэхүй, оюун санааны хөгжлийн хувьд насанд хүрээгүй, өсвөр насны хүүхдийн адил сэтгэж, үйлдэл хийж байгаа хүний хувьд хэрэглэж болох онцгой тохиолдлыг тусгайлан хуульчилсныг тэмдэглэж, тухайн тохиолдолд шүүгдэгч нь гэмт хэрэг үйлдэх үед 18 нас 01 сар 15 хоногтой, сургуулийн 12 “а” ангийн сурагч байсан нь хэрэгт авагдсан нотлох баримтаар тогтоогдсон бөгөөд шүүгдэгч ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүмүүжиж, танин мэдэх, оюун ухааны чадавхаа сургалтын хөтөлбөрийн дагуу олж байсан, өөрийн хийж буй үйлдлийг нийгэмд аюултай болохыг бүрэн ухамсарлаж ойлгоогүй, эрх зүйн ухамсар, сэтгэхүйн хувьд бүрэн төлөвшөөгүйн улмаас уг гэмт хэргийг үйлдсэн гэж үзэх үндэслэлтэй гэж дүгнэж, шинжээчийн оролцоогүйгээр шүүх хэрэгт цугларсан нотлох баримтын хүрээнд өсвөр насны шүүгдэгчийн хувийн байдлыг хэргийн үйл баримт, бусад нөхцөл байдлуудтай уялдуулан дүгнэж, түүнд Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг удирдлага болгож, мөн бүлэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх нийтлэг

27 Улсын дээд шүүхийн 2023 оны 10 сарын 04-ний өдрийн №136 тогтоол.

журмыг хэрэглэсэн байна.

Иймд, гэмт хэрэг үйлдэх үедээ 18-21 настай байсан өсвөр насны шүүгдэгчид Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг удирдлага болгож мөн хуулийн 8 дугаар бүлэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг шүүх шийдвэрлэхдээ 1) хэрэгт цугларсан нотлох баримтын түвшинд тухайн шүүгдэгч “оюун санаа, сэтгэхүйн хөгжлийн хувьд өсвөр насны хүүхдийн хэмжээнд” байгаа эсэхийг дүгнэж шууд хэрэглэх, 2) тэрээр “оюун санаа, сэтгэхүйн хөгжлийн хувьд өсвөр насны хүүхдийн хэмжээнд” байгаа эсэхийг тусгай мэдлэг бүхий мэргэжилтэн, шинжээчийн дүгнэлтээр тогтоосны эцэст хэрэглэх, эсхүл 3) дээрх хоёр нөхцөлийн аль аль нь бүрдэж байж Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг хэрэглэх эсэх талаар хууль хэрэглээний нэгдмэл байдал тогтоох шаардлагатай.

IV. ДҮГНЭЛТ

Тус ажлын хүрээнд өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессын журмын хэрэгжилт, тэдгээрт эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах тусгайлсан журмын хэрэглээнд олон улсын эрх зүйн эх сурвалжууд болон Монгол Улсын хуулиудад тусгасан нийтлэг үндэслэл, зарчмуудад үндэслэж, Шүүхийн академийн Судалгааны төвтэй хамтран гаргасан судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийхийг зорьж, дараах хоёр агуулгатай дүгнэлтэд хүрснийг тэмдэглэе.

1. Судалгаанд хамрагдсан эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 473 шийдвэрээс үзвэл, 219 шийтгэх тогтоолоор нийт 294 хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн бол 263 өсвөр насны шүүгдэгчид ялын чанартай эрүүгийн хариуцлагад нь нэмж болон дангаар нь хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авч хэрэгжүүлжээ. Тодруулбал, судалгаанд хамрагдсан нийт 473 шийтгэх тогтоолын 219 шийтгэх тогтоолоор өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн, үлдсэн 179 шийтгэх тогтоолоор хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дангаар нь хэрэглэсэн, 39 шийтгэх тогтоолоор ялаас чөлөөлсөн, 36 шийдвэрээр хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгчийг цагаатгажээ.

Өсвөр насны шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэж, ял оногдуулсан 219 шийтгэх тогтоолоос үзвэл, 88 шийтгэх тогтоолоор сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял оногдуулсан, үүнээс 25 шийтгэх тогтоолоор хорих ял оногдуулсан шийдвэрийн биелэлтийг хойшлуулсан, үлдсэн 131 шийтгэх тогтоолоор хорихоос өөр төрлийн ял шийтгэл оногдуулжээ. Судалгаанд хамрагдсан нийт 473 шийтгэх тогтоолоос өсвөр насны хүнд хүмүүжлийн чанартай албадлага хэрэглэсэн шүүхийн шийдвэрийн эзлэх жин 179 буюу 37.8 хувь байгаа бол, үүнд өсвөр насны хүнийг ялаас чөлөөлсөн болон хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгасан тохиолдлуудыг нэмж тооцоход судалгаанд хамрагдсан нийт шийдвэрийн талаас илүү буюу 53.6 хувьд нь эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй статистик гарчээ. Түүнчлэн өсвөр насны хүнд ялын чанартай буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нийт 219 шийтгэх тогтоолын 88 буюу 40.1 хувьд нь өсвөр насны хүнд хорих ял оногдуулж, 131 шийтгэх тогтоолоор буюу 59.9 хувьд нь хорихоос өөр төрлийн эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.

Өсвөр насныханд зориулсан эрүүгийн эрх зүйн бодлого, түүнийг тодорхойлох

тусгайлсан журмуудын зорилго нь тэдгээрт эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг урьтал болгохгүй байх, шаардлагатай тохиолдолд, эцсийн арга хэмжээ болгож эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөлийг нарийвчлан хуульчлах, ялын бус буюу хүмүүжлийн чанартай - тэнсэж хяналт тогтоох албадлагын арга хэмжээг түлхүү хэрэглэх, ялын чанартай эрүүгийн хариуцлага хүлээлгэх тохиолдолд хорихоос өөр төрлийн ялыг сонгож хэрэглэх хууль зүйн боломжийг өргөн хүрээнд ашиглах, эцсийн арга хэмжээ болгож гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хорих ялыг зайлшгүй нөхцөлд оногдуулах явдал бөгөөд орчин үеийн эрүүгийн эрх зүйн салбарт тэргүүлэх чиглэл болон хөгжиж буй энэхүү шударга ёсны тогтолцоог (*juvenile justice*) улс орнууд улам бүр боловсронгуй болгож, олон улсын эх сурвалжууд, энэ талаарх жишиг дүрмүүдийн онцлог зохицуулалтыг өөрийн орны хууль зүйн бодлогод нутагшуулахыг эрмэлзэж байна.

Хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудын Эрүүгийн хууль,²⁸ шүүхийн практик, жишгээс үзвэл өсвөр насны хүнд оногдуулах хорих ялын хүрээ маш хязгаарлагдмал, хорихоос өөр төрлийн ялын хэрэглээ тухайн этгээдэд хүлээлгэх нийт ялын дотор 70-80 хувийг эзэлж байхад²⁹ манай улсын хувьд, судалгаанд хамрагдсан анхан шатны шүүхийн шийдвэрүүдээс нэгтгэн дүгнэвэл, өсвөр насны хүнд ялын бус, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шийтгэх тогтоолын эзлэх жин нийт шийдвэрийн тал хувийг буюу 53.6 хувийг эзэлж, үлдсэн 46.4 хувь нь өсвөр насны шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шийтгэх тогтоолууд байна.

Өсвөр насны хүнд ялын чанартай буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шийтгэх тогтоолын 40 гаруй хувийг хорих ял, үлдсэн 60 гаруй хувийг хорихоос өөр төрлийн ялыг сонгож оногдуулсан байдал нь гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс илүүтэйгээр тэдгээрийг хянан харгалзах, хүмүүжлийн чанартай албадлага хэрэглэх, ял оногдуулах тохиолдолд хорихоос өөр төрлийн ялыг сонгож оногдуулах, хорих ялыг эцсийн арга хэмжээ болгон хэрэглэх тухай тусгай журмын хэрэгжилт, хэрэглээнд анхаарах, улмаар дэлхийн бусад улс орнуудтай харьцуулах, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулж буй эрүүгийн хариуцлага ба хүмүүжлийн арга хэмжээний зохист харьцааг нарийвчлан судалж, Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалд дүгнэлт өгөх зүй ёсны шаардлага тавигдаж байна.

2. Судалгааны явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлгийн хэрэгжилт, Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийн хэрэглээтэй холбоотой дараах хууль хэрэглээний ялгаатай нөхцөл байдлууд тогтоогдсоныг энд нэгтгэн тэмдэглэх нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

- Өсвөр насны хүнд холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг бүхэлдээ, тодруулбал шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааны ажиллагааг хаалттай явуулах;
- Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийтгэх

28 Ял шийтгэлийн бодлого буюу гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний хувьд түүнд оногдуулж буй ялын болон ялын бус хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний зохист харьцаа. С.Ө.

29 Чинбатын Болормaa, Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хүлээлгэх ялын бус эрүүгийн хариуцлагыг боловсронгуй болгох нь, <https://legaldata.mn/b/1545>, 2021, (Сүүлд үзсэн: 2025.09.14).

тогтоол, магадлалд тэдгээрийн хувийн байдлыг хуульд заасан шалгуур, үзүүлэлт бүрээр нарийвчлан тогтоон дүгнэж, шаардлагатай тохиолдолд шүүх энэ талаар прокуророос нэмэлт мэдээлэл гаргуулах бүрэн эрхээ хэрэгжүүлэх, улмаар тэдгээрт эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ тухайлан харгалзаж үзсэн талаарх үндэслэлийг шүүхийн шийдвэрт тодорхой тусгах;

- Хуульд заасан тохиолдолд өсвөр насны хүний хэрэг хариуцах чадварыг тогтоохын тулд шинжээч томилохоос гадна түүний хувийн байдлыг нарийвчилж тогтоохын тулд, *“ухаан санаа нь гүйцэд хөгжсөөгүйн улмаас өөрийнхөө үйлдлийн холбогдлыг бүрэн ойлгож байгаа”* эсэхэд эргэлзээ төрвөл шинжээч томилж, дүгнэлт гаргуулах хуулийн хэрэгжилтийг хангах;
- 18 насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны шүүгдэгч хэргээ шүүхээр шийдвэрлүүлэх үед насанд хүрсэн бол түүнийг “өсвөр насны шүүгдэгч”-ийн хувиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж, хууль зүйн туслалцаа авах эрхээр заавал хангах, энэ талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тусгайлсан зохицуулалтын хэрэгжилтийг хангах;
- Өсвөр насны хүнд Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт тусгайлан заагаагүй үндсэн ялын чанартай торгох ялыг, нэмэгдэл ялын чанартай эрх хасах ялыг оногдуулж буй шүүхийн хууль хэрэглээний ялгаатай байдлыг даруй халах;
- Өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх ялыг Эрүүгийн хуулийн тусгай ангид заагаагүй тохиолдолд мөн хуулийн 8.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримталж, 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгож шүүхээс оногдуулах эсэх асуудлаар;
- Өсвөр насны хүнд хорих ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийг хэрэглэхгүй байх, мөн хуулийн 6.7 дугаар зүйлд заасан гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх зохицуулалтыг дангаар нь хэрэглэх, эсхүл хэрэглэхгүй байх, түүнчлэн дээрх төрлийн зохицуулалтыг давхар хэрэглэсэн талаар;
- Өсвөр насны хүнд холбогдох эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх, түүнд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх зохицуулалтыг тус тус хэрэглэхдээ *“... учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол, ... нөхөн төлөхөө илэрхийлсэн бол...”* гэсэн урьдчилсан нөхцөлүүдийг хэрэглэх эсэх талаар;
- Өсвөр насны хүнд хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолын биелэлтийг хойшлуулах эсэх (Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг) талаар;
- Өсвөр насны хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авч, тодорхой үүрэг хүлээлгэсэн хугацаанд түүнийг тэнсэж хянан харгалзсан дэглэмийг зөрчсөн, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй үндэслэлээр

үйлдсэн гэмт хэрэгт нь шинээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг сануулж, Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлд хуульчлаагүй асуудалд мөн хуулийн 8.6 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийг адилтгаж хэрэглэж буй асуудлын талаар;

- Гэмт хэрэг үйлдэх үедээ, эсхүл хэргээ шүүхээр шийдвэрлүүлэх үед 18 насанд хүрсэн, 21 насанд хүрээгүй хүнд Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай мөн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг шүүхийн практикт нэг мөр, зөв хэрэглэх талаар тус тус хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж

А. Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Эрүүгийн хууль, 2002 он.
3. Эрүүгийн хууль, 2015 он.
4. Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 1963 он.
5. Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002 он.
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он.
7. Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016 он.
8. Хүүхэд хамгааллын тухай хууль, 2024 он.
9. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1976 он.
10. Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989 он.
11. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Өсвөр насны хүнд холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбоотой Бээжингийн жишиг дүрэм, 1985 он,
12. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүй хүүхдийн эрхийг хамгаалах тухай Гаванагийн жишиг дүрэм, 1990 он.
13. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох Токиогийн жишиг дүрэм, 1990 он.
14. Улсын дээд шүүхийн 2023.04.17-ны өдрийн №72, 2022.05.17-ны өдрийн №98, 2024.12.17-ны өдрийн №143, 2021.12.28-ны өдрийн №11, 2023.10.04-ны өдрийн №136 тогтоол.
15. Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2022 оны бүтэн жилийн мэдээ.
16. Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2023 оны бүтэн жилийн мэдээ.
17. Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2024 оны бүтэн жилийн мэдээ.

Б. Ном, сурах бичиг:

1. Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар, 2 дахь хэвлэл, 2024 он.
2. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), 2012 он.

В.Эрдэм шинжилгээний бүтээл:

1. Шүүхийн академи, Шүүхийн судалгааны төв, “Өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог” судалгаа, Судалгааны сан:

ЭД/05/2025/05/23, 2025 он.

2. Ч.Болормаа, Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хүлээлгэх ялын бус эрүүгийн хариуцлагыг боловсронгуй болгох нь, <https://legaldata.mn/b/1545> 2021 он.

2. Цахим эх сурвалж:

1. Монгол Улсын дээд шүүхийн цахим хуудас: <https://supremecourt.mn/mn/>
2. Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас: <https://www.judcouncil.mn/>
3. Шүүхийн академийн цахим хуудас: <https://jtrii.mn/mn/>
4. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn>
5. НҮБ-ийн Хүний эрхийн Дээд комиссарын газрын цахим хуудас: https://www.ohchr.org/en/ohchr_homepage
6. Хууль зүйн бүтээлийн цахим сан: <https://legaldata.mn>

“ХАВАЙН НЭГДСЭН ГЭР БҮЛИЙН ШҮҮХ: ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ХЭРГИЙН ДАГНАСАН ШҮҮХИЙН ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР”

Маттю Ж. Виола,
Хавай мужийн Хонолулу хотын
анхан шатны шүүхийн шүүгч (Dr.jur.)

Агуулга

I. Оршил

II. Харьяаллын цар хүрээ ба эрх хэмжээний хязгаар (англ. Comprehensive Jurisdictional Scope)

*2.1 Иргэний болон насанд хүрсэн хүнд холбогдох эрүүгийн хэрэг хянан
шийдвэрлэх ажиллагаа*

*2.2 Хүүхдийн хэргийн шүүхийн эрх мэдэл ба хүүхдийг дахин
нийгэмшүүлэхэд чиглэсэн арга хэмжээний талаарх суурь ойлголт*

2.3 Өсвөр насны хүнд холбогдох зөрчлийн хэрэг ба хамгааллын асуудал

III. Шүүгч мэргэшил болон мэдлэг, ур чадвараа цаг ямагт дээшлүүлэх үйл явц

IV. Инновац ба тогтолцооны шинэчлэл

V. Дүгнэлт

I. ОРШИЛ

1965 оны Америкийн Нэгдсэн Улс (цаашид “АНУ” гэх)-ын Хавай мужийн Гэр бүлийн шүүхийн тухай хуулийн дагуу байгуулагдсан “Хавай мужийн Гэр бүлийн шүүх” (англ. *Hawaii's Family Court*) нь иргэний хэрэгт хамаарах гэр бүлийн болон “өсвөр насны хүн” (англ. *juvenile*)-д холбогдох хэргүүдийг нэгтгэн шийдвэрлэх бүтэцтэйгээр байгуулагдсан. Тус шүүхийг байгуулахаас өмнө Хавай муж нь АНУ-ын шүүхэд нийтлэг хэрэглэж заншсан загварыг дагаж мөрддөг байсан бөгөөд гэр бүлийн хэргүүдийг Гэр бүлийн болон Өсвөр насны хүний хэргийн шүүх (англ. *Juvenile Court*) тусад нь харьяалан шийдвэрлэдэг байсан. Гэвч энэхүү загвар нь гэр бүлийн эрх зүйн асуудлын талаарх харилцан нягт, уялдаа холбоотой шинж, байдлыг бүрэн илэрхийлэхгүй байхаас гадна холбогдох хэргийг хянан шийдвэрлэхэд дутагдалтай байснаар шүүхээс гарах шийдвэр болон шүүхийн хяналтын тогтолцоонд зөрчил үүсэхэд хүргэсэн байна.

Хавай мужийн Гэр бүлийн шүүхийг үүсгэн байгуулагчид дээрх тулгамдсан асуудлыг зохион байгуулалттай, нарийн төлөвлөгөөний дагуу шийдвэрлэхийн тулд зөвхөн тус шүүхэд хамаарах өргөн хүрээний эрх мэдлийг тогтоож, шүүхийн бүтцийг шинээр тодорхойлсон ба үүгээр дамжуулан хүүхэд, гэр бүлийн харилцааг дэмжих үүднээс нэгдмэл, цогц үйл ажиллагаа явуулах шүүхийн тогтолцоог бүрдүүлэхийг зорьсон. Гэр бүлийн хэрэг, маргааныг шийдвэрлэхийн тулд зөвхөн гэр бүлийн эрх зүй бус, бусад салбарын эрх зүйн мэдлэгтэй байх мөн олон талын нарийвчилсан судалгаа, шинжилгээг хийх нь чухал бөгөөд энэ нь хүүхэд, гэр бүлийн холбогдолтой маргааныг шийдвэрлэх хамгийн оновчтой зохион байгуулалтын хэлбэр хэмээн үзсэн. Тухайлбал, 1964 онд Хүүхэд, залуучуудын хорооноос (англ. *Commission on Children and Youth*) гаргасан “Хавай мужийн нэгдүгээр тойрогт Гэр бүлийн шүүх байгуулах тухай саналд (англ. *A Proposal For The Establishment Of A Family Court In the First Circuit Of Hawaii*)” дараах агуулга тусгагджээ.

“Өнөө үед гэр бүл болон өсвөр насны хүнд холбогдох хэрэг, маргааныг шийдвэрлэх хүрээнд хууль зүйн асуудлыг чухалчлахын зэрэгцээ бусад нийгмийн хүчин зүйлсийг хамтад нь авч үзэх шаардлагатай болохыг нийтээрээ хүлээн зөвшөөрдөг болсон. Энэхүү нэгдсэн мэргэшсэн шүүхийн тогтолцоо нь хэргийн харьяаллын давхардлыг арилгаж, нэг гэр бүлд хамаарах хэргийг хэд хэдэн шүүх хүлээн авч шийдвэрлэхээс сэргийлж, ийнхүү хүүхэд, гэр бүлд чиглэсэн нийгмийн цогц үйлчилгээг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж буй хэрэг юм. Гэр бүлийн шүүхийн үндсэн үзэл баримтлал (англ. *the basic philosophy of the family court*) бол төр нь өөрийн эрх ашгийг хамгаалах боломжгүй иргэдийн эрх, ашиг сонирхол болон хүүхдийг аливаа эрсдэлээс хамгаалах, гэр бүлийн харилцааг хамгаалах, улмаар нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх үүрэгтэй байхад оришино. Иймд Гэр бүлийн шүүхийн нэгдсэн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, мэргэжлийн хүний нөөцөөр хангаж байгаа явдал нь хүүхэд, гэр бүлтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (цаашид “ХХША”)-г илүү хүмүүнлэг, үр нөлөөтэй явуулахад чухал ач холбогдолтой байна.

Хавай мужийн Гэр бүлийн шүүх нь байгуулагдсан цагаасаа хойш хэрэг, маргаан хянан шийдвэрлэхээс гадна хүүхэд, гэр бүлийн урт хугацааны сайн сайхан байдлыг хангах бусад үйл ажиллагааг тогтмол явуулсаар ирсэн бөгөөд нийгмийн

өөрчлөлт, цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцэн өөрчлөгдөн хөгжсөөр, нэг талаас оролцогч нарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, нөгөө талаас сэргээн засах (англ. *restorative*) болон эмнэлгийн чанартай (англ. *therapeutic*) арга хэмжээг авахад суурилсан шүүхийн тогтолцоог бүрдүүлсэн онцлогтой юм.

II. ХАРЬАЛЛЫН ЦАР ХҮРЭЭ БА ЭРХ ХЭМЖЭЭНИЙ ХЯЗГААР

2.1 Иргэний болон насанд хүрсэн хүнд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Хавай мужийн Гэр бүлийн шүүх нь хүүхэд, гэр бүлтэй холбоотой иргэний хэргийг анхан шатны журмаар, онцгой харьяаллын дагуу хянан шийдвэрлэдэг. Энэхүү харьяаллын хүрээнд гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж, уулзалтын цаг товлох, хүүхдийн тэтгэлэг, эцэг, эх тогтоолгох, хүүхэд үрчлэлт болон асран хамгаалахтай холбоотой хэргүүдийг шийдвэрлэхээс гадна гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн этгээдийг хамгаалахтай холбоотой хэргийг хүлээн авч, хэлэлцдэг. Мөн хөдөлмөрийн чадвараа алдсан насанд хүрсэн хүн болон хүүхдийг албадан эмчилгээнд явуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллагад хандахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй. Үүнээс гадна гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн хооронд үүссэн гэмт хэргийн шинжтэй хэрэг, тухайлбал гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах шүүхийн захирамжийг үл биелүүлсэнтэй холбоотой хэрэг болон гэр бүлийн насанд хүрсэн гишүүдэд хамаарах эрүүгийн хэргүүдийг хянан шийдвэрлэдэг.¹

1 Хуулийн шинэчилсэн найруулга §571.14. Насанд хүрсэн хүнд холбогдох хэргийн харьяалал.

(а) Хуульд 603.21.5 болон 604.8 дугаар зүйлд заасныг эс тооцвол, шүүх дараах хэргүүдийг онцгой харьяаллын дагуу хянан шийдвэрлэнэ:

“(1) Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, эсхүл хүүхдийн эрх, ашиг сонирхол, бие махбодод хохирол учирсантай холбоотой бусад этгээдийн үйлдсэн аливаа гэмт хэрэг; мөн 707-726, 707-727, 709-902, 709-903, 709-903.5, 709-904, 709-905, 709-906, 302A-1135-р зүйлүүдэд заасан зөрчлийн хэрэг (энэ зүйлийн 2 дахь хэсэг эсхүл бусад зүйлд заасан эсэхээс үл хамааран);

(2) Насанд хүрсэн хүн дараах хэрэгт гэм буруутай бол:

(А) Хууль ёсны үүргээ биелүүлж, шаардлагатай халамж, тэтгэмжийг олгоогүй;

(В) Эцэг эх, хүүхдийн хооронд эсхүл эхнэр, нөхрийн бие махбодод хохирол учруулсан үйлдэлтэй хөнгөн гэмт хэрэг;

(С) 586 дугаар зүйлд заасан шүүхээс гаргасан шийдвэрийг үл биелүүлсэн;

(D) Гэр бүлийн шүүхээс гаргасан шийдвэрийг үл биелүүлсэн.

(1) ба (2) дахь хэсэгт заасан төрлийн хэрэг нь Гэр бүлийн шүүхийн харьяаллын бус маргаанд хамаарах бол шүүгч тухайн хэргийг харьяалах шүүхэд шилжүүлэх шийдвэр гаргана.

(3) 580 болон 584 дүгээр зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх бүх төрлийн ажиллагаанд;

(4) 575 дугаар зүйлд заасан “Гэр бүлээ орхих, тэжээн тэтгэхээс татгалзахтай холбоотой зохицуулалт” (англ. the Uniform Desertion and Non-support Act) болон 576В дугаар зүйлд заасан “Муж хоорондын гэр бүлээ тэжээн тэтгэхтэй холбоотой зохицуулалт” (англ. the Uniform Interstate Family Support Act)-д заасан XXIIА-нд;

(5) Сэтгэцийн өвчтэй эсхүл сэтгэл санааны хямралд орсон гэж шүүхээр тогтоогдсон насанд хүрсэн хүнийг сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага руу шилжүүлж, албадан эмчилгээнд оруулах;

(6) Эцэг, эх, хүүхдийн хооронд, эсхүл эхнэр, нөхрийн хоорондын харилцаанд дэмжлэг үзүүлэх;

(7) Өсвөр насанд байх үедээ энэ хуулийн 571.13 болон 571.22 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжтэй үйлдлийг хийсэн насанд хүрсэн хүнд урьдчилан хорих арга хэмжээ авах, эсхүл бусад шүүх харьяалалдаа хүлээн авч шийдвэрлэхээс татгалзсантай холбоотой ажиллагаанд;

(8) 586 дугаар зүйлд “Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалахтай холбоотой шийдвэр” (англ. Domestic Abuse Protective Orders)-тэй холбогдох ажиллагаанд;

(9) 346 дугаар зүйлийн Х хэсэгт заасан тусгай асран хамгаалалт шаардлагатай насанд хүрсэн хүнийг (англ. vulnerable adult) хамгаалахтай холбоотой ажиллагаанд.

Ийнхүү тус шүүхийн нэгдсэн харьяалал нь гэр бүлийн харилцаатай холбоотой бүх төрлийн хэрэг, маргааныг нэг дор төвлөрүүлэн шийдвэрлэх боломжийг бүрдүүлж, нэг хэргийг хоёр шүүх давхар хүлээн авч, хянан шийдвэрлэхээс урьдчилан сэргийлсэн. Мөн ХХША-нд үүсэж болзошгүй зөрчил, давхардлыг арилган, харилцан уялдаа бүхий асуудлыг нэг мөр, ойлгомжтой бөгөөд нэгдсэн байдлаар шийдвэрлэх нөхцөлөөр хангажээ. АНУ-ын зарим муж болон бусад улс оронд өсвөр насны хүнд холбогдох иргэний болон эрүүгийн хэргийг өөр шүүхүүдэд тус тусад нь хуваарилан шийдвэрлэдэг бол Хавай мужийн Гэр бүлийн шүүх нь тухайн гэр бүлийн хүрээнд өөр төрлийн маргаанууд зэрэг үүссэн тохиолдолд (жишээ нь, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хүүхдийн асрамж тогтоолгох маргаан) тухайн хэргүүдийг нэгтгэн Гэр бүлийн шүүхийн харьяаллаар хүлээн авч шийдвэрлэдэг.

Ийнхүү нэгдсэн тогтолцоотой шүүх нь гэр бүлийн хүрээнд үүссэн бүхий л маргааныг нэг дор хүлээн авч шийдвэрлэдэг тул ХХША-г зохион байгуулалттай, хурдан шуурхай явуулах боломжийг бүрдүүлдэг байна. Мөн энэ нь нэг хэрэгт давхар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах асуудлыг арилгаж, оролцогч талуудын сэтгэл санаа, санхүүгийн дарамтыг багасгаад зогсохгүй шүүх гэр бүлийн нөхцөл байдлыг бүхэлд нь харгалзан үзэх, улмаар үндэслэлтэй шийдвэр гаргахад чухал нөлөө үзүүлж байна.

Шүүхийн нэгдсэн харьяалал нь тус шүүхийг туршлагатай, олон талын мэдлэг, чадвартай мэргэжилтнүүдтэй багийг бүрдүүлж ажиллах, улмаар судалгаа, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах боломжийг олгодог. Үүнд, хүүхэд, гэр бүл рүү чиглэсэн нийгмийн үйлчилгээ үзүүлж буй этгээд, хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээний үнэлгээ хийдэг мэргэжилтнүүд, багш болон бусад холбогдох мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо зэрэг хамаардаг. Ингэснээр шүүх зөвхөн хууль зүйн асуудалд анхаарлаа хандуулах бус, гэр бүлийн харилцааны тогтворгүй байдалд нөлөөлж буй үндсэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, түүнд нийцсэн үндэслэл бүхий шийдвэр гаргахад ихээхэн түлхэц үзүүлдэг ба эдгээр байгууллагуудын хамтын ажиллагаа нь шүүхийн бүтэц, зохион байгуулалтад эерэг нөлөө үзүүлж, шүүхийн үйл ажиллагааны сайн туршлагыг бэхжүүлж буйг харуулж байна.

2.2 Хүүхдийн хэргийн шүүхийн эрх мэдэл ба хүүхдийг дахин нийгэмшүүлэхэд чиглэсэн арга хэмжээний талаарх суурь ойлголт

(3), (4), (6) дугаар заалтуудад заасан хэргүүдийг Гэр бүлийн шүүх харьяалан шийдвэрлэж буй тохиолдолд Ерөнхий Прокурор хүүхдийн тэтгэлгийн асуудлыг хариуцсан агентлагаар дамжуулан 576Е-д заасны дагуу өөрийн чиг үүргийн хүрээнд холбогдох асуудлыг мөн давхар харьяалалтайгаар (англ. concurrent jurisdiction) хянан шийдвэрлэнэ.

(b) 707-712, 707-717, 707-722, 708-822, 708-823, 710-1010.5, 711-1106, 711-1106 дугаар зүйлд заасан хэргүүдийг, мөн тухайн этгээд олон гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай тохиолдолд энэ нь 586 дугаар зүйл эсхүл 709-906 дугаар зүйлд заасан зөрчилд хамаарах бол Гэр бүлийн шүүх нь Дүүргийн шүүх (англ. District Court)-тэй хамтран давхар харьяалалтайгаар хэргийг хянан шийдвэрлэнэ.

(c) Гэр бүлийн шүүх нь 711-1106.4-р зүйлд заасан зөрчлүүдийг Тойргийн шүүх (англ. Circuit Court)-тэй хамтран давхар харьяалалтайгаар хэргийг шийдвэрлэнэ.

(d) Гэр бүлийн шүүх нь насанд хүрсэн хүний хууль ёсны асран хамгаалагч томилохтой холбоотой бүх ХХША-г Тойргийн шүүхтэй хамтран давхар харьяалалтайгаар шийдвэрлэнэ.”

Хавай мужийн Гэр бүлийн шүүх нь Иргэний хэргийн шүүхийн харьяалалд хамаарах хэрэг, маргааныг шийдвэрлэхээс гадна 18 насанд хүрээгүй хүн хууль зөрчсөн үйлдэлтэй холбоотой хэргийг (хэрэв насанд хүрсэн хүн тухайн хэргийг үйлдсэн бол гэмт хэрэгт тооцогдох) онцгой харьяаллын (англ. *Exclusive jurisdiction*) дагуу хянан шийдвэрлэдэг.² Өсвөр насны хүнд авах арга хэмжээ нь түүнийг хүмүүжүүлэх, дахин нийгэмшүүлэхэд чиглэсэн бөгөөд өсвөр насны хүний сэтгэн бодох чадвар, сэтгэл хөдлөлөө хянах байдал, нийгмийн төлөвшил болон ёс суртахууны хариуцлага нь насанд хүрсэн хүнээс ихээхэн ялгаатай байдаг.

Гэр бүлийн шүүх нь өсвөр насны хүнд холбогдох хэргийг шийдвэрлэхдээ ял шийтгэл оноохоос илүүтэй хүүхдийг засан хүмүүжүүлэх, дахин нийгэмшүүлэх арга хэмжээг голчлон хэрэгжүүлдэг.³ Өсвөр насны хүн нь насанд хүрсэн хүнтэй адил Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхүүдийг эдлэх эрхтэй. Үүнд, хууль зүйн туслалцаа авах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах зэрэг эрхүүд ордог. Мөн өсвөр насны хүн Тангарагтны шүүхээр шүүлгэх эрхгүй бөгөөд шүүгч хэргийг хүлээн авсан даруйдаа шууд хянан шийдвэрлэдэг. Ингэснээр өсвөр насны хүний онцлог, нөхцөл байдалд нийцсэн, илүү оновчтой, онолын хувьд маргаан багатай

2 Хуулийн шинэчилсэн найруулга §571.11. Хүүхдэд холбогдох хэргийн харьяалал

“Энэ хэсэгт өөрөөр заагаагүй бол шүүх дараах хэргүүдийг онцгой харьяаллаар хянан шийдвэрлэнэ:

(1) 18 насанд хүрээгүй хүн дүүргийн, мужийн, орон нутгийн хууль эсхүл холбогдох дүрэм, журмыг зөрчсөн эсхүл зөрчих оролдлого хийсэн гэм буруутай бол тухайн зөрчил хаана гарснаас үл хамааран тухайн 18 насанд хүрээгүй хүний оршин суугаа газар эсхүл үйлдэл дээрээ баригдсан эсхүл олдсон (англ. found) газрын Тойргийн шүүх тухайн хэргийг хүлээн авч, шийдвэрлэнэ.

(2) Тухайн Тойрогт амьдардаг эсхүл үйлдэл дээрээ баригдсан эсхүл олдсон хүүхдийн хувьд дараах нөхцөл байдал хамаарна:

(A) Аливаа хувь хүн, байгууллага хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхэд сурч боловсрох эрхээ эдлэх боломжгүй болсон, эсхүл асран халамжлуулах эрх нь зөрчигдөж, эцэг эхдээ хаягдсан;

(B) Өсвөр насны хүн эцэг эх эсхүл асран хамгаалагчийн хяналтаас гарсан, эсхүл аливаа зан үйл нь хүүхдийн өөрийн болон бусдын эрх, ашиг сонирхлыг зөрчсөн бол;

(C) Өсвөр насны хүн өөрийн буруутай зан үйлээс үүдэн боловсрол эзэмшихгүй байх, эсхүл бусад шалтгааны улмаас сурч, боловсрох эрхээ эдлэхгүй байх;

(D) Шөнийн цагт тогтоосон хөл хориог зөрчсөн.

(3) Хүүхдийн асран хамгаалагчийг тогтоох эсхүл хүүхдийн асран хамгаалагч томилох;

(4) 578 дугаар бүлэгт заасны дагуу хүүхэд өргөж авахтай холбоотой ХХША-нд;

(5) 571-61–ээс 571-63 дугаар зүйлд заасны дагуу эцэг, эх байх эрхийг хасах (англ. termination);

(6) Хуульд заасны дагуу өсвөр насны хүн гэрлэх, ажил эрхлэх, мөн цэргийн албанд татагдах зэрэг асуудлыг хянан хэлэлцэж, шүүх зөвшөөрөл (англ. consent) олгоно;

(7) Сэтгэл гутрал, оюун ухааны хомсдолтой хүүхдэд зориулсан эмчилгээ болон асрамжтай холбоотой ХХША;

(8) 582 дугаар бүлэгт заасан “Өсвөр насны хүнтэй холбоотой муж хоорондын гэрээ” (англ. the Interstate Compact on Juveniles) болон 582D дүгээр бүлэгт заасан “Өсвөр насны хүнд зориулсан муж хоорондын гэрээ” (англ. Interstate Compact for Juveniles);

(9) 587A дугаар бүлэгт заасан хүүхдийг хамгаалахтай холбоотой хянан шийдвэрлэх ажиллагаа;

(10) 574-5(a)(2)(C)-р зүйлд заасан хүүхдийн нэр өөрчлөхтэй холбоотой хянан шийдвэрлэх ажиллагаа;

(11) АНУ-ын Цагаачлал ба Иргэншлийн тухай холбооны хууль (англ. the federal Immigration and Nationality Act)-ийн 101(a)(27)(J) зүйлд зааснаар 18 нас хүрээгүй байхдаа хүчирхийлэлд өртсөн, эцэг эх асран хамгаалах үүргээ биелүүлээгүй эсхүл эцэг эхдээ хаягдсан болохыг тогтоох нөхцөл байдлын талаар шийдвэр гаргуулах хүсэлтэд үндэслэн цагаач хүүхдийн асрамж, асран хамгаалагчийн асуудлыг шийдвэрлэх, “өсвөр насны хүн/хүүхэд” гэдэгт 21 насанд хүрээгүй хүнийг хэлнэ.

(12) 577-25-р зүйлд заасны дагуу өсвөр насны хүнд эрх зүйн харилцаанд бие даан оролцох эрхийг олгох (emancipation)”

3 Хуулийн шинэчилсэн найруулгын §571.1. Бүлгийн бүтэц ба зорилго
“Энэхүү бүлэгт хүүхэд болон гэр бүлийн эрх, ашиг сонирхол, сайн сайхан байдлыг алдагдуулж буй тохиолдолд тэдэнд туслалц, хамгаалах, шүүхийн үйл ажиллагаагаар эрхийг нь баталгаажуулах зорилготой. Шүүх нь хүүхэд, түүний гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн төлөвлөгөө гаргаж, нийгмийн

ХХША-г явуулах боломж бүрддэг.

Шүүхээс өсвөр насны хүнийг дахин нийгэмшүүлэх, хүмүүжлийн чанартай арга хэмжээнд (англ. *the Court's rehabilitative mandate*) хяналт тавих, чиглүүлэх хөтөлбөр боловсруулах, мөн аливаа эрсдэлт нөхцөлд өсвөр насны хүнийг хорих, хамгаалах байранд тусгаарлах, эсхүл асрамж, халамжийн төвд шилжүүлэх зэрэг арга хэмжээг авдаг. Шүүхийн хяналт тавих чиг үүрэг бүхий ажилтнууд хянах үүрэг гүйцэтгэхээс гадна сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, боловсролыг дэмжих, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эсрэг нөхөн сэргээх эмчилгээ, гэр бүлийн зөвлөгөө авах боломжийг олгох зэргээр өсвөр насны хүнийг дэмжих гол чиг үүрэгтэй бөгөөд эдгээр арга хэмжээ нь өсвөр насны хүний эерэг, бүтээлч зан байдлыг төлөвшүүлэх зорилготой юм.

Судалгаанд дурдсанаар, өсвөр насны хүний сайн сайхан байдалд чиглэсэн аливаа үйл ажиллагаа нь түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх, нийгэм дэх эерэг зан үйлдлийг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Энэхүү шүүхийн тогтолцооны нэгдмэл байдал болон хүмүүжлийн арга барилд суурилсан Хавай мужийн Гэр бүлийн шүүх нь дээр дурдсан зорилтыг хэрэгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлжээ.

2.3 ӨСВӨР НАСНЫ ХҮНД ХОЛБОГДОХ ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ (АНГЛ. *STATUS OFFENSES*) БА ХАМГААЛЛЫН АСУУДАЛ

Хавай мужийн Гэр бүлийн шүүх нь өсвөр насны хүнд холбогдох гэмт хэргийн шинжгүй зөрчлийн хэргүүдийг харьяалан шийдвэрлэдэг.⁴ Үүнд, хичээлээ таслах, хөл хорио зөрчих, гэрээсээ зугтах зэрэг үйлдлүүд хамаарах ба эдгээр үйлдлийг ихэвчлэн ялимгүй зөрчилд тооцож, хэргийг хэрэгсэхгүй болгодог боловч уг зөрчил нь гэр бүл, боловсрол, сэтгэлзүйн хүрээнд авч үзэх ёстой чухал асуудлуудын эхлэл нь болж байдаг. Өөрөөр хэлбэл, өсвөр насны хүнд ял, шийтгэл оногдуулахын оронд хүмүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авдаг бөгөөд эмзэг бүлгийн өсвөр насны хүний эрх ашиг, сайн сайхан байдлыг хамгаалах нь шүүхийн эрхэм зорилго юм. Энэхүү үүргээ хэрэгжүүлэх явцад шүүгчид хүүхдийг түр хугацаагаар гэрээс нь тусгаарлах, асрамжийн газар шилжүүлэх (англ. *foster*

хамгааллын шаардлагыг хангах бөгөөд үүнийг хэрэгжүүлэхдээ бүх төрийн болон нийгмийн нөөц, боломжийн ашиглах боломжтой.

Энэхүү бүлэг нь мужийн хэмжээнд “Гэр бүлийн шүүхийн тогтолцоо”-г бүрдүүлэх, улмаар шүүхийн үйл ажиллагааны үндсэн бодлого, зорилгын хүрээнд хүүхэд, гэр бүлийн эрх, ашиг сонирхол болон тэдний сайн сайхан байдлыг хамгаалах дараах зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэнэ:

- Гэмт хэрэг үйлдэх, зөрчил үйлдэх өндөр эрсдэлтэй өсвөр насны хүүхдийг гэр бүлийн харилцааг сэргээх, сайжруулах,
- Амьдралын хүнд нөхцөл байдалтай өсвөр насны хүүхдийг хүмүүжүүлэх,
- Үйлдсэн гэмт хэрэг, зөрчилд нь тохирсон арга хэмжээг авах,
- Өсвөр насны хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг бууруулахад чиглэсэн.

Шүүх нь хэрэг хянан шийдвэрлэх бүх үйл ажиллагаа нь дараах байдлаар явуулна:

Энэ бүлэгт заасан шүүхийн шийдвэрийг гэмт хэрэгт буруутгасан буюу ял оноосон гэж үзэхгүй; шүүхийн шийдвэрээс үүдэн аливаа иргэний эрх, эрх чөлөөг хязгаарлахгүй; хүүхдийг гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгаж, шүүхээр ял оноохгүй; мөн зөрчил үйлдсэн хүүхдэд оноох арга хэмжээ нь сэргээх, засах, эсхүл дахин зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх ёстой. Түүнчлэн, шүүхэд гаргасан нотлох баримт нь хүүхдийг ажил эрхлэх, цэргийн албанд татагдах зэрэгт саад болохгүй.

571-11-р зүйлд заасан хэрэгт цугларсан нотлох баримтыг иргэний, эрүүгийн болон бусад төрлийн шүүхэд шилжүүлж болохгүй, зөвхөн 571-11-р зүйлд заасан тохиолдолд л хэрэглэгдэнэ.”

4 Эшлэл 2-оос үзнэ үү.

care), улмаар нөхцөл байдлыг тогтоосноор хүүхдийг эцэг, эхэд нь буцааж өгөхгүй буюу эрх ашиг, сонирхол нь зөрчигдсөн хүүхдийн эцэг, эх байх эрхийг хязгаарлах зэрэг чухал шийдвэрүүдийг гаргадаг.

Үндсэн хуулиар баталгаажсан шударгаар шүүлгэх эрхийн хүрээнд өсвөр насны хүнд холбогдох хүчирхийлэл үйлдэх, хайхрамжгүй орхихтой холбоотой хэргүүдэд эцэг, эхийг заавал өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа авах эрхээр хангахаас гадна өсвөр насны хүний эрх ашиг, сонирхлыг хамгаалах чиг үүрэг бүхий этгээдийг (англ. *guardian ad litem*) томилж, түүнд холбогдох зардлыг мөн төлдөг.

Шүүгч нь өсвөр насны хүн хүчирхийлэлд өртөх болон өсвөр насны хүнийг халамжлах үүрэгтээ хайнга, хайхрамжгүй хандсан эцэг, эхэд холбогдох хэргүүдийг шийдвэрлэхдээ хууль, эрх зүйн мэдлэг сайтай байх, мөн гэр бүлийн хүрээнд үүссэн асуудлын сэтгэлзүйн болон нийгмийн шинж чанарыг сайтар ойлгох, нарийн мэдрэх чадваруудтай байхыг шаарддаг. Шүүгч нь тухайн өсвөр насны хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдсан эсэхийг харгалзан үзсэний үндсэн дээр эцэг, эхэд нь буцаах тухай шийдвэр гаргана. Эдгээр нарийн төвөгтэй хэргийг шийдвэрлэхдээ шүүгч нь хууль, эрх зүйн өндөр мэдлэгтэй, сэтгэлзүйн нарийн мэдрэмжтэй байх нь чухал бөгөөд өсвөр насны хүүхдийн эрх, ашгийг хамгаалах мэргэжлийн болон бусад байгууллагын дэмжлэгтэйгээр шийдвэр гаргах нь зүйтэй.

III. ШҮҮГЧ МЭРГЭШИЛ БОЛОН МЭДЛЭГ, ҮР ЧАДВАРАА ЦАГ ЯМАГТ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

Гэр бүл болон өсвөр насны хүнд холбогдох хэрэг нь шүүгчдээс өндөр түвшний мэдлэг, чадварыг шаарддаг. Бусад эрх зүйн салбарууд нь ихэвчлэн нэгэнт тогтсон хууль, эрх зүйн онолд тулгуурлаж, тодорхой нөхцөл байдалд дүгнэлт өгөх замаар хэргийг шийдвэрлэдэг бол хүүхэд, гэр бүлтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэх шүүгчид ХХША-аас гадна хүн хоорондын харилцааны нарийн төвөгтэй байдал, хүүхэд болон гэр бүлийн гишүүдийн амьдралыг ойлгох чадвар, мөн хүүхдийн бие махбодын хөгжлийн онцлогтой холбоотой аливаа мэдлэг, ойлголттой байх нь чухал.

Ихэнх иргэний болон эрүүгийн хэргүүд нь болж өнгөрсөн үйл явдлын үнэн зөвийг тогтоож, түүнээс үүссэн үр дагаварт хариуцлага тооцоход чиглэдэг бол гэр бүлийн хэрэг, маргаан нь тухайн этгээдийн өмнө гаргасан зан үйлийг үнэлж, цаашид үүсэж болзошгүй эрсдэл, нөхцөл байдлыг урьдчилан таамаглахад чиглэдэг. Жишээлбэл, өсвөр насны хүнд холбогдох асрамжийн маргаантай хэргийн хувьд шүүгч өнгөрсөн үйл явдлын талаарх нотлох баримтыг бүрэн дүүрэн үнэлж, улмаар өсвөр насны хүний цаашдын эрх ашиг, сонирхолд нийцсэн шийдвэр гаргах ёстой. Мөн шүүгч хэрэг хянан шийдвэрлэхдээ өсвөр насны хүний бие даан шийдвэр гаргах, сэтгэл хөдлөлөө хянах, аливаа эрсдэлийг урьдчилан тооцох чадвар нь хөгжлийн үе шатандаа байгааг харгалзан үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, энэ үед өсвөр насны хүний нийгмийн харилцаанд дасан зохицох үйл явц дөнгөж эхлэх үе буюу оюун санааны хувьд бүрэн төлөвшөөгүй хэвээр байдаг. Иймд Гэр бүлийн шүүхийн шүүгчид өсвөр насны хүнд холбогдох хэрэг, маргааныг авч хэлэлцэхдээ эдгээр онцлог шинжийг ойлгон хүлээн авч, хүүхдийг хүмүүжүүлэх, дахин нийгэмшүүлэхэд чиглэсэн шийдвэрийг гаргах нь зүйтэй.

Тухайлбал, гэр бүл болон өсвөр насны хүнд холбогдох хэргүүд нь ихэнх иргэний болон эрүүгийн хэргүүдээс ялгаатай байдаг бөгөөд шүүгчдийг тухайн салбарын талаарх тусгайлсан мэдлэг, ур чадварыг эзэмшсэн, мэргэшсэн байхыг шаарддаг. Түүнчлэн, шүүгчдэд зориулсан мэргэшил дээшлүүлэх сургалт орох замаар шүүгчдийг мэдлэг, ур чадвар болон туршлагаа дээшлүүлэх боломжоор хангадаг бөгөөд энэ нь хэд хэдэн аргаар хэрэгждэг.

Нэгдүгээрт, Хавай мужийн Гэр бүлийн шүүхийн шүүгчийг Хавай мужийн дээд шүүхийн Ерөнхий шүүгч томилдог. Ийнхүү томилогдсон шүүгч нар зөвхөн гэр бүл болон өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх бөгөөд бусад төрлийн иргэний болон эрүүгийн хэргийг шийдвэрлэх эрхгүй байдаг нь тухайн шүүгч нар гэр бүлийн эрх зүйн чиглэлээр мэргэшиж, мэдлэг ур чадвараа тогтмол хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Хоёрдугаарт, нэгдмэл зохион байгуулалттай Гэр бүлийн шүүхийн тогтолцоо нь шүүгчдэд тусгайлсан сургалтын системд хамрагдах, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлдгээрээ онцлогтой. Энэхүү сургалт нь гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн оюун санааны болон бие махбодын хөгжил, өсвөр насны сэтгэлзүйн онцлог, бие махбодын болон сэтгэл санааны гэмтэл, гэр бүлийн санхүүгийн асуудал, мансууруулах бодисын хамаарал, сэтгэцийн эмгэг, соёлын олон янз байдлыг ойлгох чадвар зэрэг өргөн хүрээний сэдвүүдийг багтаасан байдаг.

Гэр бүлийн хүчирхийлэл нь ил болон далд хэлбэрээр үйлдэгддэг бөгөөд шүүгч нарт энэ асуудлын талаарх цогц ойлголт өгөхийг чухалчилж, дараах чиглэлийн сургалтуудыг зохион байгуулдаг. Үүнд: илэрхий бус буюу нуугдмал хэлбэрээр үйлдэгдсэн хүчирхийлэл (жишээ нь: санхүүгийн дарамт үзүүлэх, хяналтдаа байлгах зэрэг)-ийг илрүүлэх; хүчирхийлэлтэй холбоотойгоор нийгэмд түгээмэл байдаг өрөөсгөл ойлголт, хандлагыг бууруулах; сэтгэлзүйн гэмтэлд өртсөн хүний зан үйл, хандлагыг ойлгох; өсвөр насны хүн болон хохирогчид учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх; тэднийг хамгаалсан шийдвэр гаргах зэрэг багтдаг. Өөрөөр хэлбэл, шүүгчдэд хууль хэрэглээний мэдлэг өгөхөөс гадна тухайн хэргийн нөхцөл байдлыг бодитойгоор үнэлж, хохирогчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн шийдвэр гаргах ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

IV. ИННОВАЦ БА ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ

Хавай мужийн Гэр бүлийн шүүхийн нэгдсэн зохион байгуулалтын бүтэц нь гэр бүл болон хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьсан шинэ тогтолцоог бий болгосон. Сүүлийн жилүүдэд тодорхой хүн амын бүлэг болон эрх зүйн онцгой асуудалд чиглэсэн дагнасан шүүхүүдийг (англ. *Specialized Courts*) байгуулснаар асуудлыг нэг дор төвлөрүүлэн шийдвэрлэх тогтолцоо бүрдсэн байна. Жишээ нь, дагнасан шүүх нь өсвөр насны хүн мансууруулах бодис хэрэглэсэнтэй холбоотой хэргийг шийдвэрлэхдээ эрчимжүүлсэн шүүхийн хяналт болон мансууруулах бодист донтсон хүүхдэд чиглэсэн эмчилгээ, үйлчилгээг хослуулсан арга хэмжээг авдаг.

АНУ-д анх байгуулагдсан “Охидын шүүх” (англ. *Girls’ Court*) нь гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй эмэгтэй хүнд холбогдох хэргийг хүлээн авч, хянан шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл, насанд хүрээгүй эмэгтэй хүн гэр бүлийн

хүчирхийлэлд өртсөн эсэх, сэтгэл санааны гэмтэл авсан эсэх зэрэг нөхцөл байдлыг тогтоохдоо тэдний хүйсийн онцлог болон сэтгэлзүйн нөхцөл байдлыг сайтар ойлгож, авч үзсэний үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэдэг.

Гэр бүлийн хүрээнд үүссэн мансууруулах бодистой холбоотой хэргийг хянан шийдвэрлэх шүүх (англ. *The Family Drug Court*) нь хүүхдийн эрх ашигт шууд нөлөө үзүүлэхүйц эцэг, эхийн мансууруулах бодист донтохтой холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэх чиг үүрэгтэй бөгөөд хүүхдийн эцэг, эхэд дэмжлэг үзүүлэх, эмчилгээний хөтөлбөрт хамруулах замаар тэднийг мансууруулах бодисын хамаарлаас гарахад нь тусалж, улмаар эцэг, эх хүүхдийн харилцааг сэргээж, гэр бүлийг дахин нэгтгэх үндсэн зорилготой. Харин “Сургуулиас завсардсан хүүхдийн шүүх” (англ. *Truancy Court*) болон “Эрт үеийн боловсролыг дэмжих хөтөлбөр” (англ. *the Early Education Intervention Program*) нь хүүхдийн боловсрол эзэмших эрхийг хангах, суралцах үйл явцад дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг. Ялангуяа эмзэг бүлгийн хүүхдүүдийн хувьд ихээхэн сөрөг үр дагаварт хүргэдэг боловсролын тасалдлыг бууруулах зорилготой болно.

Эдгээр дагнасан шүүхүүд нь нийгэмд шинээр үүсч буй харилцаа, хандлага болон хууль зүйн шинэ сорилтуудад дасан зохицож, үндэслэлтэй шийдвэр гаргах замаар шүүхийн үйл ажиллагааны уян хатан, хувьсах чадварыг дээшлүүлж байдаг. Мөн нийгэмд гарч буй хүнд, төвөгтэй хэргүүдийг шийдвэрлэхэд шүүгчийн мэдлэг, ур чадвар төдийгүй аливаа асуудлыг олон талаас нь харах чадвараас гадна олон нийтийн идэвх оролцоог чухал ач холбогдолтой гэж үздэг байна.

Хавай мужийн шүүхийн нэгдмэл тогтолцоо нь хүүхэд, гэр бүлийн эрх ашиг, сонирхлыг хөндөж буй суурь тулгамдсан асуудлыг илрүүлж, түүнийг шийдвэрлэх бодит арга замыг боловсруулах боломжийг олгож байна. Жишээлбэл, гэр бүлийн хэргийн шүүгч нар болон удирдлагууд хүүхдийг зохисгүйгээр удаан хорих нь ихээхэн сөрөг үр дагавартай болохыг хүлээн зөвшөөрч, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хүүхдийг хорих тоог бууруулах бодлого хэрэгжүүлсний үр дүнд “*Өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн арга хэмжээ авах*” санаачилгын хүрээнд олон нийтийн аюулгүй байдалд эрсдэл учруулахгүйгээр өсвөр насны хүнд хорихоос өөр төрлийн шийтгэл оногдуулах боломж бүрдсэнээр хууль зөрчсөн өсвөр насны хүнд хорих ял оногдуулах тоо тодорхой хэмжээгээр буурсан байна.

2014 онд батлагдсан хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд өсвөр насны хүнд холбогдох эрүүгийн хэргийг шийдвэрлэхдээ өсвөр насны хүнийг дахин нийгэмшүүлэх, хүмүүжлийн арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн.

Мөн Хавай мужийн Гэр бүлийн шүүх нь анх удаа төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг ХХША-нд татан оролцуулахгүйгээр тухайн хэргийн шинж чанарт нь нийцсэн чиглүүлэх хөтөлбөр, тогтолцоог боловсруулах ажлыг хийж байна. Өөрөөр хэлбэл, энэ нь өсвөр насны хүнийг дахин гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх, аливаа сөрөг нөлөөтэй үйлдэл хийх эрсдэлийг бууруулах зорилготой юм.

Дээрх хөгжил дэвшил, шинэчлэлүүд нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага болон хууль тогтоох байгууллага, мөн нийгэмд үйл ажиллагаа

явуулдаг хувь хүн, байгууллагуудын идэвхтэй хамтын ажиллагааны үр дүнд бий болж буйг онцлон дурдах нь зүйтэй байна.

V. ДҮГНЭЛТ

Иргэн, эрүүгийн болон өсвөр насны хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг нэгтгэн, шүүгчдийн мэргэшүүлэх сургалт, хөтөлбөрийг боловсруулж, хүүхдийг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлснээр Хавай мужийн хүүхэд, гэр бүлийн амьдралын чанарыг сайжруулах боломж бүрдсэн. Үүний үр дүнд Хавай мужийн нэгдсэн Гэр бүлийн шүүх нь ХХША-г хүртээмжтэй, шударга ёсыг хангах зарчимд нийцүүлсэн байна.

Иймд гэр бүл болон өсвөр насны хүнд холбогдох хэргийн шүүхийн харьяаллыг нэгтгэн, нэгдсэн тогтолцоог бий болгох шинэчлэл хийж буй улс, орнууд нь Хавай мужаас хууль, эрх зүйн тогтолцоо, боломж, нийгмийн онцлогоороо ялгаатай байж болох ч Хавай мужийн нэгдсэн Гэр бүлийн шүүхийн 60 жилийн туршлагаас зарим шинэлэг санаа, сургамжуудыг өөрийн улсын онцлогт нийцүүлэн хэрэглэх боломжтой юм

“ХБНГУ ДАХЬ ӨСВӨР НАСНЫ ХҮНИЙ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ”*

Стефан Сшал,
ХБНГУ-ын Бамберг хотын Ерөнхий
прокурорын газрын прокурор, орлогч дарга

* 2025.06.25-ны өдрийн хурлын видео бичлэгээс буулгав

Миний бие өсвөр насны хүний холбогдсон гэмт хэрэгт олон жил ажилласан. Яагаад өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх тусдаа хууль байдаг вэ? Өсвөр насны хүн сурч боловсрох болон өсөж хөгжих явцдаа олон төрлийн үйлдэл хийдэг ба зарим нь тухайн үйлдлээ буруу (хууль бус) гэдгийг мэдэхгүй байх боломжтой. Бидний зүгээс гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг сургалтад хамруулж, өөрийгөө хөгжүүлэхэд нь тусалж, дэмжих ёстой гэж үздэг. Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүн тухайн гэмт хэргийг үйлдэх болсон шалтгааныг тодруулах шаардлагатай. Тухайн хүүхэд гэмт хэрэгт холбогдох болсон шалтгааныг тодорхойлох шаардлага үүссэн. Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүн бусдын нөлөөнд автаж гэмт хэрэгт холбогдох магадлал өндөр байдаг ба үүнээс гадна тэдэнд шийтгэл ногдуулах гэхээс илүүтэйгээр сургалт, хүмүүжлийн арга хэмжээг авах нь илүү үр дүнтэй гэж үздэг.

Бид гэмт хэрэгт холбогдогчдыг дараах 4 төрөлд ангилдаг. Эхнийх нь 14 буюу түүнээс доош насны хүүхэд буюу эрүүгийн хариуцлага хүлээх чадваргүй, дараа нь 14-18 насны хүүхэд буюу өсвөр насны хүн, мөн 18-21 насны хүн, хамгийн сүүлд 21 болон түүнээс дээш насныхан буюу насанд хүрэгчид гэж тодорхойлдог. Бидний хувьд 14 болон түүнээс доош насны хүүхдүүд буюу хэрэг хариуцах чадваргүй хүний үйлдсэн гэмт үйлдлийг Иргэний хуульд нийцүүлэн шийдвэрлэхийг эрмэлздэг. 14-18 насны хүнийг “өсвөр насны хүн” гэж нэрлэдэг ба шууд эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэхээс илүүтэй өөрийн хийсэн үйлдэлд гэмшиж байгаа эсэх, өөрийн үйлдлийн бодит шинж чанар, хор уршгийг ухамсарлаж байгаа эсэхийг харгалздаг. Харин 18-21 настай боловч сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдолын улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, хор уршгийг ухамсарлах чадваргүй тохиолдолд “өсвөр насны хүн” гэж үзэн хариуцлага хүлээлгэдэг. Гэхдээ ийм тохиолдол цөөн гардаг.

18-21 насны хүний хувьд бүрэн хариуцлага хүлээх чадвартай гэж үздэг. 14-21 насны хүн гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд Хүүхдийн хэргийн шүүх шийдвэрлэдэг бол 21 болон түүнээс дээш насныхны үйлдсэн хэргийг “Насанд хүрэгчдийн эрүүгийн хэргийн шүүх”-ээр шийдвэрлэж хариуцлага тооцдог. Бид өсвөр насны хүнийг хорих ялаар шийтгэдэггүй, харин сахилгын арга хэмжээ авдаг. Сахилгын арга хэмжээнд нийтэд тустай ажил хийлгэх, мөн сургалтад хамруулах (тухайн хүүхдийн хийсэн үйлдлийг буруу гэдгийг ойлгуулж, таниулах) зэрэг багтдаг.

Түүнчлэн өсвөр насны хүний мансууруулах бодис болон согтууруулах ундаа хэрэглэх зэрэгт хяналт тавих, зарим тохиолдолд хүмүүнлэгийн байгууллагад мөнгөн хандив өгөх арга хэмжээг зохион байгуулдаг. Өсвөр насны хүн ноцтой гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд бид түр саатуулах байранд 1 хоногоос 4 долоо хоног хүртэлх хугацаагаар саатуулдаг. Энэ нь хорих байгууллага боловч саатуулагдаж буй хүүхдүүдэд сургалт орох, мэргэжлийн хүнтэй уулзуулж, хийсэн үйлдлийнхээ талаар ярилцах боломжийг олгох, амралтын өдрөөр амрах зэрэг арга хэмжээг авч ажилладаг. Харин тухайн хүүхэд дахин давтан гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд хорих арга хэмжээ авдаг.

Шүүх хуралд шүүгч болон мэргэших тусгай сургалтад хамрагдсан прокурор оролцоно. Уг прокурор нь зөвхөн өсвөр насны хүний холбогдсон гэмт хэрэг дээр

ажилладаг. Бид хэргийг түргэн шуурхай шийдвэрлэхийг зорьдог ба гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш 7 хоногийн дотор шүүх хурлыг товлон хэргийг шийдвэрлэдэг. Өмнө нь энэ төрлийн хэргийг шийдвэрлэхэд 1 жилийн хугацаа шаардагддаг байсан бөгөөд хугацаа их алдсанаар гэмт хэрэгт холбогдсон хүүхэд өмнө нь ямар буруу үйлдэл хийж, гэмт хэрэгт холбогдсон гэдгээ мартаж хэмжээнд хүрдэг байсан. Мөн хүүхдийн сайн сайхны төлөөх байгууллага гэж байдаг бөгөөд уг байгууллагын мэргэжилтэн гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн сургууль дээр очих, эцэг, эхтэй нь уулзах зэргээр гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөлийг тогтоохоор ажилладаг. Үүнээс гадна тухайн хүүхдэд ямар арга хэмжээ авах талаар өөрийн санал, дүгнэлтийг гаргах эрхтэй байдаг. Өөрөөр хэлбэл, энэхүү мэргэжилтэн нь тухайн хүүхдийн талаарх мэдээллийг бүрэн цуглуулдаг гэсэн үг.

Шүүгч тухайн хүүхэдтэй шүүх хуралдааны явцад уулзсаны дараа хангалттай мэдээллийг олж авч чадахгүй учраас энэ төрлийн хэрэгт хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын мэргэжилтэн оролцох нь чухал ач холбогдолтой. Эрүүгийн хэргийн шүүхээс тусад нь Өсвөр насны хүний хэргийн шүүх болон Гэр бүлийн шүүхийг байгуулсан шалтгаан нь хүүхдийн холбогдсон хэргийг тусад нь шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм. Энэхүү тогтолцоо сайн ажиллаж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ГУРАВДУГААР ХЭСЭГ: ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН
ХЭРГИЙН ШҮҮХИЙН ХЭРЭГ ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА БА ШҮҮХИЙН БҮТЭЦ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

“ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХ: ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, ШҮҮХИЙН ҮҮРГИЙН ТАЛААРХ ЭРГЭЦҮҮЛЭЛ”*

Тон Лиефаард,
Хүүхдийн эрхийн чиглэлээр мэргэшсэн профессор, ЮНИСЕФ-ийн Хүүхдийн
эрхийн асуудлыг хариуцсан тэргүүлэх мэргэжилтэн, Лейдений их сургуулийн
Хууль зүйн сургуулийн Хүүхэд ба Эрүүл мэндийн салбар хариуцсан тэнхимийн
эрхлэгч, Хууль зүйн доктор (Ph.D)

* 2025.06.25-ны өдрийн хурлын видео бичлэгээс буулгав

Эрүүл, аюулгүй орчинд өсөж бойжих, тухайн хүүхэд сайн хүн болж хүмүүжих зэрэг асуудал нь хүүхэд наснаас эхлэлтэй билээ. Иймд хүүхдийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, түүнд хөрөнгө оруулах нь нийгэмд ихээхэн хэрэгцээтэй ба өнөөгийн төдийгүй ирээдүйн хүүхдүүдийн сайн сайхны төлөөх үйл ажиллагаа юм.

Миний бие илтгэлээ олон улсын хүүхдийн эрхийн талаар танилцуулан эхлүүлж байна. Хүүхдийн эрх гэдэг бол тухайн хүүхэд, түүний гэр бүл, цаашилбал шүүхэд хамаарах өргөн хүрээний ойлголт юм. Илтгэлийн хамрах хүрээнд хүүхэд, гэр бүлтэй холбоотой ямар асуудлууд байгаа талаар, хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа ямар байх ёстой талаар, үүнд Гэр бүлийн тухай хууль, шүүхийн асуудал зэргийг хамруулах болно.

1989 онд НҮБ-аас хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор Хүүхдийн эрхийн тухай конвенцыг баталсан нь бахархууштай үйл явдал болсон. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас олон улсын энэхүү баримт бичгийг баталсан нь хүүхдийн үндсэн эрхийг тунхагласан явдал болжээ. Ингээд 1989 оноос хойш, хүүхэд нь насанд хүрсэн хүнтэй адил эрх эдэлнэ гэж үзсэн байна.

Хүүхдийн эрх нь хүний эрхийн үндсэн дөрвөн чиглэлтэй адил хэрэгжинэ, үүнээс үүдэн асар их анхаарлын төвд орж, шинэтгэлүүд ихээр явагдаж хууль тогтоомж ч олноор батлагдаж, шүүхийн салбарт ч мөн адил томоохон шинэчлэлт, шилжилтүүд гарч байсан. Уг шилжилт хөдөлгөөн нь зөвхөн аль нэг улс бус дэлхий даяар өрнөсөн хөдөлгөөн болно. Бид одоо ч мөн адил олон улсын хүүхдийн эрх, хүний эрхийн талаар ярьж байна. Энэ нь хүүхдийн эрхийг зохист хэмжээнд хамгаалж чадахгүй байгаатай холбоотой. Учир нь бидэнд одоог хүртэл хүүхдийн эрхийг хамгаалах тал дээр асар их сорилт, бэрхшээлүүд тулгарч байна. Гэвч бүх л улсад, Монгол Улсад ч мөн адил хүүхдийн асуудлыг ярихдаа хүний эрхийн хандлага, үзэл баримтлал талаас нь ярих ёстой гэдгийг тэмдэглэн, хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Энэ сэдвээр судалгааны ажил хийх нь бидний дэвшүүлж буй “хүүхдийн эрх, түүнийг хамгаалахтай холбоотой асуудал нь дэлхий дахины асуудал юм” гэсэн аргументыг нэмэгдүүлж, улам баталгаажуулах үр дагавартай юм.

Хүүхдийн эрхийн тухай конвенц нь өөрөө эрх зүйн баримт бичиг болох тул түүнийг батламжлах, соёрхон батлах үйл ажиллагаа явагдахаас гадна хамгийн гол нь түүнийг хэрэгжүүлэх явдал юм. Ийнхүү хэрэгжүүлэхийн тулд тухайн улс хууль тогтоомж батлах ёстой, ийнхүү баталсан хуулийг үндэслэж шийдвэр гаргах, шүүхийн шийдвэрт түүнийг эшлэх ажиллагаа явагдах ёстой юм. Иймд улс бүр конвенцыг хэрэгжүүлэхийн тулд өөр өөрийн гэсэн арга хэмжээг авна.

Конвенц нь дан ганц баримт бичиг биш, нэмэлт гурван протоколтой. Конвенц нь дан ганц баримт бичиг биш, нэмэлт гурван протоколтой. Энэ нь Монгол Улсын олон улсын гэрээ Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол (OPSC), Монгол Улсын олон улсын гэрээ Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол (OPAC), Хүүхдийн эрхийн тухай конвенцын “Мэдээлэл хүргүүлэх журмын тухай” нэмэлт протокол (OPIC) болно.

Хүүхдийн эрхийн тухай конвенц буюу үндсэн баримт бичиг нь гурван баганатай. Нэгдүгээрт, хүүхэд нь өөрөө хүн болохынхоо хувьд хүний эрхийг ч мөн адил насанд хүрсэн хүний адил эдэлнэ гэдгийг хүлээн зөвшөөрч, түүнийг дээдлэн дасан зохицох ёстой. Хоёрдугаарт, хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрч байгаа бол хүүхэд гэдэгт хэнийг ойлгох талаар буюу эрх зүйн баримт бичигт 18 нас хүртэлх хүн гэх мэтээр тодорхойлж болох боловч 18 нас хүртэлх хүүхэд бүрийн хөгжлийн түвшин өөр өөр, зарим нь хурдан байхад зарим нь үеийнхэнтэйгээ харьцуулахад өсөлт хөгжлийн процесс удаан байх нь бий. Хүүхэд бүр хүн учраас тэдний хэрэгцээ, бие даасан байдал нь өсөлт, хөгжилтэйгөө зэрэгцэн хувьсан өөрчлөгдөж байдаг. Тиймээс хүүхдийн өсөлт нь хөгжлийн бүх үе шатыг дамждаг болохыг хүлээн зөвшөөрч, энэхүү үйл явцын давхарга бүрд тохирсон зохицуулалт хийх шаардлагатай. Гуравдугаарт, хүүхэд амьдралын ухаан суух, мөн тархи болон оюун ухааны хөгжил нь сайн төлөвшсөн байх асуудлыг авч үздэг бөгөөд энэ нь тухайн улсын эрх зүйн систем, гэр бүл, асран хамгаалагч, эцэг эхийн үүрэг, хариуцлагатай салшгүй холбоотой ойлголт юм. Хүүхдийн өсөлт, хөгжлийн шат ахихын хэрээр нийгмийн харилцаанд оролцохоос гадна гэр бүлийн орчинд өсөж, хүмүүжиж байгаа тул өөрийгөө хүний хувьд хүндэтгэл хүлээх бүрэн эрхтэй гэдгийг ойлгуулах, хүлээн зөвшөөрүүлэх хэрэгцээ үүсдэг. Энэ нь шүүхийн үйл ажиллагаа, цагаачлалын асуудал, мөн нийгэм дэх сургалт, боловсрол зэрэгтэй салшгүй холбоотой тулгамдсан асуудлуудыг үүсгэж байна. Бидний хэлэлцэж байгаа энэхүү хүүхдийн эрхтэй холбоотой асуудал нь маш нарийн төвөгтэй асуудал бөгөөд хуулийн салбарын хувьд нэлээн шинэлэг сэдэв тул уг ойлголтыг нарийвчлан авч үзэх шаардлагатай юм. Конвенцын хүрээнд олон талт үзэл баримтлал, онолын асуудал хөндөгдөж болно.

Хүүхдийг хамгаалах хэрэгцээ шаардлага нэмэгдэхийн хэрээр түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ өөр өөр байна. Жишээ нь: Хүүхдийн хүчирхийлэл. Дээрх конвенц нь бүх хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх эрх зүйн үндэс нь болдог. Хүүхдийн үндсэн дөрвөн эрхийн талаар дурдвал, хүүхдийн эрхийн асуудлыг ганц шүүхийн байгууллагад хамааруулснаас гадна энэ тухайд шүүгч нар тус бүрийн бие даасан үүрэг, хариуцлага нь асар их хувь нэмэр оруулдаг. Өөрөөр хэлбэл, нийгмийн бүхий л харилцаа, үйлдэл нь хүүхдийн эрхтэй салшгүй холбоотой ба шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ч үүнд багтана.

Дараагийн асуудал бол тэнцэтгэх (англ. *equivalence*) буюу хүүхдэд эрх тэгш хандах, харьцах тухай юм. Энэ нь эрх тэгш харьцах, хүний нэр хүнд, хүний мөн чанарыг хүндэтгэж харьцана гэсэн үг. Олон улсын хүүхдийн эрх нь бүх хүүхдэд хамаарах, хүүхэд бүр хүний эрхээр хангагдах, нийгмийн давхарга, гарал үүсэл, гэр бүлийн эдийн засгийн байдал зэргээс үл шалтгаалан эрхээ баттай эдлэх ёстой. Олон улсууд хүүхдийг тухайн улсын “иргэн”-тэй адил эрх, үүрэгтэй нэгэн гэж үзэн хандаж, тэднийг сонсох эрхийг хангах, шүүхэд хандах эрхийг хангах зэргээр шударга ёсонд тэдний үйл ажиллагааг дэмжих хэрэгсэл гэж үзэн үүнийг хөгжүүлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн цахим орчин, байгаль орчны уур амьсгалын өөрчлөлт, цар тахал зэргээс улбаалан нийгмийн нөхцөл байдал хувьсан өөрчлөгдөж байсан ч хүүхдийн эрх болон түүнийг хамгаалах асуудлыг хэзээ ч орхиж болохгүй. Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлын хувьд сүүлийн 35 жилийн туршлагаас харахад

эрх зүйн хөгжил улам бүр нэмэгдэж улсууд холбогдох хууль, дүрэм баталж, олон улсын хэмжээнд дэвшил гарч байна. Жишээ нь: технологийн хөгжлийг даган цахим орчин хөгжиж, ковидын дараагаас хүүхдэд олон асуудал, хүндрэл буюу давхар хямрал тулгарч эхэлсэн.

Үүнээс гадна, 2024 онд хүүхдийн эрхийг хамгаалах асуудал цаашилбал, цөөнхийн эрхийг хамгаалах асуудлуудыг орхигдуулах, улмаар авч хэлэлцэхгүй хойш тавих болсон нь санаа зовоосон асуудал болж байна. Энэ нь дан ганц нэг улсад тохиолдож байгаа асуудал бус дэлхий даяар бүх улсуудыг хамарсан асуудал тул бусад улсууд тус салбарт гарч байгаа хөгжил, дэвшлийн талаар анхаарал хандуулж эхэлжээ. Тэдний үзэж байгаагаар, хүүхдийг эрх эзэмшигч гэж харахгүй байх, тэнцэтгэж харьцахгүй байх, хүүхдийн оролцоог хангахгүй байгаа нь асуудал үүсгэж байна гэж үзжээ.

Иймд би илтгэлийнхээ төгсгөлд энэхүү сэдэвтэй хамаарах 3 эргэцүүлэл буюу санал хэлье. Нэг, Хариуцлага хүлээх - Би хангалттай хийж чадсан уу, хүүхдийн эрхийн төлөө ойлгомжтойгоор, хэрэгцээг нь хангаж, тэдний оролцох эрхийг хангаж чадав уу, тэдэнд хэрэгтэй үйлчилгээг хүргэж чадав уу гэдэгт төвлөрнө. Хамгийн чухал элемент нь сөрөг арга хэмжээний эсрэг арга хэмжээ авах. Эрхийг мэдлээ, ойлголоо гээд хэрэгжүүлэх механизмгүй бол үр дүнгүй. Олон улсын хэмжээнд шударга ёсонд хүүхдийн оролцоог хангах гэдэг нь НҮБ-ын Дээд комиссаруудын хувьд аливаа асуудлыг шууд шуурхай шийдвэрлэх тухай дурдсан. Хамгаалахтай утга нэг хэрэгжүүлж болох арга хэмжээ нь ямар ч үйлдэл хийхгүй байх явдал бас байж болно. Энэ нь хамгаалах хамгийн эхний алхам юм. Хоёр, Шударга ёсыг хүүхдэд түгээх - Шүүхийн системийг өргөжүүлэн хөгжүүлэх талаар бид олон жил хүүхэдтэй хамтран ажиллаж байна. Үүнд хүүхдийг оролцуулах ёстой, ингэснээр үр дүнтэйгээр хүүхдийн эрхийг хангах талаар тэдний харах өнцөг, оролцоог сонсох боломж бүрдэх юм. Хүүхэд өөрийг нь сонсож байна, намайг хүндэтгэж байна гэсэн сэтгэл ханамжтай үлдэж, би процессын нэг хэсэг юм байна гэх мэдрэмж авснаар шүүхийн шийдвэрийг биелүүлэх, хүлээн зөвшөөрөх, ойлгох хандлагатай төлөвшил бий болно. Энэхүү алхмыг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалт илүү хэрэгтэй. Гурав, Хүүхдийн эрхэд үндэслэх - Хүүхдийн шүүх, хүүхдийн эрхийг хамгаалах бүхий л арга хэмжээг авна гэдэг нь нийгмийн хэмжээнд суурь ойлголтыг бүрдүүлэх эх үндэс болох учиртай. Энэ нь цаашилбал урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Өмнөд Африкийн шүүхийн нэгэн шүүгч хэлэхдээ, “Үндсэн хуульт улсад шударга ёс цаг ямагт үйлчлэх ёстой”. Энэ нь саад тотгор учирсан ч, яаж, ямар арга санаачилгаар хүүхдийн эрхийг хамгаалах арга замыг олох вэ гэдэгтэй холбогдох ба хүүхэд бол манай нийгмийн иргэн ба шүүхийн системд хэзээ ч хүлэгдсэн байж болохгүй, шударга ёсны хүртээмж хэзээ ч алдагдах ёсгүй гэсэн агуулгатай.

Ийнхүү илтгэлээ энэ хүрээд өндөрлүүлж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

“БНСУ-ЫН ГЭР БҮЛИЙН ШҮҮХИЙН ТҮҮХ, СҮҮЛИЙН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА”

Ким Хён Рюл,
БНСУ-ын Сөүлийн Гэр бүлийн шүүхийн Ерөнхий шүүгч, (LL.M)

Агуулга

I. Анх байгуулагдсан нь

II. Тэлэлт ба хөгжил

1. 1990 оны Иргэний хуулийн нэмэлт, өөрчлөлт
2. 1990 онд Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсан нь
3. 1997 онд гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тогтолцоог нэвтрүүлсэн нь
4. 2001 онд гэр бүлийн хэргийн шинжээч томилох тогтолцоог нэвтрүүлсэн нь
5. Гэр бүлийн шүүхийг улс даяар өргөжүүлсэн нь
6. 2014 онд хүүхэд хамгаалах тогтолцоог нэвтрүүлсэн нь

III. Сүүлийн үеийн чиг хандлага ба тулгамдаж буй асуудлууд

1. Хүүхдийн тэтгэлэг тогтоох жишиг ба нэмэлт, өөрчлөлт оруулах
 2. Хүүхэдтэй уулзах эрхийг дэмжих төв
 3. Гэр бүлийн хэргийн шинжээчийн тоог нэмэгдүүлэх
 4. Гэр бүлийн шүүхийн “албадан эмчлэх” чиг үүргийг өргөжүүлэх нь
 5. Супер өндөр настны нийгэмд бэлдэх
 6. Хүүхдийн тэтгэмж тогтоох жишиг ба нэмэлт, өөрчлөлт оруулах
-

I.АНХ БАЙГУУЛАГДСАН НЬ

1963 оны 10 дугаар сарын 01-ний өдөр гэр бүлийн маргаан, өсвөр насны хүнийг хамгаалах хэргийг мэргэшлийн түвшинд шийдвэрлэх зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улсын (цаашид “БНСУ” гэх) анхны Гэр бүлийн шүүх буюу Сөүл хотын Гэр бүлийн шүүх байгуулагдсан. Үүнээс өмнө эдгээр хэргүүдийг ердийн шүүх болох Сөүл хотын анхан шатны шүүх шийдвэрлэдэг байсан. Ийнхүү БНСУ нь Япон Улсын дараа Дорнод Азид Гэр бүлийн шүүх байгуулсан хоёр дахь улс болсон юм.

II.ТЭЛЭЛТ БА ХӨГЖИЛ

2.1 1990 оны Иргэний хуулийн нэмэлт, өөрчлөлт

Иргэний хуульд үлдсэн уламжлалт, күнзийн сургаалд суурилсан эцгийн эрхт ёсны тогтолцоонуудыг 1990 оны нэмэлт, өөрчлөлтөөр ихэнхийг нь халсан. Энэ нэмэлт, өөрчлөлтөөр гэр бүлийн гишүүдийн хувь хүний эрх, хүйсийн тэгш байдлын зарчимд тулгуурлан тусгагдсан гол агуулгыг доор харуулбал:

- a. Эцгийн болон эхийн талыг адил тэгш хүлээн зөвшөөрч, 8 үеийн доторх төрөл садны харилцааг үндэслэл болгох;
- b Өмнө нь гэр бүлийн тэргүүнд ногдож байсан эрх мэдэл, онцгой эрхийг ихэнхийг нь цуцалж, хүйсээр ялгаварлах явдлыг багасгах;
- c Гэрлэлтээ цуцлуулсан талуудын аль нэг тал нөгөө талаасаа эд хөрөнгө хуваалгах тухай нэхэмжлэл гаргах эрх болон хүүхэдтэй уулзах эрхийг баталгаажуулах;
- d. Хүүхдийн хүйсээс хамаарсан өв залгамжлалын ялгаварлалыг арилгаж, өвлөх эрхийн тэгш байдлыг хангах.

Сөүл дэх Гэр бүлийн шүүх нь 1991 оны 05 сарын 16-ны өдөр шинэчлэгдсэн Иргэний хуульд үндэслэн гэр бүлийн дундын эд хөрөнгө хуваалгах тухай нэхэмжлэлийг шийдвэрлэсэн анхны шийдвэрийг гаргасан бөгөөд эхнэрийн хийсэн гэрийн ажлыг хамтарсан хөрөнгийн 50%-д хувь нэмэр оруулсан гэж үзэн, өмчийн тэнцүү хуваарилалт хийх нь зүйтэй гэж үзжээ.

2.2 1990 онд Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсан нь

Дээр дурдсанчлан шинэчлэгдсэн Иргэний хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд, мөн ондоо буюу 1990 онд “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль” (가사소송법) батлагдсан. Үүнээс өмнө гэр бүлийн маргааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль, харин захиргааны журмаар гэрлэлт цуцлах тохиолдолд гэр бүлийн урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явагддаг байсан нь 2 хууль хоорондоо зөрчилдөх, давхцах асуудал багагүй гардаг байв. Шинээр батлагдсан “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль” нь бүх төрлийн гэр бүлийн хэрэгт нэгдсэн байдлаар хэрэглэгдэх суурь хууль болж, хууль зүйн нэгдмэл байдлыг ханган, үр нөлөөг дээшлүүлсэн. Улмаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль нь зөвхөн иргэний хэрэгт үйлчилж, Гэр бүлийн

хэрэг урьдчилан шийдвэрлэх хуулийг хүчингүйд тооцсоноор дагнасан Гэр бүлийн шүүхийн эрх, үүргийг улам бэхжүүлсэн.

2.3 1997 онд гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тогтолцоог нэвтрүүлсэн нь

Гэр бүлийн хүчирхийлэл, ялангуяа нөхөр нь эхнэртээ хүчирхийлэл үйлдэх нь нийгмийн томоохон асуудал болж эхэлсэнтэй холбоотойгоор БНСУ-ын Засгийн газар 1997 онд “Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх тусгай хууль”(가정폭력범죄의 처벌 등에 관한 특례법)-ийг баталсан. Энэхүү хууль нь Гэр бүлийн шүүхэд хөнгөн хэлбэрийн гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэх эрхийг олгосон. Гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт ял оногдуулахаас илүүтэйгээр, зөвлөгөө өгөх, боловсрол олгох, сэтгэл заслын эмчилгээ хийх зэрэг аргаар гэр бүлийн харилцааг сэргээх, дахин хүчирхийлэл гарахаас урьдчилан сэргийлэх зорилготой юм.

2.4 2001 онд гэр бүлийн хэргийн шинжээч томилох тогтолцоог нэвтрүүлсэн нь

Гэр бүлийн хэрэг нь нийгмийн халамж, сэтгэл судлал, боловсрол судлал зэрэг хүний зан үйлийн шинжлэх ухааны мэдлэг, ойлголтыг шаарддаг. Харин шүүгч болон шүүхийн ажилтнуудын дийлэнх нь хуулийн чиглэлээр мэргэшсэн байдаг тул, 2001 онд гэр бүлийн хэргийн шинжээчийн тогтолцоог нэвтрүүлсэн. Гэр бүлийн хэргийн шинжээч нь хүний зан үйлийн шинжлэх ухааны чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй мэргэжлийн хүмүүс байдаг. Энэхүү тогтолцоог нэвтрүүлснээр гэр бүлийн хэргийн судалгаа бодитойгоор хэрэгжиж эхэлсэн бөгөөд Гэр бүлийн шүүхийн мэргэжлийн түвшин улам бүр бэхжсэн гэж үздэг.

2.5 Гэр бүлийн шүүхийг улс даяар өргөжүүлсэн нь

Сөүл дэх Гэр бүлийн шүүхийн амжилттай үйл ажиллагаанд тулгуурлан, 2004 оноос эхлэн Сөүлээс бусад бүс нутгуудад жижиг хэмжээтэй Гэр бүлийн шүүхүүдийг байгуулж эхэлсэн. 2011 он гэхэд улсын гол томоохон хотуудад бие даасан Гэр бүлийн шүүхүүд байгуулагдсан. Одоогийн байдлаар Сөүл, Сувон, Инчон, Тэжон, Тэгү, Пусан, Улсан, Куанжу гэсэн 8 хотод Гэр бүлийн шүүх үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс гадна орон нутгийн салбар шүүхүүд ч хамтран үйл ажиллагаа явуулж байгаа тул улс даяар Гэр бүлийн болон Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн хүртээмж эрс сайжирсан байна.

2.6 2014 онд хүүхэд хамгаалах тогтолцоог нэвтрүүлсэн нь

Хүүхдийн хүчирхийлэл нь нийгэмд ноцтой асуудал болон гарч ирснээр, 2014 онд “Хүүхэд хүчирхийллийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх тусгай хууль”(아동학대범죄의 처벌 등에 관한 특례법)-ийг баталсан. Энэхүү хуульд үндэслэн Гэр бүлийн шүүх нь хөнгөн хэлбэрийн хүүхдийн хүчирхийллийн хэргийг хянан шийдвэрлэх эрхтэй болсон. Гэр бүлийн шүүх нь ял оноох бус, боловсрол, зөвлөгөө, сэтгэл заслын эмчилгээ зэргээр гэр бүлийн харилцааг сэргээж, хүчирхийлэл дахин гарахаас сэргийлэх зорилготой.

III. СҮҮЛИЙН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА БА ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

3.1 Хүүхдийн тэтгэлэг тогтоох жишиг ба нэмэлт, өөрчлөлт оруулах

Хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь орон нутаг болон шүүх бүрд харилцан адилгүй байсан нь тэнцвэргүй байдлыг үүсгэж, 2014 онд “Хүүхдийн тэтгэлгийн хэмжээ тогтоох жишиг хүснэгт”-ийг анх нэвтрүүлсэн. Уг хүснэгт нь амьжиргааны өртөг, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг харгалзан 3-4 жил тутамд шинэчлэгддэг. Одоогийн үйлчилж буй шалгуур хүснэгт нь хамгийн сүүлд 2021 онд шинэчлэгдсэн. Доорх хүснэгт нь хуулиар заавал дагаж мөрдөх хүчин чадалтай биш ч, ихэнх Гэр бүлийн шүүхүүд энэхүү жишгийг баримталдаг.

Хүснэгт 1.

2021년 양육비 산정기준표											
부모합산 소득	0 ~ 199만 원	200 ~ 299만 원	300 ~ 399만 원	400 ~ 499만 원	500 ~ 599만 원	600 ~ 699만 원	700 ~ 799만 원	800 ~ 899만 원	900 ~ 999만 원	1,000 ~ 1,199만 원	1,200만 원 이상
자녀 만 나이	평균양육비(원) 양육비 구간	평균양육비(원) 양육비 구간	평균양육비(원) 양육비 구간	평균양육비(원) 양육비 구간	평균양육비(원) 양육비 구간	평균양육비(원) 양육비 구간	평균양육비(원) 양육비 구간	평균양육비(원) 양육비 구간	평균양육비(원) 양육비 구간	평균양육비(원) 양육비 구간	평균양육비(원) 양육비 구간
0~2세	621,000 264,000~ 686,000	752,000 687,000~ 848,000	945,000 849,000~ 1,021,000	1,098,000 1,022,000~ 1,171,000	1,245,000 1,172,000~ 1,323,000	1,401,000 1,324,000~ 1,491,000	1,582,000 1,492,000~ 1,685,000	1,789,000 1,686,000~ 1,893,000	1,997,000 1,894,000~ 2,046,000	2,095,000 2,047,000~ 2,151,000	2,207,000 2,152,000 이상
3~5세	631,000 268,000~ 695,000	759,000 696,000~ 854,000	949,000 855,000~ 1,031,000	1,113,000 1,032,000~ 1,189,000	1,266,000 1,190,000~ 1,345,000	1,422,000 1,345,000~ 1,510,000	1,598,000 1,511,000~ 1,702,000	1,807,000 1,703,000~ 1,912,000	2,017,000 1,913,000~ 2,066,000	2,116,000 2,067,000~ 2,180,000	2,245,000 2,181,000 이상
6~8세	648,000 272,000~ 707,000	767,000 708,000~ 863,000	959,000 864,000~ 1,049,000	1,140,000 1,050,000~ 1,216,000	1,292,000 1,217,000~ 1,385,000	1,479,000 1,386,000~ 1,546,000	1,614,000 1,547,000~ 1,732,000	1,850,000 1,733,000~ 1,957,000	2,065,000 1,958,000~ 2,101,000	2,137,000 2,102,000~ 2,224,000	2,312,000 2,225,000 이상
9~11세	667,000 281,000~ 724,000	782,000 725,000~ 885,000	988,000 886,000~ 1,075,000	1,163,000 1,076,000~ 1,240,000	1,318,000 1,241,000~ 1,406,000	1,494,000 1,407,000~ 1,562,000	1,630,000 1,563,000~ 1,758,000	1,887,000 1,759,000~ 2,012,000	2,137,000 2,013,000~ 2,158,000	2,180,000 2,159,000~ 2,292,000	2,405,000 2,293,000 이상
12~14세	679,000 295,000~ 734,000	790,000 735,000~ 894,000	998,000 895,000~ 1,139,000	1,280,000 1,140,000~ 1,351,000	1,423,000 1,352,000~ 1,510,000	1,598,000 1,511,000~ 1,654,000	1,711,000 1,655,000~ 1,847,000	1,984,000 1,848,000~ 2,071,000	2,159,000 2,072,000~ 2,191,000	2,223,000 2,192,000~ 2,349,000	2,476,000 2,350,000 이상
15~18세	703,000 319,000~ 830,000	957,000 831,000~ 1,092,000	1,227,000 1,093,000~ 1,314,000	1,402,000 1,315,000~ 1,503,000	1,604,000 1,504,000~ 1,699,000	1,794,000 1,700,000~ 1,879,000	1,964,000 1,880,000~ 2,063,000	2,163,000 2,064,000~ 2,204,000	2,246,000 2,205,000~ 2,393,000	2,540,000 2,394,000~ 2,711,000	2,883,000 2,712,000 이상

전국의 양육자녀 2인 가구 기준

Жишиг хүснэгтийн хөндлөн шугам нь эцэг, эхийн нийт орлогын хэмжээ, босоо шугам нь хүүхдийн насыг заах бөгөөд 2 хүүхэдтэй өрхийг жишээ болгон тооцсон. Хамгийн бага тэтгэлгийн хэмжээ 450 ам.доллар (1,200,000 төгрөг орчим), Хамгийн их тэтгэлгийн хэмжээ 2,130 ам.доллар (7,630,000 төгрөг орчим) байна.

3.2 Хүүхэдтэй уулзах эрхийг дэмжих төв

Гэр бүл цуцлалтын дараа хүүхдийг асрамжлах эрхгүй эцэг, эхийн хүүхэдтэй уулзах эрхийг хангахын тулд 2014 онд Сөүл дэх Гэр бүлийн шүүх анх удаа “Хүүхэдтэй уулзах эрхийг дэмжих төв” байгуулсан ба өнөөдөр энэ төв нь улсын хэмжээний ихэнх Гэр бүлийн шүүхүүдэд байгуулагдсан байна. Тус төв нь эцэг,

эх хоорондын зөрчил маргаан хүүхдэд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлж, гэрлэлт цуцлалтын дараа ч эцэг, эх, хүүхдийн харилцаа тогтвортой үргэлжлэх боломжоор хангах бөгөөд төвийн үйл ажиллагаа нь гэр бүлийн хэргийн шинжээчийн мэргэжлийн ур чадвараас ихээхэн хамаардаг. Уг төвийн хэрэгцээ, шаардлага нэмэгдэж буйтай холбогдуулан 2024 онд Гүри хотод шинэ уулзалтын төв нээгдсэн.

3.3 Гэр бүлийн хэргийн шинжээчийн тоог нэмэгдүүлэх

Одоогийн байдлаар улс даяар ажиллаж буй гэр бүлийн хэргийн шинжээчийн тоо 200 орчим байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт бөгөөд Япон Улсад 1,600 гаруй шинжээч ажиллаж байна. Хоёр улсын хүн амын харьцааг харгалзан үзвэл (Япон Улс~120 сая, БНСУ~50 сая) бөгөөд БНСУ-д хамгийн багадаа 480 орчим шинжээч шаардлагатай гэсэн тооцоо гарч байна. Гэр бүлийн шүүхийн үүрэг нь зөвхөн гэрлэлт цуцлалт, хүүхэдтэй уулзах асуудлаар хязгаарлагдахгүй ба өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийлэл, **хүүхдийн асрамж тогтоолгох зэрэг өргөн хүрээг хамарч байгаа** тул шинжээчдийн орон тоог яаралтай нэмэгдүүлэх нь чухал асуудал болоод байна.

3.4 Гэр бүлийн шүүхийн “албадан эмчлэх” чиг үүргийг өргөжүүлэх нь

Сэтгэцийн өвчин болон төрөл бүрийн донтох эмгэгээс шалтгаалсан гэмт хэрэг нэмэгдэж байна. БНСУ-д “Мансууруулах бодистой холбоотой хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүх” байгуулах төлөвлөгөө байхгүй ч Гэр бүлийн шүүх тодорхой хэмжээнд энэ үүргийг гүйцэтгэж байна. Жишээлбэл, өсвөр насны хүнийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, хүүхдийн хүчирхийллээс урьдчилсан сэргийлэх тохиолдолд холбогдол бүхий этгээдийг сэтгэц эмчилгээний эмнэлэгт албадан эмчлүүлэх шийдвэр гаргах боломжтой. Гэвч ийм төрлийн мэргэшсэн эмнэлэг хангалтгүй байгаа нь томоохон хүндрэл болоод байна. Үүнийг шийдвэрлэх зорилгоор БНСУ-ын Засгийн газар өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зориулан дагнасан эмнэлэг байгуулах асуудлыг судалж байна.

3.5 Супер өндөр настны нийгэмд бэлдэх

65 ба түүнээс дээш насны хүн ам нийт хүн амын 20%-д хүрвэл тухайн улс “супер өндөр настны нийгэм” гэж тооцогддог. БНСУ нь 2024 оны 12 дугаар сараас эхлэн албан ёсоор энэ түвшинд хүрсэн. Ойролцоогоор 800,000 хүн насжилтаас шалтгаалсан сэтгэцийн хямрал буюу “зөнөх” өвчинд нэрвэгдээд байгаа нь “насанд хүрэгчдэд асрамжлагч тогтоох тогтолцоо”-ны ач холбогдлыг улам бүр нэмэгдүүлж байна. Энэхүү тогтолцоо нь сэтгэцийн эмгэг, өвчин, насжилт зэргээс шалтгаалан өөрийн хэрэг, гэрээ, өмч хөрөнгийн асуудлыг бие даан шийдвэрлэж чадахгүй болсон насанд хүрэгчдэд Гэр бүлийн шүүхээс хууль ёсны асрамжлагч тогтоох тогтолцоо юм. Ийм хэргүүд цаашид эрчимтэй өсөх төлөвтэй тул Гэр бүлийн шүүх нь мэргэшсэн шүүгч, шинжээчийн орон тоог нэмэгдүүлж, мэргэжлийн ур чадвартай хууль ёсны асран хамгаалагчдыг сургах, бэлтгэх ажилд түлхүү анхаарч ажиллаж байна.

“ГЭР БҮЛИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН СЭТГЭЛЗҮЙН ЭРҮҮЛ МЭНД”*

Карли Шревер,
“Human Ethos” захирал, University of Western
Australia-ийн Хуулийн тэнхимийн дэд профессор, (PhD),
Салли Раян “Human Ethos” захирал

Агуулга

-
- I. Өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй стресс гэж юу вэ?
 - II. Өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй стресс хэрхэн үүсдэг вэ?
 - III. Шүүхийн байгууллагад өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй стресс ямар хэлбэрээр илэрдэг вэ?
 - IV. Өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй стрессээс яаж хамгаалж чадах вэ?
-

* Энэхүү нийтлэлийг 2023 оны 06 сард Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн ‘Wellbeing Special Issue’ сэтгүүлд нийтлэгдсэн нийтлэлээс эш татсан болно.

“Би өөрийгөө бусдын өмнөөс сэтгэл зовох эмгэг (англ. *vicarious trauma*), болон удаан хугацааны туршид хуримтлагдсан сэтгэлзүйн гэмтэлд (англ. *cumulative trauma*) өртсөн гэдэгтээ итгэлтэй байна... Энгийн хүмүүсийн үзэж, сонсдоггүй зүйлсийг харж, сонсдог. Би сургуулийн арга хэмжээнд оролцох үед яагаад ч юм энд хэчнээн хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл гэртээ хүчирхийлэлд өртөж байгаа бол гэж боддог... Аав хүн ингэж бодох ёсгүй шүү дээ.”

Энэ бол Австрали Улсад хийгдсэн шүүгч нарын сэтгэлзүйн эрүүл мэндийн талаарх судалгаанд оролцсон шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын олон арван сэтгэгдлийн ердөө нэг нь бөгөөд шүүх ажиллагаанд өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй стресс (англ. *empathy based stress*) хэрхэн нөлөөлж байгааг харуулж байна. Энэхүү богино хэмжээний өгүүлэлд бид өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй стресс гэж юу болох, шүүгч нарт хэрхэн нөлөөлдөг талаарх асуудлыг хөндөж, улмаар уг асуудлыг хэрхэн зохицуулах тухай хэд хэдэн санааг дэвшүүллээ.

I. ӨРӨВДӨХ СЭТГЭЛЭЭС ҮҮДЭЛТЭЙ СТРЕСС ГЭЖ ЮУ ВЭ?

Эмпати буюу бусдын юу мэдэрч, туулж байгааг өөрийн сэтгэл хөдлөл болон танин мэдэхүйгээр (англ. *cognitively*) ойлгох чадвар нь энэхүү ойлголтын гол цөм юм. Хүний төрөлх зан байдлын энэхүү хариу үйлдэл нь бидэнд ажлаасаа авах сэтгэл ханамж, чин сэтгэлээ зориулан ажиллах боломжийг олгодог хэдий ч нөгөө талаараа ажлын байрны стресст өртөх эрсдэлийг бий болгодог.

“Өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй стресс”¹ гэдэг нь аливаа нөхцөл байдлын нөлөөллөөс үүдэлтэйгээр үүсэж буй сэтгэлзүйн хариу үйлдлийг хамарсан өргөн хүрээний ойлголт бөгөөд үүнд:

- Хоёрдогч буюу гэмтлийн дараах стрессийн эмгэг (STS) (англ. *Secondary traumatic stress*) – Бусдын хүнд хэцүү сэтгэлийн зовлонг мэдрэх эсхүл тухайн үйл явдлыг харснаас хойш илэрдэг эмгэг (сэтгэлзүйн хувьд тогтворгүй болох, гэмтлийн үеийн дурсамж дахин сэдрэх, түгшүүр мэдрэх PTSD-тэй төстэй шинж тэмдгүүд үүсч хөгжих явц)
- Бусдын өмнөөс сэтгэл зовох (англ. *vicarious trauma*) – Өөрийн аюулгүй байдал, өөрийгөө удирдах чадвар (англ. *self-agency*) болон ертөнцийг үзэх үзэлтэй холбоотой итгэл үнэмшил нь алдагдаж, хямралд орох
- Сэтгэл санааны гүн хямралд орох – Хүний сэтгэлзүйн байдал удаан хугацаанд муудах болон бусдыг ойлгох чадвар буурах
- Бие, сэтгэлийн тэнхээ барагдах (англ. *burnout*) – Сэтгэл санааны гүн ядаргаа, бусдаас тусгаарлагдсан байдал, болон амьдралаас авах сэтгэл ханах мэдрэмж буурах шинж тэмдэг илэрдэг.

Эдгээр асуудлууд нь шүүгч нарт тулгарах боломжтой мэргэжлийн эрсдэл

1 Рэйчел С.Раувола, Дуле М.Вега, Кристи Н.Лавин, Өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй ядаргаа, хоёрдогч буюу гэмтлийн дараах стресс ба далд гэмтэл: чанарын тойм, судалгааны хөтөлбөр”, (2019), №3, Хөдөлмөрийн эрүүл мэндийн сэтгүүл, 297-336.

болох (англ. *occupational hazards*) нь олон судалгаагаар нотлогдсон байна. Карли судлаачийн хийсэн судалгаагаар шүүхийн албан хаагчдын 30 орчим хувьд гэмтлийн дараах стрессийн эмгэгийн (STS) шинж тэмдэг гэмтлийн дараах сэтгэлзүйн эмгэг (PTSD)-ийн албан ёсны үнэлгээ хийлгэх шаардлагатай түвшинд хүртэл илэрчээ.² Энэхүү мэдээлэл нь дараагийн Нью Саут Уэльсийн (NSW)³ шүүхийн тогтолцоонд хийсэн судалгааны үр дүнтэй давхцахын зэрэгцээ, олон улсын хууль, эрх зүйн салбарын мэргэжилтнүүдэд мөн адил судалгаа хийхэд ижил үр дүн гарсан байна.

Бид шүүхийн байгууллагатай хамтран ажиллах явцдаа өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй стрессийн үндэс нь шүүгчийн ажлын байран дахь хүний сэтгэлзүйн хэмжээсийг ойлгоход тустай болохыг олж тогтоосон. Учир нь энэ ажил нэг талаасаа асар их сэтгэл ханамж өгөх боломжтой ч нөгөө талаасаа сэтгэлзүйн хувьд дарамттай байх эрсдэлтэй. Энэ нь хохирогчийн нөлөөллийн мэдүүлэг, гэрчийн мэдүүлгийг сонсох, график зураг, дүрс бичлэг үзэх, шүүх байгууллагын орчинд сэтгэл хөдлөл өндөртэй хүмүүсийн дунд удаан хугацааны турш ажиллах зэрэг нөхцөлд үүсдэг сэтгэл хөдлөлийн хүчтэй хариу үйлдлийг ойлгоход тусалдаг. Ийм нөхцөлд бидний өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй стрессийн хариу үйлдэл эрчимтэй өсөхийн зэрэгцээ оюуны хувьд нарийн төвөгтэй үүргийг хэрэгжүүлэх шаардлага давхар үүсдэг.

II. ӨРӨВДӨХ СЭТГЭЛЭЭС ҮҮДЭЛТЭЙ СТРЕСС ХЭРХЭН ҮҮСДЭГ ВЭ?

Өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй стресс нь гэмтлийн зэрэг болон өрөвч зангаар хандах байдлын (англ. *Empathic Engagement*) харилцан үйлчлэлээс бүрддэг. Гэмтэлд өртөх түвшин нь гэмтэлд ноцтой нөлөөлсөн эсэх, давтамж, бүтэц болон сэтгэлзүйн дэмжлэгийн хүртээмжээс тус тус хамаарна. Өрөвч зангаар хандах нь бид бусдын туулж өнгөрүүлсэн зүйлийг хэр зэрэг ойлгож, өөртэйгөө холбон мэдэрч байгаагаар тодорхойлогддог бөгөөд энэ нь бидний амьдралын түүх, амьдралын үе шатыг даван туулах арга барилаас хамаардаг.

Гэмтлийн зэрэг, өрөвч зангаар хандах байдал өндөр байх үед өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй стресс үүсэх эрсдэлд ордог. Хэрэв үүнд байгууллагын хангамж хангалтгүй, нөхөн сэргэх хугацаа бага байвал энэхүү стресс нь ажлаас халшрах хам шинж, сэтгэл гутрал, түгшүүр зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн ноцтой асуудалд хүргэж болно.

III. ШҮҮХИЙН БАЙГУУЛЛАГАД ӨРӨВДӨХ СЭТГЭЛЭЭС ҮҮДЭЛТЭЙ СТРЕСС ЯМАР ХЭЛБЭРЭЭР ИЛЭРДЭГ ВЭ?

Судалгаагаар, шүүгч өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй стресст өртөж байгаа явдал нь түүний мэргэжлийн онцлог, тухайлбал хийж гүйцэтгэж буй ажил, үүргээс ихээхэн хамаардаг хэмээн үзэж болохоор байна. Хэрэг хянан шийдвэрлэж буй

2 Карли Шревер, Кэрл Халберт, ба Таня Соурдин, “Шүүгчийн ажлын сэтгэлзүйн нөлөө: Австрали Улсын шүүгч нарын стресс ба сэтгэлзүйн эрүүл мэндийн анхны эмпирик судалгаа,” Шүүхийн захиргааны сэтгүүл 28, № 3 (2019): 141–68 дахь тал.

3 К. О’Салливан, Ж. Хантер, Р. И. Кемп, ба П. Вайнс, “Шүүхийн ажил ба сэтгэцийн гэмтэл: Гүтгэлэг, заналхийлэл ба шүүгчийн хоёрдогч гэмтлийн стресс,” Сэтгэл судлал, Нийтийн бодлого ба Хууль 28, №4 (2022): 532–45.

шүүгч нь ажилдаа хувь хүнийхээ өнцгөөс хандаж эхлэх тэр мөчөөс асуудал үүсдэг. Энэ нь тухайн хэрэгт хэт хувийн өнцгөөс хандах, ажил үүргээ өөртөө итгэлтэй гүйцэтгэх ур чадвар, мэдлэг дутмаг байх, эсхүл ажлын ачааллаас болж хямрах зэргээс хамаардаг байна. Ийм нөхцөлд шүүгч нар хэт эмзэг болох, айдас мэдрэх, нойргүйдэх, бие махбод, сэтгэл санааны ядаргаанд орох, огцом, ширүүн авирлах зэрэг шинж тэмдгийг мэдэрдэг талаараа бидэнд ярьдаг.

Гэр бүлийн шүүгч нар хянан шийдвэрлэж буй хэргийнхээ оролцогчид болон гэр бүлийн гишүүдийн оронд өөрийгөө тавьж бодох тохиолдол их байдаг ба энэ нь тэдний бусдын зовлонг ойлгох чадвар өндөртэй байхад нь нөлөөлдөг. Мөн тэд бусдад тохиолдсон хүнд, хэцүү явдлын талаар нарийн мэдээлэлтэй байдаг учраас түүний талаар хүсээгүй байхдаа ч төсөөлөн бодох тохиолдол гардаг. Энэ мэт зүйлс нь шүүгчийн хувийн болоод шударга ёсны, цаашлаад хорвоо ертөнцийн талаарх итгэл үнэмшил нь өөрчлөгдөхөд хүргэх боломжтойн дээр эдгээр асуудлууд далд байдлаар явагдаж болдог. Мөн тодорхой тохиолдлуудаас зайлсхийх, нийгэмшихийг хүсэхгүй байх, өөрийн болон мэргэжлийн үнэт зүйлстэй нийцэхгүй зан авир гаргах зэрэг нь зан үйлийн сөрөг үр дагавар үүсгэх боломжтой байдаг.

Аливаад сэтгэл хөдлөлөөр хандахгүй байхыг хичээх нь өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй стрессийг нэмэгдүүлэх эрсдэлтэй байдаг ба энэ нь шүүгчдийн хувьд шударга ёсыг баримтлах, хэрэгжүүлэхэд байнгын сорилт болдог. Тодруулбал, хэргийн оролцогчийн бүх зовлон, асуудлыг шийдэх хэрэгтэй мэт хэт их оролцох эсхүл хэргийн нарийн асуудлуудыг харгалзан үзэхээс зайлсхийн хэт бага оролцоотой байх эрсдэлтэй. Үүнээс гадна, шүүхийн ажилтан, туслах болон өмгөөлөгч нар дээрх асуудлуудад өртөх магадлалтай юм.

IV. ӨРӨВДӨХ СЭТГЭЛЭЭС ҮҮДЭЛТЭЙ СТРЕССЭЭС ЯАЖ ХАМГААЛЖ ЧАДАХ ВЭ?

Уг стресстэй холбоотой эрсдэлийн олонх нь өөрийн хамгаалалтын шинж чанарыг агуулсан хоёр талтай. Өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй стрессээс урьдчилан сэргийлэх, түүнд тохирсон хариу үйлдэл үзүүлэх тухай ойлголт нь аливаа хүн энэхүү стрессийн талаар мэдлэгтэй байх тухай, цаашилбал, хувь хүн буюу шүүгч болон түүний ажлын байр буюу шүүхийн байгууллага хоёрын хүлээх хариуцлагын тухай харилцан уялдаатай ойлголт юм. Түүнчлэн ажил болоод хувийн асуудлаа ялгах, мөн аливаад хил хязгаар тогтоож чаддаг байх нь нэн чухал юм.

Хувь хүн болохынхоо хувьд өөрсдийн сэтгэлзүйн өдөөгч хүчин зүйлсийг танин мэдэж, түүнийгээ удирдаж сурах, өөртэйгөө ярилцах болон хүнд байдалд байгаа гэр бүлийн гишүүд, сэтгэлзүйн гэмтэл авсан хүмүүсийг таньж мэдэх нь чухал юм. Мөн ажлын өдөр эхлэхээс өмнөх, ажлын үед болон ажил дуусах үед тус тусад нь тохирох төлөвлөгөө гаргах нь мэргэжлийн байдлаа алдахгүйгээр аливаа хуулийн асуудалд хандахад тусална. Ийм аргаар бид хүнд хэргүүд дээр ажиллаж байхдаа ч сэтгэлзүйн хувьд тогтвортой байж, стрессээс хамгаалагдах боломжтой болох юм. Мөн сэтгэл хөдлөлөө зохицуулах стратегиудыг эзэмших нь ажил мэргэжлийн үүднээс тогтвортой хандах суурь нөхцөл болдог.

Австрали Улсын дээд шүүхээс гаргасан Козаровд холбогдох хэргийн

шийдвэрт⁴ дурдсанаар, ажил олгогч нь ажилчдаа бусдын өмнөөс сэтгэл зовох сэтгэлзүйн хохирлоос хамгаалах (англ. *psychological harm of vicarious trauma*) үүргийг хүлээдэг. Энэхүү “Козаров”-ын шийдвэр нь шүүхийн ажилтнуудад хамаарах эсэх нь тодорхойгүй байгаа ч шүүх байгууллага нь ажлын байр болж байдгийнхаа хувьд шүүгчийн сэтгэлзүйн сайн сайхан байдлыг хамгаалах үүрэгтэй гэж үзэж болно.

Гэр бүл болон шүүхийн бусад оролцогчдыг ойлгож харьцах нь хуульчийн мэргэжлийн хувьд өрөвдөх сэтгэлээс үүдэлтэй стресст хүргэхгүй. Стресс учруулж болзошгүй ажлыг хийхдээ ажлын байран дахь эрсдэлийн удирдлага, боловсролын тасралтгүй байдал болон шүүхийн ажилтнуудад үүрэг гүйцэтгэхэд нь туслах нотолгоонд суурилсан стратегийг ашигласнаар сэтгэл ханамж нэмэгдэж, зорилго нь тодорхой болно. Карли судлаачийн хийсэн судалгаанд өөр нэг магистрант хэлэхдээ:

“Энэ бол сэтгэлзүй, оюун санааны хувьд олон сорилтыг агуулж байдаг ажил юм. Би хүмүүсийн төлөө санаа зовж, тэдэнд юу тохиолдох бол гэж боддог, тэд хэр зэрэг хүчирхийлэлд өртөж байгаад уурлаж болох ч гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгтэнд ч гэсэн зарим талаар өрөвдөх сэтгэлтэй ханддаг. Энэ нь магадгүй сайн зүйл гэж би бодож байна. Учир нь хүмүүс нарийн төвөгтэй, тэдний энэ үйлдлийг сонгох нөхцөл, боломжийг олж харж, судлах нь миний зорилго. Тиймээс би үргэлжлүүлэн судалж, хайж, олж, урамшуулж байх эрмэлзэлтэй. Энэ нь миний сэтгэл ханамжийн түвшин юм” гэжээ.

4 Заги Козарова ба Виктория муж [2022] НСА 12

“ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТАЛААР”

О.Оюунзул,
Хууль зүй, дотоод хэргийн яамны
Хууль зүйн бодлогын газрын Хувийн
эрх зүйн хэлтсийн дарга (LL.M)

Агуулга

I. Оршил

II. Үндсэн хэсэг

2.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”

2.2. Нийтийн болон хувийн эрх зүйн маргаан шийдвэрлэх ажиллагааны зарчим

2.3. Шүүхийн шатанд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэр бүлийн гэрлэлт цуцлах

2.4. Гэр бүлийн холбогдолтой зарим хэргийн талаар

2.5. Гэрлэлт цуцлалтын хэргийг шүүхээс шийдвэрлэхэд хүүхэдтэй холбоотой бусад асуудал

2.6. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлал

III. Дүгнэлт

Ном зүй

I. ОРШИЛ

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалтад Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх, 2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1 дэх заалтад Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийг тус тус байгуулахаар заасан.¹

Шүүх байгуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд тус зохицуулалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан.²

Ийнхүү энэхүү илтгэлээр гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгохтой холбогдуулан онцлох үзэл баримтлалын талаар танилцуулах болно.

II. ҮНДСЭН ХЭСЭГ

2.1 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” 12 дугаар бүлгээр гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулж байна.

Гэсэн хэдий ч уг бүлэг нь зөвхөн гэрлэлт цуцлуулах болон түүнтэй холбоотой хүүхдийн асрамж, тэтгэлэг гаргуулах гэх мэт нэхэмжлэлийн үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах журмаас бүрддэг буюу бусад гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааны төрлийг хамруулаагүй, гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх онцлог зохицуулалт дутмагшилтай байгаа болно.

Түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд “гэр бүлийн холбогдолтой хэрэг”, “гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан” гэхчилэн нэр томьёоны хувьд өөр өөрөөр заасан байдаг бөгөөд зарим гэр бүлийн холбогдолтой хэрэг болох эцэг, эх тогтоох, эцэг, эх байх эрхийг хасах, хязгаарлах, сэргээх, хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох зэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэдэг бөгөөд гэр бүлийн холбогдолтой хэрэг гэх ойлголтод хамаарахгүй байна.

Олон улсын туршлагаас үзвэл, 1949 онд Япон Улсад байгуулагдсан Гэр бүлийн дагнасан шүүх нь Азийн хамгийн анхны Гэр бүлийн дагнасан шүүх болж байгуулагдаж байсан. Дагнасан шүүхтэй тул Personal Status Litigation Act буюу Гэр бүлийн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэх хуулиар процесс ажиллагааг нь

1 Шүүх байгуулах тухай хууль (2025)-ийн 1 дүгээр зүйлийн 3.1 “Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх”

2 Шүүх байгуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль (2024)-ийн 5 дугаар зүйл “Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө”

зохицуулдаг байна.³

Үүний дараа БНСУ-д 1963 онд Сөүл хотын Гэр бүлийн дагнасан шүүх байгуулагдсан нь Япон Улсын дараа орох анхны Гэр бүлийн дагнасан шүүх болно. Тус шүүх нь *Family Litigation Act* буюу Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх бие даасан хуулийн дагуу хэргийг шийдвэрлэдэг. Ингэхдээ гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог зохицуулалтыг уг хуульд тусгасан байх ба уг хуульд зохицуулаагүй харилцааг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиар зохицуулдаг.⁴

Эдгээр Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиудад гэр бүлийн холбогдолтой хэрэг гэдэгт гэрлэлт цуцлалт, түүнтэй холбоотой хүүхдийн тэтгэлэг гаргуулах, хүүхдийн асрамжийг хэнд үлдээх, дундын хөрөнгийг хуваах зэрэг хэргээс гадна үрчлэлт, асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоох, хүчингүй болгох, эцэг, эх тогтоох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бусад тооцох зэрэг олон төрлийн хэргийг хамруулдаг байна.⁵

Мөн БНСУ-ын хувьд *litigious cases* буюу маргаан бүхий, *non-litigious cases* буюу маргаангүй хэрэг гэж нийт харьяаллын хэргийг 2 ангилж, 5 дэд хэсэгт хувааж жагсаасан. Товчхондоо маргаантай хэрэг, маргаангүй хэрэгт ялгамжтай процессын журам хэрэглэгддэг бөгөөд маргаантай хэрэгт иргэний процессын хуулийн зохицуулалт, маргаангүй хэргийг *Non-Contentious Case Procedure Act* буюу Маргаангүй хэргийг шийдвэрлэх процессын хуулиар зохицуулдаг.

А, В, С ангиллын хэргүүд нь маргаантай хэрэг тул *conciliation-precondition principle* буюу эвлэрүүлэн зуучлалаар тэргүүн ээлжид орох зарчим хэрэгждэг. Эдгээр хэрэгт гэрлэлт цуцлалт, гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бусад тооцох, үрчлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох, тэдгээрийн улмаас учирсан хохирлыг төлүүлэх, хамтын амьдрал байсан эсэх зэрэг хэрэг ордог.

Харин D, E ангиллын хэрэг маргаангүй хэрэг буюу сураггүй алга болсонд тооцох, хүчингүй болгох, дундын хөрөнгө хуваах зэрэг нь маргаангүй хэрэгт орох боловч хэрэв маргаантай хэргийн хэсэг дэх гэрлэлт цуцлалтын нэхэмжлэлтэй хамт дундын хөрөнгө хуваах нэхэмжлэл гаргасан бол эвлэрүүлэн зуучлалаар орж, нэг процессоор нэгтгэн шийдвэрлэж болдог.

Иймд гэр бүлийн холбогдолтой хэргийн төрлийг өргөжүүлж, ангилан, онцлогт нь тохирсон процессыг боловсронгуй болгох шаардлагатай байгаа болно.

2.2 Нийтийн болон хувийн эрх зүйн маргаан шийдвэрлэх ажиллагааны зарчим

Нийтийн болон хувийн эрх зүйн маргаан шийдвэрлэх ажиллагааны зарчим

3 Япон Улсын эрх зүйн мэдээллийн Англи хэл дээрх систем: <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4178/en>

4 Бүгд Найрамдах Солонгос Улсын эрх зүйн мэдээллийн Англи хэл дээрх систем: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=1081&lang=ENG

5 *Personal Status Litigation Act Japan (2003)*, Art 2. *Family Litigation Act (2007)*, Art 2.

ялгаатай хэдий ч гэр бүлийн холбогдолтой хэрэгт диспозитив зарчмаас гадна хүүхдийн хууль ёсны дээд эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс шүүх өөрийн санаачилгаар гэр бүлийн хэргийн шинжээч (*family investigator*)-ээр нөхцөл байдлыг шалгуулж, дүгнэлт гаргуулах ач холбогдол бүхий зохицуулалт байдаг.

Тухайлбал, БНСУ-д Гэр бүлийн шүүх эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахаас өмнө болон шүүхэд гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ гэр бүлийн нөхцөл байдлын талаар шалгах ажиллагааг гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчээр дамжуулан явуулдаг.⁶

Энэхүү нөхцөл байдлыг шинжлэх ажиллагаа (*fact finding*)-ны хүрээнд шүүгч шаардлагатай гэж үзвэл цагдаагийн байгууллага, захиргааны байгууллага болон бусад байгууллага, эсхүл хувь хүнээс (банк, сургууль гэх мэт) гэрлэгчдийн дансны мэдээлэл, хөрөнгийн байдал, орлого, боловсролын байдал болон бусад шаардлагатай мэдээллийг нягтлан шалгаж болох бөгөөд захирамж гарган шинжээч томилон шалгуулна.⁷ Шинжээч нягтлан шалгаж, хэрхэх арга замыг санал болгох үүрэгтэй буюу шүүгч шийдвэрээ гаргахад шаардлагатай нөхцөл байдлыг тал талаас нь судална.

Энэхүү шинжээч нь хуульч бус аль ч талд орохгүй хараат бусаар олон талт асуудлыг тал бүрээс нь судлах үүрэгтэй бөгөөд нийгмийн ухаан, сэтгэлзүй, боловсрол зэрэг чиглэлийн магистрын зэрэгтэй байх шаардлага тавигддаг.⁸

БНСУ-ын хувьд гэрлэлт цуцлалт, үрчлүүлэх, асран хамгаалах шийдвэр гаргах зэрэг олон хэрэгт энэхүү шинжээчийн нөхцөл байдлыг шинжлэн судалсан үнэлгээг ашигладаг.⁹

Мөн БНСУ-д шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, нөхцөл байдлын шинжээч нь төрийн байгууллагад мэдээлэл гаргаж, нөхцөл байдлыг шинжлэн судлуулахыг үүрэг болгож болдог, тухайлбал цагдаа зэрэг төрийн байгууллагад энэ нөхцөл байдлыг шинжлэн судлахыг даалгаж, нөхцөл байдлын үнэлгээний тайланг гаргуулж авч болдог.¹⁰

ХБНГУ-д шүүх гэр бүлийн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэх үндэслэл болох нөхцөл байдлыг тогтоох зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зарим шаардлагатай шалгах ажиллагааг явуулах ёстой.¹¹

Манай улсын хувьд холбогдох процесс хуульд энэ талаар зохицуулалт байхгүй ч Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан нөхцөл байдлын үнэлгээг хийлгүүлж, гэрлэлт цуцлахад нотлох баримтаар авч үзэж байгаа практик байна. Хуулийн төслөөр гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлах үе шатыг бий болгож, шүүгч шаардлагатай тохиолдолд захирамж гарган ач холбогдолтой нөхцөл

6 БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйл, 56 дугаар зүйл.

7 БНСУ-ын ГБХМХШТХ-ийн 8 дугаар зүйл. БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 3 дугаар зүйл (Дээд шүүхийн журам).

8 IDLO зөвлөх Hyoung-ryul, KIMPresiding Judge, Seoul Family Court-ийн хуулийн төсөл боловсруулахад өгсөн зөвлөмж (2025).

9 IDLO зөвлөх Hyoung-ryul, KIMPresiding Judge, Seoul Family Court-ийн хуулийн төсөл боловсруулахад өгсөн зөвлөмж (2025).

10 БНСУ-ын ГБХМХШТХ-ийн 9 дүгээр зүйл.

11 ХБНГУ-ын Иргэний процессын хуулийн 125 дугаар зүйл.

байдлыг тогтоолгох онцгой эрхийг тусгах шаардлага үүссэн.

Ингэснээр гэрлэлт цуцлахад хүүхдийг хэний асрамжид нь үлдээх, хүүхдийг үрчлүүлэх эсэхийг бодит нөхцөлийг судлан хүүхдийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэрлэх боломж бүрдэнэ.

2.3 Шүүхийн шатанд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэр бүлийн гэрлэлт цуцлах

Шүүхийн шатанд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэр бүлийн гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг хүлээн авахдаа аливаа шаардлага, цензур, холбогдох нотлох баримтыг шаардаж шалтаг заан буцаахгүй байхад анхаарах хэрэгтэй байгааг судлаачид онцолжээ.¹²

Хүчирхийлэл үйлдэгдсээр байтал нотлохыг шаардаж, гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг хүлээж авахгүй байх талаарх ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсэг, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг нь тус тус хүүхдийн болон гэр бүлийн гишүүдийн эрх, эрх чөлөөг хязгаарласан зохицуулалт болсон. Ийнхүү хязгаарлах нөхцөл нь эдгээр хуулийн зохицуулалт зорилгодоо нийцэхгүй байгааг илтгэж байна.

Иймд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй бол заавал нотлох баримт шаардахгүйгээр хүсэлтийг авч эвлэрүүлэн зуучлалаар орохыг шаардахгүй болгох шаардлага үүссэн.

Мөн түүврийн аргаар Shuukh.mn хуудаснаас гэрлэлт цуцлалттай холбоотой 5 хэргийг түүж судлахад дараах дүр зураг ажиглагдаж байна. Үүнд:

Гэрлэлт цуцлах шалтгаан гэрлэгчид тусдаа амьдарсны улмаас гэрлэлтээ цуцлах болсон. Гэрлэлт цуцлах асуудлаар шүүхийн Эвлэрүүлэн зуучлагчид хандаж байсан боловч эвлэрлийн ажиллагаа амжилтгүй болсон байна. Нотлох баримт хэргийн оролцогчид өөрсдөө нотлох баримтаар тайлбар, гэрлэлтийн лавлагаа зэргийг гаргасан. Шүүхээс нотлох баримт гаргаагүй байна.¹³

Гэрлэлт цуцлах шалтгаан зан харьцааны хувьд таарч тохирохгүй нөхрийн архи уудаас болж тусдаа амьдарснаар салах болсон. Нотлох баримтаар талуудын өөрсдийн гаргасан гэрлэлтийн гэрчилгээ, зохигчийн тайлбар, хүүхдийн гэрчилгээний хуулбар зэрэг материал авагдсан бөгөөд шүүхээс нотлох баримт цуглуулаагүй. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсан боловч гэрлэгчид эвлэрээгүй байна.¹⁴

Зан харилцааны таарамжгүй байдлаас тус тусын амьдралтай болсон. Нотлох баримтаар зохигчдын гаргасан гэрлэлтийн гэрчилгээ, хүүхдийн гэрчилгээ, тайлбар

12 Б.Дугармаа, Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, Хууль дээдлэх ёс, №4, 2019, 112 дахь тал.

13 Сэлэнгэ аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2020 оны 12 сарын 30 өдрийн 148/ШШ2021/00005 дугаар шийдвэр, https://shuukh.mn/single_case/100666?daterange=2020-01-01%20-%202025-08-27&id=1&court_cat=1&bb=1

14 Орхон аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2019 оны 12 сарын 25 өдрийн 142/ШШ2020/00019 дүгээр шийдвэр, https://shuukh.mn/single_case/96769?daterange=2019-01-01%20-%202025-08-27&id=1&court_cat=1&bb=1

зэрэг авагдсан. Шүүхээс баримт цуглуулаагүй. Шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлэн зуучлалын арга хэмжээ амжилтгүй болсон буюу эвлэрээгүй.¹⁵

Хариуцагч өөр хүнтэй хамтран амьдрах болсон учир салах болсон байна.

Эвлэрүүлэн зуучлал дуусгавар болсон эвлэрээгүй. Талууд гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа, хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар нотлох баримтаар гаргаж өгсөн. Шүүхээс нотлох баримт цуглуулаагүй.¹⁶

Тусдаа амьдарсны улмаас гэрлэлт цуцлах шалтгаан болсон. Эвлэрлийн ажиллагаа амжилтгүй болсон. Нотлох баримтаар гэрлэлт бүртгэлийн лавлагаа, тайлбар авагдсан. Шүүхээс баримт цуглуулаагүй.¹⁷

Дүгнэхэд, түүврийн аргаар сонгосон 5 шийдвэрийн 2 нь тусдаа амьдралтай болсон, 2 нь зан харилцаа таарахгүй, 1 нь өөр хүнтэй хамтран амьдрах шалтгааны улмаас гэрлэлт цуцалсан байна. 5 шийдвэрийн хувьд бүгдэд нь эвлэрүүлэн зуучлалаар орсон боловч амжилтгүй болж, шүүхээс гэрлэлтийг цуцалсан байна. Мөн бүх шийдвэрт талууд нотлох баримт гэж лавлагаа гаргаж, шүүхээс огт материал цуглуулж, шалгалт хийгээгүй болно.

Иймд тусдаа амьдраад тодорхой хугацаа өнгөрсөн бол эвлэрүүлэн зуучлал шаардахгүй байхаар тусгах шаардлага үүссэн.

2.4 Гэр бүлийн холбогдолтой зарим хэргийн талаар

Гэр бүлийн холбогдолтой зарим хэргийн талаар зөвхөн талууд бус сонирхогч тал хүсэлт гаргах боломжийг хуульчлах шаардлага үүсэж байна.

ИХШХШТХ-ийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэгч гэж хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргагч этгээдийг хэлэх бөгөөд гэр бүлийн холбогдолтой хэрэгт зөвхөн хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргагч л нэхэмжлэл гаргаж болно.

Харин онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэдэг хэргүүд болох тухайлбал, эцэг, эх байх эрхийг хасах, хязгаарлах, сэргээх, гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох зэрэг нь сонирхогч талын хүсэлтээр эхэлдэг боловч гэр бүлийн холбогдолтой хэрэгт хамаардаггүй.

Бусад улсын туршлагаас үзвэл, БНСУ, Япон Улсын хувьд, гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох, гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваах, гэрлэлттэй адилтгах харилцаанд гэр бүлийн дундын эд хөрөнгө

15 САДСДАШШ-ийн 2017 оны 12 сарын 13 өдрийн 148/ШШ2017/00648 дугаар шийдвэр, https://shuukh.mn/single_case/153423?daterange=2017-01-01%20-%202025-08-27&id=1&court_cat=1&bb=1

16 Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 12 сарын 27 өдрийн 102/ШШ2017/00041 дүгээр шийдвэр, https://shuukh.mn/single_case/51539?daterange=2016-01-01%20-%202025-08-27&id=1&court_cat=1&bb=1

17 САДСДАШШ-ийн 2020 оны 12 сарын 30 өдрийн 148/ШШ2021/00005 дугаар шийдвэр, https://shuukh.mn/single_case/100666?daterange=2020-01-01%20-%202025-08-27&id=1&court_cat=1&bb=1

хуваахтай адил зарчмаар хуваах, үрчлүүлэх, үрчлэлтийг хүчингүйд тооцох, асран хамгаалагчийг томилох, эцэг эх байх эрхийг хасах, хязгаарлах, сэргээх, тэжээн тэтгэх, тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, хүүхдийн хуваарьт хөрөнгийг зориулалтын бусаар ашиглах зэргийг гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай бие даасан хуулиараа зохицуулж байна.

Мөн эдгээр төрлийн нэхэмжлэлүүдэд гэрлэгчид төдийгүй, хүүхэд, төрөл садны хүн, прокурор, орон нутгийн байгууллага зэрэг сонирхогч этгээд нэхэмжлэл гаргах эрхтэй буюу гуравдагч этгээдийн нэхэмжлэл гаргах эрх, түүнчлэн шүүх өөрийн санаачилгаар авч болох арга хэмжээ, тухайлбал нөхцөл байдлын шинжилгээ хийлгүүлэх, бусад этгээдээс баримт, нотолгоо шаардах зэргийг тусгажээ.

Сонирхогч талын нэхэмжлэх эрхийг бий болгосноор тухайн маргааны улмаас хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдсөн байдлыг цаг алдалгүй мэдэгдэх ач холбогдолтой зохицуулалт байдаг тул энэ талаарх зохицуулалтыг холбогдох нэхэмжлэлийн төрөлд бий болгох шаардлагатай байна.

2.5 Гэрлэлт цуцлалтын хэргийг шүүхээс шийдвэрлэхэд хүүхэдтэй холбоотой бусад асуудал

Гэрлэлт цуцлалтын хэргийг шүүхээс шийдвэрлэхэд хүүхэдтэй холбоотой бусад асуудлыг заавал хамтад нь шийдвэрлэж, гэрлэлт цуцлалтаас үүдэж хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх шаардлага үүссэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн шинэчилсэн мэдээллээр, 2021 онд 45,444 иргэний хэрэг шийдвэрлэснээс Гэр бүлийн тухай хуулиар 4690 буюу нийт иргэний хэргийн 10.3 хувийг, 2022 онд нийт шийдвэрлэгдсэн 57,633 иргэний хэргийн 6263 буюу 10.8 хувийг, 2023 онд шийдвэрлэгдсэн нийт 63,407 иргэний хэргийн 5913 буюу 9.3 хувийг Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн иргэний хэрэг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл, *Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэгдсэн иргэний хэргийн 5 жилийн дундаж нийт иргэний хэргийн 10.1 хувь* байна.

Монгол Улсын хэмжээнд 2016 онд 16,8 мянган хос, 2017-2019 онд жилдээ 20,0-21,0 мянган хос гэрлэлтээ бүртгүүлж байсан бол 2020, 2021 онд тус бүр 14,2 ба 16,1 мянга болж буурчээ. Түүнчлэн 2016 онд 4,0 мянган гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан бол 2020, 2021 онд тус бүр 3,3, 3,4 мянга болж буурчээ.

Харин 2022 онд 17694 хос гэрлэлтээ бүртгүүлсэн бол 4515 гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулсан байна. 2023 оны 1-10 дугаар сард 15,128, 2024 оны мөн хугацаанд 11,186 гэрлэлт бүртгэлт бүртгэгдэж, тус бүр 4102 ба 3692 гэрлэлт цуцалсны бүртгэл бүртгэгджээ.¹⁸

Эндээс *нийт гэрлэлтийн бүртгэлд оногдох гэрлэлт цуцлалтын хувь хэмжээ 27-33 хувь* байна гэж дүгнэж болохоор байна.

Түүнчлэн гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг 2020 онд 2176 шийдсэн бол мөн онд хүүхдийн тэтгэлэг гаргуулах тусдаа нэхэмжлэлийг 1333-ыг шийдсэн, 2021 онд гэрлэлт цуцлуулах 2823 хэргийг, хүүхдийн тэтгэлэг гаргуулах 1297 хэргийг

¹⁸ Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан ёсны цахим хуудас, <https://burtgel.gov.mn> (Сүүлд үзсэн: 2025.08.27).

тус тус шийдвэрлэснийг харвал гэрлэлт цуцлуулахад хүүхдийн асуудлыг хамтад нь заавал шийдвэрлэхгүй байна.¹⁹

2017 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, 10 шийдвэр буюу 20 хувь нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэж, 40 шүүхийн шийдвэр буюу 80 хувь нь хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлээгүй гаргасан байна.

2022 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, хүүхдийн тэтгэлэг гаргуулж шийдвэрлэсэн 5 шүүхийн шийдвэр буюу 10 хувь, 45 шүүхийн шийдвэр буюу нийт шүүхийн шийдвэрийн 90 хувь нь хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлэлгүй орхигдуулсан байна.²⁰

Бусад улсын туршлагаас үзэхэд, тухайлбал, БНСУ-д гэрлэлт цуцлуулахад нэхэмжлэгч нэхэмжлэл гаргаагүй ч шүүх өөрийн санаачилгаар хүүхдийн эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах үүднээс тэжээн тэтгэх, тэтгэлгийн асуудлыг заавал шийддэг.²¹

Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулах үед хүүхдийг тэжээн тэтгэх асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд харилцан тохиролцож чадаагүй бол Гэр бүлийн шүүх нэхэмжлэлийн дагуу, эсхүл өөрийн санаачилгаар тэжээн тэтгэхтэй холбоотой шийдвэр гаргана. Үүнд:²²

1. Тэтгэлэг төлөгчийг тогтоох;
2. Тэтгэлгийн хэмжээг тогтоох;
3. Өсвөр насны хүнтэй уулзах эрх, уулзалтын арга хэлбэрийг тогтоох.

Гэр бүлийн шүүх нь тэжээн тэтгүүлэгчийн ирээдүй, хэрэгцээ шаардлагыг харгалзан шаардлагатай гэж үзвэл эцэг, эх болон тэжээн тэтгүүлэгч, прокурорын хүсэлтээр мөн өөрийн санаачилгаар тэжээн тэтгэх асуудлыг өөрчлөх, түүнтэй холбоотой бусад арга хэмжээг авч болно.²³ Ийнхүү цуцлахдаа заавал хүүхдийн хууль ёсны асран хамгаалалт, тэжээн тэтгэх тухай тохиролцоог баталгаажуулсан шийдвэрийг гаргадаг.

ХБНГУ-д гэрлэлт цуцлуулах тухай болон гэр бүлийн бусад маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг хамт явуулна. Гэр бүлийн бусад маргаанд тэтгэвэр хуваах, өсвөр насны хүний тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой асуудал, мөн хуульд заасан тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой маргаан, гэр бүлийн хөрөнгийн маргаан, гэр бүлийн оршин суух газрын талаарх маргаан зэргийг ойлгоно.^{6 24}

19 Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны албан бичгээр ирүүлсэн статистик тоо мэдээ.

20 Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 19 дэх тал.

21 БНСУ-ын ГБХМШтХууль, 1991 он.

22 БНСУ-ын Иргэний хуулийн 837 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг.

23 БНСУ-ын ИХ-ийн 837 дугаар зүйлийн 5 дахь хэсэг.

24 ХБНГУ-ын Иргэний процессын хуулийн 133 дугаар зүйл.

Хүүхдийн оршин суух газар, хүүхэдтэй уулзах, шилжүүлэн авах болон эцэг тогтоох зэрэг хүүхдийн эрх ашиг сонирхолд шууд нөлөөлөхүйц ажиллагааг тэргүүн ээлжид яаралтай шийдвэрлэнэ.²⁵

2.6 Шүүх дэх эвлэрүүлэн зуучлал

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар гэрлэгчид шууд утгаар эвлэрэхээс гадна гэрлэлт цуцлалттай холбоотой бусад асуудал болох хүүхдийн асрамж, уулзах цаг, хүүхдийн тэтгэлэг, эд хөрөнгө хуваах асуудлыг тохиролцох боломжтой байдлаар тусгах шаардлага үүссэн.

ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна.” гэж, 132 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ хуулийн 132.1-д заасан эвлэрүүлэх арга хэмжээг зөвхөн нэг удаа хэрэглэнэ. Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон байх нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн маргааны талаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас татгалзах үндэслэл болохгүй.” гэж заасан нь гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргасан гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсоноос бусад тохиолдолд заавал шүүхийн шатанд, гэрлэлт цуцлуулахгүй буюу бодит утгаар эвлэрэхэд чиглэсэн ажиллагаа явагдсаны дараа шүүх иргэний хэрэг үүсгэхэд хүргэсэн байна.

Мөн үүнээс өмнө Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зохицуулалт нь шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулж, амжилтгүй болсон ч шүүхэд хандаад дахин эвлэрүүлэн зуучлалаар орох давхар эвлэрүүлэн зуучлалаар орох шаардлагыг харуулж байна.

Тодруулбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 129 дүгээр зүйлийн 1.7 дахь заалтад “Шүүгч шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэхдээ зохигчид эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрэх хугацаа заах арга хэмжээг урьдчилан авахаар захирамж гаргаж болно” гэж, мөн хуулийн 132 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Гэрлэгчид шүүхээс эвлэрүүлэх арга хэмжээ авсан хугацаанд эвлэрээгүй бол шүүгч гэрлэлтийг цуцлах шийдвэр гаргана” гэж зааснаас харахад заавал шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалд орох, ингэж орох зорилго нь цуцлуулах нэхэмжлэлтэй гэрлэгчдийг гэрлэлтээ цуцлуулахгүй байх буюу бодит утгаараа эвлэрүүлэхэд чиглэж байна.

Ингэснээр гэрлэлт цуцлалтын тохиролцоог талууд эвлэрүүлэн зуучлалын үе шатанд хийлгүйгээр эвлэрүүлэн зуучлалын хугацаа өнгөрөх, шүүх өөрөө үүний дараа шууд цуцлан хүүхдийн болон эд хөрөнгийн асуудлаар шийдвэр гаргахаар байна.

Энэ нь гэр бүл нь аливаа нийгмийг бүрдүүлэгч суурь нэгж, үнэт зүйл болохын хувьд төрөөс гэр бүлийн тогтвортой байдал, хүүхдийн тасралтгүй хөгжил, хүмүүжлийг хадгалах бодлогыг баримтлан гэрлэлтийг шүүхээс аль болох

²⁵ ХБНГУ-ын ИПХ-ийн 151 дүгээр зүйл.

шууд цуцлахгүйгээр эвлэрүүлэх арга замыг эрэлхийлжээ.²⁶

Гэтэл 2018 онд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд гэр бүлийн эрх зүйн маргааны 2995 өргөдөл ирсэн бөгөөд үүнээс 412 өргөдөл буюу 13.6 хувьд нь амжилттай эвлэрсэн, 2019 онд гэр бүлийн эрх зүйн маргааны 3020 өргөдөл ирснээс 377 өргөдөл буюу 12.4 хувьд нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай явагдсан байна.²⁷ Эндээс үзэхэд, **77 хувьд нь гэр бүлийн эрх зүйн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй явагддаг** байна.

Гэрлэлт цуцлах маргааны тухайд, 2020 онд 3015 маргааныг эвлэрүүлэн зуучлалд шилжүүлснээс 88 хувьд нь **амжилтгүй буюу 353-т нь буюу 12 хувьд нь л амжилттай эвлэрсэн** байна. 2021 онд **3861 гэр бүлийн хэргийг эвлэрүүлэн зуучлалд шилжүүлснээс 88 хувьд нь амжилтгүй эвлэрээгүй** байна.

Мөн Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт “Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдээ хэний асрамжид үлдээх, түүнийг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө хуваах тухайгаа бие даан, эсхүл эвлэрүүлэн зуучлалын журмаар харилцан тохиролцож болно.” гэж зааснаас харахад эвлэрүүлэн зуучлалаар цуцлуулахтай холбоотой хүүхэд, хөрөнгийн асуудлаа шийдвэрлэж болох байдлаар тусгажээ.

Бусад улсын туршлагаас үзэхэд, БНСУ-ын хувьд, шүүхийн журмаар цуцлуулах нэхэмжлэл гаргахад эвлэрүүлэн зуучлалаар заавал орохыг шаарддаг бөгөөд хэрэв ороогүй бол шүүхээс эвлэрүүлэн зуучлалд шилжүүлдэг боловч агуулга нь бодит байдлаар эвлэрч цуцлуулахгүй байхад биш **эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад талууд гэрлэлтээ цуцлуулах тохиролцоонд хүрэхээр зорьдог**. Энэ нь шүүхийн шатанд эвлэрсэнтэй адилд тооцогдож, цуцлалттай холбоотой хүүхэд, эд хөрөнгийн асуудлаар тохиролцсоноор гэрлэлтийг цуцалдаг.

Япон Улсын хувьд²⁸ гэрлэлтийг харилцан тохиролцох буюу захиргааны журмаар шүүхэд хандах, шүүхийн журмаар цуцлах гэж 2 төрлийн журам байдаг.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах ч гэрлэлт цуцлуулах тохиролцоонд хүрч болдог. Өөрөөр хэлбэл, талууд бодитоор гэрлэлтээ цуцлахгүй болж эвлэрэхэд биш гэрлэлт цуцлалтаа эвийн журмаар хийж, хүүхэд, эд хөрөнгийн асуудлаа эвээр тохиролцож, гэрлэлтээ цуцлахад эвлэрүүлэн зуучлалын зорилго нь чиглэж байна.

Эвлэрүүлэн зуучлагч шүүгч, эвлэрүүлэн зуучлагчаа чиглүүлэх, эвлэрүүлэн зуучлагч эвлэрэх тохиролцоог хийлгэх, хэрэв эвлэрвэл уулзалтыг эвлэрүүлэн зуучлагч шүүгчийг оролцуулан хийж шийдвэр гаргах, харин эвлэрэхгүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлдэг БНСУ, Япон Улсын туршлагаас тодорхой хэмжээнд нутагшуулж, үнэхээр цуцлах шийдвэрт хүрсэн гэрлэгчдийг эвийн журмаар маргаанаа шийдвэрлэхэд хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүгч эвийн тохиролцоо хийлгүүлж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэх, үүнээс өмнөх шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч нар мэргэшсэн, гэр бүлийн хэргээр дагнасан байх

26 Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа” (Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ), 2022/01. 259 дэх тал.

27 Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг ТББ, “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа”, 2020, 59 дэх тал.

28 Япон Улсын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль.

нөхцөлийг авч үзэх шаардлагатай байна.

III. ДҮГНЭЛТ

Хуулийн төсөл батлагдсанаар гэр бүлийн холбогдолтой хэргийг хүүхдийн эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах буюу гэрлэгчдийн цуцлалт, эцэг, эх байх эрх хасах, хязгаарлахад хүүхэд хохирохгүй үлдэх, хүүхэдтэй холбогдолтой асуудлыг гэрлэлт цуцлах болон холбогдох бусад гэр бүлийн холбогдолтой хэргийг шийдвэрлэхэд нэхэмжлэл гаргасан эсэхээс үл хамаарч заавал шийддэг болох, зарим төрлийн гэр бүлийн хэрэгт хүүхдийн эрх, ашиг сонирхлын төлөө нөхцөл байдлыг нь шинжлэн судалсны үндсэн дээр хүүхэдтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргах, хүүхэд, гэр бүл сэтгэлзүйн зөвөлгөө авах, шүүгч, эвлэрүүлэн зуучлагч нар гэр бүлийн эрх зүйгээр цаашид дагнасан, мэргэшсэн болох, цаашлаад эцэг, эхийн хүүхдийн өмнө хүлээх гэр бүлийн хариуцлага дээшлэхэд эерэгээр нөлөөлөх зэрэг эерэг үр дагавар бий болгоно гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Шүүх байгуулах тухай хууль, 2025 он.
2. Шүүх байгуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2024 он.
3. Сэлэнгэ аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2020 оны 12 сарын 30-ны өдрийн 148/ШШ2021/00005 дугаар шийдвэр,
4. Орхон аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2019 оны 12 сарын 25-ны өдрийн 142/ШШ2020/00019 дүгээр шийдвэр,
5. САДСДАШШ-ийн 2017 оны 12 сарын 13-ны өдрийн 148/ШШ2017/00648 дугаар шийдвэр,
6. Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 12 сарын 27-ны өдрийн 102/ШШ2017/00041 дүгээр шийдвэр,
7. САДСДАШШ-ийн 2020 оны 12 сарын 30-ны өдрийн 148/ШШ2021/00005 дугаар шийдвэр,

Б. Ном, сурах бичиг

1. Б.Дугармаа, Гэр бүлийн эрх зүй, 2016 он.
2. Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүйн онолын асуудал, 2018 он.
3. SA RINA, Шүүхийн журмаар гэрлэлт цуцлалтаас үүсэх хүүхдийн эрхийг хамгаалах тулгамдсан асуудал шийдэл, 2023 он.

В. Эрдэм шинжилгээний бүтээл

4. Б.Дугармаа, Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, №4, 2019 он.
5. Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ.
6. Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа”, 2022 он.
7. Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг ТББ, “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа” 2020 он.

Г. Бусад

1. Шүүхийн ерөнхий зөвлөл, Статистик тоон мэдээ, 2024 он.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:

А. Солонгос хэл дээр

1. БНСУ-ын Иргэний хууль, 2013 он.
2. БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль, он.
3. Hyoung-ryul, KIM Presiding Judge, Seoul Family Court-ийн хуулийн төсөл боловсруулахад өгсөн зөвлөмж, 2025 он

Б. Япон хэл дээр

1. Personal Status Litigation Act Japan (2003)
2. Family Litigation Act (2007)
3. Япон Улсын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль, 2003 он.

В. Герман хэл дээр

1. ХБНГУ-ын Иргэний процессын хууль, 1950 он.

3. Цахим эх сурвалж:

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан ёсны цахим хуудас: <https://burtgel.gov.mn>
2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас: <https://www.judcouncil.mn>
3. ХБНГУ-ын хуулийн мэдээллийн сангийн цахим хуудас: https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/englisch_bgb.pdf
4. БНСУ-ын хуулийн мэдээллийн сангийн цахим хуудас: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55222&lang=ENG
5. Япон Улсын эрх зүйн мэдээллийн Англи хэл дээрх систем: <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4178/en>

ХУРЛЫН ХӨТӨЛБӨР



Монгол Улсын дээд шүүх



Шүүхийн сургалт, судалгаа,
мэдээллийн академи



IDLO Олон улсын эрх зүйн
хөгжлийн байгууллага



Hanns
Seidel
Stiftung

Ханнс-Зайделлийн сан

Хурлын огноо: 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг.

Хурал болох газар: Монгол Улс, Улаанбаатар хот, Новотел зочид буудал, 4 давхар, Ballroom

08:00-08:30	Бүртгэл, цай, кофе
Модератор:	УДШ-ийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг.
08:30-08:40	Д.Ганзориг, УДШ-ийн Ерөнхий шүүгч. Нээлтийн үг, мэндчилгээ
08:40-09:10	П.Золзаяа, УДШ-ийн Иргэний хэргийн танхимын шүүгч. Үндсэн илтгэл: “Үндсэн хууль болон Иргэний эрх зүй дэх гэр бүлийн хамгаалалт”
09:10-09:40	Др. Ч.Хосбаяр, УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, хууль зүйн доктор. Үндсэн илтгэл: “Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх: үзэл баримтлал, харьяалал, Монголын загвар”
I. Гэр бүл ба хамтын амьдрал, үрчлэлт, гэрлэлт цуцлалт, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхол, асран хамгаалалт, дундын эд хөрөнгийн харилцаан дахь тулгамдсан асуудал	
Модератор:	УДШ-ийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг.
09:40-10:00	Япон Улсын зочин илтгэгч: Др. Харада Аяако, Япон Улсын Нагояагийн их сургуулийн профессор, хууль зүйн доктор. “Япон Улсын Гэр бүлийн шүүхээс гэр бүл цуцлалт, хүүхдийн асрамжтай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх нь”
10:00-10:20	Др. Н.Баярмаа, УДШ-ийн Иргэний хэргийн танхимын шүүгч, хууль зүйн доктор. “Монгол Улс дахь гэр бүлийн хөрөнгийн эрх зүйн зохицуулалтын онцлог, шүүхийн практик”
10:20-10:40	БНТУ-ын зочин илтгэгч: Севил Картал, БНТУ-ын дээд шүүхийн Иргэний хэргийн 2-р танхимын шүүгч, Гэр бүлийн эрх зүйн үнэлгээний зөвлөлийн дарга. “Бүгд Найрамдах Турк Улсын Гэр бүлийн тухай хууль дахь хүүхдийн асрамж ба хүүхдийн эрхийн тухай”
10:40-10:50	Эрүүл мэндийн завсарлага

10:50-11:10	Ж.Лхагвасүрэн, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Г.Нямсүрэн, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч “Монгол Улс дахь хүүхдийн асрамжийн эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал”
11:10-11:30	Н.Оюунтуяа , Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Т.Энхтуяа, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч “Хүүхэд үрчлэлтийн талаарх зарим зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал”
11:30-12:30	<i>Хэлэлцүүлэг</i> Панелист: Др. О.Отгонтуяа , Дотоод хэргийн их сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, хууль зүйн доктор, А.Дугармаа , МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, хуульч.
12:30-13:30	Өдрийн хоол
II. Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа	
Модератор:	УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн.
13:30-13:50	С.Өмирбек, Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч. “Монгол Улс дахь өсвөр насны хүнд холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа”
13:50-14:10	АНУ-ын зочин илтгэгч: Маттю Ж. Виола, Хавай мужийн Хонолулу хотын анхан шатны шүүхийн шүүгч. “Хавайн нэгдсэн гэр бүлийн шүүх: гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүхийн тогтолцооны загвар”
14:10-14:30	ХБНГУ-ын зочин илтгэгч: Стефан Сшал, ХБНГУ-ын Бамберг хотын Ерөнхий прокурорын газрын прокурор, орлогч дарга. “ХБНГУ дахь өсвөр насны хүний эрүүгийн эрх зүй”
14:30-15:30	<i>Хэлэлцүүлэг</i> Панелист: Др. Д.Сүнжид , Хүний эрхийн үндэсний комиссын дарга, хууль зүйн доктор, Др. Т.Золбоо , МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн доктор
15:30-15:50	Эрүүл мэндийн завсарлага

III. Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба шүүхийн бүтэц, зохион байгуулалт	
Модератор: Др. Н.Баярмаа, УДШ-ийн Иргэний хэргийн танхимын шүүгч, хууль зүйн доктор.	
15:50-16:10	Нидерланд улсын зочин илтгэгч: Проф. Др. Тон Лиефаард, Хүүхдийн эрхийн чиглэлээр мэргэшсэн профессор-ЮНИСЕФ-ийн Хүүхдийн эрхийн асуудлыг хариуцсан тэргүүлэх мэргэжилтэн, Лейдений их сургуулийн Хууль зүйн сургуулийн Хүүхэд ба Эрүүл мэндийн салбар хариуцсан тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор. “Олон улсын хүүхдийн эрх: Хүүхэд, гэр бүл, шүүхийн үүргийн талаарх эргэцүүлэл”
16:10-16:30	БНСУ-ын зочин илтгэгч: Ким Хён Рюл, <i>БНСУ-ын Сөүлийн Гэр бүлийн шүүхийн Ерөнхий шүүгч.</i> “БНСУ-ын Гэр бүлийн шүүхийн түүх, сүүлийн үеийн чиг хандлага”
16:30-16:50	Австрали Улсын зочин илтгэгч: Карли Шревер, <i>“Human Ethos” захирал, University of Western Australia-ийн Хуулийн тэнхимийн дэд профессор,</i> Салли Раян, <i>“Human Ethos” захирал.</i> “Гэр бүлийн шүүхийн шүүгчийн сэтгэлзүйн эрүүл мэнд”
16:50-17:10	О.Оюунзул, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлалын талаар”
17:10-18:10	Хэлэлцүүлэг Панелист: Проф. Др. Херта Дойблер-Гмелин, хуульч, ХБНГУ-ын Парламентын гишүүн асан, ХБНГУ-ын Хууль зүйн сайд асан, хууль зүйн доктор, Др. А.Батбаатар, Их Засаг олон улсын их сургуулийн багш, өмгөөлөгч, судлаач, хууль зүйн доктор, О.Оюунзул, ХЗДХЯ-ны Хувийн эрх зүйн хэлтсийн дарга
18:10-18:20	Дүгнэлт, хаалт Др. Ч.Хосбаяр, УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, хууль зүйн доктор. Г.Алтанчимэг, УДШ-ийн Иргэний хэргийн танхимын тэргүүн

ХАВСРАЛТ¹

Стефан Сшал,

ХБНГУ-ын Бамберг хотын Ерөнхий прокурорын

газрын прокурор, орлогч дарга

ӨСВӨР НАСНЫ ХҮНД ЭРҮҮГИЙН ТУСГАЙЛСАН ХУУЛЬ ХЭРЭГЛЭХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

- Өсвөр насны хүн нь хүүхдээс насанд хүрсэн хүн болж буй шилжилтийн үед хамаардаг.
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тохирсон журмыг тодорхойлох шаардлагатай

- гэмт хэргийн сэдэл

- тэдний боловсрол болон хүмүүжлийн дутагдлыг илрүүлэх

ХБНГУ ДАХЬ ӨСВӨР НАСНЫ ХҮНИЙ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ

ХБНГУ-ын Ерөнхий прокурорын газрын прокурор
Стефан Сшал, 2025.06.25, Улаанбаатар хот

¹ Хавсралт хэсэгт видео бичлэгээс буулгасан илтгэгч нарын илтгэлийг хавсаргасан болно.

ӨСВӨР НАСНЫ ХҮНД ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ ХЭРЭГЛЭХ НӨХЦӨЛ

- 14 насанд хүрээгүй хүн эрүүгийн хариуцлага хүлээхгүй
- зөвхөн өсвөр насны хүний асрамжийн болон Иргэний хуулийг хэрэглэж болно

(шийдвэр гаргахад гэмт хэрэг үйлдэх үед тухайн хүн хэдэн настай байсныг харгалзан үзнэ)

ӨСВӨР НАСНЫ ХҮНД ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ХЭРЭГЛЭГДЭХ НӨХЦӨЛ

- Өсвөр насны хүнд (14-18 нас)
- Гэвч эрүүгийн ямар хариуцлага хүлээлгэх нь харилцан адилгүй ойлголт.
- Эрүүгийн хариуцлагыг зөвхөн өсвөр насны хүнд тухайн гэмт хэргийн бодит шинж чанарыг бие бялдарын болон оюун ухааны хөгжлийн түвшинд ойлгож, энэ ойлголтдоо нийцсэн үйлдэл хийх чадвартай тохиолдолд хүлээлгэнэ.

Залуучууд / өсвөр насны хүн (18-21 нас)

- Эрүүгийн хариуцлага хүлээх чадвартайд тооцогдоно.

Өсвөр насны хүнд Эрүүгийн хууль дараах тохиолдолд хэрэглэгдэх боломжтой. Үүнд:

- Оюун ухааны хомсдолтой;
- Эсхүл үйлдсэн гэмт хэрэг нь өсвөр насны хүнд нийтлэг тохиолддог (and should still be treated as juveniles) шинжтэй бол.

Харин дээрх нөхцөлд хамаарахгүй тохиолдолд эдгээр этгээдийг насанд хүрсэн хүнтэй адилтган үзэж, насанд хүрсэн хүнд хэрэглэгдэх Эрүүгийн хуулийг хэрэглэж, хариуцлага хүлээлгэнэ.

ХБНГУ ДАХЬ ЗАЛУУЧУУД (НАСАНД ХҮРСЭН) ГЭМТ ХЭРЭГТНҮҮДИЙН НАСНЫ АНГИЛАЛ БА ЯЛ ОНОГДУУЛАЛТ

Гэмт хэрэг үйлдсэн үеийн нас

14-21

Өсвөр насны
хүний шүүх
(Youth court)

14-18

18-21

Насанд хүрээгүй хүний Эрүүгийн хуулиар хүлээлгэх хариуцлага
Боловсрол олгох арга (education measures)
Сахилгын арга хэмээ (disciplinary measures)
Насанд хүрээгүй хүний хорих ялыг түдгэлзүүлэх (2 жил хүртэл)
Насанд хүрээгүй хүний хорих ялыг тохиролцохгүй байх (5 жил хүртэл, онц ноцтой гэмт хэрэгт 10 жил хүртэл)

21-ээс дээш

Насанд
хүрэгчдийн
эрүүгийн хэргийн
төв шүүх (General
criminal court for
adults)

Эрүүгийн ерөнхий хуульд заасан гэмт хэрэгт оногдуулах ялын төрөл:
Энгийн
Хорих ялыг түр хойшлуулах (2 жил хүртэл)
Хорих ялыг тохиролцохгүй байх (15 жил эсхүл бүх насаар нь хорих ял)

ӨСВӨР НАСНЫ ХҮНД ОНОГДУУЛАХ БОЛОМЖТОЙ ШИЙТГЭЛҮҮД

1. Сахилгын арга хэмжээ (англ. *disciplinary measures*)

- Жишээлбэл: Албадан хөдөлмөр эрхлэх үүрэг оноох
- Нийгмийн сургалтад хамруулах
- Архи, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох
- Хохирсон этгээдээс уучлал гуйлгах
- Хандивын байгууллагад мөнгөн хандив өгөх
- Учруулсан хохирлыг арилгуулах

2. Өсвөр насны хүнийг цагдан хорих (англ. *Juvenile Detention*) (1 өдрөөс 4 долоо хоног хүртэлх хугацаагаар өсвөр насны хүний тусгай хорих байранд)

- Энэ төрлийн ялыг ихэвчлэн сахилгын арга хэмжээтэй хослуулж хэрэгжүүлдэг

3. Өсвөр насны хүнд оноох хорих ял, ихэвчлэн тэнсэн харгалзах ял (англ. *Prison sentence, often suspended on probation*)

Зөвхөн дараах нөхцөлд хорих ял онооно:

- Өсвөр насны хүн дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэхэд хөнгөн шийтгэл хангалтгүй гэж үзсэн тохиолдолд (ямар нэг муу зан төлөвтэй тохиолдолд)
- Үйлдсэн гэмт хэрэг нь хүнд бөгөөд шүүхээс хорих ял оноох шаардлагатай гэж үзсэн тохиолдолд

Хорих ялын хугацаа: Хамгийн багадаа 6 сар, хамгийн ихдээ 10 жил.

ТЭНСЭН ХАРГАЛЗАХ ЯЛ (АНГЛ. *APPROBATION*)

- Дараах тохиолдолд тэнсэн харгалзах ял онооно:
- Хорих ял 2 жилээс хэтрэхгүй байх
- Гэмт этгээд дахин гэмт хэрэг үйлдэхгүй гэх урьдчилсан таамаглал байх
- Шүүхээс тухайн этгээдэд дагаж мөрдөх тодорхой заавар, үүрэг тогтоох
- Түүнийг хянах үүрэгтэй хяналтын ажилтан томилох
- 3 жил өнгөрмөгц ялыг тэнсэх
- Зааврыг дагаж мөрдөхгүй тохиолдолд гэмт этгээдэд хорих ял оногдуулах

ӨСВӨР НАСНЫ ХҮНИЙ ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

- Шүүгч (*Judge*)
- Өсвөр насны хүний хэрэгт тусгай мэргэшсэн прокурор (*Special Prosecutor*)
- Өсвөр насны хүний хэргийн шүүх дэх залууст туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий газрын ажилтан
- Гэмт этгээд (*Perpetrator*)
- Эцэг, эх эсхүл хууль зүйн төлөөлөгч (*Legal guardian*)
- Онц ноцтой гэмт хэрэгт: Өмгөөлөгч

Асуулт ?

Холбоо барих мэдээлэл:

Стефан Сшал

Ерөнхий прокурорын орлогч дарга

И-мэйл: Stephan.Schael@gensta-ba.bayern.de

Тон Лиефаард,
Хүүхдийн эрхийн чиглэлээр мэргэшсэн профессор,
ЮНИСЕФ-ийн Хүүхдийн эрхийн асуудлыг хариуцсан тэргүүлэх мэргэжилтэн,
Лейдений их сургуулийн Хууль зүйн сургуулийн Хүүхэд ба Эрүүл мэндийн
салбар хариуцсан тэнхимийн эрхлэгч, Хууль зүйн доктор (Ph.D)

“ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХ: ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, ШҮҮХИЙН ҮҮРГИЙН ТАЛААРХ ЭРГЭЦҮҮЛЭЛ”

Нидерланд Улсын зочин илтгэгч: Проф. Др. Тон Лиефаард, НҮБ-ын
Хүүхдийн Сангийн дарга, хүүхдийн эрхийн профессор, Лейдений их
сургуулийн Хууль зүйн сургуулийн Хүүхэд ба эрүүл мэндийн салбар
хариуцсан тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор.

1989 оны 11 дүгээр сар




НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ (CRC) – ТОГЛООМЫН ДҮРМИЙГ ӨӨРЧЛӨГЧ

- Хүүхдийн эрхийн тухай олон улсын гэрээ + гурван нэмэлт протокол
- **Хүүхэд (CRC-ийн 1-р зүйл: < 18 нас):**
 - Эрхийн эзэмшигч
 - Тусгай хэрэгцээтэй хөгжлийн шатанд буй хүн
 - Гэр бүлийн гишүүн (Өргөтгөсөн)
- 2025 оны байдлаар (тайлбарлахдаа) – иж бүрэн, олон давхаргат, динамик, төвөгтэй, харьцангуй шинэлэг эрх зүйн салбар
- *Олон янз байдлыг хүлээн зөвшөөрдөг* – нээлттэй хэм хэмжээ
- *Илүү өндөр хамгаалалт хэрэгтэй юу?* – чиглүүлэх шинжтэй хэм хэмжээ



ДЭЛХИЙ НИЙТИЙН ӨГҮҮЛЭМЖ



ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ҮНДСЭН СУУРЬ ҮНЭТ ЗҮЙЛС

- I. Хүүхдийн эрх ашиг нэн чухал байр суурь эзэлнэ
 - Хүүхдийн эрхтэй холбогдуулан, түүний хөгжих чадамжийг харгалзан үзэх
- II. Хүүхдийн нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэх – адил тэгш байдал буюу тэнцэтгэх
- III. Бүх хүүхэд үнэ цэнтэй– ялгаварлан гадуурхахгүй, оролцоог хангах
- IV. Хүүхэд бол иргэн – оролцох эрх болон шүүхэд хандах эрх



НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ 'АМЬД ХЭРЭГСЭЛ' БОЛОХ НЬ (АНГЛ. 'LIVING INSTRUMENT')



НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН КОНВЕНЦЫН 35 ЖИЛИЙН ОЙ

- 1989 оноос хойших ахиц дэвшил ба амьд хэрэгсэл
- “Давхар хямрал” – UNICEF 2023
- Бууралт ба эсэргүүцэл – Skelton 2024
- “Эрх зүйн хийдэл”
 - Хүүхдийг эрх эзэмшигч гэж хүлээн зөвшөөрөхгүй байх
 - Хүүхдийг тэнцэтгэхгүй байх (англ. *equivalence*) буюу хүүхдэд эрх тэгш хандахгүй байх
 - Орхигдуулах ба ялгаварлан гадуурхалт → оролцоог хангахгүй байх
 - Хариуцлагын дутагдал

ЭРГЭЦҮҮЛЭЛ 1 –ХАРИУЦЛАГА БА ХҮҮХДИЙН ШҮҮХЭД ХАНДАХ ЭРХ



ЭРХИЙГ БОДИТ БОЛГОХ НЬ: ҮР НӨЛӨӨТЭЙ ХАМГААЛАЛТ

- “Эрхийг утга учиртай байлгахын тулд зөрчлийг засах үр нөлөөтэй хамгаалалт заавал байх ёстой” — НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны Ерөнхий тайлбар №5, 24-р хэсэг
- “Хамгаалалтгүй эрхийн ач холбогдол нь бэлгэдлийн шинжийг агуулахаас хэтрэхгүй” — Майкл Фриман (2007)
- Шүүхэд хандах эрх: “Үндэсний болон олон улсын хэм хэмжээ, стандарт (CRC)-д заасан эрхийн зөрчлийг арилгуулахын тулд түүнийг шударгаар, цаг хугацаанд нь шийдвэрлүүлэх боломж” — НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар (2013) / Хүний эрхийн зөвлөл (2014)



ХҮҮХДИЙН ШУДАРГА ШҮҮХЭД ХАНДАХ ОЛОН УЛСЫН БОЛОМЖ

- Хүүхдийн эрхийн тухай конвенцын Харилцаа холбооны журамтай нэмэлт протокол (ОПИС)
- “Хүүхдийн шүүхэд хандах эрхийг хүлээн зөвшөөрсөн”
- ОПИС-ийн 10 жилийн ой – 2024 оны 4 дүгээр сар
- Нэгдэж буй улсуудын тоо нэмэгдсээр (53 улс)-ОПИС
- Шүүхийн практик хурдтай хөгжиж байна
- Төвөгтэй, эмзэг шинжтэй хэргүүд
- Хувь хүний болон ерөнхий/системийн хамгаалалт
- Хүүхдийн шударга шүүхэд хандах эрхийн талаарх мэдлэг, судалгааны хүрээ өргөжин тэлж байгаа.

ЭРГЭЦҮҮЛЭЛ 2



Global Initiative on Justice With Children - justicewithchildren.org

ЭРГЭЦҮҮЛЭЛ 3 – ХҮҮХДИЙН ЭРХЭД ҮНДЭСЛЭХ



ШҮҮГЧ АЛБИ САКС, 2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 06
(Шүүгч Сандил Нгкобог эш татсан)

"Үндсэн хуульт улсад шударга ёс цаг ямагт үйлчлэх ёстой."



Constitutional Court
of South Africa

• **Баярлалаа!**

Проф. Доктор Тон Лиефаард
UNICEF-ийн Хүүхдийн эрхийн суудалтай
профессор
Хүүхдийн эрх ба Эрүүл мэндийн эрхийн
тэнхимийн эрхлэгч
Лейденийн Хууль зүйн сургууль
Цахим шуудан: t.liefwaard@law.leidenuniv.nl



Universiteit
Leiden
The Netherlands

ХҮҮХДИЙН ЭРХ – ЛЕЙДЕНИЙН ИХ СУРГУУЛЬ



ХҮҮХДЭД ШУДАРГА ЁСЫГ ТҮГЭЭЖ ХҮРГЭСЭН 10 ЖИЛ – 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР САР



Лейденийн Хүүхдийн Эрхийн Хяналтын Төв ба Хүүхдийн Эрхийн Хууль Зүйн Шинэчлэл



ХҮҮХДИЙН ЭРХИЙН БОЛОВСРОЛ – ЛЕЙДЕНИЙН ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

- **Master of Laws (LL.M):** Олон улсын хүүхдийн эрхийн дээд түвшний судалгааны хөтөлбөр
- **(Нидерланд) Хүүхдийн эрхийн хууль** – Энгийн магистрын хөтөлбөр (Нидерланд хэлээр)
- **Олон улсын хүүхдийн эрхийн удиртгал** – Англи хэлээр
- **Нидерландын хүүхдийн эрхийн удиртгал** – Нидерланд хэлээр
- **Хүүхдийн хүчирхийллийн эрх зүйн асуудлууд** – Нидерланд хэлээр; хүүхдийн хүчирхийллийн олон салбарын сургалтын нэг хэсэг
- **Хүүхдийн эрх ба олон улсын хүүхдийн эрх**
- **Хүүхдийн эрхийн шүүхийн тэмцээн 2025**
 - 2025 оны 7 сар – Лейден / Гааг – 11 дэх удаа

LL.M. – ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУДАЛГАА



НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Англи	Монгол
Best interest of the child	Хүүхдийн дээд эрх, ашиг сонирхол
Conciliation	Эвлэрүүлэн зуучлал
Commission on Children and Youth	Хүүхэд, залуучуудын хороо
Custody	Хүүхдийн асрамж
Disciplinary measures	Сахилгын арга хэмжээ
Exclusive jurisdiction	Шүүхийн онцгой харьяалал
Family Court	Гэр бүлийн шүүх
Family Tribunal	Гэр бүлийн танхим
Foster care	Асрамжийн газар
Juveniles Act	Өсвөр насны хүний тухай хууль
Juvenile detention	Өсвөр насны хүнийг цагдан хорих
Juvenile Court	Өсвөр насны хүний хэргийн шүүх
Juvenile Tribunal	Өсвөр насны хүний танхим
Investigator	Шинжээч
Girls’ Court	Охидын шүүх
Guardian ad litem	Шүүхээс томилсон асран хамгаалагч
Non-adversarial proceedings	Үл маргах журмаар явагдах ажиллагаа
Penal code	Эрүүгийн хууль
Perpetrator	Гэмт этгээд
Probation	Тэнсэн харгалзах ял
Punishment	Ял шийтгэл
Specialized court	Дагнасан шүүх
Status offenses	Өсвөр насны хүнд холбогдох зөрчлийн хэрэг
Therapeutic	Эмнэлгийн чанартай
The family drug court	Гэр бүлийн хүрээнд үүссэн мансууруулах бодистой холбоотой хэргийг хянан шийдвэрлэх шүүх
The Personal Status Litigation Act	Хувийн байдал тогтоох хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
The Court’s rehabilitative mandate	Гэмт хэрэгтнийг сэргээн засах шүүхийн чиг үүрэг
Truancy Court	Сургуулиас завсардсан хүүхдийн шүүх
Victim impact statement	Хохирогчийн нөлөөллийн мэдүүлэг

